

ОРШИЛ

Сүүлийн жилүүдэд газрын бодлого нь газар болон түүний нөөц баялгийг эдийн засгийн эргэлтэнд эрчимтэй оруулах /техник, эдийн засгийн хүч чадлын хирээр/, газар ашиглалтын үр ашгийг дээд зэргээр нэмэгдүүлэхэд чиглэгдэж ирлээ.

Ялангуяа атар газар эзэмших, услалтын систем барих, байгалийн хадлан бэлтгэх, мал аж ахуйн үйлвэрлэлийг эрчимжүүлэх зэрэгт газрын нөөцийг бүрэн илрүүлэн эзэмших, ой модны нөөцийг үйлдвэрийн аргаар ашиглах, газрын хэвлийн баялгийг олзворлох, боловсруулах зэргээр байгалийн нөөц баялгийг эрчимтэй ашиглаж улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд чармайлт тавин ажилласан нь нилээд үр дүнд хүрсэн билээ.

Үүний үр дүнд газар тариалан, малын тэжээлийн үйлдвэрлэл, ой, уул уурхайн салбарын үйлдвэрүүд бие даасан тулгуур салбар болтлоо хөгжсөн нь тухайн үеийн бодлого зорилго хэрэгжиж байсан ч экологийн эерэг, сөрөг үр дагаврыг тооцож судлаагүй орхисон явдал нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх болсон байна. Үйлдвэрлэлийг экологитой хослон хөгжүүлэх арга зам нь Газар зохион байгуулалт, түүний оновчтой төлөвлөлт болно.

Газрын нөөцийг бүрэн дүүрэн, үр ашигтай хэрэглэх нь газар зохион байгуулалтын гол зарчим юм. Одоогийн газар ашиглалт нь тооцоо судалгаа муутай хэт төвлөрсөн нь байгаль-экологийн тэнцвэр алдагдахад хүргэсэн байна. Энэ нь хүн, газар хоёрын язгуур эрх ашиг хүйн холбоог холдуулж, газар эзэнгүйтэх, үнэ цэнээ алдах, дур зоргын хэрэглээ, зарцуулалтыг хүлээн зөвшөөрсөн нийгмийн нөхцөл байдлыг бий болгож байна.

Аймгийн газар ашиглалтын ерөнхий төлөвлөгөөгүйгээр нийгэм эдийн засгийг хөгжүүлэхэд дараахь нөхцөл байдлын төсөөлөл буй болж байна.

- ⊕ Хүн амын нутагшил, суурьшил нь хот, тосгоны маягаар суурьших, нэг газар нутагт удаан суух хандлага давамгайлснаас хүн амын нягтран нэг дор бөөгнөрөх, газар элэгдэлд хэт орж тухайн орчин доройтох, нутаг дэвсгэрийн ялгаа ихсэх, зарим нутаг эзэнгүйдэж газрын нийлүүлэлтийн харьцаа алдагдах, үнэ цэнэ буурах зэрэг эсрэг тэсрэг хандлага үүсэх
- ⊕ Дэлхийн уур амьсгалын үйл явц, чийг, дулааны горим аажмаар өөрчлөгдөж буй өнөө үед усалгаагүй газар тариалан, хадлан, жимс жимсгэнэ хөгжүүлэх боломж алдагдаж, бэлчээрийн биомассын хэмжээ багасаж, малын тоо толгойг өсгөхөд сөргөөр нөлөөлж, эдийн засгийн хувьд эрчимжиж чадаагүй мал аж ахуйд хүндрэл учирах

- Орчны нөхцөл, зохицолдлого сайтай нутагт хүн амын төвлөрөл үүсэж, бэлчээр нутагт цөлжилт явагдаж, цөлжсөн нутаг дэвсгэр их хэмжээгээр бий болох.
- Нөхцөл боломж сайтай нутагт ачаалал ихсэж, малын тоо толгой нэмэгдэж түүнийг эрчимжүүлэх боломж алдагдах, зах хязгаар нутагт эзэнгүйдэл ихсэх
- Тодорхой бүс нутгуудад ургамлан нөмрөг сийрэгжиж, бэлчээрийн даац, багтаамж багасан, ган зудын аюул нүүрлэх

Үүнтэй уялдан өрхийн, ялангуяа малчдын амьжиргааны түвшин буурах магадлал ихсэнэ.

Байгаль орчин-эдийн засаг-нийгмийн тогтвортой хөгжлийг хангах гол хүчин зүйл нь газар ашиглалт юм.

Иймээс газрын шинэтгэл нь экологийн хувьд хохиролгүй, эдийн засгийн хувьд ашигтай, газар усаа дэмжин тэтгэсэн газар ашиглалтын үр өгөөжийг хөгжүүлэх нь чухал.

Өнөө үеийнхэн газраас хэрэгцээгээ хангахын зэрэгцээ, хойч үеийнхээ ашиг сонирхолыг хамгаалж байхад оршино.

Цаг агаарын байдал тааламжгүй, нийт нутаг дэвсгэр хуурайшилт, цөлжилтийн нөхцөл хурдастай явагдаж байгаа өнөөгийн нөхцөлд газар ашиглалтыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн хөгжүүлэх хойшлуулашгүй зорилт болж байна. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан Говь-Алтай аймгийн удирдлага болон газрын алба аймгийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх зорилт тавьж энэхүү ажлыг газрын мэргэжлийн байгууллага “Геоботаник”, “Экоговь” ХХК-уудтай ажил гүйцэтгэлийн гэрээ байгуулан 2006-2023 он хүртэлх тус аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг гүйцэтгүүлэв.

Аймгийн ГЗБ-ийн төлөвлөгөө боловсруулах ажлыг ГХГЗЗГазар болон аймгийн газрын албанаас боловсруулсан заавар удирдамжуудыг үндэс болгон тоон мэдээллийг GIS-ийн ARCVIEW 3.2, GiS-ийн ArcMap 8.3, Dak 4.0, ARCINFO 3.5, Erdas imagine-8.4 программын дагуу хийж гүйцэтгэв.

Энэхүү ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад удирдлага, орон нутаг, үйлдвэрлэл, газар ашиглалтын талаар гүн туслалцаа үзүүлсэн аймгийн ИТХ-ын дарга Б. Дорждагва, аймгийн засаг дарга Р. Цогтбаатар, аймгийн газрын албаны дарга Д.Эрдэнэцогт нарт талархалаа илэрхийлье.

Хээрийн судалгааны ажил болон төлөвлөлтийн ажилд туслалцаа үзүүлсэн аймгийн Газрын албаны ажилтан Ж. Мөнхболд, Г. Ганхуяг, Ц. Базаррагчаа, мөн орон нутгийн ИТХ-ын тэргүүлэгчид, засаг дарга, бусад мэргэжилтэн, ялангуяа

сумдын газрын даамал болон энэхүү ажилд сэтгэл тавин санал бодлоо чөлөөтэй илэрхийлсэн иргэд, аж ахуйн нэгжүүдэд гүн талархаж буйгаа илэрхийлье.

Энэхүү төлөвлөгөө боловсруулахад гидрогеологич доктор, профессор М.Алей, газарзүйч доктор Б. Оюунгэрэл, Д. Энхтайван, ойн инженер доктор Ж. Цогтбаатар, А. Хауленбек, ой зүйч Н. Баянхишиг, хөрс судлагч доктор Ө. Бэхтөр, Ж.Мандахбаяр, газар зохион байгуулагч инженер доктор Д. Жамц, ургамал зүйч доктор Ч.Төмөрбаатар, газар зохион байгуулагч инженер Ч. Цанжид, Н. Амарбат, Ц.Ханбүргэд, Б. Пүрэв-Очир, П.Жанчивдорж, экологич магистр С. Түмэннаст, Д.Цэгмид, Б. Оюунтуяа, ургамал зүйч Л.Дамдинжав, Б. Уртнасан нар оролцов.

І БҮЛЭГ. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ЦАГ УУР, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ

І.1 ГОВЬ - АЛТАЙ АЙМГИЙН ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Говь-Алтай аймаг нь 1940 онд байгуулагдсан 141.2 мянган ам.км нутаг дэвсгэртэй, засаг захиргааны нэгжийн хувьд 18 сум 2 тосгон 83 багтай, 2005 оны байдлаар 63.5 мянган хүн амтай, баруун болон хойд талаараа Ховд, Увс, Завхан аймаг зүүн талаараа Баянхонгор аймагтай, өмнөд, баруун урд талаараа БНХАУ-тай хил залган оршдог, манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулдаг томоохон аймгийн нэг юм.

Аймгийн төв Алтай хот нь Хантайшир уулын өвөр бэлд Улаанбаатар хотоос 1001 км зайтай оршдог. 2005 оны тоо бүртгэлээр 20,1 мянган хүн амтай байв.

Тус аймаг нутаг дэвсгэрийн хэмжээгээр Өмнөговь аймгийн дараагаар улсын хэмжээнд хоёрдугаарт, малын тоогоор Өвөрхангай, Хөвсгөл, Завхан, Увс, Ховд зэрэг аймгуудын дараа 10 дугаарт, нэг хүнд ноогдох малын тоогоор Дундговь, Сүхбаатар аймгийн дараа 3 дугаар өрнөд бүсийн хэмжээнд тэргүүн байранд явж байна.

Говь-Алтай аймгийн үүсч хөгжсөн түүхээс товч дурьдвал Ар Монголын халх долоон хошууны нэг Засагтхан аймаг 16-р зууны дундуур үүсчээ. 1923 онд тусгаар тогтносон шинэ монгол улсын анхны таван аймаг нэг Хан Тайшир уулын аймаг, Засагт хан аймгийн эртний нутаг дэвсгэр дээр байгуулагдсан байна. Улс орны гадаад, дотоод байдал, нийгмийн үйл явцаас хамааран өнөөгийн бие даасан Говь-Алтай аймгийг үүсгэн байгуулах хүртэл түүхэн хөгжлийн үе шатыг туулжээ.

Тус аймаг нь байгаль газар зүйн ангилалаар Алтайн уулархаг болон говийн их мужид хамаарна. Нутгийн төв хэсгийг Монгол-Алтай нуруу түүний салбар уулс болох мөнхцаст Сутай /4090 м/, Алаг хайрхан /3798 м/, Бурханбуудай /3765 м/, Хасагт хайрхан /3578 м/, Хантайшир /3070 м/, Аж богд /3802 м/ болон Харазарга, Их Багатаян, Атас, Сэрх, Эдрэн, Гичгэнэ зэрэг өндөр уул нурууд эзэлдэг.

Эдгээр уулсын хооронд Хүйс, Шарга, Бигэр, Захуй-Зарман, Алагнуур, Цэнхэр номингийн говиуд, Тахь, Аж, Гуулин, Дэлгэрийн өргөн талууд оршдог. Хамгийн өндөр цэг нь Сутай хайрхан далайн түвшнээс дээш 4090 м өргөгдсөн байхад хамгийн нам цэг нь Номин цэнхэрийн говийн Их сайрын хотгор далайн түвшнээс дээш 721 м өргөгдсөн байдаг.

Аймгийн нутаг дэвсгэр нь өндөр сүрлэг уулс, өргөн цэнхэр говь, ээлжлэн солигдсон байгалийн өвөрмөц тогтоцтой тансаг нутаг билээ. Алтайн сүрлэг уулсаар Аргаль, Янгир сүрэглэн бэлчиж, цасан дуулгат ян оргилын дээгүүр нь тураг шувууд

халин нисэж байхад, Хүйс Шаргын хонхорт монгол бөхөн, Алтайн өвөр говиор нь хулан, тахь, хавтгай идээшлэн явдаг унаган төрхөө алдаагүй дэлхийд ховор амгалан дагшин газар юм. Тус аймгийн бүтээлч ард түмэн улс орныхоо төлөө ихийг хийж нэр алдраа цуурайтуулж явсан билээ. Тэдний дундаас улсын болон хөдөлмөрийн баатар 31, ардын цолтон, гавъяат, төрийн шагналтан 72, академич, ШУ-ны доктор дэд доктор, зохиолчид 270 гаруй тодорчээ. Улсын цолтой бөхчүүд, нэр алдар нь түгсэн тамирчид аврага малчдын тухай ийм жишээ олныг дурьдаж болох юм.

Тус аймгийн бүтээлч иргэд улс орны тэмдэглэлт ойг угтсан уралдаанд удаа дараа тэргүүн байранд шалгарч мал сүргээ өсгөх төлөвлөгөөг биелүүлж ирснийг төр засгаас өндрөөр үнэлж “Хөдөлмөрийн гавъяаны улаан туг”-ийн болон “Алтан гадас” одонгуудаар удаа дараа шагнаж байв. Говь-Алтай аймгийн хөдөлмөрч дайчин уламжлалтай ахмадууд, залуу сэхээтнүүд, аймаг орон нутгаа зах зээлийн харилцааны нөхцөлд хөгжүүлэх, бүс нутгийн хэмжээний өргөн цар хүрээтэй хөтөлбөр бодлого боловсруулан ажиллаж байна.

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд, Говь-Алтай аймгийг 2010 он хүртэл хугацаанд хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр болон баруун бүс нутгийн хөгжилд тус аймгийн оролцох чиглэл, тэргүүлэх салбарыг оновчтой тогтооход анхаарал тавин ажиллаж ирлээ.

Аймгийн эдийн засгийн үндэс нь мал аж ахуй бөгөөд нийт өрхийн 67.8 %, хүн амын 53 % буюу 35 мянга нь тус салбарт ажиллаж байна. Өнгөрсөн онд 549.9 мянган төл бойжуулж мал сүргийн тоо толгойг 1834,2 мянгад хүргэн 5 төрлөөр нь өсгөжээ. Мал аж ахуйн болон газар тариалангийн бүтээгдэхүүнд анхан шатны боловсруулалт хийх зорилгоор ноос угаах үйлдвэр байгуулсны зэрэгцээ өлөн гэдэс боловсруулах цехийг сэргээн ажиллуулж байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн уналтыг зогсоож, тариалах талбай хураан авах ургацыг нэмэгдүүлснээр аймгийн хэрэгцээт гурилын 10 шахам хувь, төмс хүнсний ногооны 35-46 хувийг дотооддоо хангадаг болжээ.

Тус аймаг хүрэн нүүрс, шатдаг занар, хүлэр, төмрийн хүдэр, зэс алт вольфром, хөнгөн цагаан, хар цагаан тугалга, боржин, шөрмөсөн болон шохойн чулуу, өнгө бүрийн будаг, гантиг, гялтгануур, давс хужир, төрөл бүрийн шавар, хаш мана, гартаам, оюу зэрэг эрдэнийн чулууны орд илэрцээр баялаг юм.

Байгалийн орд газар илэрцүүдэд түшиглэн уул уурхайн салбар, барилгын материалын үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх талаар хөтөлбөр боловсруулан ажиллаж байна.

Тус аймагт зам, барилга үйлдвэрлэлийн чиглэлийн 10-аад аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагийн дотор өөрийн аймаг сумдаас гадна хөрш зэргэлдээ Завхан аймгийн Түдэвтэй, Сонгино зэрэг сумуудад үйлчилдэг боллоо. Мөн мэдээлэл, харилцааны салбарт шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, эрчим хүчний асуудлыг аймаг, бүс нутгийн хэмжээнд шийдвэрлэхэд томоохон алхам хийж эхэлжээ.

2005 онд интернет мэдээллийн төвийн барилгыг дуусгаж ашиглалтанд оруулсан байна.

Их Говийн Дархан Цаазат газрын ашиглалтын асуудлыг шийдвэрлэсэн нөхцөлд Нарансэвстэйн боомтыг дахин нээж БНХАУ-ын өндөр хөгжилтэй Ганьсу мужтэй худалдаа арилжаа явуулах, улмаар Талын Мэлстийн алтны үндсэн ордын хайгуул судалгааг хийлгэн ашиглалтанд оруулснаар аймаг, бүс нутаг төдийгүй улс орны хөгжилд томоохон түлхэц болох ирээдүйтэй ажил болох юм.

1.2 БАЙГАЛЬ-НУТАГ ДЭВСГЭРИЙН ЦОГЦОЛБОР НӨХЦЛИЙН МУЖЛАЛ

Монгол орны газарзүйн олон төрлийн мужлалыг судалж Монгол орны байгаль нутаг дэвсгэрийн ялгаа болон аж ахуйн ашиглалтын түвшин, цаашдын хөгжлийн хандлагын аль алиныг тусгахыг зорьсон газрын байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн мужлалыг ландшафт экологийн хандлагын үүднээс бүсийн нийтлэг зүй тогтолд тулгуурлах зарчмыг баримтлан ялгаварласан байдаг. Ингэхдээ байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлөөр нь мужуудад, хотгор гүдгэрийн ялгаа, түүнтэй уялдан илрэх газар ашиглалтын онцлогийг харгалзан тойргуудад хуваасан байна. Энэхүү мужлал нь 3 бүс нутаг, 12 муж, 31 тойрогт хуваагддаг.

Монгол орны газрын байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн мужлалаар авч үзвэл Говь-Алтай аймаг нь дараах 4 мужийн 7 тойргийг төлөөлж байгаа нь байгалийн нөхцөл, газрын хэв шинжийн хувьд олон янз болохыг харуулж байна. Үүнд:

1. Хангайн бүс нутгийн Монгол Алтайн өндөр уулын муж:

- а. Мөнххайрханы өндөр уулын тойрог
- б. Хар-Азарга-Гичгэний нурууны өндөр уулын тойрог

2. Говийн бүсийн Алтайн ар говийн цөлөрхөг муж:

- а. Алтайн нурууны салбар уулс, хотгорын тойрог,
- б. Нууруудын хөндийн тойрог

3. Алтайн өвөр говийн цөлийн муж:

- а. Баруун хуурайн хотгорын тойрог
- б. Алтайн өвөр говийн тойрог.

4. Говийн Алтайн муж

- а. Их, Бага, Богдын тойрог

1.2.1 Уур амьсгалын нөхцөл

Говь-Алтай аймаг өндөр уул, ой, тал говь цөл хосолсон өвөрмөц нөхцөлтэй, байгалийн хэд хэдэн бүс бүслүүр багтаасан өргөн уудам нутагтай юм.

Өндөр уул нуруудаас урагшлах тутам хээр тал, говь, цөл болж өөрчлөгдөхийн хирээр дулааны хангамж, салхины хурд нэмэгдэж, хур тунадас, хөрсний чийг буурдаг. Тус аймгийн нутаг дэвсгэр нь гол мөрний сүлжээ бага, өндөр уул нуруунаас эхтэй жижиг гол горхи нь усны нөөц багатай тул төдөлгүй хөрсөнд шурган замхардаг онцлогтой. Үүний зэрэгцээ газрын гадарга нь ерөнхийдөө уулархаг тул уур амьсгалын хуваарилалтанд зохих нөлөө үзүүлсээр иржээ. Уулын өндөр ихсэх тутам үүлшил, унах тунадасны хэмжээ нэмэгдэнэ.

Уур амьсгалын мужлалын хувьд Алтай, түүний салбар уулс орчмын нутаг нь чийглэгдүү хүйтэн таг, хуурай хүйтэн өндөр уул нь хуурай сэрүүн уулын хээрийн мужид хамрагддаг.

Нарны цацраг, гадаргын халалт, хүйтэн агаарын урсгал нэмэгдэх зэргээс зуны улиралд 100 м өгсөх тутам агаарын температур 0.6-0.7⁰-аар буурдаг байна. Энэ үзэгдэл зөвхөн дулааны улиралд ажиглагддаг бөгөөд хүйтний улиралд ууландаа орчин тойрныхоо хөндий хотгороос арай дулаан болдог. Харин хотгор газар агаарын хөдөлгөөн бага, орж ирсэн агаар нь удаан хадгалагддагаас өвөл хүйтэн, зун халуун байх нь ердийн үзэгдэл юм.

Шарга, Дарви, Бигэр зэрэг өндөр уулсаар хүрээлэгдсэн хонхор нь салхины урсгал хязгаарлагдмал байдал тод илэрдэг.

Тус аймгийн өмнөд хилээр хүрээлэн тогтсон уул нуруу цөөн бэсрэг уулс цав толгод бүхий талархаг гадаргатай учраас дулаан бүсийн хуурай халуун агаар өмнө зүгээс чөлөөтэй нэвтрэн орж ирдэг. Нөгөө талаар элс, чулуурхаг, гадарга халж агаарын температурыг ихэсгэж ууршилтыг идэвхжүүлдэг. Мөн баруун болон хойд зүгийн өндөр уулс нь хур тунадасыг хааж тогтсон зэрэг нь ерөнхийдөө цөл, цөлөрхөг нөхцлийг үүсгэжээ.

Баруун өмнө болон өмнө зүгээс орж ирсэн циклон ихэнхдээ Алтайн нурууны өврөөр зүүн урагш шилждэг боловч, зарим үед Алтайн нурууг даван Олон нуурын хөндийд нэвтрэх үедээ Сибирийн хүйтэн агаартай мөргөлдөн дахин хүч аван сэргэж заримдаа тус аймгийн нутгаар, ялангуяа хавар, намрын улиралд цаг агаар богино хугацаанд өөрчлөгдөн хямрах, үлэмж хэмжээний цас бороо орох, хүчтэй салхи, шуурга дэгдэх зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдох нөхцлийг бүрдүүлдэг байна.

Дулаан хүйтний горим: Өвөл нь ууландаа -17 °С - 19 °С, хөндий, хотгор, говь нутгаар - 20 - 23 °С хүрч хүйтэрнэ. Хамгийн хүйтэн сар нь нутгийн аль ч хэсэгт 1 дүгээр сар, хамгийн дулаан сар нь 7 дугаар сар байдаг. Зарим үед өвөл ууландаа - 40 °С - 45 °С, хөндий хонхор газарт - 45 °С - 50 °С хүрч хүйтний эрч эрс чангарна.

Зуны улиралд ууланд 8 °С - 15 °С, хөндий говь, хотгортоо +20 °С - 24°С хүрч халдаг. Зуны хамгийн халуун нь 2000 м-ээс дээш өндөрт 20 °С - 30 °С, нам хотгор говьдоо 30 °С - 35 °С хүрдэг. Зарим үед нам хотгор газарт хөрсний гадаргад 65 °С - 70 °С хүрч халах тохиолдол бий.

Говь цөлийн бүсэд намар хожуу хүйтэрч, хавар эрт 3 дугаар сарын 20-доор дулаарч байхад өндөр уулын бүсэд эрт хүйтэрч (9 дүгээр сарын 25), хавар 5 дугаар

сарын эхээр дулаарах тул ууландаа жилийн 235-260 хоног, говьдоо 180-220 хоног хүйтэн байна.

Хүснэгт 1

Говь - Алтай аймгийн цаг агаарын хур тунадас, салхи, шуурганы үндсэн үзүүлэлт /олон жилийн дунджаар/

№	Сумын нэр	Хур тунадасны нийлбэр (мм)			Чийг хангамж дунджаар	Цасан бүрхүүлтэй өвлийн тоо	Цасан шуургаатай өдрийн тоо	Бороотой өдрийн тоо	Шороон шуургаатай өдрийн тоо 1-5 сар, 9-12-р сарын нийлбэр	15 м/с-ээс дээш хүчтэй салхитай өдрийн тоо	Салхины хамгийн их хурд м/сек 4-р сар
		Жилийн дундаж	Дулааны улиралд 4-10 сар	Хүйтний улиралд 11-3 сар							
1	Алтай	60.2	51.2	9.0	4.7	16	13	29	9	18	20
2	Баян - Уул	129.3	110.7	18.6	3.1	14	10	14	8	25	25
3	Бигэр	81.4	72.6	8.8	2.8	59	16	28	9	22	20
4	Бугант	151.6	102.0	49.6	2.8	12	10	15	10	9	20
5	Дарви	77.0	67.7	9.3	4.3	17	25	7	12	9	20
6	Дэлгэр	110.9	98.8	14.1	5.6	43	12	15	10	14	20
7	Есөнбулаг	180.2	166.6	13.6	3.3	3	9	20	8	28	20
8	Жаргалан	82.6	72.8	9.8	5.2	20	13	23	12	18	20
9	Тайшир	127.2	112.9	14.3	3.4	39	8	21	11	16	20
10	Тонхил	138.3	131.2	7.1	1.0	109	11	39	9	25	28
11	Төгрөг	48.3	38.3	10.2	3.5	23	11	35	6	18	17
12	Халиун	96.7	87.5	8.6	3.5	35	13	21	5	15	20
13	Хөх морьт	99.7	89.2	10.5	6.2	11	9	14	15	8	20
14	Цогт	138.4	129.0	9.4	0.8	44	18	39	14	27	24
15	Цээл	98.1	89.7	8.4	3.2	38	27	24	22	7	20
16	Чандмана	119.2	102.4	16.8	2.9	20	23	25	21	5	20
17	Шарга	76.4	63.5	12.0	0.1	51	8	20	10	30	40
18	Эрдэнэ	157.2	140.4	16.8	1.4	191	15	35	13	25	30

Харин 10 °С-ээс дээших идэвхитэй хэмийн нийлбэр 1500-2000 м хүртэлх өндөрт 1100-1400⁰ байх бөгөөд 1000 м хүртэлх өндөрлөг нутагт +2800⁰С-ээс дээш дулаантай.

Дээр дурьдсанаас үзвэл ургамал ургах дулааны хангамж тагийн бүслүүрт хангалтгүй, хээрийн бүсэд дунд зэрэг, цөлөрхөг хээр болон говийн бүсэд сайн гэсэн үнэлэмж авч байна.

Улсын хэмжээнд явуулсан сүүлийн 60 жилийн ажиглалтаас үзвэл жилийн дундаж температур 1.56 °С нэмэгджээ. Энэ өсөлтийн дийлэнх нь өвлийн улиралд (3.61 °С), хавартаа арай бага (1.4-1.5 °С)-аар нэмэгдэж харин зуны улиралд -0.3 хэмээр сэрүүсэх хандлагатай болжээ.

Температурын өөрчлөлт нь орон зайн хувьд харилцан адилгүй. Өвлийн дулааралт уулархаг нутаг, тэдгээрийн хоорондын хөндийд илүү эрчимтэй, тал хээр говь цөлд сул нэмэгдсэн бол зуны сэрүүсэл нь говьд илрээгүй ажээ (Дагвадорж болон бусад 1994, 1999 он).

Чийгшилтийн горим: Монгол орны нэгэн адил Говь - Алтай аймаг нь далай тэнгисээс алслагдсан, эргэн тойрон өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, агаар хуурай, хур тунадас бага, жилийн температурын зөрүү ихтэй эх газрын эрс тэс уур амьсгалтай, хуурайдуу нутаг юм. Агаар хуурай учраас жилийн дулааны улиралд чийгшил нийт нутагт 50-60 %, үүнээс говьд 30-50 % байдгаас үзэхэд агаар нилээд хуурай, агаарын харьцангуй чийг ууландаа 9-10 %, говьд 3-4 хувьд хүрч буурна.

Агаарын хуурайшилтаас шалтгаалан хур тунадасны хэмжээ нийтдээ бага, далайн түвшнээс дээш 2500 м газарт 260 мм, 2000 м-ийн өндөрт 180 мм, харин 1000-1500 м өндөрт 50-80 мм хур тунадас дулааны улиралд унадаг. Уулархаг нутагт цас эрт ордог бөгөөд өндөр уулын бүсэд намрын анхны цас 8 дугаар сарын эхээр, хаврын сүүлчийн цас 6 дугаар сарын эхний 10 хоногт ордог. Энд жилийн 188-200 хоног цасан бүрхүүлтэй байна. Хээр, говь-цөлийн бүсэд цасан бүрхүүл бараг тогтдоггүй, тогтсон ч 24-50 хоногоос үл хэтэрнэ. Алтайн уулс, түүний орчмоор цасан бүрхүүл 5-10 см, бусад нутгаар 5 см-ээс ихгүй зузаантай байдаг. Мөн цасан шуурга шуурах тохиодол цөөнгүй, ууландаа цасан шуургатай өдрийн тоо 15-23, говь хөндийд 5-6 хоног байдаг.

Салхины горим: Говь-Алтай аймгийн нутаг нь салхины нөлөө ихтэй. Жилийн дундаж салхины хурд ууландаа 2 м/сек, говь 5 м/сек байна. Салхитай өдрийн тоог жилээр гаргавал өндөр ууландаа 123, үүнээс 2000 м хүртэлх өндөрлөг нутагт 37-86, говьд 60-122 хүрнэ. Харин 15 м/сек-ээс дээш хүйтэн салхитай өдрийн тоо өндөр ууланд 35 хоног, уулын хээрт 25 хоног, говьд 30 хоног байна. Салхины хамгийн их хурдны хэмжээг 20-30 м/сек гэж тэмдэглэжээ.

Уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн төлөв: Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт нь цаг агаарын гамшигт үзэгдлийн давтамж ойртон дулааралт, хуурайшил эрчимтэй явагдаж гол горхи, булаг шанд хатаж ширгэн бэлчээрийн болон хөдөө аж ахуйн таримал ургамал ганд нэрвэгдэх, цөлжих явц улам бүр газар авч буйгаар илэрч байна.

Тус аймаг уур амьсгалын энэхүү сөрөг нөлөөлөлд бараг жил бүр өртөх болжээ.

Ерөнхий орчил урсгалын загвар (ЕОУЗ)-аар бодсон уур амьсгалын өөрчлөлтийн тооцооноос харахад ХХI зууны эхний 25 жилд Монгол орны жилийн дундаж агаарын температур ойролцоогоор 1.8-2.8 °С-ээр дулаарах төлөвтэй байна. Өвлийн улиралд энэ дулааралт эрчимтэй (1.4 -3.0 °С) нэмэгдэх тооцоо гарчээ. Цаашид энэ зууны хоёр дахь 25 жилд дээрх дулааралт үргэжлэн эхний 25 жилд ажигдагдах хэмжээнээс даруй 2 дахин хүчтэй дулаарч болзошгүй байна.

Энэ хугацаанд хур тунадасны хэмжээ одоогийнхоос дунджаар 20-40 хувь нэмэгдэнэ.

Холдрижийн ангиллын загвараар хийсэн тооцоогоор говь цөлийн болон хээрийн бүс хойт зүгрүү улам бүр шилжиж эзлэх талбайн нь нэмэгдэх ажээ. Дулаарлын улмаас өндөр уулын бүсийн хил уулын орой өөд огшиж, улмаар мөнх цас хайлах бөгөөд мөнх цэвдэг гэссэнээр намаг үүсэх төлөвтэй.

Уур амьсгалын өөрчлөлтөнд ургамлын аймгийн экосистем хамгийн ихээр өртөх болно. Ингэснээр мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн өөрчлөгдөх буюу багасаж болзошгүй юм. Уур амьсгалын өөрчлөлт байгалийн нөхцөл нөлөөллийг нарийвчлөн тооцож, хөгжлийн ирээдүйн чиг хандлагад үнэлгээ өгөх замаар уур амьсгалын орчны нөхцөлд дасан зохицох стратеги боловсруулах нь үндэсний тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хангах нэгэн нөхцөл болж байна.

Говь-Алтай аймгийн цаг агаарын сар, жилийн дундаж температурын үзүүлэлт (олон жилийн дунджаар)

№	Сумын нэр	Жилийн дундаж агаарын температур		Агаарын үнэмлэхүй бага температур 1-р сар	Агаарын үнэмлэхүй их температур 7-р сар	Хөрсний гадаргын температур 5-р сар	Хөрсний гадаргын үнэмлэхүй хамгийн бага температур	Хөрсний гадаргын үнэмлэхүй хамгийн их температур	-40°C-аас дээш хүйтэн өдрийн тоо	+30°C-аас дээш хүйтэн өдрийн тоо	Хүйтэн өдрийн тоо	Хүйтэрдэггүй хугацаа			Хоногийн температурын нийлбэр		
		5-р сарын агаарын дундаж температур	Жилийн дундаж агаарын температур									олон	дунд	цөөн	0 °C их	5 °C их	10 °C дээш
1	Алтай	4.9	14.8	-32.2	38.0	21.2	38.6	68.8	0	38	171	180	145	122	3150.9	3072.0	2377.5
2	Баян - Уул	1.2	9.8	-40.6	33.4	16.0	-40.0	61.0	0	9	221	139	109	95	2264.8	2178.7	2189.6
3	Бигэр	3.3	14.6	-36.0	37.0	20.9	-36.9	66.0	0	29	208	157	136	108	2770.1	3032.0	3392.4
4	Бугант	1.0	9.3	-34.7	31.6	15.9	-37.2	60.0	0	6	225	133	106	93	2093.8	1991.6	1867.4
5	Дарви	1.4	12.4	-38.3	35.1	18.7	-40.6	60.3	0	18	220	129	114	98	2381.0	2512.2	2283.3
6	Дэлгэр	-1.0	8.3	-40.5	34.2	14.4	-44.1	55.6	3	6	240	140	112	101	1964.9	1758.5	1664.6
7	Есөнбулаг	-1.7	6.9	-40.8	29.2	11.9	-45.0	65.0	1	-	237	115	92	57	1636.1	1553.2	1157.8
8	Жаргалан	1.4	12.1	-45.0	35.0	19.2	-48.0	58.0	19	11	220	132	114	101	2659.0	2520.8	2662.3
9	Тайшир	-3.7	12.2	-51.6	34.0	15.5	-52.0	61.0	18	11	234	120	94	80	2546.9	2425.5	1808.6
10	Тонхил	-0.6	6.1	-36.0	29.1	10.1	-41.0	53.0	0	-	234	123	100	83	1636.1	1544.9	1470.8
11	Төгрөг	2.5	11.6	-36.4	38.4	17.2	-14.3	59.8	0	5	206	179	122	106	2661.0	2564.5	2360.7
12	Халиун	2.2	13.4	41.0	38.9	18.0	-42.4	64.9	2	22	208	175	133	104	2836.8	2520.6	2773.8
13	Хөх морьт	1.1	12.8	-45.8	38.9	19.0	-43.0	64.0	10	18	209	161	127	114	2696.9	3072.0	2491.4
14	Цогт	1.2	8.4	-39.2	29.5	10.9	-42.0	61.0	0	-	246	125	90	53	1851.6	1755.9	1456.2
15	Цээл	-0.2	7.3	-36.1	33.3	13.7	-37.4	57.0	0	12	234	121	102	82	1970.6	1855.9	1548.6
16	Чандмана	-0.5	7.9	-39.6	29.1	13.4	-40.3	60.2	0	-	239	122	92	57	1856.6	1782.2	1544.6
17	Шарга	3.7	16.3	42.6	41.5	20.6	-51.5	67.0	14	59	201	168	147	120	3538.9	3392.4	3631.0
18	Эрдэнэ	-1.5	6.7	-45.0	29.9	13.9	-46.0	53.6	3	-	262	117	93	58	1719.6	1519.3	1206.9

1.2.2 Газрын гадарга

Аймгийн нутаг дэвсгэр нь Алтайн уулархаг их муж, говийн их мужийн ангилалд багтдаг.

Нутгийн төв хэсгээр баруун хойноос зүүн урагш дамнан тогтсон Монгол Алтайн нуруу, түүний салбар уулс, тэдгээрийн хоорондох цайдам хөндий, хотгор хонхор нь гадаргуугийн төрх байдлыг тодорхойлдог. Уул, нурууд, хотос хоолой нь хойноос урагш ээлжлэн тогтсон онцлогтой.

Тус аймгийн уул, нуруудын онцлог нь хад асга, эгц босоо бэл хажуу бүхий шовх оргилуудтай, уулсын бэл хормойноос шууд говийн бүс эхэлдэг онцлогтой. Байгалийн бүс, бүслүүрийн хувьд гол төлөв говь, цөлийн бүсэд оршино. Гэхдээ бага зэрэг хээр тал, өндөр уулын босоо бүслүүр бий. Ерөнхийд нь дүгнэвэл баруун хойноос зүүн тийш дамнан тогтсон Монгол - Алтайн, Говь - Алтайн нурууд, аймгийн байгаль, цаг уур, хөрс, ургамлан бүрхүүл бүрэлдэн тогтоход онцгой нөлөө үзүүлсэн байна.

Тус аймгийн Алтай өвөр говийн өмнөд, баруун өмнөд хэсэг нь улсын хил дагуу байрлах бөгөөд дэлхийн шим мандлын дархан газрын сүлжээнд хамрагдсан их говийн дархан цаазат газар энд байдаг. Иймээс хүн ам бараг оршин суудаггүй онгон зэлүүд нутаг юм. Эндэхийн Баянбүрдүүд болон ил задгай ус түшиглэн зарим ан амьтад байршдаг.

Аймгийн нутгийн хойт зах Завхан голын сав дагуу 20-30 км өргөн, 330 км урт зурвас газарт алдарт Монгол элс оршдог бөгөөд элсний бэлчээрийг буруу ашигласнаас элэгдэл эвдрэлд орж, зонхилох салхины дагуу нүүж хүндрэл учруулж байна. Тус аймгийн нутаг нь гол горхины сүлжээ багатай ч нуур тойром, булаг шанд, баян бүрдүүд элбэгтэй. Тэдгээр нь Монгол - Алтайн нуруу түүний салбар уулсаас бууж ирсэн гол горхи, үерийн ус болон өнгөн хөрсний усаар тэжээгддэг.

Уулс хоорондын болон өргөн хөндийнүүдээр үерийн усны нөлөөгөөр үүссэн огцом эрэгтэй гуу, жалга, хуурай сайр элбэгтэй. Түүнийг дагаж говь, цөлийн бутлаг ургамал арай түлхүү ургана.

Уулс хоорондын өргөн хөндий, говь цөл нутаг нь гадаргын хувьд тэгшивтэр, уулсаас үерийн усаар урсаж ирсэн чулуу гадаргууг нилд нь бүрхсэн байдаг. Дундаж өндөртэй уулсын хөрс нь бага зэрэг элэгдэлд орсон, бөөрөнхийдүү оройтой, тачир сийрэг ургамлын бүрхэвчтэй.

1.2.3 Хөрс, хөрсөн бүрхэвч

Тус аймгийн нутаг нь Говийн хөрсний их мужид багтах бөгөөд Монгол - Алтай, Говь - Алтайн нуруу болон говь цөлийн бүсэд хамрагдана. Уур амьсгалын

нөхцөл үлэмж хуурай, тундас бага унана. Уулын чулуулгийн өгөршил, хөрс үүсэх үйл явц өвөрмөц юм. Энд цаг агаар дулаавтар, температурын эрс тэс хэлбэлзэлтэй хэт хуурай нөхцөлд хөрс үүсвэрийн үйл явц явагддаг учраас цөлөрхөг хээрийн бор, цөлийн бор саарал хөрс зонхилон тогтворжиж тус тусдаа бие даасан хөрсний бүсийг үүсгэдэг.

Уулархаг газраа хөрсний босоо бүслүүрүүд тодорхой илэрч хөрсөн бүрхэвчийн хувьд биеэ даасан өвөрмөц байдалтай боловч түүнийг хүрээлэн орших говь цөлийн хуурайшуулах нөлөө, уур амьсгал, ургамал, хөрс болон ландшафтын шинж байдалд хүчтэй туссан байдаг. Үүний улмаас уулсын хоорондох хөндий хотгорууд өндөршлөөс үл шалтгаалан ихээхэн хуурайшиж, цөлөрхөг хээрийн ландшафт зонхилон Монгол - Алтайн нурууны ар өвөр хажуугийн уулст цөлөрхөг хээрийн хөрс, ургамал зонхилон тархдаг.

Хур бороо цөөн орох бөгөөд борооны дараахи хэсэгхэн хугацаанд хөрсний амьдрал сэргэж, биологийн үйл явц дээд хэмжээнд идэвхиждэг байна. Биологийн идэвхижилийн энэ ахархан үе нь хөрс үүсвэрийн үйл явцад шийдвэрлэх нөлөө үзүүлдэг.

Тус аймгийн нутгаар тархсан гол хэв шинжийн хөрс нь цайвар хүрэн, цөлөрхөг хээрийн бор, хээржүү цөлийн цайвар бор, цөлийн гөлтгөнөт бор саарал, шалархуу хөрс, хужирлаг элсэн хөрс, аллювийн нугын хужирлаг, ил хужир зонхилно.

Энэ нутгийн хөрс, ургамлын төрх байдал гагцхүү хур борооны байдлаас шалтгаалдаг онцлогтой. Хөрс хэт халах, хөрөх, хагсарч хуурайсах, түр зуурын чийг авч норох зэрэг үзэгдэл эрин зууны турш үргэлжилсээр цөлийн хөрсний өвөрмөц шинж бүрэлдэн тогтох нөхцлийг бий болгожээ. Энэ нь хөрсний өрөмтөн хатуурч тогтсон өнгөн үе, түүний доод талд орших хуудас шиг үелсэн бүтэц зэрэг шинж тэмдгээр тод илэрнэ. Цөлийн хөрсөнд органик үлдэгдлийн эрдэсжилт хүчтэй байдаг учраас ялзмагийн хуримтлал бараг байхгүй онцлогтой.

Монгол-Алтайн уулс, Алтайн өвөр говийн хөрсөн бүрхэвчийн талаар Н.Д.Беспалов, Н.А.Ногина, Ю.Г.Евстифеев, Л.П.Рубцова, Д.Доржготов, Д.Батбаяр нарын олон эрдэмтэд судалгаа шинжилгээний ажил хийсэн байдаг. Тус аймгийн Шаргын хотгорын хөрсөн бүрхэвчийн талаар анхны нарийвчилсан судалгааг доктор /Ph.D/ О. Батхишиг (2002 он) хийсэн байна.

Тус аймгийн нутагт зонхилон тархсан хөрсний бүс, төрөл ангиллыг доорхи байдлаар тодруулав. Үүнд:

I. Уулын хөрс

Уулын хар хүрэн хөрс ховор тохиолдоно. Уулын хүрэн (121) болон уулын цайвар хүрэн нунтаг карбонатлаг хөрс (131), Хасагт хайрхан уулын урд хэсэг Хан

тайширын нурууны салбар уулсын нам газраар, Сэрх уул болон Дарвийн нурууны хойт тал, Тонхил, Төгрөг сумдын нутаг дээрх Монгол Алтайн нурууны уулс, Аж богд уулын эргэн тойрны налуу хажуу бэлээр тархана. Толгодын нунтаг карбонатлаг хүрэн, цайвар хүрэн хөрс (122), нутгийн хойт хэсгээр Баян -Уул Тайшир, Дэлгэр, Жаргалант сумдын нутаг, Хасагт хайрхан, Хантайшир, Сэрхийн нуруу налуу хажуу, толгодоор тохиолдоно. Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Тонхил сумдын нутагт үлдмэл нугын шинжтэй хүрэн хөрс (123) бага талбайд тархсан байна.

Уулын цайвар хүрэн нунтаг карбонатлаг хөрс (131) Монгол - Алтай, Говь - Алтайн нуруу, түүний салбар уулс, Дарви, Хасагт хайрхан, Хантайшир, Сэрхийн нурууны өвөр бэл, Таян, Аж богдын ар хажуу, Атас богд зэрэг уулс, Монгол элс, Хүйсийн говийн зарим хэсгээр тархжээ. Уулын хажуугийн зүг зовхис, эгц, налуугаас хамааран хөрсний тогтворжилт адилгүй, уулын хажуу эгц болох тусам элэгдэл эвдрэлийн явц хүчтэй илэрч, хөрсний үе давхаргууд нимгэрэн хоорондын ялгаа зааг нь бүдгэрч, сул сайр чулууны агуулагдах хэмжээ нэмэгдэнэ. Хөрсний гадарга дээрх сайр чулуу нь ихэнхдээ цөлийн түлэнхий бараан хардуу гандаасаар хучигдсан байна. Энэ хөрс дэх 0-20 см үеийн ялзмагийн нөөц 30-40 т/га орчим байдгаас харахад байгалийн үржил шимээр тааруухан байна.

II. Тал хөндийн хөрс

Цайвар хүрэн хөрс (133) Хүйсийн говийн баруун, зүүн, өмнөд хэсэг, Шаргын хотгорын эргэн тойрны уулсын бэлийн доод бие, Хасагт хайрхан, Хантайшир, Сэрхийн нурууны ар, өврийн доод хормой, Гуулингийн тал, Улаан шалын хоолой, Гичгэн, Дарвийн нурууны ар өвөр, бэл, Бурхан буудай уулын өвөр хэсгээр д.т.д. 1500 орчим өндөрт цайвар хүрэн хөрс зонхилон тохиолддог. Хайрга чулуун хучаастай, ургамал нөмрөг 15-25%, Ялзмагт давхарга А-17 см зузаан, цайвар хүрэн өнгөтэй, хайрга чулуурхаг хөнгөн шавранцар, шилжилтийн В давхарга 17-40 см гүнд боровтор өнгийн, карбонатын цайвар толбуудтай, ВС давхарга 40-70 см-ийн гүнд, түүнээс доош хайрга, элс шавранцар холилдсон, карбонатжсан пролювийн хурдас хөрс үүсгэгч чулуулаг болно. Энэ хөрс нь өнгөнөөсөө эхлэн давсны хүчилд буцална. Урвалын орчин шүлтлэг байна. Ялзмагийн агууламж дээд давхаргандаа 2.20 % хүрэх бөгөөд нийт давхарга чулуурхаг, давс жигд агуулсан (хуурай үлдэгдэл 0.1%) сульфат-гидрокарбонат кальцийн ион давамгайлна.

Цөлөрхөг хээрийн бор хөрс (143) Хүйс, Шаргын хонхор, Ихэс, Бигэр нуурын эргэн тойрон, Чандмань уулын ар, Сэрхийн нурууны зүүн хөндий, Улаан шалын хоолой зэрэг талархаг газраар тархсан байдаг. Мөн Монгол элсний баруун, өмнөд хэсэг, Алаг хайрханы баруун тал, Монгол-Алтай нурууны өврөөр багахан зурвас газраар цөлөрхөг хээрийн бор хөрс тархана. Ургамлын нөмрөг 10-15 %, хайрга чулуун

хучаастай, өнгөн үе нь (К) 1 см зузаан бүдэг илэрсэн, доод үе нь (Q) 2 см зузаан, цайвар-бор хөнгөн шавранцар, ялмагт давхарга (АВ) 3-16 см гүнд бүдэг илэрсэн, үе давхарын тал хувь нь чулуурхаг, 16 см-ийн гүнд карбонат хуримтлалын давхарга (Вк), 50 см-ийн гүнд хөрс үүсгэгч эх чулуулагт хүрнэ. Дээд давхаргад ялмагийн агууламж 1.51-1.70% , урвалын орчин шүлтлэг, үе давхарга нь карбонатжсан байна. Хөрсний давсжилт нь 0.11-0.15% хүрэх бөгөөд давсны найрлаганд нь сульфат-гидрокарбонат кальцийн ион зонхилно. Бага хэмжээний (0.08-0.22%), гөлтгөний давс илэрч байна.

Уулын болон толгодын цөлөрхөг хээрийн бор хөрс (141,142) Тамчийн нурууны ар, Шаргын хонхорын зүүн өмнө, Хар азаргын нурууны араар тохиолддог. Монгол - Алтай, Говь - Алтай нурууны өвөр бэлээр нарийн зурвас газраар, Хөхморьт сумын баруун хойд хэсэг Их Монгол элсэнд бага хэмжээгээр тархжээ. Гичгэний зэрэг 2000-3700 метр өргөгдсөн уул нуруудын заримд нь босоо бүслүүр бүдэг илрэх ба Цээл сумын нутаг, Алтайн нурууны хойт талын ухаа толгодоор д.т.д. 2000-2400 м үнэмлэхүй өндөрт тохиолдоно. Цөлийн бүс дэх уул нуруудын хажуу олон тооны хуурай сайр, хад чулуун хавцлаар хэрчигдэж, хөрсний гадарга нь цөлийн түлэнхий гандаас бүхий сайр чулуугаар битүү бүрхмэл байна.

Заримдаг цөлийн цайвар бор хөрс (153) Хуурай уур амьсгалын нөлөөгөөр орчин үеийн хөрс үүсэх ба өгөршлийн үйл явцын эрч хүч сул, сэвсгэр хурдас чулуулгийн дээд хэсгийн харьцангуй нимгэн үеийг хамардаг. Хөрсөн дэх ус-чийгийн нэвчилт гүн биш, ургамлын үндэсний массын ихэнхи нь хөрсний дээд давхаргуудад бөөгнөрсөн, үе давхарга нимгэнтэй байдаг онцлогтой. Ийм хөрс Төгрөг, Цээл сумын урд хэсгээр д.т.д. 1100-1200 метрийн түвшинд тархана. Шаргын хонхорын эргэн тойрон, Хөхморьт сумын баруун хойд хэсэг, Гичгэний нурууны өврөөр нарийн зурвас газраас тархсан байдаг. Ургамлын нөмрөг 5-10%, хар бараан өнгийн хайрган чулуун хучаастай, өнгөн үе болон доод үе нь тод илэрсэн үелсэн бүтэцтэй, сүвэрхэг, нягт, 4 - 20 см-ийн гүнд В давхарга, 20 - 32 см-т ВС давхарга, 32 см-ээс доош шавранцар хайргархаг пролювийн хурдас хөрс үүсгэгч чулуулаг болно. Хээржүү цөлийн цайвар бор хөрс нь цөлөрхөг хээрийн бор хөрсийг бодвол өнгөн үе болон доод үе нь тод илэрсэн, ялмагийн агууламж багатай 0.32 - 0.62% болно. Энэ хөрсний давсжилт нь доод хэсэгтээ ихсэж 0.22- 0.36% хүрч давсны найрлаганд нь сульфат - хлор, кальций зонхилно. Хөрсний дээд хэсэг нь давсжилт багатай (0.12-0.13%). Хөрсний давсжилт нь үлдмэл шинжтэй буюу гуравдагчийн улаан хурдастай холбоотой байна.

Цөлийн гөлтгөнөт бор саарал хөрс (163) Аж богдын арын хөндий, Алаг нуурын орчим, Таянгийн нурууны өмнөх хөндий, Захуй, Зармангийн говь, Эдрэнгийн нурууны ар өвөр хоолой, Ажийн тал, Шар тооройн тал зэрэг аймгийн нутаг

дэвсгэрийн төв хэсгээр ихээхэн хэмжээний талбайг эзлэн тархжээ. Шаргын нурууны эргэн тойрон ялангуяа Цагаан нуураас баруун хойш 4-5 км-т, тэгш талыг нэрлэж болно. Ургамал бүрхэвч 5 - 10 %. Энэ хөрс нь нилээд зузаавтар, нүх сүвэрхэг өнгөн болон доод үетэй. Доод үе давхаргууд нь тод улбардуу туяатай, ялзмагийн хэмжээ 12-32 см-т 0.56 % хүрнэ. Урвалын орчин шүлтлэг, бүх үе давхарга карбонатжсан. Шингээгсэн сууриудын нийлбэр 16.5- 37.0 мг-экв/100 г хөрсөнд, хөдөлгөөнт фосфор бага, харин кали нилээд их байна. Энэ хөрс нь 13 см-ийн гүнээс доош гөлтгөнжсөн, хөрс үүсгэгч чулуулагт гөлтгөний агуулга 16.3 - 14.2% хүрч байна. Хөрсний бүх үе давхарга давсжсан сульфат-кальцийн давс давамгайлна.

Уулын болон толгодын цөлийн бор саарал хөрс (161, 162) Тахийн Шар нурууны зүүн тал, Эдрэнгийн нуруу, Ээж Хайрхан уулын орчимын нам газраар болон Алтайн өвөр говийн Их шивээ улаан, Хар хайрхан, Отгон, Атас богд уул нуруудын хоорондох хоолой, хар сайрын хөндийгөөр алаг цоог тархалттай байна.

Шалархуу хөрс (182) Алтай өврийн Шаргын говь, баруун зүүн Шаргын булгууд, Наран сэвстэйн эргэн тойрны хотгордуу газраар тохиолдоно. Хөрс нь үелсэн бүтэцтэй, ялзмагийн агууламж харьцангуй өндөр 2.22-2.56 %, карбонатжсан, гөлтгөний агууламж бага, давсжилт хөрсний өнгөр хэсэгт бага гүнрүүгээ нилээд өндөр (0.46-0.65 %) сульфат карбонат давамгайлна.

Хөдөлгөөнт болон хагас бэхжсэн элс (82), (83) Нутгийн баруун хойт хэсгээр Монгол элс ихээхэн газрыг хамран тархсан байдаг. Энд хөдөлгөөнт элс, хагас бэхжсэн элс тархсан байна. Шаргын хонхор, Шалын хоолой болон Алтайн чанадах говьд алаг цоог байдлаар хагас бэхжсэн элс тархжээ.

Хужирлаг элсэн хөрс (32) Нууруудын баруун урд хэсгээр манхан элснүүд тохиолдоно. Гадарга дээр сул элстэй, бүх үе давхарга давсны хүчилд сул буцална. 0-11 см-т цайвар шаргал өнгийн нарийн ширхэгтэй сийрэг бутрамтгай элсэн хучаастай, 11-36 см-ын гүнд чийгэрхүү бор шаргал нарийн ширхэгтэй элс, давсны толбуудтай, ургамлын үндэстэй, шавранцар судлуудтай, 36 см-ээс тод шаргал нягтавтарт элсэнцэр. Хөрс нь 11 см-ээс доош бага зэрэг чийгтэй, бүх үе давхарга карбонатжсан, гөлтгөнийн агууламж дунд болон доод хэсэгт нилээд өндөр байна. Давсжилтын хэмжээ 0.81-1.73 % хүртэл, хлорт-кальцийн давс зонхилно.

Ил хужир буюу марз (32) Эргэн тойрны уулс өндөрлөг газраас туугдан ирсэн элс, шавар, хялбар уусах давс нь хотгорын төв хэсэгт хуримтлагдаж хөрс нь нилээд хэмжээгээр давсждаг байна. Нууруудын эргэн тойрон, голын захаар хужирлаг хөрс их хэмжээгээр тохиолдоно. Зарим газраар хужир нь газрын гадарга дээр нилээд зузаан өнгөр үүсгэнэ. Зулзган заг зэгстэй, элсэн дов сондуултай, гадарга дээр сул элс, хужрын өнгөртэй. Дээд хэсэг нь давсжилт ихтэй, сульфат-натрий зонхилно, зүсэлтийн

дунд хэсэгт хлор, кальцийн агууламж ихсэнэ. Шаргын Цагаан нуурын захын сэвсгэр хужир нь мөн сульфат-натрийн давсжилттай байна. Шарга сумын Олонбулаг бригад орчим Шаргын голын урд татам ил хужрын хуурай үлдэгдэл 42.74 % хүрч сульфат-натрийн давамгайлна.

Нугын мараалаг хужир (32) Ихэс нуурын зүүн-урд хэсэгт нуурын захаас 1 км-т. д.т.д. 1620 м. Тэгшивтэр жижиг дов сондуултай, хиаг зэгс шарилжтай, ургамал нөмрөг 50-60 %. Гадарга дээр хужрын өнгөртэй. Ялзмагт давхарга 0 - 8 см зузаан, хуурай боровтор хүрэн өнгийн шавранцар, самранцар бүтэцтэй, мараалаг давхарга 8 - 35 см гүнд, бараан хүрэн нягт, самранцар бүтэцтэй, хөнгөн шавранцар, 35 - 100 см-ийн гүнээс цэвдэгтэй. Ихэс нуурын ил хужир нь сульфат-магнийн давсжилттай, давс нь хөрсний дээд хэсэгт ажиглагдана. Монгол Алтайн уулс хоорондын хотгорын (Шарга, Ихэс нуурын) төв хэсгийн хөрсөнд сульфат-хлор, натрий-кальцийн давсжилт зонхилно. Содын давсжилт байхгүй. Давсжилтын найрлага нь хөрс үүсгэгч эх чулуулагтай шууд холбоотой байна. Хөрсний давсжилтанд орчин үеийн давс хуримтлагдах үйл явц нөлөөлөхөөс гадна, хөрс үүсгэгч чулуулгийн бүтэц, палеогазарзүйн нөхцөл, уур амьсгал, олон жилийн цэвдэг зэрэг нь мөн тодорхой нөлөө үзүүлж байна.

Хэт хуурай цөлийн борзон хөрс (181) Алтай өвөр говь, Бугат, Тонхил, Алтай, Цогт, Эрдэнэ сумын нутгийн урд хэсгийн хуурай сайруудын хоорондох төвгөрдүү тэгш газар болон өвс ургамалгүй жижиг толгодоор алаг цоог тархана. Жилд 40-50 мм тунадас унадаг. Зарим жилд хур тунадас орохгүй тохиолдолд гардаг. Хэт хуурай учраас хөрсний биологийн идэвхжил маш богино хугацаанд болж өнгөрдөг. Хөрс үүсэх үйл явцад дээд ургамлын оролцоо бараг байхгүй юм.

Хэт хуурай цөлийн сайрын борзон хөрс (191) Алтайн өвөр говийн урд хэсгээр (дээрх сумдын) цөлийн борзон хөрстэй газрын сайр, жалгаар тохиолдоно. Хөрс үүсгэгч эх чулуулагт пролюви, дельюви-пролювийн сайр чулуурхаг, элсэн хурдас зонхилохын зэрэгцээ эрт үеийн давсархаг хурдас ил гарч ирсэн нь цөөнгүй байдаг. Хур борооны үеэр сайрууд усаар дүүрч усны эвдлэх үйл ажиллагаа идэвхжиж, усны урсгалаар зөөгдсөн элс-сайргархаг хурдас энд тэнд тогтсон байна.

III. Чийгт гарлын хөрс

Тус аймгийн нутагт голын татмын хөрс ховор тохиолдоно. Нутгийн хойт хил дагуу урсах Завхан голын эрэг дагуухи нам газраар **Аллювийн нугын ялзмагт хөрс тархана (30)**. Аллювийн нугын ялзмагт хөрс нь чийгийн хангамжаар арай илүү шар усны үерийн нөлөөгөөр нэмэгдэл ус чийг хуримтлагддаг голын эрэг дагуухи нам газраар тогтворжсон байна. Харин Шаргын гол зэрэг жижиг улирлын чанартай урсдаг голуудын эрэг дагуу Аллювийн нугын хужирлаг хөрс тархана.

Аллювийн нугын хужирлаг хөрс Шарга болон Баян голын татмаар тархана. Ургамлын нөмрөг 80-90 %. 0-6 см зузаан, үндсээр торлогдсон ширэгт давхаргатай, 6-32 см-ийн гүнд чийгтэй зэгэл саарал, бор толбуудтай глейжсэн ялзмагт давхарга, 33-48 см-ийн гүнд нойтон, механик бүрэлдэхүүнээр жигд биш элс шавар үелсэн шилжилтийн глейт давхарга, 48 см-ээс доош усархаг хөх саарал наанги элс, 65 см-ийн гүнд хөлдүү цэвдэгт давхаргатай. Ялзмагийн агууламж өндөр 7.69 - 5.66 %, хөрсний дээд хэсэг нь карбонатгүй, давсжилт өндөр доошоо буурна. Сульфат-натрийн давсжилт зонхилно. Аллювийн нугын хөрс давсжихад цэвдэг тодорхой нөлөө үзүүлж байна.

Говь-Алтай аймгийн төв Алтай хот орчмын хөрс

Хан Тайширын нурууны баруун хойт бэлд, хойт өргөргийн $46^{\circ} 24'$, зүүн уртрагийн $96^{\circ} 15'$ -ын солбицолд д.т.д. 2167 м өндөрт орших ба байгалийн ерөнхий төлөв байдлын хувьд заримдаг цөлийн бүсэд хамаарах цөлжүү хээрийн шинжтэй. Хотгор гүдгэрийн хувьд их биш хэрчигдэлтэй дундаж өндөр уулсын хоорондох хэвгйдүү талархаг газар байрлах тул дөрөвдөгчийн делюви-пролювийн, пролювийн гаралтай хайрга, сайр чулуу бүхий элс, элсэнцэр сэвсгэр хурдас дэвсэж тогтсон байна. Эргэн тойрны уулсын үндсэн суурь чулуу нь нэн эртний амфиболит, гнейс бүхий чулуулгаас гадна гипербазит, габбройд, хүрмэн чулуу зэргээс бүтсэн байна. Эдгээр уулсын хажуу, бэлээр элливи-делювийн сайр чулуурхаг хөнгөн шавранцар хурдастай.

Энд олон жилийн цэвдэг чулуулаг тохиолдлын байдалтай тархана. Ул хөрсний улирлын хөлдөлтийн гүн элсэнцэр, шавранцар хөрстэй газар 2.7 - 2.9 м элс-хайрганцар хурдсанд 3.2 - 3.8 м хүрнэ. Хөрсний хөлдөлт дунджаар 10-р сарын 12-нд эхэлж, 4-р сарын 10-нд өнгөнөөсөө гэсэж эхэлдэг. Газар чичирхийллийн мужлалтаар Алтай хот 9 баллын бүсэд багтах ба энд 6.6 - 7.0 баллын хүчтэй газар хөдлөлтийн талбайлаг голомт үүсэж болохыг судлаачид урьдчилан тооцсон байна.

Алтай хот орчимд үржил шим багатай цайвар хүрэн нимгэн давхаргатай хөрс голлон тархах бөгөөд харин уулын бэл, хажууд хүрэн, уулын хүрэн хөрстэй болж гадарга дээрх сайр чулууны хэмжээ нэмэгдэнэ. Хот орчимын хөрс хүний нөлөөгөөр эвдэрч үгүй болох нь ердийн үзэгдэл бөгөөд ялангуяа автомашины олон салаа зам эрүүл газрын хөрс ургамлыг устгаж, сул шороон хөрс болгосон байна.

Алтай хот бусад аймгуудын төвийг бодвол хамгийн өндөр газар байрладаг учраас зундаа илүү сэрүүн, $+ 10^{\circ}\text{C}$ -ээс дээшхи температурын нийлбэр 1153°C орчим байхад бусад аймгуудын төвд энэ үзүүлэлтээс бага байна. Үүнээс үзэхэд таримал ургамлын хэвийн ургалтыг хангах дулааны нөөц Алтай хотод хангалтгүй юм. Усалгаатай нөхцөлд ердийнхөөс хавьгүй илүү дулаан шаардах учраас бэрхшээлтэй

болно. Иймд Алтай хот орчимд тариа ногоо ургуулах нөхцөл хязгаарлагдмал, зөвхөн эрт болцын сортыг сонгон тариалах эсвэл хүлэмжинд тарих нь зүйтэй. Нэг талаас дулааны хангамж хүрэлцээгүй нөгөө талаас услах нөхцөл дутагдалтайн улмаас хот орчимын тариа ногооны аж ахуйг хөгжүүлэх боломжоор ирээдүй багатай юм.

ХӨРС АШИГЛАЛТ

Говийн хөрс уур амьсгалын онцлогтой шууд холбогдон хөрс нимгэн хуурай, элсэрхэг байдгаас гадна шим тэжээл муутай юм. Мөн хөрсөн бүрхэвчид бор хөрс говийн нийт талбайн 50% -ийг эзэлдэг.

Нутгийн ихэнхи хэсэг хад чулуу ихтэй, сайр, гуу жалгаар ихээхэн хэрчигдсэнээс гадна зарим газарт энгэр хажууд нь эрэгцэг цөөнгүй тохиолддог.

Алтайн өмнөх говьд уур амьсгалын нөхцлөөс шалтгаалан хөрсөн бүрхэвч бараг тогтоогүй байна. Хотгор газраар нь шал тойрмын шавранцар гадарга зонхилно. Нутгийн урд хэсэгт Алтайн өвөр говийн хэт хуурай уур амьсгал зонхилж, хөрс нь бараг ургамлын нөмрөггүй болж, хөрсний гадаргуу гөлтгөнө ихтэй сэвсгэр бамбалзуур төрх байдлыг үүсгэжээ.

Хавар салхины хүч ширүүсэхийн хамт их хэмжээний шороон шуурга, түүрэн байн байн тохиолддог.

Газрын өнгөн хэсэг он удаан жилийн турш ус, салхины үлээгдэлд нэрвэгдэж нунтаг шороо нь нимгэрч хөрсний гадарга дээр бүрхмэл хуяг мэт сайр чулуун хучаас тогтсон. Ийм элс чулуу, сайр чулуун хучаас нутгийн ихэнхи хэсэгт нийтлэг дүр төрхийг илтгэх бөгөөд зузаан нь 1-3 см хүрч улмаар хөрсний дээд хэсгийг салхинд хийсэхээс хамгаалах үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ хөрсний тогтоцын нэг өвөрмөц хэсэг нь болж хөрсний үйл явцад багагүй нөлөө үзүүлнэ.

Салхины хүчтэй үйлдлийн нөлөөгөөр зарим газар элсний нүүлт үүсэж хөрсний гадарга дээр элсэн хучаас тогтох явдал ажиглагдаж байна.

Хүснэгт 3

**Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн тойргуудын хөрсний химийн шинж чанар
Мөнххайрханы өндөр уулсын тойргийн /X-13/ хөрсний химийн шинж чанар**

Хөрсний нэр	Үе давхаргын тэмдэглэгээ	Хөрсний орчин	Ялзмаг %	Ерөнхий азот %	Шингээгдсэн сууриуд мг-экв			Шингээгдсэн сууриудын нийлбэр мг-экв	Карбонат %	Хөдөлгөөнт фосфор мг-аар	Солилцох кали мг	Шингээх багтаамж %
					кальций	магний	натрий					
Уулын цайвар хүрэн хөрс	А	7.4	1.5	0.1	18.0	10.6	8.4	28.6		3.2	23.7	
	АВ	7.4	2.3	0.2	24.2	11.2	10.1	34.4		3.4	20.6	
	Вк	7.6			19.6	8.2		42.1	3.4	4.4	13.4	
	ВС	7.8			16.3	18.0		25.8				
	Ск	8.3			0.1				0.6			

Энэ тойрогт аймгийн баруун хилийн шугамаас дотогш Мааньтын хөтөл хүртэлх Монгол-Алтайн Сутай, Цагаан Чулуут Бүс, Алаг хайрхан, Дарвийн нуруудын орчмын уулархаг нутаг хамрагдана.

Хүснэгт 4

Хар азарга-Гичгэний нурууны өндөр уулын тойргийн /X-14/ хөрсний химийн шинж чанар

Хөрсний нэр	Үе давхаргын тэмдэглэгээ	Хөрсний орчин	Ялзмаг %	Ерөнхий азот %	Шингээгдсэн сууриуд мг-экв			Шингээгдсэн сууриудын нийлбэр мг-экв	Карбонат %	Хөдөлгөөнт фосфор мг-аар	Солилцох кали мг	Шингээх багтаамж %
					кальций	магний	натрий					
Уулын хүрэн хөрс	А	7.5	2.8	0.3	44.88	6.12	12.3	51	12.3	0.92	15.7	
	АВ	7.7			52.52	7.07		59.59		0.2		
	В	7.7			35.7	53.1		88.8				
Уулын цайвар хүрэн хөрс	А	7.9	1.3	0.01	20.2	40.8		61			1	
	Вс	8.5			69.36	24.48		93.84				
Цөлөрхөг хээрийн сулавтар хөгжилтэй уулын бор хөрс	А	7.7	1.76	0.2	19.94	36.35		56.29		1.58	14.445	
	С	8			22.44	42.8		65.24				
Ил хужир	А	8.1								0.6	26.1	
	АВ	8.4										
	В	9.49										

Их хүрэн, Хар азарга, Гичгэний нуруудын орчмын уулархаг нутаг хамрагдана.

Хяргас нуурын хотгорын тойргийн /Г-2/ хөрсний химийн шинж чанар

Хөрсний нэр	Үе давхаргын тэмдэглэгээ	Хөрсний орчин	Ялзмаг %	Ерөнхий азот %	Шингээгдсэн сууриуд мг-экв			Шингээгдсэн сууриудын нийлбэр мг-экв	Карбонат %	Хөдөлгөөнт фосфор мг-аар	Солилцох кали мг	Шингээх багтаамж %
					кальций	магний	натрий					
Дунд зэргийн зузаан хүрэн хөрс	А	7.3	1.4		15.8	5.1		20.9		1.6	19.4	
	АВ	7.5	0.6		12.1	9.6		21.7		1.2	13.1	
	Вс	8.0										
	Вк	8.1										
	Ск	7.9										
Уулын хүрэн хөрс	А	7.0	2.9	0.2	20.2	12.6		32.8	1.0	1.4	13.1	
	АВ	7.4	0.5	0.0	21.0	8.7		29.7	0.9	1.6	14.1	
	Вк	7.7							5.9			
	Ск	7.6										
Нугын карбонатлаг хүрэн хөрс	А	7.9	4.1	0.4	18.8	28.9	0.8	47.7	0.7	6.2	19.1	
	Вк	8.3	1.0	0.5	29.7	12.6	1.6	42.3	10.3	6.1	17.6	
	Вс	8.2							11.2			
	Ск	8.2							26.9	9.0	48.0	
Нугын карбонатлаг хөрс	А	7.0	1.2						1.3			
	Вк	7.8	0.8						12.3			
	Вс	7.6							2.0			
	Ск	8.0							4.0			
Аллювийн нугын карбонатлаг хөрс	А	7.0	2.0	0.2	11.0	12.4	8.1	19.7	0.2	1.2	29.8	
	АВ	6.9	1.7	0.1	9.1	8.7	0.5	17.1	1.0	1.1	16.2	
	Вк	7.0			10.1	6.2	0.4	16.3	2.5			
	Вс	7.2			9.1	8.2		17.3				
	Ск	7.5										
Аллювийн нугат намгийн карбонатлаг хөрс	А	7.1	10.8					6.2	34.0	0.8	23.7	
	В	6.8	1.1									
	Вк	7.0										
	Ск	7.0										

Хүснэгт 6

Говь-Алтайн салбар уулсын тойргийн /Г-3/ хөрсний химийн шинж чанар

Хөрсний нэр	Үе давхаргын тэмдэглэгээ	Хөрсний орчин	Ялзмаг %	Ерөнхий азот %	Шингээгдсэн сууриуд мг-экв			Шингээгдсэн сууриудын нийлбэр мг-экв	Карбонат %	Хөдөлгөөнт фосфор мг-аар	Солилцох кали мг	Шингээх багтаамж %
					кальций	магний	натрий					
Нимгэн карбонатлаг цайвар хүрэн хөрс	А	8.0	1.6	0.1	16.7	12.6		29.3	10.2	1.6	15.8	
	Вк	8.2			24.2	16.2		40.4		1.4	17.8	
	ВС				28.1	10.3		38.4				
Уулын карбонатлаг цайвар хүрэн хөрс	А	8.0	1.6	0.1	20.8	17.3		38.1				
	Вк	7.6	0.8		18.2	8.6	5.0	26.8	46.5	4.1	18.9	28.3
	Ск	8.9			23.3							
Цөлөрхөг хээрийн бор хөрс	А	7.4	1.1									
	В	7.6	0.8		17.2	8.6	5.0	25.8		0.9	11.9	
	ВС	7.9			23.3	23.1		46.5				

Хүснэгт 7

Нууруудын хөндийн тойргийн /Г-4/ хөрсний химийн шинж чанар

Хөрсний нэр	Үе давхаргын тэмдэглэгээ	Хөрсний орчин	Ялзмаг %	Ерөнхий азот %	Шингээгдсэн сууриуд мг-экв			Шингээгдсэн сууриудын нийлбэр мг-экв	Карбонат %	Хөдөлгөөнт фосфор мг-аар	Солилцох кали мг	Шингээх багтаамж %
					кальций	магний	натрий					
Нимгэн цайвар хүрэн хөрс	А	8.0	1.4	0.1	13.2	7.2	8.1	20.4		1.1	25.2	14.8
	Вк	7.9			20.4				28.5			
	ВС	7.8									16.2	
Нугын хүрэн хөрс	А	7.3	1.7	0.1	15.2	13.3	6.0	28.5		1.8	18.3	
	АВ	7.6	1.6	0.1	17.1	12.6		27.8				
	Вк	8.0										
	ВС	8.0										
Цөлөрхөг хээрийн бор хөрс	Ск	8.3										
	А	8.3	0.9	0.1	18.3			29.1				
	Вк	8.4			12.2	5.5		24.0				
	ВС	8.2	0.2		13.6		7.6		4.4		14.1	
	Ск	8.1			22.2	2.0		15.7				

Хүснэгт 8

Их, Бага уулын тойргийн /Г-5/ хөрсний химийн шинж чанар

Хөрсний нэр	Үе давхаргын тэмдэглэгээ	Хөрсний орчин	Ялзмаг %	Ерөнхий азот %	Шингээгдсэн сууриуд мг-экв			Шингээгдсэн сууриудын нийлбэр мг-экв	Карбонат %	Хөдөлгөөнт фосфор мг-аар	Солилцох кали мг	Шингээх багтаамж %
					кальций	магний	натрий					
Нимгэн мараалаг цайвар хүрэн хөрс	A	7.9	1.1	0.1	26.7		9.7	32.9		6.9	28.3	
	AB	7.7			26.7	9.1		35.8		7.7		
	B	7.5							9.8			
	BC	8.2							7.9			
Цөлөрхөг хээрийн мараалаг бор хөрс	A	7.9	0.9	0.1	24.6	11.0	13.6	44.8		3.1	34.5	
	B	8.0			27.7		13.0	42.0		4.2	28.9	6.5
	Bк	8.1						35.6	3.4			
Аллювийн нугын хөрс	A	7.4	0.8	0.2	16.3	4.0		20.3				
	AB	7.8	1.3	0.1	16.1	6.0		22.1				

Хүснэгт 9

Баруунхуурайн хотгорын тойргийн /Г-7/ хөрсний химийн шинж чанар

Хөрсний нэр	Үе давхаргын тэмдэглэгээ	Хөрсний орчин	Ялзмаг %	Ерөнхий азот %	Шингээгдсэн сууриуд мг-экв			Шингээгдсэн сууриудын нийлбэр мг-экв	Карбонат %	Хөдөлгөөнт фосфор мг-аар	Солилцох кали мг	Шингээх багтаамж %
					кальций	магний	натрий					
Нимгэн цайвар хүрэн хөрс	A	8.0	1.2	0.1	20.3	5.7		25.6	2.3		10.3	
	AB	8.2	0.7	0.0	19.2	4.8		24.0	1.9	1.2	11.0	
	B	7.4	0.3	0.1	15.6	5.0		20.6	0.9	1.0	11.0	
	Bк	8.2	0.9	0.1	23.9	18.9		37.8	5.4	1.4	11.0	
	BC	8.0			20.3	15.3		56.1	2.0	3.6	10.0	
	C	7.3	0.3		13.8	9.8		23.6	0.7	1.1		
Хээржүү цөлийн цайвар бор хөрс	A	7.8	0.4	0.0	31.4	9.2		40.6	3.0	1.8	18.4	
	AB	7.4	0.4	0.1	28.4	8.5		36.9	2.1	1.1	16.0	
	Bк	8.1	0.7	0.1	23.7	6.2		29.8	1.2	1.6	6.6	
	BC	8.4			22.4	12.3		34.7	2.5	2.8	2.0	
	Cк	8.3			12.4	11.1		23.4	1.7	1.2	5.0	

Алтайн өвөр говийн тойргийн /Г-8/ хөрсний химийн шинж чанар

Хөрсний нэр	Үе давхаргын тэмдэглэгээ	Хөрсний орчин	Ялзмаг %	Ерөнхий азот %	Шингээгдсэн сууриуд мг-экв			Шингээгдсэн сууриудын нийлбэр мг-экв	Карбонат %	Хөдөлгөөнт фосфор мг-аар	Солилцох кали мг	Шингээх багтаамж %
					кальций	магний	натрий					
Уулын хүрэн хөрс	А	7.6	2	0.2	23.23	44.44	35.7	67.67	61.2	1.16	19.04	25.5
	АВ	7.5	1.8	0.1	26.26	14.14		40.4		0.76	10.3	
	Всн	7.3										
Цөлөрхөг хээрийн карбонатлаг бор хөрс	А	7.8	1.9	0.16	44.9	31.3	10.8	76.2	42.1	6.4	64.4	31.3
	Вк	7.6							44	5.3		
	С	7.6							0.2			
Хээржүү цөлийн цайвар бор хөрс	А	7.1	0.9	0.01	25.9	9.6	10.6	21.1	36.5	7.5	19	19.2
	В	7.4				11.5	8.6		16.2	6.1		
	С	7.4							27.8			
Хээржүү цөлийн карбонатлаг цайвар бор хөрс	А	7.4	1.7	0.1	18.6	23	1.6	28.4	32.6	4.9	49.9	23
Цөлөрхөг хээрийн уулын бор хөрс	А	7.5	0.7	0.01	23.7	16.6	6.8	39.9	23.4	3.8	15.8	
	В	7.9								1.3		
Цөлөрхөг хээрийн нугат бор хөрс	А	7.6	1.55	0.1	19.9	15.75	20.3	35.6	37.05	2.9	8.25	21
	АВ	7.95	0.8	0.008	23.9	11.5	4.4	35.4	14.7	0.9	9.65	12.1
	Всн	8.15					4.1					
	Ск	7.6										
Цөлийн бор саарал хөрс	А	8.2	0.2	0.02	15.2	7.7	7.7	22.9	1.8	2.9	15.4	18.2
	АВ	8.4	0.4	0.02	9.7	11.2	9.6	20.9	5.5	3.8	5.2	56.6
	Всн	7.5					1.1			1.1		
	С	8.4									19.8	
Шалын хөрс	А	8	0.9	0.01	45	9.8		54.8	7.3		15.3	
Нугын хужирлаг хөрс	А	7.4	1.1	0.1	33.6	24	9.6	57.6		2.6	17.3	16.3
	Всн	7.6					10.6					
	ВС	7.8										
Нугын хужир	А	7.7	0.5	0.002	7.5	19.3	17.1	26.8	1.6	0.5	25.2	17.4
	Всн	7.5						26.8	1.3			
	С	8.7										

1.2.4 Ургамал газарзүйн мужлал

Говь-Алтай аймгийн нутаг нь физик газарзүйн өвөрмөц тогтоцтой. Тус аймгийн нутаг дэвсгэрийг ургамал газарзүйн мужлалаар Ёвро Азийн хээрийн муж, Азийн цөлийн муж гэсэн 2 мужид хувааж мужуудаа дараахи тойрогт хуваажээ.

1. Ёвро Азийн хээрийн муж
 1. Монгол- Алтайн уулын хээрийн тойрог
 2. Их нууруудын хотгорын тойрог
 3. Олон нуурын хөндийн тойрог
 4. Говь-Алтайн нурууны цөлөрхөг хээрийн тойрог
2. Азийн цөлийн муж
 1. Зүүн гарын цөлийн тойрог
 2. Алтайн өвөр говийн цөлийн тойрог.

1.2.5 Ургамалшиллын бүс бүслүүр

Тус аймгийн нутаг дэвсгэрийн ургамалшил нь дараах 4 бүс бүслүүрт хамрагдана.

1. Өндөр уулын
2. Уулын ойт хээрийн
3. Цөлөрхөг хээрийн
4. Цөлийн гэж ангилна.

Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэр нь ерөнхийдөө хур тунадас, чийг багатай тул тачир сийрэг ургамалтай.

Жилийн ихэнх хугацаа нь байнга хүйтэн сэрүүн, дулааны нийлбэр дутмаг, ургамал ургах хугацаа богино, хүйтэн салхитай зэрэг нь ургамлын өсөлт хөгжилтөд таагүй нөлөө үзүүлдэг.

⊕ Өндөр уулын бүслүүрийн доод захаар хавтгайвтар оройтой намагжсан хажуу багавтар хөндий тохиолддог. Энэ бэлчээрийг зусланд ашиглахад тохиромжтой. Сэрүүвтэр ялаа, шумуул зэрэг шимэгчид багатай нь мал сүрэг идээшлэн өвөл, хавар алдсан тарга хүчээ сэргээх боломжтой болдог.

Тагийн бүслүүрт элдэв зүйлийн бушилз, өлөнгүүд, Алтайн биелэг, тагна сорвой, ботууль зэрэг бушилз-өлөн-үетэн зонхилсон байдаг.

Хуурайшилтын давамгайлах нөлөөгөөр хээрийн бүсийн болон цөлийн зарим ургамлууд тагийн бүсэд нэвтэрч өндөр уулын хуурай хээр, өндөр уулын цөлөрхөг хээрийн өвөрмөц бэлчээрийг үүсгэдэг.

Монгол-Алтай нурууны төгсгөл болох Жавхлант, Хархайрханы нурууны ар хажуу, хяр зоогоор өндөр уулын бушилзат тагийн нуга бага биш талбайг эзлэн ургасан байдаг.

Түүнээс арай намсаж Говь-Алтай нурууны эхлэл Борхайрхан, Цагаанбугат, Самдандамба, Намын нурууны уулсаар жижиг дэгнүүлт үетэн, бушилз, ботууль, агь хялгана, ерхөг зонхилон ургадаг.

⊕ Алтай нурууны захын зарим уулсаар уулсын ойт хээрийн бүслүүрт багавтар талбайг эзэлсэн ой тохиолддог. Энэ нь зөвхөн шинэсэн ой бөгөөд нилээд сийрэг юм.

Бурханбуудай, Харазаргын нурууг дамжин эдгээрийн ар, өвөрийн уулын хээрийн бүслүүрт ботууль, монгол өвс, хялгана, ерхөг, агь холилдон ургадаг. Дарви, Хасагтхайрхан, Хантайшир, Сэрх нуруудын эргэн тойрны хуурай уур амьсгалын нөлөөгөөр уулын ойт хээрийн бүслүүрт говь цөлийн ургамлууд түрж ирсэн байдаг.

Монгол-Алтай өмнөд хэсэг Алаг нуурын хоолой жинхэнэ хээрийн төрхтэй юм.

⊕ Цөлөрхөг хээр буюу заримдаг цөлийн ихэнхийг нууруудын хөндий, тэгш өндөрлөг ухаа толгод бүхий цайдам хөндий эзэлдэг. Энэ бүсэд жилд дунджаар 100-125 мм тунадас унадаг. Ургамал ургах тогтвортой дулаан (+5-С-ээс дээш) үе нь 170-190 хоног үргэлжлэх боловч ургалтын хугацаанд байнгын гандуу байдаг. Энэ бүсэд байнга тохиолдох шороон шуурга, хүчтэй салхи ургамлын амьдралд таагүй нөлөө үзүүлдэг. Шаргын нуурын хонхор нь энэ бүсэд хамрагддаг бөгөөд цөлжилтөнд нилээд өртжээ. Тэнд дан баглуурт, эсвэл хялгана-баглуурт, өдлөг хялгана-таанат цөлийн хэвшил багахан хэмжээний талбайг эзэлдэг. Харин цөлөрхөг хээр нь, Шаргын хонхроос баруун тийшлэх тутамд (уулын ургамлын эзлэх хувь нэмэгдэх хэдий ч) ерөнхий төрхөө алдалгүй уулс хоорондын хөндийд шургадаг.

Нутгийн хойд хэсгээр байрлах Монгол элсэнд цульхир, элсний шарилж, сул, сөөгөн шимэрс төрөл бүрийн харгана ургадаг.

Цөлөрхөг хээрийн үндсэн хэлбэр нь хуурайсаг сөөгөнцрүүд оролцсон дэгнүүлт, жижиг үетэн зонхилон ургадаг онцлогтой.

Энэ бүсийн уулс хоорондын өргөн хөндий толгод түүний бэл ухаа гүвээг дамжин өдлөг хялгана, говийн хялгана, сайрын хялгана (монгол өвс) үлэмжхэн талбайг эзлэн ургадаг.

⊕ Тус аймгийн нутаг Алтайн өвөр говь цөлийн үндсэн төрхийг илэрхийлдэг. Цөлийн бүсэд жилдээ 40-80 мм хүрэхгүй тунадас унадаг бөгөөд зарим үед хур тунадас орохгүй хэдэн жил өнжих ч бий. Жилд 37 мм тунадас унахад хангалттай чийг болдог. Ус чийг хомс, хуурай, салхи шуургатай нь өвс ургамлын ургалтанд муугаар нөлөөлж иржээ. Тэндхийн ургамал үлэмж сийрэг төдийгүй тачир, намхан ургадаг. Алтайн өвөр говьд хойноос урагшлах чиглэлд хээржүү цөл, жинхэнэ цөл, хэт хуурай цөл гэсэн цөлийн гурван дэд бүс тод илэрдэг.

Алтайн өвөр говьд ихэвчлэн чулуут цөл тохиолддог. Тэнд заримдаг сөөг, сөөгөнцөр, бударганууд ихэвчлэн ургадаг. Зүүн гарын цөлийн зонхилогч үндсэн

ургамал нь ихэнхдээ 1.5-2 м-ээс үл хэтрэх өндөртэй. Зайсан заг бөгөөд Пржевальскийн зээргэнэ, монгол зорлог, шар мод (нохой шээрэн) улаан бударгана, төлөгч дүү боролзой, өргөст ортууз зэрэг сөөг сөөгөнцөр ургамлууд юм.

Толгодын энгэр бэл болон түр зуурын ус урсах сайраар битүү хэрчигдсэн өндөрлөг газар тэдгээрийн хоорондох багавтархан хөндийгөөр сөөгт цөл үргэлжилдэг. Сөөгт цөлд заг тааралдахгүй боловч бусад ургамлын үндсэн бүрэлдэхүүн онц өөрчлөгдөхгүй. Хотир (нохой шээрэн) улаан бударгана, Коржинский (цагаан) харгана, Пржевальскийн зээргэнэ байнга тохиолддог. Хотос хотгорт боролзой, тэсэг, лавай хургалж, бударгана холилдон ургасан байдаг. Их бага зарман, хатан суудал, талын мэлтсийн молцог болон довцог элсэнд заг сухай, хармаг ургадаг.

Эдгээр нь үндсээрээ элсийг барьж 1-2 м өндөр довцог үүсгэж, элсийг нүүхээс хамгаалдаг онцлог ургамлууд юм.

Алтайн чанад дахь цөлийн бүсэд Шар хулстай, Мянган тоорой, Нарийн тоорой, Захуй-зармагийн баянбүрдүүд, Хавтгай, Мазаалай, Хулангийн шанд, Гүн тамга, Талын мэлтэс, баруун зүүн шаргын булаг зэрэг шанд булгууд байдаг.

Эдгээрийн ихэнх нь ГИДЦ газрын “А.Б” хэсэгт орших бөгөөд өдгөө дэлхийд ховордсон хавтгай, тахь, мазаалай зэрэг амьтдын ундаалж, идээшлэх, үржих төлжих, орогнож байрлах үндсэн бэлчээр нутаг, экосистемийн хувьд чухал ач холбогдол бүхий түшиц газар болно. Азийн унаган ургамал болох хармагт, зээргэнэт, хотирт, таарт цөлүүд ихээхэн хэмжээний талбайг эзлэн тархдаг.

Тэнд ургамлын зүйлийн бүрэлдэхүүн нэн ядуу байдаг. Баян бүрдүүдийн ургамалжилд Муркрофтын жигд, олон цэцэгт сухай, Сибирийн болон Роборосвскийн хармаг, элдэв навчит тоорой, хонхот харгана, зүүн гарын буураа, модлог сөөгөн бүхий саванны гаралтай үлдвэр нэн ховордсон ургамлаас бүрдсэн байдаг. Эдгээр үлдвэрийн дотор түүхэн хөгжлийн хувьд доройтон үрээр үржих чадваргүй болж мөхөж устахын ирмэгт тулсан нилээд ургамал тохиолддогийг тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна.

1.2.6 Ан амьтан

Говь Алтай аймаг нь байгалийн төрөл бүрийн бүс бүслүүрт хамрагдах өргөн уудам нутагтай. Тэнд өндөр уул хад асга, ой, хээр тал, говь цөл, нуур ус, зэгс, шугуй, элсний орчны амьтад хөршлөн амьдардаг.

Тус аймагт нийт 5 ангийн 335 зүйл буюу манай орны сээр нуруутан амьдын зүйлийн бүрэлдэхүүний 51.4 хувь нь оршин амьдардагийн зэрэгцээ нэн эртний ховор болон говь цөлийн унаган төрөл зүйлийн амьтад цөөнгүй бий.

Тус аймгийн төв хэсгийн уулархаг нутгаар хярс, үнэг, бор туулай зэргээс гадна тарвага, цайвар үлий, алаг даага, зурам болон бусад олон зүйлийн мэргэчид өргөн тархжээ. Алтайн ар говийн цөлөрхөг нутгаар шилүүс, мануул мий эрээн өмхий хүрэн, үен, дэлдэн зараа, үхэр огодой, уссаг багваахай, шар чичүүл, орог зусаг, бозлог зурам, боролзон туулай, хөх шишүүхэй, жирх, солонго, хадны барагчин, цагаан үен зэрэг амьтад өргөн тархсны зэрэгцээ байгалийн аясаар ховордож буй тавируу атигдаахай ч байдаг. Алтайн өвөр говьд 7 баг, 16 овгийн 64 зүйл дэлэнтэн амьтан тэмдэглэгдсэн нь манай орны дэлэнтний зүйлийн бүрэлдэхүүний 46 % болж байна. Үүнээс далавчтан 7, туулайтан 3, мэрэгчтэн 33, махчтан 16, туурайтан 6 зүйл тархсан байна.

Алтайн өвөр говь нь монголд төдийгүй дэлхий дахинаа ховордсон амьтдын унаган нутаг юм. Тэнд төв болон дундад азийн говь, цөлийн амьтад, ховордсон юмуу зөвхөн энэ бүс нутагт тархсан 20 гаруй зүйл амьтад байдгаас гозоорой зурам, сухайн чичүүл, элсний тажигдаахай, өөхлөг тажигдаахай, шарнад цөөвөр, мазаалай баавгай цоохор ирвэс, цоохондой мий, хулан адуу, тахь адуу, хар сүүлт, янгир ямаа, аргаль хонь, шилүүс мий, мануул мий, түвд үнэг, тавруу атигдаахайг нэрлэж болох юм. Алтайн өвөр говь нь дэлэнтний асар их үнэ цэнэтэй генофондыг хадгалан үлдсэн дэлхийн цөөн тооны газарт тооцогддог.

Эдгээр амьтадын ихэнхийг агнахыг хуулиар хориглосны зэрэгцээ үндсэн тархац нутгийг тусгай хамгаалалтанд авч, булаг шанд бут сөөг, зэгс хулс, заг, сухайн ширэнгийг хамгаалах, нөхөн сэргээх зэргээр байршлыг тогтворжуулах нөхөн үржих нөхцлийг бүрлүүлж удмын санг хамгаалж байна. Тахь, хавтгай, монгол бөхөн зэрэг нэн ховор амьтад олон улсын улаан номонд оржээ.

Монголын Улсын улаан номонд цөөвөр чоно, цоохондой мий, цоохор ирвэс, эрээн хүрэн, мазаалай баавгай, тахь адуу, монгол хулан, зэгсний гахай, хавтгай тэмээ, монгол бөхөн, хар сүүлт зээр, Алтай аргаль хонь, янгир ямаа, гоозоорой зурам, Таван хуруут атигдаахай, элсний атигдаахай, өөхлөг атигдаахай, соотон, алаг даага, сухай чичүүл зэрэг амьтад орсон байна.

Тус аймгийн нутагт саарал чоно жигд тархсан бөгөөд сүүлийн жилүүдэд тоо нь олширч, туруутан амьтдын хэвийн өсөлтөнд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ ирвэсний тэжээлийн гол өрсөлдөгч болж байна.

Тус аймгийн нутаг дэвсгэрт нийт 18 баг, 45 овгийн 252 зүйл шувуу бүртгэгдсэний дотор зүйлийн тоогоор бор шувууны багийнхан тэргүүлдэг. Мөн шонхор хэлбэртний баг, шар шувуу, тахиа хэлбэртний баг, хөгчүү хэлбэртэн, өдөр ба шөнийн махчин хэрээний овгийн жигүүртэн тархсан байдаг. Өндөр уулс, хадан халилаар олон зүйлийн махчин шувууд амьдардагаас цармын бүргэд, дэлт бүргэд,

бахим бүргэд, сохор элээ, тас, ёл, идлэг шонхор, морин харцгай, шилийн сар, начин шонхор зэргийг нэрлэж болох юм.

Тус аймгийн Ногоон нуур Сангийн далай, Эрээн нуурууд, Завхан голын сав, ус чийг намгархаг нутаг нь Энэтхэг, Хятадын хойг, Зүүн өмнөд Азийн дулаан бүсээс нүүдлэн ирж зусдаг 62 зүйл, дамжин өнгөрдөг 26 зүйл шувуудын нүүдлийн зам, өсөж үржих үндсэн түшиц газар нь болдог.

Эдгээрээс Алтайн өвөр говийн нуур цөөрөм, гол усанд галуу хэлбэртэн 6 зүйл, тогоруу хэлбэртэн 4 зүйл болон шунгууртан, орвилог, хөгчүү хэлбэртний баг болон бусад бүлгийн шувууд зусч үрждэг.

Тус аймгийн нутагт ус намгийн амьдралтай галууны багийн 28 зүйл шувуу байдаг. Үүний ихэнх нь спорт, агнуур зүйн өндөр ач холбогдолтой юм.

Монгол улсын улаан номонд бүртгэгдсэн ёл, тас, гангар хун, алтайн хойлог, жороо тоодог, реликт цахлай өгөөдэй шулганаа, хулан жороо зэрэг ховор, нэн ховор шувууд тус аймгийн нутагт тархсан байдаг.

Монгол - Алтайн нурууны өмнөд, зүүн салбар уулсын хөндийг даган Төв Азийн говь цөлийн гаралтай төмөр гүрвэл, цоохор хонин гүрвэл, замба гүрвэл, монгол гүрвэл, могой гүрвэл, бамбай хоншоорт могой, рашааны могой зэрэг зүйлүүд төрөл бүрийн биотопт оршин амьдрах түгээмэл тархалттай, тоо толгойн өндөр нягтшил бүхий мөлхөгчид юм.

Алтайн өвөр говь нь мөлхөгчидийн зүйлийн бүрэлдэхүүнээр хамгийн баялаг нутаг юм. Энд 6 овгийн 16 зүйл буюу манай орны мөлхөгчидийн зүйлийн бүрэлдэхүүний 76.1 хувь нь тэмдэглэгджээ.

Алтайн өвөр говьд нүцгэн хуруут гүрвэл, нохойн гүрвэл, говийн гүрвэл, загалт гүрвэл, монгол гүрвэл зэрэг жинхэнэ Төв азийн цөлийн гаралтай амьтад оршин амьдардаг нь түүний нэгэн онцлог юм.

Харин цоохор хонин гүрвэл, төмөр гүрвэл, замба гүрвэл, могой гүрвэл рашааны могой, бамбай хоншоорт могой зэрэг нь зүүн гарын говьд нэгэн адил тархсан байдаг. Говийн нүцгэн хуруут гүрвэл, тойрмын хонин гүрвэл, толбот гүрвэл, тэмээ сүүл могой, нарийн могой зэрэг зүйлүүд Монгол улсын Улаан номонд орсон ховор амьтад юм.

Алтайн өвөр говийн тэмээн сүүл могой нь зэрлэг амьтан ургамлын зүйлийг Олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн 2 дугаар хавсралтанд орсон байдаг.

Алтайн өвөр говийн тойргийн нутагт багтах Захуй-Зармангийн баян бүрд, Хутаг нуур орчмын газруудаар монгол бах оршино.

Зүүн гарын говийн зарим баян бүрдээр явцуу тархалттай нэгэн зүйлийн хоёр нутагтан ногоон бах байдаг. Ногоон бах нь полипloid хромсом бүхий ховор амьтан учир Монгол улсын Улаан номонд оржээ.

Тус аймгийн нутаг дэвсгэрт томоохон гол мөрний сүлжээгүй, нуурууд нь ихэнхдээ шорвог устай тул эндемик маягийн цөөн зүйлийн загас амьдардаг.

Сангийн далай, Эрээн нуур болон Завхан голд Алтайн шар загас, нохой загас, монгол хадран тархжээ.

1.2.7 Ус зүй

Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэр ус зүйн сүлжээний хувьд Төв Азийн гадагш урсацгүй ай савд багтдаг. Гадаргын усны хуваарилалтаар Монгол-Алтайн ар болон өвөр хажуугийн мужид хамрагдана.

Тус аймаг гадаргын усны сүлжээний нягтрал бага, жигд бус тархсан цэнгэг усны нөөцөөр харьцангуй хязгаарлагдмал уур амьсгалын нэн эмзэг өргөмтгий бүс нутаг юм.

Аймгийн усны нөөцийг гол горхи, нуур цөөрөм, мөнх цас, газрын доорхи ус, хиймэл нуур гэж ангилж болох юм. Эдгээрээс газрын гүний усны нөөц нилээд элбэгтэйд тооцогддог.

Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэрийн баруун зүүн сугаас эх авсан Завхан гол нийт 808 км урт бөгөөд ус цуглуулах талбай нь 71210 ам км² юм. Тус аймгийн хойд хэсэг Дэлгэр, Тайшир, Жаргалан сумдын нутгаар 300 гаруй км урт замыг туулан урсаж Айраг нуурт цутгадаг. Завхан гол эхэндээ уулархаг, дунд хэсэгтээ говийн уулс толгодоор, адагтаа уулын хормойн элсэн манхнаар урсдаг.

Шургийн голтой нийлэх бэлчирийн эхэнд ихээхэн салаалж Ажиг, Эрээн нуурын орчимд үлэмжхэн газрыг намагжуулдаг нь түүний урсацыг зохицуулахад голлох үүрэг гүйцэтгэдэг. Завхан голын усны эрдэсжилт 150 мг/л, хатуулаг нь 1.60 мг экв/л, найрлагын хувьд гидрокарбонатын ангиллын кальцын бүлэгт хамаарагдах устай гол юм.

Завхан голын ус нь эрдэсжилт бага боловч элсэн хурдас дундуур урсдагаас хатуу урсац, булингар харьцангуй ихтэй.

Сутай, Хасагт хайрхан, Бурхан буудай, Алаг хайрхан, Гичгэний нуруунаас эх авсан Зүйл, Гурван шар, Уст чацран, Сагсай, Төгрөг, Шарга, Биж, Мянган, Ботгон зэрэг голууд Тонхил, Шарга, Халиун, Цогт, Бугат, Бигэр, Чандмань сумдын нутагт байдаг.

Эдгээр гол нь гүний болон цас мөсний усаар тэжээгддэг бөгөөд уулс хоорондох уудам цайдам, говиудын хотгор хонхор болон нууруудад ил хийгээд гүний урсацаар цутгадаг, орон нутгийн чанартай жижгэвтэр голууд юм.

Үүнээс гадна хур тунадас элбэгтэй жил түр зуурын урсгалтай сайр садарга олонтой. Эдгээр сайр садарга нь говийн хотгоруудыг хүрээлэн тогтсон уул нуруудын бэл хормойг даган хэдэн арван бээр үргэлжилдэг ба газар доорхи усны тэжээлийн муж болно.

Монгол улсын хэмжээний бүх нууруудын 1.6 хувь, тэдгээрийн нийт талбайн 0,8 хувьтай тэнцэх 49 нуур тус аймгийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн. Нууруудын нийт талбай 130,8 км².

Завхан голын их тохойд 1451 метр өндөрт элсэнд хаагдаж тогтсон үзэсгэлэнт Эрээн нуур, Сутай хайрханаас эх аван урсдаг Зүйлийн голын адагт 2085 метрийн өндөрт орших Ногоон нуур зэрэг цэнгэг устай нуурууд бий. Гэвч ихэнх нь эрдэст, шорвог нуурууд юм.

Алтайн уулсын голууд нь горимын хувьд хавар, зуны шар усаар үерлэдэг голуудад багтдаг бөгөөд голуудын тэжээлийн 60 %-ийг өндөр уулсын мөнх цасны ус эзэлдэг байна.

Тус аймгийн гадаргын усны нөөцийг 0,058 шоо км³ хэмээн тогтоосон бөгөөд үүний 0,01 км³-ыг ашиглах боломжтой гэж үздэг.

Монгол улсын нутаг дэвсгэрийн гуравны хоёр хувьд газрын доорхи ус тархсан бөгөөд бүх хот аймгийн болон, ихэнх сумын төв, бэлчээрийн нилээд хэсэг нь газрын доорхи усаар хангагддаг.

Газрын харилцааг зохицуулах, газрыг үнэлэх, гүний усны төлбөр тогтооход ашиглах зорилгоор газар доорхи усны нөөц баялгийн зургийг 1:1000000-ын масштабтай үйлдсэн байна.

Төвлөрсөн хот суурин, нөөц бүхий уул уурхайн үйлдвэрүүд, зарим сумдын төвийн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох эрэл хайгуул явуулснаар улсын хэмжээгээр газар доорхи усны томоохон 130 орд илрүүлэн нөөцийг тогтоожээ. Дээрх ордуудаас улс ардын аж ахуйд ашиглагдаж буй 115 ордын байршлын координатыг тогтоосны дотор, тус аймгийн нутагт орших Харзат, Баянтоорой, Цээлийн ордууд хамрагдсан байна.

Хүснэгт 11

**Говь-Алтай аймгийн нутагт илрүүлж судалсан
газрын доорхи усны ордууд**

№	Ордуудын нэр	Усны нөөцийн зэрэглэл	Усны эрдэжилт	Ордын байршлын координат					
				46	19	0	96	20	0
1	Харзат	В-846	0,5 mg-их	46	19	0	96	20	0
2	Баянтоорой	В+С-32869	-	44	53	0	96	46	30
3	Цээл	С-40	07	45	20	0	95	30	0

Говь-Алтай аймгийн газрын доорхи ул хөрсний ус 0,10 шоо км³ үүнээс 0,03 шоо км-ыг нь ашиглах боломжтой гэж үздэг. Эдгээрээс Баянтооройн орд нь нөөц нөхөгдөн сэргээгдэх чадвар нь бусдаас давуу юм.

1.2.8 Инженер геологийн нөхцөл

Хот байгуулалт, нутагшилтын таатай нөхцлийг бүрдүүлэх тулгуур хүчин зүйл нь тухайн хот, төв суурингийн газар байрлаж буй талбай, түүний хэмжээ хязгаар, онцлог дүр төрхөөс ихээхэн шалтгаалдаг.

Хот байгуулалтын явцад сөрөг нөлөө үзүүлэх байгалийн болон төлөвлөлтийн хүчин зүйлүүд нь төв суурин байрлаж буй талбайн хэмжээнд шууд нөлөөлж, үлэмжхэн хязгаарладаг байна. Энэ хүчин зүйл нь байгалийн /гадаргын эгц налуу, олон жилийн цэвдэг, чулуулаг болон ул хөрсний бусад төрөл байдал, ул хөрсний ус, намаг, элсний нүүлт, үерт автагдах байдал гэх мэт/ болон төлөвлөлтийн /хамгаалагдсан нутаг дэвсгэр, цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугам, авто болон төмөр зам, тариалан, хадлан, жимс жимсгэний талбай гэх мэт/ гэсэн хэлбэрээр илрэн гардаг. Энэ утгаараа хот, төв суурин оршиж байгаа газар нь аль болохоор цаашид хөгжих нөөц талбайтай байхын хирээр тааламжтай нөхцлийг бүрдүүлэх болно.

Тус аймгийн хувьд энэ хүчин зүйлийн нөлөө нийт хот, төв суурингуудад төдийлэн их илрээгүй бөгөөд зарим хүчин зүйлийг тодруулан үзүүлэв.

Хот, төв суурингийн талбайн хэмжээнээс хамаарч тухайн сууринд оршин суух хүн амын боломжит багтаамжийг тооцож төлөвлөдөг бөгөөд багтаамжийн энэ үзүүлэлт байгалийн даацаас хэтэрсэн тохиолдолд хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлээд зогсохгүй, хот төв суурингийн цаашдын хөгжилд таагүй орчныг бүрдүүлэх үндсэн нөхцөл болдог байна.

Хот, төв суурин газрын төлөвлөлт болон зам талбай, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламж барьж байгуулахад газрын гадаргын эгц налуу чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд байгалийн энэ хүчин зүйлийг эгц налууугийн хувиар үнэлдэг бөгөөд гадаргын эгц налуу нь 0.05-8.0 хувь хүртэл тохиромжтой, 8.0-20.0 хувьд хязгаарлагдмал тохиромжтой, 0.05 хувиас бага, 20.0 хувиас дээш нөхцөлд тохиромжгүй гэж үздэг. Гадаргын эгц налуу ихсэх тутам барилга байгууламж, зам талбай, инженерийн шугам сүлжээг барьж байгуулахад газар шорооны ажлын өртөг эрс өсөхийн зэрэгцээ хот, төв суурин газрын цаашдын хөгжилд зохих нөлөө үзүүлдэг.

Эрдэнэ сумын төв энэ үзүүлэлтээр хязгаарлагдмал тохиромжтой нөхцөлд, бусад хот, суурин газрууд нь тохиромжтой нөхцөлд оршиж байна.

МУ-ын нутагшилтын ерөнхий схемд үнэлснээр Говь-Алтай аймгийн нийт нутаг дэвсгэр нь гадаргын эгц налууугийн үнэлгээгээр 9.0 хувь буюу 12.6 мян.м² нутаг

тохиромжгүй нөхцлөөр үнэлэгдсэн нь бусад аймгуудтай харьцуулахад дунджаас доогуур үзүүлэлт юм.

Улирлын хөлдөлт гэсэлтээс хамаарч ул хөрсний овойлт, суулт, хөөлт зэрэг төрөл байдаг. Манай орны хувьд элбэг тохиолддог бөгөөд хөөлттэй хөрс, Алтай хот, Бугат, Дарви, Хөхморьт, Эрдэнэ зэрэг сум суурин газруудад тохиолдож байв.

Газар чичирхийллийн хувьд нутагшилт, хот байгуулалтын шаардлагаар хот, төв суурин газрыг барьж байгуулах, төлөвлөлт хийхэд 6 болон түүнээс доош балл /Рихтерийн шаталбараар/-д тохиромжтой, 7-8 баллд хязгаарлагдмал тохиромжтой, 9 болон түүнээс дээш баллтай нөхцөлд тохиромж муутай гэж үздэг.

Тус аймгийн сумын төвүүдийг хот байгуулалтын үнэлгээгээр авч үзвэл Дэлгэр, Тайшир, Хөхморьт, Цээл, Шарга, Цахиурт зэрэг сум суурин газар 7-8 баллын бүсэд, Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарви, Жаргалан, Тонхил, Төгрөг, Халиун, Цогт, Чандмань, Эрдэнэ, Зээгт зэрэг сум суурин 8-9, Алтай хот 9 баллын бүсэд хамрагдаж байна. Эндээс харахад аймгийн нийт нутаг дэвсгэр ерөнхийдөө нэлээд өндөр баллын /7-10 балл/ бүсэд орших тул энэ хүчин зүйлээс шалтгаалан барилга байгууламж, шугам сүлжээний төсөвт өртөгт сөрөг нөлөө үзүүлж иржээ.

Уулархаг газар орон, нуур цөөрмийн эрэг хөндий, намссан хотгор, намгархаг газруудад ихэвчлэн хөрсний ус зохих нөлөөллийг үзүүлнэ.

Хот байгуулалтын хувьд хөрсний ус 3.0 м-ээс доош гүнд илэрсэн бол тохиромжтой, 3.0-1.0 м-т хязгаарлагдмал тохиромжтой, 1.0 м-ээс дээш гүнд тохиромжгүй нөхцлөөр үнэлэгдэх бөгөөд үүнээс хамаарч барилга байгууламж, шугам сүлжээний төсөвт өртөг мөн нэмэгддэг.

Алтай, Дарви, Хөхморьт, Чандмань, Эрдэнэ, Бугат сумын төвд хөрсний ус 1,0-3,0 м, Алтай хотод 1,0 м гүнд байна. Үүний зэрэгцээ Чандмань сумын төвийн зарим хэсэгт намагжсан талбай байдаг.

Аймгийн нутаг дэвсгэрт гүний усны нөөц хомсоос ихээхэн шалтгаалж томоохон хот суурин барьж байгуулахад нэлээд хүндрэлтэй юм.

Говь-Алтай аймгийн хот, тосгон төв суурингийн газруудад нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа

д/д	Хот байгуулалтын хүчин зүйл хот төв суурин	Усан хангамж	Олон жилийн цэвдэг хөрс	Газар чичирхийлэл /балл/	Ул хөрсний нягтрал	Ул хөрсний норматив ачаалал кг/км.см	Хөрсний усны түвшин метр	Үерт автагдсан байдал	Газрын гадаргын налуу	Барилгын уур амьсгалын бүс	Далайн түвшнээс дээш өргөгдсөн байдал метр	Бусад
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Алтай хот		алаг цоог	9	хөөлт		0.8		2.0	II	2100.0	
2	Цахиурт	+		7								
3	Зээгт	+		9								
4	Алтай	дунд		8-9	хөөлт	3.5	1.4		0.1	III	1400.0	
5	Баян-Уул	+		9		3.5				II	1800.0	
6	Бигэр	+		9		3.0	5.6		1.6-4.5	II	1500.0	
7	Бугат	+		9	хөөлт		2.6-7.3		5.0	II	2100.0	
8	Дарви	+		9	хөөлт		0.5-5.0		2.0	II	1600.0	
9	Дэлгэр	+		7		3.0-4.0	2.8		0.9	II	1200.0	
10	Жаргалант	+		8-9		3.0	5.0-9.6		1.0	III	1300.0	
11	Тайшир	+		8		3.5			1.2-2.0	III	1600.0	Гуу жалгатай
12	Тонхил	+		9		3.0			3.0	II	2200.0	
13	Төгрөг			9		5.0		үер, хам	3.0	II	2900.0	
14	Халиун	дунд		9					1.0	II	1400.0	
15	Хөхморьт	+		7	хөөлт		1.5-2.7		0.09	II	1400.0	
16	Цогт	+	алаг цоог	9		3.0				II	2300.0	Гуу жалгатай
17	Цээл			7		3.5	5.6		3.0	II	1500.0	
18	Чандмань	дунд		9		3.0	1.5-3.1		0.5	II	2200.0	намагтай
19	Шарга	+		7						II		
20	Эрдэнэ	+		9	хөөлт		2.8-5.0		10.0	II	2400.0	

Дүгнэлт

Говь-Алтай аймгийн байгаль цаг уурын нөхцөл байдлын тодорхойлолтоос дараахи дүгнэлтүүдийг хийж болох юм. Үүнд:

1. Тус аймгийн нутаг дэвсгэрт унах хур тунадасны хэмжээ, газрын гадаргын өндөр намаас хамаарч харилцан адилгүй байдаг. Өндөр уулархаг хэсэгт 200-300 мм тунадас унадаг. Говь-цөлийн бүсэд 80-100 мм унадаг байна.
2. Уур амьсгалын өөрчлөлт дулаарлын улмаас өндөр уулсын мөнх цас хайлах, газрын гүний цэвдэг гэсэх зэргээр одоогийн бэлчээрийн нам дор газарт намаг үүсэх, цөлжих үйл явц эрчимжин умар тийш хүрээгээ тэлэх жижиг гол горхи булаг шанд нуурууд ширгэх зэрэг өнөөгийн арга технологиор мал аж ахуй, газар тариалан эрхлэх явуулахад бэрхшээлтэй болно. Иймд гол горхи булгийн усны эхийг хамгаалах, малын тоо толгой сүргийн бүтцийг зохицуулах, бэлчээрийг хуваарь сэлгээтэй ашиглах замаар цөлжилтийг сааруулах, цаг уурын өөрчлөлтөнд дасан зохицох нөхцөлийг одооноос бүрдүүлэх шаардлагатай байна.
3. Усалгааны техникийг шинэчлэх замаар усны үргүй алдагдлыг багасгах, ус хуримтлуулах хөвийг сэргэх, бололцоотой газруудад шинээр байгуулан хаврын шар ус болон үерийн усыг нөөцлөн уст цэгийн тоог нэмэгдүүлэх нь зүйтэй.
4. Сулавтар хөгжилтэй элсэнцэр хөрстэй бэлчээрийн газрыг зөвхөн өвлийн улиралд ашиглах, дулааны улиралд нөөцлөх, Хөх морьт, Баян-Уул, сумдууд, Баянтоорой тосгоны төвд элсний нүүдэл эхэлсэн байдлыг харгалзан түүнтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.
5. Дэлхийн хэмжээнд ховордсон, нэн ховордсон амьтан, ургамлын өлгий болсон тусгай хамгаалалттай газруудад тавих хараа хяналтыг сайжруулах, хамгаалалтын бүсэд мал бэлчээрлүүлэх, өвс ургамлыг түүж устгах, ан амьтдыг үргээж даажуулдаг явдалыг зогсоох, Алтай өвөр говийн баян бүсүүдэд бүртгэгдсэн үр боловсруулах чадвараа алдсан, нэн ховор, эртний үлдвэр ургамлуудыг тусгай зориулалтын талбайд мөчир нахиагаар нь үржүүлэн мөхөж сөнөхөөс хамгаалах, үүнд ГИДГ-ын захиргаа, түүний материал баазыг түшиглэж болох юм.
6. Услалтын системүүдийн Хөрс, усны бололцоог түшиглэн мод үржүүлэгийн газар байгуулан “Ногоон хүрэм төсөлд” суулгац бэлтгэх, нөгөө талаар системийн талбайд ойн зурвас байгуулах ажлыг хамтруулан гүйцэтгэх нь зүйтэй.

1.3 НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ

1.3.1 Нийгэм-эдийн засгийн суурь нөхцөл

Тус аймгийн нийгэм эдийн засгийн суурь нөхцөл нь дэд бүтэц, (зам харилцаа, холбоо, эрчим хүч, инженер, шугам сүлжээ, бусад байгууламж гэх мэт) түүний хөгжлийн түвшинг голлох нөлөөллийг үзүүлэх бөгөөд эдгээр салбарын одоогийн байдлыг товч дурьдвал:

Зам харилцааны талаар: Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэр дээгүүр улсын чанартай 434.5 км зам дайран гардаг.

Аймгийн нутгийн зүүнээс баруун тийш дайран өнгөрсөн баруун аймгуудыг Улаанбаатар хот, төвийн бүстэй холбосон сайжруулсан шороон зам, хойноос урьд зүгт дайран гарсан баруун болон хойт чиглэлийн аймгуудыг БНХАУ-ын ШУӨЗО-ны Хами аймагтай холбогдсон босоо тэнхлэгийн замууд нь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд стратегийн хувьд ихээхэн ач холбогдолтой юм.

Дэлхийн банк болон Засгийн газар бусад байгууллагуудын тусламжтайгаар улсын бүртгэлтэй авто замыг сайжруулах ажлыг хийж байна. Тайшир, Естийн төмөр бетон гүүрийг ашиглалтанд оруулж, Шаргын голын 351.0 сая төгрөгийн төсөвтэй төмөр бетон гүүрийг барьж дуусгасан байна.

Аймгийн төв сумдууд энгийн шороон замаар холбогддог. Улсын чанартай болон орон нутгийн замууд энгийн шороон замууд байгаа нь олон салаа зам гарах, хөрс эвдрэх бэлчээр талхлагдах зэрэг сөрөг нөлөө үзүүлж ирлээ. Мөн ачаа тээврийн эргэлт удаашрах, тээврийн хэрэгсэл эвдэрч саатах зэрэг эдийн засгийн алдагдалтай үр дагавар дагуулдаг. Говь-Алтай аймгийн төв Алтай хот бүх сумдтайгаа газрын авто шуудангаар холбогдсоны дээр Улаанбаатар хоттой байнгын нислэгээр холбогдсон юм.

Говь-Алтай аймгийн алслагдсан бүх сумдуудад онгоцны буудлууд байсан боловч зах зээлд шилжих явцад татан буугдсан ажээ. Цогт сумын ИТХ, засаг дарга, тамгын газрын хамт олон нутгийн иргэдийн хандив тусламж, хүч хөдөлмөрөөр Бумбатын даваанд 3 км зам зассанаар сумаас Алтай хот орох замыг 30-40 км дөт болгожээ. Гэгээт багийн замыг зассанаар урьд 185 км байсныг ердөө 80-хан км болгон товчилжээ.

Тус сум сүүлийн жилүүдэд 250 км замыг засаж сайжруулан бартаа саадыг арилгасан байна.

Холбооны шугам сүлжээний талаар: Говь-Алтай аймгийн бүх сумын төвөөс Алтай, Улаанбаатар хот болон дэлхий бусад хотуудтай холбоо барих боломжтой болжээ. Зарим багийн төвөөс, сумын төвтэй холбоо барих зөөврийн станцаар хангагдаж байна. Харин багаас иргэдтэй холбоо барих асуудал хараахан

шийдэгдээгүй боловч улс орны хамарсан цаг хугацааны асуудал тул ойрын ирээдүйд бүрэн шийдэгдэх боломжтой юм.

Алтай-Улиастай хотыг холбосон өндөр хурдны шилэн кабелийн дамжуулах байгууламжийг байгуулсан бөгөөд бүх сумдад алсын хэрэглэгчидтэй шууд харьцах АТС суурилсан байна.

Алтай хотод 1768 хэрэглэгчидтэй электрон АТС-ыг ашиглалтанд оруулсны зэрэгцээ мобикомын үүрэн телефоны сүлжээг аймгийн төв Шарга зэрэг сумдад суурилуулсан нь мэдээллийг шуурхай дамжуулахад чухал түлхэц боллоо. Сансрын холбоо, интернет үйлчилгээ зэрэг орчин үеийн технологийг нэвтрүүлж, интернет мэдээллийн төвийг барьж ашиглалтанд оруулжээ.

Радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах станцын хүчин чадлыг нэмэгдүүлж, хамрах хүрээ, тархац чанарыг дээшлүүлсэн байна.

Эрчим хүчний хангалтын талаар: Тус аймгийн нийт сумд одоогийн байдлаар Япон улсын буцалтгүй тусламжаар ирсэн 60-10 КаВт-ын 2-3 дизель цахилгаан станцаар эрчим хүчний хэрэгцээгээ хангаж байна.

Бага оврын усан цахилгаан станц ажиллуулан Дэлгэр сум, Гуулин тосгоныг эрчим хүчээр хангадаг. Тайшир сумын Улаанбоомд баригдаж буй 12 мгвт-ын усан цахилгаан станц ашиглалтанд орсноор тус аймийн Алтай, Завхан аймгийн Улиастай хотууд болон дээрх аймгуудын төвийн ойролцоох нийт 8 сумын төвүүдийг байнгын эрчим хүчээр хангах нөхцөл бүрдэх юм. Үүний зэрэгцээ Цогт сумын Төгрөг, Бугат сумын Бижийн гол дээр бага оврын усан цахилгаан станц барих судалгааны ажлыг хийж хэтийн хөгжлийн төлөвлөлтөнд суулгаж өгсөн байна.

Бугат сумын төвийг нар салхины эрчим хүчээр хангах ажлыг туршилтын журмаар явуулж байна. Монгол Улсын засгийн газрын “Бумбат нарны гэрэл” хөтөлбөрийн дагуу хөдөөгийн малчин өрхүүдэд нарны цахилгаан эх үүсгүүрийг зээлээр олгосон нь үр дүнтэй болжээ.

Инженерийн дэд бүтцийн талаар: Говь-Алтай аймгийн инженерийн дэд бүтэц, Алтай хотын дулаан хангамжийн 30 гаруй жижиг халаалтын зуух, нийлбэр дүнгээр 29.0 км урт дулааны төв шугам хамрагдана. Тэдгээрийн 80 гаруй хувь нь сүүлийн 30 гаруй жил засвар, шинэчлэл хийгдээгүйгээс дулаан хангамжийг хэрэглэгчдэд хэвийн хүргэхэд хүндрэл учруулж байна. Дээрх шалтгааны улмаас хотын үйлдвэр аж ахуйн газрууд, орон сууцны халаалт жигд биш, ахуйн хэрэглээний халуун усны хангамж, техникийн нөхцөл хангалтгүй явж иржээ. Тус аймгийн сумдын төвүүдийн хувьд төвлөрсөн халаалтын системүүд төслийн хүчин чадлаар ажиллахаа больж, албан байгууллагууд нь бие даасан жижиг оврын нам даралтын зуух ашиглах болжээ.

Харин Эрдэнэ сумын Тамгын газар, сургууль, эмнэлэг гэх мэтийн цөөн газрууд нэгдсэн халаалт авч байна.

1.3.2 Хүн ам зүй

УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоолоор Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталж, эдийн засгийн баруун, хангай, төвийн, зүүн гэсэн 4 бүсийг тогтоож, Улаанбаатар хотыг бие даасан бүсийн жишгээр хөгжүүлэхээр зааж бүс бүрд хамаарах аймгуудын ерөнхий хуваарыг тогтоосон юм.

Баян - Өлгий, Ховд, Говь - Алтай, Завхан, Увс аймгуул баруун бүсэд хамрагдсан. 2004 оны байдлаар улсын нийт хүн амын 16.2 хувь нь энэ бүс нутагт оршин сууж байна.

Монгол улсын иргэдийн ёс заншил, газар нутгийн ашиглалт, аж ахуй эрхлэлтийн хоорондын ялгагдах байдлаар хүн амын нутагшилтын 6 ерөнхий том бүс болгон хуваасны дагуу тус аймаг Алтайн уулархаг бүс нутгийн хэсэгт хамрагддаг.

Говь - Алтай аймаг 2005 оны байдлаар 63.6 мянган хүн амтайгаас 67.8 хувь нь хөдөөд амьдарч байна. Мөн 15.5 мянган өрхтэй ба үүний 10.5 мянга нь хөдөө орон нутагт байгаа юм. Тус аймгийн өрх, хүн амын тоог 2001 оны үзүүлэлттэй харьцуулахад өрх 0.4 мянга, хүн ам 3.3-5.6 мянгаар тус бүр цөөрсөн ажээ. Үүнийг ган, зудад нэрвэгдсэн иргэд, малчдын Улаанбаатар, Эрдэнэт, Дархан зэрэг томоохон хот, аймгийн төв зэрэг суурин газар болон түүний ойролцоо, зах зээлд ойртон суурьших хандлага давамгайлан, шилжих хөдөлгөөний урсгал ихэссэнтэй холбоотой гэж үзэж байна.

2001-2005 онуудад Дэлгэр, Чандмань, Жаргалан, Баян-Уул, Цээл сумдаас 404-587 иргэд гадагш шилжжээ. Харин Бугат, Шарга сумдаас 24-57 иргэд шилжсэн нь хамгийн цөөн ажээ. Энэ хугацаанд Алтай хотод 1873 хүн шилжин ирж суурьшжээ.

Дараахи хүснэгтээс харахад Баян-Уул, Дэлгэр, Цогт сумдууд хамгийн олон 3067-4380 хүн амтай байхад Тайшир, Төгрөг, Дарви сумдууд дөнгөж 1625-1913 хүн амтай хамгийн цөөнд орж байна. Есөнбулаг сумын хүн ам 20101 болж 2001 оныхоос 12.1 хувь өсчээ.

Монгол Улсын Их Хурлаас 2004 онд баталсан “ Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого” -д “Хүн амын орон нутагтаа тав тухтай амьдран суурьших нөхцлийг хангаж, байгаль орчны зохисгүй өөрчлөлт, зах зээлийн болзошгүй эрсдэлээс хамгаална” гэж заасан байна.

**Аймгийн болон сум дундын төвүүдэд хамрагдах сумдын
хүн амын суурьшил, шилжих хөдөлгөөний үзүүлэлт**

№	Аймаг, сум дундын төв	2001	2005	Зөрүү	
				+	-
1	Алтай /Есөнбулаг/	17927	20101	2174	-
	Жаргалант	2842	2299		543
	Дэлгэр	3837	3385		452
	Халиун	3173	2871		302
	Тайшир	1823	1625		198
	Дүн	29602	30281	2174	1495
2	Баян-Уул	3572	3067		505
	Хөхморьт	2814	2585		229
	Дүн	6386	5652	-	734
3	Бигэр	2849	2597		252
	Чандмань	2775	2235		540
	Цогт	4544	4398		146
	Эрдэнэ	2471	2243		228
	Дүн	12639	11473	-	1166
4	Шарга	2550	2417		133
	Тонхил	2928	2564		364
	Дарви	2060	1913		147
	Дүн	7538	6894	-	644
5	Төгрөг	2164	1817		347
	Бугат	2864	2844		20
	Дүн	5028	4661	-	367
6	Цээл	2780	2161		619
	Алтай	2516	2465		51
	Дүн	5296	4626	-	670
Нийт дүн		66489	63587	2174	5076

Тус аймагт сүүлийн жилүүдэд тохиолдсон байгаль цаг уурын бэрхшээл түүний улмаас мал аж ахуй, газар тариаланд учирсан хохирлыг богино хугацаанд нөхөх зорилгоор малчид, тариаланчдад хөнгөлттэй зээл олгох, малжуулах, бэлчээрийг усаар хангах, худаг гаргах, тодорхой хэмжээний газар эзэмшүүлэн хагалж боловсруулан, тарих үрийг хөнгөлттэй үнээр өгөх зэрэг олон талт арга хэмжээ авсан байна. Гадаад дотоодын зээл тусламж, хандивийн хөрөнгийг энэ чиглэлд хандуулан төрөл бүрийн сургалтанд хамруулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авсан нь төврүү шилжих хөдөлгөөнийг саармагжуулахад бодитой нөлөө үзүүлж байна.

1.3.3 Газар тариалан

Говь-Алтай аймгийн 2005 оны газар тариалангийн үйлдвэрлэлийг, 1995 үзүүлэлттэй харьцуулбал хураасан үр тариа 3.1 дахин буурч, харин төмс 59,8 хувиар, хүнсний ногоо 2, 3 дахин илүү нэмэгджээ. Сүүлийн 6 жилийн үзүүлэлтийг харьцуулан үзэхэд хүнсний ногооны хувьд хэлбэлзэл багатай байна.

Харин үр тарианы ургац тогтворгүй, харьцуулсан хугацаанд 2003 онд хамгийн өндөр 1578,3 тн ургац авч байсан бол 2005 онд 520,2 тн ургац хурааж хамгийн доод хэмжээнд очжээ.

Газар тариалангийн үйлдвэрлэлийн судалгаа

Он	2000	2001	2002	2003	2004	2005	
Эргэлтийн талбай	1055.2	1283.3	1470.5	1689.4	1636.9	1665.0	
Ү н э э с	Үр тариа	553.0	581.6	760.9	950.3	1097.6	1122.2
	Га-гийн ургац цн	10.9	10.1	12.2	16.6	8.1	8.9
	Нийт ургац	602.0	587.3	930.2	1578.3	888.3	520.2
	Төмс га	155.2	178.3	263.5	236.9	135.0	138.5
	Га-гийн ургац цн	78.5	73.9	67.7	93.4	98.5	78.2
	Нийт ургац	1217.7	1318.1	1830.0	2213.7	1280.5	1522.6
	Хүнсний ногоо	162.2	150.5	171.5	178.5	100.9	100.9
	Га-гийн ургац цн	83.2	56.4	52.9	82.5	117.6	82.7
	Нийт ургац	1349.6	849.2	907.3	1472.5	1186.7	1076.9
	Тэжээлийн ургамал га	184.8	372.9	264.6	323.7	238.4	314.1
	Га-гийн ургац цн	24.5	16.3	20.3	30.5	40.1	30.4
	Нийт ургац	452.0	609.0	536.9	985.7	956.5	724.9

Дээрх хүснэгтээс үзэхэд 2004 онд тариалсан талбай хураан авсан ургацыг 2005 онтой харьцуулахад тариалсан талбай 26.2 %, хураан авсан үр тариа 41.4 хувь, хүнсний ногоо 9.2 хувь, тэжээлийн ургамал 24,2 хувиар тус тус буурч харин төмс 18,9 хувиар өссөн байна.




График 1. Газар тариалангийн зориулалттай эргэлтийн талбай




График 2. Ургацын хэмжээ

Тус аймгийн нутаг дэвсгэр цаг уурын онцлогоос хамааран газар тариалангийн ажлыг зуун хувь усалгаатай нөхцөлд явуулдаг. Жижиг гол горхи булаг, баянбүрдийг

түшиглэн эртнээс газар тариалан эрхэлж ирсэн уламжлалтай. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр төмс, хүнсний ногоо тариалах санаачлага амжилттай өрнөж байна.

Аймгийн орон нутгийн төр захиргааны байгууллага ногоон хувьсгалын хүрээнд иргэдийн санал санаачлагыг дэмжиж, хөнгөлттэй зээл олгох, үр бордоогоор хангах зэргээр тал бүрийн туслалцаа үзүүлж байна. Ингэснээр сүүлийн жилүүдийн цаг агаарын өөрчлөлт хэт халалт гантай үед ч төмс, хүнсний ногооны тогтвортой ургац авч байна. Харин инженерийн хийцтэй услалтын системүүдийн усалгааны техник үрэгдэн, тоногдсоноос усалгааг зөвхөн гар аргаар хийдэг болсноор үр тарианы ургац буурахад хүрчээ.

1.3.4 Мал аж ахуй

Говь - Алтай аймгийн эдийн засгийн үндсэн салбар уламжлалт бэлчээрийн мал аж ахуй юм. Тус аймгийн нутаг дэвсгэрийн ихэнх нь говь, цөлөрхөг хээр, өвөл нь богино, намар урт, өвс ургамал тачир сийрэг боловч шимт чанар сайтай, өндөр уул, хотос говийн бэлчээрийг улирлын байдалд тохируулан сэлгэн ашиглах боломжтой зэрэг нь мал аж ахуйг хөтлөх явуулахад таатай нөхцлийг бүрдүүлж иржээ.

Оросын эрдэмтэн А. А. Юнатов “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хадлан бэлчээр дэх тэжээлийн ургамлууд” товхимолдоо “Монголын бэлчээр нь ерөнхийдөө гарц багатай боловч тэжээлийн шимт чанараар үлэмж сайн бөгөөд говь нутагт бэлчээрийг өндөр үнэлэх нь онцгой тод харагддаг” гэжээ.

Тус аймаг өөрийн орон нутгийн байгаль цаг уурын нөхцөлд дасан зохицсон өндөр ашиг шимтэй нутгийн шилмэл омгийн мал сүргийг өсгөн үржүүлдэг. Үүний дотор Төгрөг сумын хос зогдортой “Төхөм тунгалаг”, Ханын хэцийн хүрэн тэмээ, Алтайн уулын болон өвөр говийн бэлчээрийн маллагааны нөхцөлд зохицсон чийрэг бие цогцостой, мах өөхний ашиг шим сайтай “ Говь-Алтай” үүлдрийн хонь, Алтайн уулархаг нутгийн цаг уурын нөхцөлд зохицсон махны ашиг шим давуутай “ Сутай” омгийн хонийг сонгон үржүүлж байна.

Баруун бүсийн үржлийн шилмэл малын үзэсгэлэн, худалдаанд эдгээр үүлдрийн хоёр хуц медальт байранд шалгарч байв. Тус аймгийн Бугат, Тонхил, Цээл зэрэг 15 сумдад нийт 147,6 гаруй мянган толгой “ Говь-Алтай” үүлдрийн хонь өсгөж байна. Мөн Цээл, Халиун зэрэг 9 сумдад “ Говь-Гурвансайхан” (нутгийн) 121,1 гаруй мянган ямааг сонгон үржүүлдэг. Үүний зэрэгцээ “ Алтайн улаан” (нутгийн болон Ховдын) “ Өлгий” , “ Баяндэлгэрийн улаан” , “ Тулман хөхт” ямаа, “ Үзэмчин” , “ Барга” , “ Байдраг” , “ Торгууд” хонь, “ Алатау үүлдрийн үхэр, “ Галшар” ,


“Тэсийн” хурдан угшлын адууг цэвэр үүлдэр болон эрлийз мал, нутгийн шилмэл омгийн сүргийг цөөн тоогоор үржүүлдэг.

2006 оны байдлаар нийт 83 багт 8283 малчин өрх мал маллагааны ажлыг биечлэн гүйцэтгэдэг бөгөөд тэдний амьжиргааны түвшин улам бүр дээшилж байна. Сүүлийн үед мал сүргийн тоо толгойг өсгөхийн зэрэгцээ, цаг уурын өөрчлөлтийг даван туулах биологийн чадавхитай, бэлчээрийн маллагаанд бүрэн зохицсон, ашиг шим арвинтай, хосолмол чиглэлийн үүлдэр, омгийн мал сүрэг үржүүлэх сонирхолтой иргэд, малчид олноор гарах болжээ. “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Говь-Алтай аймгийн мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр” боловсруулан амжилттай хэрэгжүүлж байна.

Гэвч мал аж ахуй нь байгаль цаг агаарын нөхцлөөс хамааран эрсдэл ихтэй аж ахуй юм.

Гэнэтийн цасан шуурга, хүйтэн бороо, цас их орж хөрлөн мал бэлчээрлэх боломжгүй болох, харын зуд, ган, элсний нүүдэл зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн давтамж ойртож, зарим үед жил дараалан тохиох болсон нь мал аж ахуйд ихээхэн хохирол учруулдаг байна.

2000-2001 онуудад тохиолдсон байгаль цаг агаарын гамшигт аймгийн нийт мал сүргийн 50.3 хувь буюу 1024.6 мянган толгой мал хорогдсон байна.



2000-2001 онд ямаа, адуу, үхэр 58.8-79.1 хувиар хорогдсон бол тэмээ, хонины 35.4-43.4 хувь нь хорогджээ. Үүнээс харахад бут, сөөг, сөөгөнцөрт хэвшлийн бэлчээртэй тэмээн сүрэг цаг агаарын өөрчлөлтөнд зохицон амьдрах чадвар сайтай болох нь анзаарагдаж байна.

Малын төрөл тоо толгой, сүргийн бүтцийн судалгаа
/мян.толгой/

Малын төрөл	2000 он		2001 он		2002 он		2003 он		2004 он		2005 он	
	тоо	%	тоо	%	Тоо	%	тоо	%	тоо	%	тоо	%
Бүх мал	2035.1	100.0	1714.7	100,0	1010.5	100,0.	1261.2	100,0	1539.6	100,0	1834,2	100,0
Ү Тэмээ	31.8	1.6	28.3	1.6	22.3	2,2	23,8	1,9	24,8	1,6	25,7	1,4
Ү Адуу	91.9	4.5	75.1	4.3	35.1	3,5	40,5	3,2	47,2	3,1	53,2	2,9
н Үхэр	60.0	2.9	39.9	2.3	16.5	1,6	19,9	1,6	24,5	1,6	31,2	1,7
ээ Хонь	847.6	41.6	692.7	40.7	357.6	35,4	401,9	31,8	482,5	31,3	588,7	32,1
с Ямаа	1003.8	49.3	878.7	51.2	579.0	57,3	775,1	61,5	960,6	62,4	1135,4	61,9

Аймгийн 2005 оны нийт малын бүтцийн хувьд хонь, ямаа 32-61,9 хувь, үхэр тэмээ адуу 1.4-2,9 хувь байна.




График 4. Нийт малын бүтэц 2005 он

Нийт малын дотор бог малын тоо 94 хувийг эзэлж байхад бод малын тоо дөнгөж 6,0 хувийг эзэлж буй нь зохистой харьцаа биш юм.




График 5. Аймгийн таван хошуу малын өсөлт, хорогдлын график





График 6. Аймгийн таван хошуу малын өсөлт, хорогдлын график

Зах зээлийн өнөөгийн нөхцөлд хэдийгээр хамгийн таваарлаг сүрэг боловч ямааны тоо толгойг хяналтгүй хэт өсгөх нь сүргийн бүтэц алдагдах, цаашид элсэрхэг, эмзэг хөнгөн хөрстэй бэлчээрийн даац хэтэрч шимт чанар идэмж сайтай үнэт ургамал цөөрөх, тачир сийрэг болох, улмаар элсний нүүлт, цөлжилт зэрэг сөрөг нөлөө үүсэхэд хүргэх боллоо.

Сумдын малын тоо толгойн үзүүлэлт



Зураг 1. Малын тоо толгойн бүлэглэл

Малын тоо толгойн хувьд Дэлгэр, Дарив, Цогт, Бугат, Баян-уул, Тонхил зэрэг нийт 9 сум 104,5-170,2 мянган толгой малтай тэргүүлж байгаа бол Тайшир, Чандмань, Хөхморьт сумууд 56,6-60,6 мянган толгой малтай байна. Нутаг

бэлчээрийн багтаамж, өвс ургамлын гарц, уст цэгийн хүрэлцээнээс хамааран сум бүрт малын тоо толгой харилцан адилгүй байгаа юм.

Хамгийн олон тэмээтэй сум нь Шарга 3.0, хамгийн олон адуу, үхэртэй нь Баян-Уул 5.4, Жаргалан 3.5, хонь ямаатай нь Тонхил 85.3, Цээл 92.1 мянган толгой байгаа юм.

1.3.5 Үйлдвэр, үйлчилгээ, бусад салбар

Тус аймаг нь төвийн бүсээс алслагдсан зах зээлээс зайдуу, дэд бүтэц хязгаарлагдмал хөгжсөн бүс нутаг юм.

Аймгийн байгаль цаг уурын онцлог нөхцөл, газар нутгийн өвөрмөц байршилд тулгуурлан оновчтой бодлого явуулснаар бүс нутгийн хэмжээнд нөлөө бүхий үйлдвэр үйлчилгээний салбарыг хөгжүүлж иржээ.

Аж үйлдвэр - Өнөөгийн байдлаар тус аймагт жилдээ 1200 тонн ноос угаах үйлдвэр, хоногт 250 ам.метр эсгий үйлдвэрлэх хүчин чадалтай эсгийний цех, жилд 100 мянган нүүрс олзборлох чадалтай Зээгтийн нүүрсний уурхай зэрэг үйлдвэрлэлийн газрууд ажиллаж байна. Засгийн газраас авч хэрэгжүүлж буй “Алт” хөтөлбөрийн хүрээнд 1990 оноос алт олзборлох 2 компани байгуулагдан ажилладаг. Аймгийн эдийн засагт аж үйлдвэрийн салбарын гүйцэтгэх үүрэг чухал юм.

Аймгийн статистик мэдээллээс харахад 2005 онд аж үйлдвэрийн салбарт 120 аж ахуйн нэгж үйлдвэрлэл явуулж нийт 2690,6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 2710,4 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оныхоос үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн 164,6 мянган төгрөгөөр доогуур байна.

Тус салбарт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн 68,6 хувь, борлуулсан бүтээгдэхүүний 63,6 хувийг цахилгаан дулаан эзэлж байгаа нь өнгөрсөн оныхоос өссөн байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 84,7 хувь, борлуулсан бүтээгдэхүүний 84,9 хувийг аймгийн төвд, үлдэх хувийг сумдад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн эзэлж байна. Гол нэрийн бүтээгдэхүүнээс хиам, талх, нарийн боовны үйлдвэрлэл нэмэгдсэн байна.

Зам барилга, барилгын материалын үйлдвэр - Говь-Алтай аймаг байгалийн нөөц баялаг арвинтай түүний дотор барилгын материалын орд илэрц элбэгтэй. Тус аймагт барилгын үйлдвэрлэлийн чиглэлээр байгуулагдсан 16,0 сая тоосго боловсруулах, ханын материалын болон жилд 310 мянган кубметр бетон эдлэл хийх хүчин чадалтай барилгын материалын үйлдвэрүүд ашиглалтанд орсон боловч төдийлэн үр бүтээлтэй ажиллалгүй зогссон билээ.

Сүүлийн жилүүдэд зам барилга, барилгын материалын 10 гаруй аж ахуйн нэгж байгууллага амжилттай хөгжиж байна. Эдгээрийн зарим нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд юм. Зам барилга үйлдвэрлэл эрхэлдэг компаниуд

өөрийн аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ Ховд, Улиастайд замын ажил гүйцэтгэж, Завхан аймгийн Түдэвтэй, Сонгино сумуудын холбооны салбарын барилгыг барьж ашиглалтанд өгсөн байна.

2005 онд зам барилгын салбарт нийт 1007,2 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оныхоос 27,5 хувиар өссөн байна.

Аймгийн барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэлд сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц ахиц гарсны дотор зөвхөн 2004 онд 790.03 сая төгрөгийн барилга угсралт, засварын ажил гүйцэтгэжээ.

Аймгийн засаг дарга түүний тамгын газраас орон нутгийн нөөц бололцоонд түшиглэн барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэлийг өргөтгөх хөтөлбөр боловсруулан ажиллаж байна. Уг хөтөлбөр хэрэгжсэнээр баруун бүс нутгийн хэрэгцээний барилгын материалын зарим хэсгийг өөрийн аймагтаа үйлдвэрлэх барилга угсралтын үйлчилгээ үзүүлэх томоохон зорилт биелэх юм.

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл Өдөр тутмын өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүнээс гадна нутаг орныхоо уламжлалт бүтээгдэхүүнийг улам боловсронгуй болгон олон нийтэд сурталчилан бренд бүтээгдэхүүн болгоход багагүй амжилт олж байна.

Өнгөрсөн онд “Алтайн түншлэл 2005” үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулан, баруун бүсийн 3 аймгийг оролцуулжээ. Уг үзэсгэлэн худалдаанд “Баянтоорой”, “Тулга-Алтай” ХХК-ийн даршилсан өргөст хэмх, иоджуулсан давс, Алтай сумын Ажийн бор ааруул, Хөх морьт сумын сулийн гурил, Цээл сумын цагаан идээ, Шаргын сумын нутагшсан “Астила” сортын төмс, Төгрөг сумын ингэний хоормог зэрэг бүтээгдэхүүн шилдэгээр шалгарсны дотор Халтар арвайн гурилаар хийсэн “Ашвай” Монгол улсын шилдэг бүтээгдэхүүнээр шалгарсан нь Засгийн газрын “Нэг сум-нэг бүтээгдэхүүн” хөтөлбөр тус аймагт амжилттай хэрэгжиж буйн илрэл юм.

Соёл боловсрол, эрүүлийг хамгаалах - Тус аймагт 2006-2007 оны шинэ хичээлийн жилд Анагаах ухааны коллеж, Физик техникийн дунд сургууль, Үйлдвэрлэлийн сургалт, Шатрын болон Ерөнхий боловсролын сургуулиуд нийт 16,8 мянган оюутан, сурагчид суралцаж байна.

Мөн нийт 26 цэцэрлэгт 3,4 мянган хүүхэд сурч хүмүүжиж, малчдын 3,3 мянган хүүхэд сургуулийн дотуур байранд амьдардаг. Эдгээр 58 сургууль, коллеж, цэцэрлэгт дээд, дунд мэргэжлийн 864 багш, ажилчид хамрагдан ажиллаж байна.

Эрүүлийг хамгаалах салбарын хувьд аймгийн төвд дотор, мэс засал, хүүхэд, төрөх, эмэгтэйчүүд зэрэг төрөл бүрийн мэргэжлийн тасгуудтай, клиник, биохими, бактериологи, шинжилгээний лаборатори бүхий нэгдсэн эмнэлэг, ариун цэвэр,

халдвар судлалын болон гоц халдварт өвчнийг эсэргүүцэх станц, хөдөөд сум дундын 3 эмнэлэг, нийт сум хүний их эмчийн салбартай ажиллаж байна.

“Ардын урлагийг дэмжих хөтөлбөр”, аймгийн “Морин хуур, уртын дуу” дэд хөтөлбөрийн хүрээнд УГЖ Ц. Оюунцэцэг, З. Лхагва, МУСТА Н. Энхбат, Б. Лхагваа, Жамбал, Оюунцэцэг, Амарсайхан нарын тайлан тоглолтыг Улаанбаатар, Алтай хотод хийжээ. Зарим уран бүтээлчдийг морин хуур, уртын дууны сургагч багш, менежерийн сургалтанд хамруулахын зэрэгцээ авъяаслаг сургагчдыг сонгон морин хуурын дамжаанд суралцуулж байна.

Уран бүтээлчдийн хувцаслалт, хөгжмийн зэвсгийг шинэчлэхэд анхаарал тавьж уран бүтээлчдийн нэг ээлжийн шинэ хувцасаар хангасны үндсэн дээр 2005 онд нийт 21,0 мянган үзэгчидэд урлагаар үйлчилж 5,6 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Аймгийн нийтийн болон сургуулиудын номын сангууд, орон нутгийг судлах музей, бүх сумдуудын соёлын төвүүд хэвийн ажиллаж уран сайханч, ардын авъяастнууд иргэд малчдад тогтмол үйлчилж байна. Мөн 700 хүний суудалтай спорт цогцолбор, 6000 хүний багтаамжтай цэнгэлдэх хүрээлэн, биеийн тамирын талбайд улсын болон бүс нутаг, аймгийн аварга шалгаруулах төрөл бүрийн спортын уралдаан тэмцээнийг амжилттай явуулж байна.

Нийгмийн даатгал, хөдөлмөр халамжийн үйлчилгээ:

- Нийгмийн даатгалын шимтгэл, тэтгэврийн санхүүжилтээр нийт 3205,0 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрүүлсэн нь өнгөрсөн оныхоос 28,4 хувиар өссөн байна. Нийт 7,0 мянган иргэнд 2770,5 сая төгрөгийн тэтгэвэр, 50,0 сая төгрөгийг тэтгэмжинд, олгосны зэрэгцээ үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын 41,6 сая төгрөгийг олгожээ.
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээнд 29,4 мянган хүн хамрагдсаны дотор хөдөлмөр эрхлэхийг хүсч бүртгүүлсэн иргэдийн 88,9 % буюу 912 иргэдийг ажлын байраар (түр хугацааны болон үндсэн ажилчнаар) хангаж, 28,3 мянган иргэнд 1101,2 сая төгрөгийн халамжийн, тэтгэвэр тэтгэмж олгожээ. Тус аймагт нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээ хэвийн явагдаж төр захиргааны зүгээс иргэдэд чиглэсэн үйлчилгээ хууль зүйн хүрээнд явагдаж байна.

Тус аймагт зөвхөн Бургастайн боомтоор таван удаа хил худалдаа хийхэд нийт экспорт 3,3 сая ам.доллар байхад импорт нь 4,2 сая ам.долларт хүрч байна. Энэ нь экспорт, импортын харьцаа 1:1,8 болж буй нь эдийн засгийн хувьд тийм ч зохимжтой үзүүлэлт биш юм.

Экспортод ихэвчлэн тэмээний эр эм ноос, хонины нэхий, ямааны ноолуур, хонин угаасан болон бохир ноос зэрэг МАА түүхий эд гаргаж, импортоор түлш шатахуун, гурил, цемент, нүүрс зэрэг бүтээгдэхүүн оруулж ирсэн байна.

Дүгнэлт

Говь-Алтай аймгийн Нийгэм эдийн засгийн одоогийн байдалд дараахь дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Нийгэм эдийн засгийн бүх салбарыг хөгжүүлэх үндсэн нөхцөл, эрчим хүчний эх үүсвэрийг амжилттай шийдвэрлэж буй ололтондоо тулгуурлан Биж, Төгрөгийн гол дээр УЦС барих хөрөнгийн эх үүсвэрийг шийдүүлэхэд төр засгийн дээд өндөрлөгийн анхаарлыг хандуулах, Хаяагийн зэрэг услалтын системийг түшиглэн бага хүчин чадалтай УЦС байгуулах боломжийг судлах нь зүйтэй. Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр гарч ирж буй шинжлэх ухааны ололт, үйлдвэрлэл туршилтын талаар мэдээлэл цуглуулан дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрт хамрагдсанаар алслагдсан сум суурин газруудыг эрчим хүчний эх үүсвэртэй болгох. Энэ талаар дараагийн ээлжийн хөтөлбөрийг боловсруулах.
2. Мянганы замын босоо тэнхлэгийн Ханх-Бургастайн чиглэлийн замыг барьж байгуулах ажлыг түргэвчилэхийн зэрэгцээ аймгийн нутаг дэвсгэр дээрх улсын чанартай бусад замуудыг сайжруулах улмаар цардмал зам болгоход УИХ, Засгийн газар болон хандивлагч, түншлэгч орнуудын анхаарлыг хандуулах, нөгөө талаар Алтай хотын нисэх буудлын зурвасыг цардах шаардлагатайг анхаарах хэрэгтэй.
3. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх асуудлыг бодлогоор дэмжсэнээр хүн амыг тогтвор, суурьшилтай болгох улмаар ажилгүйдэл ядуурлыг эрс бууруулах.
4. Услалтын системүүдийг хэвийн ажиллагаанд оруулснаар хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх, гадаад дотоодын түншлэгчдийг судлах, уур амьсгалын нөхцөлд тохирсон сортын үрээр тариалалт явуулах нь чухал байна.
5. Сүргийн бүтцийг сайжруулах, ашиг шим сайтай, уур амьсгалын өөрчлөлтөнд зохицох чадвартай, үүлдэр, омгийн малыг үржүүлэхийн зэрэгцээ хадлан бэлтгэх, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд анхаарах, энэ чиглэлийн хоршоолол, хувийн хэвшлийг, зээл олгох, бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх.
6. Мал аж ахуйн гаралтай түүхий эд ашиглан цагаан идээ, арьс шир, ноос ноолуур, мах боловсруулах төрөл бүрийн хувцасны үйлдвэр, барилгын материалын үйлдвэр, иоджуулсан давсны үйлдвэр байгуулах зэргээр

импортоор авдаг бүтээгдэхүүнийг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх.

7. Аж үйлдвэрийн салбарт бүтцийн өөрчлөлт хийхдээ уул уурхайн чиглэлийн өндөр технологитой эцсийн бүтээгдэхүүн гаргах, цөөн тооны боловсруулах, тэргүүлэх, чиглэлийн үйлдвэр байгуулах, нөгөө талаар иргэдийн хэрэгцээг хангах, ажлын байр бий болгоход чиглэсэн хөнгөн хүнсний, жижиг үйлдвэрүүдийг хөгжүүлэх бодлого баримтлах нь зүйтэй.
8. МУ-ын Засгийн газраас баталсан “Нэг сум нэг бүтээгдэхүүн” хөтөлбөрийн хүрээнд өнөөгийн олсон амжилтыг бататган, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнээр баяжуулах, зарим хэсгийг жижиг үйлдвэр, цехийн нөхцөлд үйлдвэрлэх, реклам сурталчилгааг эрчимтэй явуулах шаардлагатай байна.

II БҮЛЭГ. АЙМГИЙН ГАЗРЫН НЭГДСЭН САНГИЙН БҮТЭЦ, АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

II.1 АЙМГИЙН ГАЗРЫН НЭГДСЭН САНГИЙН БҮТЭЦ

2005 оны аймгийн газрын нэгдсэн сангийн ангиллын тайлангаас үзэхэд тус аймгийн нийт нутаг дэвсгэр 14144767.0 га газартай. Үүний 61.61 хувь нь ХАА-н зориулалтын, 0.10 хувь нь хот тосгон бусад суурин, 0.040 хувь нь зам шугам сүлжээний, 8.63 хувь нь ойн сангийн, 0.10 хувь нь усан сан бүхий газар, 29.52 хувь нь тусгай хэрэгцээний газар тус тус эзэлж байна.

ХАА-н аж ахуйн нийт эдэлбэр газрын 99.89 хувь нь бэлчээр юм.

Тус аймгийн Тайшир сумын нутаг Улаанбоомын усан цахилгаан станцаас Завхан аймгийн Улиастай хотын чиглэлд цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугам шинээр татахад 113.7 га газар шилжүүлсэн нь ХАА-н газраас хасагдсан байна. Дээрх 113.7 га газар нь зам, шугам сүлжээний газарт шилжин тооцогджээ.

Тус аймгийн хэмжээнд ойн сан, усан сангийн газрын хэмжээ өнгөрсөн оныхоос өөрчлөгдөөгүй байна.

Аймаг дундын отрын бэлчээрт зориулан Дэлгэр сумаас 106000 га, Чандмань сумаас 8000 га нийт 114000 га газрыг бэлчээрээс хасаж тусгай хэрэгцээний газрын ангилалд оруулжээ. Ингэснээр ган, зудын бэрхшээлтэй үед өөрийн аймаг болон Завхан, Баянхонгор аймгуудын ойролцоохи сумдын мал сүрэг оторлох нөөц нутаг бэлчээртэй болсон байна.

Хүснэгт 16

Газрын нэгдмэл сангийн үндсэн бүрэлдэхүүний бүтэц /га-гаар/

Газрын нэгдсэн сангийн ангилал		Аймгийн газрын сангийн 2006 оны тайлангаар	Эзлэх хувь (%)
Аймгийн нийт нутаг		14144767.0	100,0
Үүнээс	ХАА-н зориулалтын газар	8714139.8	61,61
	Хот тосгон бусад суурин газар	14157.3	0,10
	Зам шугам сүлжээний газар	5683.7	0,04
	Ойн сангийн газар	1221261.0	8,36
	Усан сангийн газар	14254	0,10
	Тусгай хамгаалалттай газар	4175270.2	29,52

II.2 ХӨДӨӨ АЖ АХУЙН АНГИЛЛЫН ГАЗРЫН БҮТЭЦ, АШИГЛАЛТ ХАМГААЛАЛТЫН БАЙДАЛ

ХАА-н газрыг зориулалтын дагуу ашиглах, үр өгөөжийг нэмэгдүүлэх явдал, улам бүр чухалчлан тавигдах болов. Тус аймгийн байгаль цаг уурын өвөрмөц нөхцөл, хөрс ургамлын эмзэг байдал нь ХАА-н газартай тусгайлан боловсруулсан бодлого төлөвлөлтийн дагуу хандах нэн тэргүүний асуудал болж байна.

2005 оны газрын нэгдсэн сангийн тайлангаас үзэхэд тус аймгийн хөдөө аж ахуйн эдэлбэр газар 8714139.8 га буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 61.61 хувийг эзэлж байна.

Алтай, Бугат, Цогт, зэрэг сумдууд 605101.1-866292.2 га эдэлбэр газартай томоохонд орж байхад Есөнбулаг, Төгрөг, Дарив сумдад 209146.0-303083.0 га эдэлбэр газартай байна.

Аймгийн нийт ХАА-н эдэлбэр газраас 8704619.8 га бэлчээр, үлдэх 9520 га нь хадлан тариалан, жимс, жимсгэнэ болон хөдөө аж ахуйн барилга байгууламжийн газар юм.

Хүснэгт 17

ХАА-н зориулалтын газрын дотоод бүтэц

Газрын нэгдмэл сангийн ангилал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Дотоод бүтцэд эзлэх хувь (%)
ХАА-н зориулалтын газар бүгд	Га	8714139,8	100,0
Тариалан бүгд	Га	3609	0,04
Үүнээс усалгаатай	Га	3609	0,04
Хадлан	Га	2266	0,03
Бэлчээр	Га	8704619,8	99,89
Үүнээс /талхлагдсан /	Га		
Атаршсан	Га	1941	0,02
Жимс жимсгэнэ	Га	65	0,007
ХАА-н барилга байгууламж	Га	1704	0,,21
ХАА-д тохиромжгүй газар	га		

II.2.1 Тариалангийн газар түүний, ашиглалт хамгаалалтын өнөөгийн байдал

Тус аймгийн ихэнх нутаг нь говь-цөлийн бүсэд хамрагддаг, хуурайвтар уур амьсгалтай, чийг тунадас дутагдалтай нь газар тариалангийн үйлдвэрлэлийг энгийн аргаар эрхлэх боломжгүй юм. Ийм нөхцөлд үр тариа, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээлийн таримал, олон наст ургамлыг амжилттай тариалах, арвин ургац авах эсэх нь зөвхөн усалгааны асуудлыг хэрхэн шийдвэрлэснээс хамаарсаар иржээ.

1982 онд тус аймагт явуулсан атар газрын экспедицийн судалгаагаар усалгаатай нөхцөлд газар тариаланд ашиглах боломжтой 34.6 мянган га газар судлагдсанаас 14.9 мянган га газрыг ус хүрэлцээгүй зэргээс ойрын ирээдүйд ашиглах боломжгүй хэмээн үзсэн байна.

Тус аймгийн ХАА-н зориулалтын газрын дөнгөж 0,04 хувийг эзлэх буюу 3609 га талбайг тариаланд ашиглаж буй нь маш хангалтгүй үзүүлэлт юм. 1967-1989 онуудад улсын хөрөнгө оруулалтаар нийт 5547 га талбайд тариалалт явуулах төслийн хүчин чадалтай, иж бүрэн 17 услалтын системийг ашиглалтанд оруулжээ. Өнөөгийн тариаланд ашиглаж буй талбайг дээрхи төслийн хүчин чадалд харьцуулбал зөвхөн 34.9 хувийг эзэмшиж байгаа боловч 1941 га буюу 34,9 хувийг атаршуулж, 1943,98 га буюу 46,1 хувийг өнжөөх нэрээр орхигдуулсан байна. Тариалангийн талбайн бүтэц, ашиглалтын түвшингийн үзүүлэлт нь тариалангийн талбайг хэр зэрэг үр ашигтай ашиглаж буйг харуулдаг чухал үзүүлэлт юм.

Хүснэгт 18

Тариалангийн талбайн ашиглалтын өнөөгийн байдал (2004 он)

	Тариалангийн талбайн бүтэц, тарималын төрөл	Талбайн хэмжээ /га/	%	Хураан авсан нийт ургац /тн/	1 га-гаас авсан ургац /цн/
1	Эргэлтийн талбайн бүтэц /га/	3609	100,0		
2	Үр тариа бүгд	1122,2	31,1	520,1	12,4
	Үүнээс	693,1	19,2	386,4	11,5
	Улаан буудай	429,1	11,9	133,7	6,3
	Бусад				
3	Төмс	138,5	3,8	1522,6	78,2
4	Хүнсний ногоо	100,9	2,8	1076,9	82,7
5	Тэжээлийн ургамал	238,4	6,6	724,9	30,4
6	Жимс, жимсгэнэ	65,0	1,8	92,7	14,3
7	Өнжөөсөн	1944,0	53,9	-	-

Дээрхи услалтын системүүдийн нийт хүчин чадал нь улсын хэмжээнд Увс, Сэлэнгэ аймгуудын системүүдийн дараа 3-рт орж байв. Эдгээрийн дотор Ази тивд 2-рт орох өндөр далан бүхий томоохон систем ч баригдсан байна.

Гэвч зарим талбайн хөрс давсжсан, тоног төхөөрөмж, барилга байгууламж хэт хуучирсан, ус хүрэлцээгүй, ашиглалтын явцад хөрс нь тохиромжгүй болсон зэргээс УТК-ын 1984 оны болон БОХУХ-ны 1993 оны 20 дугаар тогтоолоор нийт 1949 га талбайг газар тариалангийн үйлдвэрлэлээс хасагдсаны дотор Бургас, Шал, Шарын гол, Цахирын тал, Намалзах зэрэгт нийт 522 га талбай бүхий инженерийн хийцтэй 5 систем орсон байна. Эдгээрээс Шаргын гол, Намалзах зэрэг системүүдийн ус хүрэлцээтэй бөгөөд зөвхөн толгойн барилгыг засварлан суваг шуудуу, хашаа хамгаалалтыг сэргээсэн нөхцөлд дахин ашиглах боломжтой юм.

1993 оны эцэст тус аймагт ашиглах боломжтой нийт 3598 га талбай бүхий 12 инженерийн хийцийн услалтын систем ажиллаж байв. Гэвч зах зээлийн харьцаанд шилжсэн, мөн өмч хувьчлалын алдаатай бодлогын улмаас өнөөгийн байдлаар ихэнх системийн услах техник, барилга байгууламж нь хуучрах, тоногдож үрэгдэх зэргээр цаашид бүрэн хүчин чадлаар ажиллах боломжгүй болсноор багахан хэмжээний талбайг гар аргаар услан тариалалт явуулдаг болжээ. Түүгээрч зогсохгүй хоёр байшин, Бижийн, системийн усалгааны далд төмөр хоолойг ухан авсан нь туйлын

харамсалтай зүйл болжээ. Гэвч сүүлийн жилүүдэд дотоод гадаадын төсөл, хөрөнгө оруулалтаар системийн барилга байгууламжийг засварлах, өндөр хүчин чадалтай орчин үеийн услах техникээр шинэчлэх зэрэг нааштай алхмууд Гуулин, Ёлтон, Дагналтайн системүүд дээр хийгдэж байна.

Говь-Алтай аймгийн инженерийн хийцтэй услалтын системийн ашиглалтын оноогийн байдал

	сум		Услалтын системийн нэр	Ашиглалтанд орсон он	Төслийн анхны хүчин чадал /га/	Услалтын системийн байршил солбилцол	1990 оны эхэнд байсан хүч чадал	БОХУХ-ны 1993 оны 20 дугаар тогтоолоор хасагдсан хүч чадал /га/	1993 оны эцэст үлдсэн хүчин чадал /га/	Тайлбар
1	Дэлгэр	1	Гуулингийн тал	1967	1898	46°34', 97°15'	1898	698	1200	Засвар хийгдэж байгаа
		2	Дагналтай	1973	65	46°04', 97°57'	65	20	45	
2	Тайшир	3	Хуримт	1973	135	46°34', 96°45'	135	25	110	Эвдэрсэн
3	Бигэр	4	Хоёр байшин	1970	260	45°38', 97°25'	152	-	152	Эвдэрсэн
		5	Бургас	1973	25	45°40', 97°26'		-		Тоногдсон
		6	Мянгай	1974	100	45°38', 97°38'	100	-	100	
4	Жаргалан	7	Тээл	1973	172	47°17', 95°47'	172	40	132	Эвдэрсэн
		8	Цахирын тал	1969	206	46°51', 96°12'	206	206		Хасагдсан
5	Шарга	9	Шарын гол	1974	179	46°13', 95°12'		-		Хасагдсан
6	Цогт	10	Шал	1975	37	44°53', 96°48'		-		Хасагдсан
		11	Шугуй	1983	662	45°00', 96°55'	644	212	432	
		12	Хаяа	1989	400	45°23', 96°55'	400	-	400	
7	Чандмань	13	Хөрхрөө	1972	267	45°34', 97°47'	267	65	202	
8	Бугат	14	Бижийн гол	1978	578	45°10', 94°27'	578	206	372	
9	Халиун	15	Намалзах	1972	75	45°53', 96°37'	75	75		Эвдэрсэн
		16	Ёлтон	1980	315	45°54', 96°17'	315	13	302	
10	Дарви	17	Харгана түрүү	1983	173	46°45', 94°20'	173	22	151	Эвдэрсэн
			Аймгийн дүн		5547		5180	1582	3598	

Тариалангийн талбайн ашиглалтын бас нэгэн гол үзүүлэлт нь нэгж талбайгаас авч буй ургацын хэмжээ юм. Тус аймаг сүүлийн 4 жилд 1 га талбайгаас үр тариа дундажаар 12,4 цн, төмс 77,55 цн, хүнсний ногоо 117,6 цн, тэжээлийн ургамал 40,1 цн-ийг тус тус хураан авсан нь байгаль цаг уурын илүү тааламжтай нөхцөлд оршдог төвийн бүсийн үзүүлэлттэй ойролцоо байгаа юм.

Энгийн усалгаатай тариалан

Тус аймгийн нутаг дэвсгэр булаг, шанд, баян бүрд элбэгтэй. Эдгээрийг түшиглэн иргэд малчид эртнээс нааш энгийн усалгаатай тариалан эрхлэн ирсэн уламжлалтай билээ.

Сүүлийн жилүүдэд иргэд малчдын санаачлагаар услах боломжтой газрыг шинээр эзэмших нэмж хагалах хуучныг сэргээх услаж бордон үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалах, хадлан бэлтгэх болжээ.

2002 онд тус аймагт явуулсан тариалан хадлангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны материалаас үзэхэд энгийн усалгаатай 935 га газар бүртгэгдсэний дотор Төгрөг, Тайшир сумдын Өгөөмөр, Баюуны буланд 44 га Жаргалан сумын Тээл услалтын системд 4 га газрыг хуучныг сэргээх, өргөтгөх замаар эзэмшижээ. Мөн Эрдэнэ, Тонхил, Шарга, Төгрөг, Халиун сумдууд 31.5 га-г шинээр эзэмших зэргээр нийт 79.5 га газрыг нэмж ашиглаж байна.

II.2.2 Жимс, жимсгэний газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал

Тус аймаг төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоот нийгмийн үед Хөдөө аж ахуйн хоршоологчдын нэрт зохион байгуулагч хөдөлмөрийн баатар Г. Лодойхүү, Ч. Чулуун нарын идэвх санаачлагаар 1960-аад оны эхээр Халиун, Бигэр сумдуудад анхны жимсний цэцэрлэг байгуулж ирсэн түүхэн уламжлалтай билээ.

Жимс жимсгэний цэцэрлэг нь Алтай нутгийн хөрс, цаг уурт гойд тохирсон эдийн засгийн өндөр үр өгөөжтэй шинэ соргог таримал байлаа.

Тус аймгийн говь-цөлийн бүсэд гол горхи, булаг шанд элбэгтэй, дулааны хангамж сайтай, үржил шимт бор хөрстэй баян бүрдүүдийг түшиглэн энгийн болон инженерийн хийцтэй системүүдэд 1995 оны байдлаар 72.3 га-д жимсний цэцэрлэг байгуулсан байна.

Тус аймаг “Жимс” хөтөлбөр боловсруулан жимсний цэцэрлэг байгуулах газар, суулгах жимсний мод бутны төрлийг тогтоон нилээд далайцтай ажиллаж байв. Дээрх хөтөлбөр хэрэгжсэн тохиолдолд жимсний цэцэрлэгийн газар 919.8 га-д хүрэх байлаа.

Монгол улс зах зээлийн харилцаанд шилжиж нийгмийн байдал өөрчлөгдөх явцад уг хөтөлбөрийн ажиллагаа тасалдсан байна. Говь-Алтай аймгийн газрын нэгдсэн сангийн ангиллын тайлангаас үзэхэд Халиун, Цогт сумдуудын жимсний

талбай 22 га-гаар нэмэгдсэний дээр 2005 онд Ёлтонгийн системд чацаргана, үхрийн нүдний суулгац 0.3 га-д тариалсан зэрэг нааштай үзүүлэлтүүд байгаа боловч жимсний цэцэрлэгийн газар аймгийн дүнгээр 1990 оны хэмжээнээс 7.3 га-гаар буурчээ. Үүнд: Алтай, Бигэр сумдад 2.8-8.0 га-гаар багассаны дотор Тайшир, Гуулин, Шарга сумдын нийт 18.5 га жимсний газар ямар нэг хэмжээгээр сүйтгэгдэн аймаг, улсын чанартай мэдээ тайлангаас хасагдах болжээ.

Хүснэгт 20

Аймгийн жимс, жимсгэний газрын өөрчлөлт

№	Сумын нэр	1990 он /га/	2004 он /га/	Талбайн өөрчлөлт /га/		Тайлбар
				нэмэгдсэн	хасагдсан	
1	Алтай	5.8	3.0	-	2.8	
2	Бигэр	28.0	20.0	-	8.0	
3	Халиун	15.0	35.0	20.0	-	
4	Цогт (Баян тоорой)	5.0	7.0	2.0	-	
5	Тайшир	2.5	-	-	2.5	
6	Шарга	10.0	-	-	10.0	
7	Гуулин	6.0	-	-	6.0	
	ДҮН	72.3	65.0	22.0	29.3	

Түүнчлэн одоогоор ашиглаж буй жимсний цэцэрлэгийн талбайн хамгаалалт арчилгаа тордолт муудаж, мод бут, хөгширч өмхрөн зэрлэг ургамалд баригдаж ургац нь буурах болжээ.

II.2.3 Хадлангийн газар, түүний ашиглалт, хамгаалалтын өнөөгийн байдал

Тус аймгийн нутаг дэвсгэр нь өндөр уулс, түүний хоорондох өргөн хөндий, говь цөлөөс тогтсон, хур тунадас дутмаг, өвс ургамал тачир сийрэг зэргээс байгалийн хадлан бэлтгэх талбай хомстой аймагт ордог. Зөвхөн гол горхи булаг шандны хөл тохойг ашиглан зориудаар услах, хашиж хамгаалах, тордож сайжруулах замаар өвс хадлан бэлтгэж байна.

Улсын Газрын Хэрэг Эрхлэх газраас (хуучин нэрээр) өгсөн зөвшөөрлийн дагуу “Геоэкоб” ХХКомпани тус аймгийн нийт сумдын тариалан хадлангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 2002 онд хийсний дээр хадлан, тариалангийн газрын тооллогыг хамт явуулжээ.

Тооллогын материалаас үзэхэд:

Чандмана, Цээл, Тайшир, Бигэр, Есөнбулаг, Бугат сумдуудад 304 га газарт суваг шуудуу татах, бут довонг тэгшлэх зэргээр сайжруулан шинээр хадлангийн талбай болгон ашиглан үр дүнд хүрчээ.

Аймгийн 2005 оны Газрын нэгдсэн сангийн ангиллын тайлангаас үзэхэд тус аймаг 2266 га хадлангийн талбайтай, түүний 79.4 хувь буюу 1800 га нь зөвхөн Шарга сумын нутаг Шарын цагаан нуурын сав газарт оршдог.

Бигэр, Бугант сумууд 41-100 га хадлангийн талбайтай нь аймагтаа томоохонд ордог ажээ. Есөнбулаг, Тайшир сумдад 6-22 га талбайтай, Алтай, Баян-Уул, Дарви, Дэлгэр, Жаргалан, Төгрөг зэрэг 8 сум хадлангийн ямар ч газаргүй байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын 2005 оны жилийн эцсийн мэдээлэлд тэмдэглэснээр тус аймаг өнгөрсөн онд 4493.5 тн хадлан бэлтгэсэн байна. Үүний 6.7 хувь болох 300 тн-ыг дээрх Шарга сум бэлтгэсэн бол 31.4 хувь буюу 1412.3 тн-ыг нь хадлангийн талбайгүй хэмээгдэх 8 сум бэлтгэжээ.

Халиун сумын иргэн хувиараа аж ахуй эрхлэгч Т. Гал, Х. Лиза (нэг гэр бүлийн) нар өөрсдийн жимс, ногооны газрын усалгааны шуудууны орчмыг усалж тордон хадлан бэлтгэж малтай иргэдэд борлуулдаг тухайгаа ярьж байв. Энэ мэтчилэн Цогт, Цээл зэрэг сумдад бололцоотой газрыг хашин хамгаалан дэрс бутыг тэгшлэх, услах зэргээр ургацыг нэмэгдүүлж өвс хадлан бэлтгэн зах зээлд борлуулах бизнесийн эхлэл тавигдаж буй нь сайшаалтай байв.

II.2.4 Бэлчээрийн газар, түүний ашиглалт хамгаалалтын байдал

Говь-Алтай аймаг 8704619.8 га бэлчээрийн эдэлбэр газартай энэ нь аймгийн нутаг дэвсгэрийн 61.6 хувь, хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 99.89 хувийг тус тус эзэлдэг. Үүнээс 3392717.5 га буюу 38.98 хувь нь өвлийн, 5311902.3 га буюу 61.02 хувь нь зун намрын бэлчээр эзэлдэг. Аймгийн бэлчээрийн газрын 68 хувь нь экологийн эмзэг тогтоцтой говь, цөл, хээрийн бүсэд хамрагдана. Хөрсний үржил шим харьцангуй хангалтгүй, ургамлын бүрхэвч сийрэг, тачир ил задгай усны эх үүсвэр нь хомсын зэрэгцээ сүүлийн жилүүдэд цаг агаарын дулаарлын улмаас нутгийн 60 гаруй хувь буюу 5419 мянга га бэлчээр цөлжилтөнд өртсөн мэдээ байдаг. Тус аймаг нь байгаль цаг уур, газар зүйн онцлогоос хамааран хэд хэдэн бүс бүслүүрт хуваагддаг. Монгол-Алтайн нурууны мөнх цас оргилууд, түүний салбар өндөр уулс, тэдгээрийн хоорондох нам хотгор өргөн хөндий, говь цөлүүд хойноос урагш ээлжлэн тогтсон байдаг. Эдгээр өвөрмөц нөхцлийг харгалзан тус аймгийн бэлчээрийн эдэлбэр газрыг доорхи байдлаар ангилан үздэг. Үүнд:

1. Өндөр уулын
2. Уулын хээрийн
3. Хээрийн
4. Цөлөрхөг хээрийн
5. Цөлийн гэсэн 5 үндсэн бүлэгт хуваан үзсэн байна.

Өндөр уулын бэлчээр: Аймгийн нутаг дэвсгэрийн төв хэсгээр баруун хойноос зүүн урагш Монгол-Алтайн гол нурууны үргэжлэл, Мянган угалзын нуруу, Бүс хайрхан, Алаг хайрханы уулс, Их хүрэн, Баян-Өндөр уул, Харазаргын нуруу

Бурханбуудай уул, Гичгэний уруу болон Говь-Алтайн нурууны баруун хэсгийн уулсууд Тонхил, Бугат, Төгрөг, Халиун, Цээл, Цогт, Бигэр, Эрдэнэ, Дэлгэр, сумдын нутаг дамнан тогтсон байдаг.

Алтайн гол нуруутай нэгэн чиглэлд тогтсон түүний салбар уулс болох Хасагт хайрхан, Хантайшир, Сэрхийн нуруу нутгийн хойд хэсгээр Баян-Уул, Жаргалан, Тайшир, Есөнбулаг сумдын урьд хэсэг, Шарга, Халиун, Бигэр сумдын хойд талаар оршдог. Мөн Дарви, Аж богд зэрэг салбар нурууны Дарви, Алтай сумын нутгийн төв хэсгээр байрладаг онцлогтой. Монгол-Алтай нуруу, түүний салбар уулсын д.т.д 2000-2500 метрийн өндөрт өргөгдсөн тэгшивтэр зоо, бага шиг налуу хажуу өндөр уулын бэлчээр багагүй талбайг эзлэн тархсан. Тус аймгийн нутаг дэвсгэр дэх өндөр уулын бэлчээр нь нийт бэлчээрийн 6.8 хувийг эзэлдэг.

Энэ бэлчээрийг ихэвчлэн дулааны улиралд зуслангийн чиглэлээр ашигладаг. Хэт их халуун биш, ялаа шумуул багатай зэрэг нь мал сүрэг тавтай идээшлэн тарга тээвэрэг авахад таатай нөхцлийг бүрдүүлдэг.

Хасагтхайрхан, Хантайшир, Сутай, Алагхайрхан, Харазрагын нурууны уулсаар бушилз-үетэнт, ботууль-алаг өвст, жижиг үетэн-алаг өвст бүлгэмдлүүд зонхилон тохиолддог. Сутай, Ажбогд зэрэг уулын орой нь хад цохио элбэгтэй, тэнд хаг-хөвдөг эвшил цөөн тохиолдоно. Тэнд ботууль, шивээт хялгана, дааган сүүл, хазаар өвс, агь наптуул, энгийн буржгар, алтайн гол гэсэр зэрэг ургамлууд ургадаг.

Уулын хээрийн бэлчээр: Энэ бэлчээр нь дээр дурьдсан уул нуруудын нам дуу бэл хормой, болон бэсрэг уулсын дээд хэсгээр тархсан байна.

Аймгийн нутаг дэвсгэрийн нийт бэлчээрийн 27.6 хувийг эзэлдэг. Уулын хээрийн бэлчээр нь бүх төрлийн малд тохиромжтой, жилийн аль ч улиралд ашиглах боломжтой зэрэг нь өндөр ач холбогдолтойд тооцдог.

Уулын хээрийн бэлчээрт ботууль-үетэнт, жижиг үетэн-алаг өвст, үетэнт-агьт монгол өвс-ерхөгт, саман ерхөг-алаг өвст төрлүүд зонхилон тархжээ. Энд ботууль, хялгана, саман ерхөг, агь, гичгэнэ, шувуун тарна, хөх яргуй үлд өвс зэрэг ургамлууд ургадаг.

Цөлөрхөг хээрийн бэлчээр: Монгол-Алтай нуруу болон, Хасагтхайрхан, Тайшир, Сэрхийн нурууны ар өвөр, Тонхил, Хулан, Хутаг нуурын эргэн тойрон, Тайшир, Дэлгэр, Чандмань Хүйсийн говийн хонхорын эргэн тойрон Тайшир, Дэлгэр, Чандмань, Эрдэнэ, Тонхил сумын нутгаар тархсан байдаг. Тус аймгийн нутаг дэвсгэрийн 32.6 хувьд цөлөрхөг хээрийн бэлчээр эзэлдэг нь бусад төрлийн бэлчээрээс нилээд давамгайлж байгаа юм. Ургамал нөмрөгийн ерөнхий төрхийг цөлөрхөг хээрийн монгол өвс-баглуурт, тэсэг, харгана оролцсон монгол өвс-боролзойт, монгол

өвс-таанат, уулын хээрийн сийрэг ургамалтай хялгана-үетэнт, үетэн-агь-алаг өвст, ерхөг-алаг өвст, бүлгэмдлүүд бүрдүүлдэг.

Энд шивээт хялгана, монгол өвс, ботууль, саман ерхөг, дааган сүүл, агь, таваг, таана, тэсэг, баглуур, цагаан дэмэг, боролзой зэрэг ургамлууд элбэг тохиолдоно. Цөлөрхөг хээрийн ургамал тачир сийрэг боловч бүх төрлийн малд тохиромжтой.

Цөлийн бэлчээр: Алтай өвөр говь, зүүн гарын говь (цөл), Тонхил, Бугат, Алтай, Цогт, Эрдэнэ сумдын өмнөд хэсэг, Монгол-Алтай нурууны арын Шарга, Хүйс, Бигэр нуур зэрэг хонхорын эргэн тойроны дэвсэг, тэгшивтэр газраар өргөн уудам нутаг дэвсгэрийг хамран нийт бэлчээрийн 26.8 хувийг эзлэн цөлийн бэлчээр тархсан байна. Цөлийн бэлчээрийн ургамал нь тачир сийрэг боловч шимт чанар сайтай бүх төрлийн мал, ялангуяа тэмээн сүрэгт нэн тохиромжтой, намрын улиралд ашиглахад илүү зохимжтой.

Зүүн гар, Алтайн өвөр говь, Шарга, Бигэр Хүйсийн хотгороор бударганат дэрст, баглуур-бударгана-сийрэг загт, холимог сөөгт бүлгэмдэлд бэлчээр зонхилно. Нам хотос газраар шар, бор бударганууд дэрс баглуур, тэсэг таана, улалж зэрэг ургамлууд голчлон ургадаг.

Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд бэлчээрийн төрөл, тархац, тэдгээрийн ургамлын бүрэлдэхүүн ургац зэргийг сум бүрээр дэлгэрэнгүй тайлбарлан зурагт тусган өгсөн тул энд давхардуулах шаардлагагүй хэмээн үзсэн болно.

II.2.6 Бэлчээрийн даац ашиглалт

Бэлчээр даац ашиглалтын үзүүлэлт нь бэлчээрийн талбайн 1 га-гийн ургац, уг бэлчээрт бэлчээрлэж буй малын төрөл тоо толгой, тухай бүс нутагт нэг хонин толгой мал бэлчээрээс ирэх өвсний хэмжээ зэргийн харилцан хамаарлаар илэрхийлэгддэг үзүүлэлт юм. Бэлчээрийн даац ашиглалтын түвшин 95-105 хувийн хооронд хэлбэлзэж байвал бэлчээрийн даац ашиглалт хэвийн бөгөөд энэ нөхцөлд бэлчээрийг жигд хуваарьтай ашиглаж чадвал бэлчээрийн талхлагдал үүсэхгүй гэж үздэг. Харин бэлчээрийн даац ашиглалтын түвшин 95 хувиас бага нөхцөлд даац ашиглалтын түвшин хангалтгүй, малын тоо толгойг зохих хэмжээгээр нэмэгдүүлэх нөөц бэлчээртэй гэж тооцдог.

Бэлчээрийн даац ашиглалтын хэмжээ нь 105 хувиас дээш бол даац хэтэрсэн, бэлчээр талхлагдах нөхцөл бүрдсэн гэж үздэг. Тус аймгийн нийт сумдын бэлчээрийн тэжээлийг нөөцийг сүүлийн 15 жилд хоёр удаа тодорхойлжээ.

Анх удаа 1900-1991 онд газар зохион байгуулалтын ерөнхий схемийн судалгаагаар, дараагийн удаа нь 2001-2002 онуудад “Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаагаар” тодорхойлсон байна.

Бэлчээрийн даац ашиглалтын түвшин

№	Сумдын нэр	Бэлчээрийн чадавхи /мянган хонин толгой/	2005 оны малын тоо /мянган хонин толгойд шилжүүлснээр/	Бэлчээрийн даац ашиглалтын хувь (+ -)
1	Алтай хот	301.9	101.1	33.5
2	Баян - Уул	344.2	176.1	51.2
3	Бигэр	130.6	103.2	79.0
4	Бугат	302.0	145.3	51.8
5	Дарви	133.0	148.2	111.4
6	Дэлгэр	172.4	123.8	71.8
7	Есөнбулаг	80.8	99.9	123.6
8	Жаргалан	104.3	147.3	141.2
9	Тайшир	121.2	77.8	64.2
10	Тонхил	341.6	194.3	56.8
11	Төгрөг	149.2	100.5	67.3
12	Халиун	148.4	143.5	96.7
13	Хөх морьт	101.6	88.1	86.7
14	Цогт	349.1	156.8	44.9
15	Цээл	139.9	134.7	96.3
16	Чандмань	137.0	70.5	51.4
17	Шарга	183.2	130.2	71.1
18	Эрдэнэ	456.0	104.2	22.8
	Дун	3696.4	2245.4	60.7

Дээрх хүснэгтээс үзэхэд бэлчээрийн даац ашиглалтын аймгийн дундаж түвшин 60,7 хувьтай байгаа нь “Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа” хийхдээ ГИДЦГ-ын бэлчээрийг хамруулж тооцсоноос Алтай, Бугат, Тонхил, Цогт, Эрдэнэ сумуудын бэлчээрийн газар нэмэгджээ гэж үзэж болно.

Бэлчээрийн даац ашиглалт Эрдэнэ суманд 22,8 хувь, Алтай суманд 33,5 хувь Цогт суманд 44,9 хувь тус тус тооцогдсон нь үүний жишээ болж байна. Чандмань, Дэлгэр, Шарга, Төгрөг, Тайшир, Бигэр зэрэг сумдын бэлчээр ашиглалт 64,2-79,0 хувьтай нь малын тоо толгойг зохих хэмжээнд өсгөх нөөц бололцоотой болохыг харуулж байна. Мөн Халиун, Цээл сумдын бэлчээрийн даац ашиглалтын түвшин 96,3-97,7 хувь байгаа нь даац ашиглалт хэвийн болохыг харуулж байгаа бол Дарви, Есөнбулаг, Жаргалан сумдад 111,4-141,2 хувьтай байгаа нь бэлчээрийн даац ашиглалт хэтэрсэн, бэлчээр талхлагдах нөхцөл бүрдсэн болохыг харуулж байна.

Аймгийн нийт бэлчээрийн 17,6 хувь талхлагдсанын дотор Шарга, Баян-Уул, Дарви, Төгрөг сумуудын нийт бэлчээрийн 26,3-33,9 хувь нь талхлагджээ. Мөн нийт 231281 га бэлчээр элсэнд дарагдаж 82682 га бэлчээрт үлийн цагаан оготоно тархсан байна.

Талхлагдсан хөрс, ургамлын бүрхэвч нь доройтсон бэлчээр үлийн цагаан оготны амьдрах таатай орчин болдгийг анхаарах нь зүйтэй юм. Автомашины зэрэгцээ олон салаа зам бэлчээрт хохирол учруулсаар ирсэн бөгөөд тус аймагт 45313 га бэлчээр автогений элэгдэлд өртсөн байна. Алтай, Баян-Уул, Бугат зэрэг сумуудад

нийт 1710,116 га бэлчээр ус хүрэлцээгүй, алслагдсан зэрэг шалтгаанаар ашиглалтгүй байгаа юм.

Хүснэгт 22

Бэлчээрийн нийт талбайд талхлагдсан бэлчээрийг харьцуулсан хувь

№	Сумдын нэр	Бэлчээрийн газар /га/	Талхлагдсан бэлчээр /га/	Бэлчээрийн нийт талбайд харьцуулсан хувь
1	Алтай хот	866225.3	124659.0	14.4
2	Баян - Уул	581957.7	156999.0	26.9
3	Бигэр	351301.4	39657	11.3
4	Бугат	728405.9	100670	13.8
5	Дарви	302847.4	102906	33.9
6	Дэлгэр	552239.4	68073	12.3
7	Есөнбулаг	209055.8	28388.0	13.6
8	Жаргалан	349625.4	42867.0	12.6
9	Тайшир	389150.8	94840	24.4
10	Тонхил	516420.1	109194	21.1
11	Төгрөг	292060.4	80968	27.7
12	Халиун	437242.6	110389	25.2
13	Хөх морьт	628846.8	85510	13.6
14	Цогт	604149.5	50285	8.3
15	Цээл	548113.7	81515	14.8
16	Чандмань	452900.5	62739	13.8
17	Шарга	487426.6	128281	26.3
18	Эрдэнэ	406653.5	63796	15.6
	Дун	8704619.8	1531742	17.6

Хүснэгт 23

Говь-Алтай аймгийн бэлчээрийн талхлагдаж, элсэнд дарагдаж бусад нөлөөлөлд өртсөн байдал

№	Сумдын нэр	Нөлөөллийн үзүүлэлтүүд /га/						Ашиглагдахгүй байгаа	
		автоген	техноген	Бохирд-сон	хортон мэрэгчдийн хөнөөл	талхлагдсан	Элсэнд дарагдсан	ус хүрэлцээгүй	алслагдсан
1	Алтай хот	-	-	5	38424	124659	39262	590975	-
2	Баян - Уул	56	-	35	-	156999	-	106104	30963
3	Бигэр	3701	437	5	9945	39657	3701	-	-
4	Бугат	110	-	-	-	100670	120	55745	96114
5	Дарви	145	-	11	-	102906	-	23404	-
6	Дэлгэр	7490	186	5	1618	68073	1648	-	-
7	Есөнбулаг	5275	1322	10	14691	28388	-	-	-
8	Жаргалан	3722	-	5	-	42867	-	-	-
9	Тайшир	5042	-	-	-	94840	312	-	-
10	Тонхил	165	-	-	-	109194	-	-	-
11	Төгрөг	2975	-	4	-	80968	-	-	-
12	Халиун	2935	-	6	-	110395	8470	-	-
13	Хөх морьт	70	-	-	-	85510	115000	87519	27172
14	Цогт	1867	562	5	9164	50285	24086	-	-
15	Цээл	3885	-	3	4963	81515	5120	-	-
16	Чандмань	6437	415	5	3877	62739	-	-	-
17	Шарга	163	-	151	-	128281	-	-	-
18	Эрдэнэ	-	-	-	-	63796	33492	-	-
		45343	2922	270	82682	1531742	231281	863747	846369

II.2.7 Цөлжилт ба элсний нүүлт

Цөлжилт гэдэг нь байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хүчин зүйлсийн үйлчлэлийн дор газрын биологийн чадавхи буурах үзэгдлийг хэлнэ. Энэ нь

өргөн хэмжээний нутаг дэвсгэрийг хамарч, хэдэн арван жил үргэлжлэх байгалийн хувьслын үйл явц юм.

Дэлхий нийтийн хэмжээнд эмзэг экосистем бүхий бүс нутгийн цөлжилтийн үйл явцыг сааруулах зорилгоор 1992 онд НҮБ-ын цөлжилттэй тэмцэх конвенцийг баталсан байна.

НҮБ-ын конвенцэд цөлжилтийг хуурай, хуурайвтар, чийг дутмаг буюу хур тунадас, чийгийн ууршилтын харьцаа 0.05-0.65 байх нутгийг хамруулдаг.

Манай улс 1996 онд конвенцэд нэгдэн орж, “Монгол улс цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг УИХ-аар батлуулжээ. Уг хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл явц, цөлжилтийн мониторинг болон цөлжилтийг сааруулах арга чиглэлийн судалгааг туршилт үйлдвэрлэлийн хүрээнд явуулах зэрэг эхлэлийн байдалтай ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт “Доройтож буй газар нутгийг цөлжилтээс урьдчилан сэргийлэх, сааруулах арга хэмжээ авна” хэмээн тусгажээ.

Монгол орон дэлхийн бөмбөрцгийн орших бүсдээ хамгийн хуурай уур амьсгалтайд тооцогдох бөгөөд ихэнх нутгийнх нь хур тунадас ууршилтын харьцаа 0.05-0.65-ын хооронд хэлбэлздэг нь цөлжилтөд хялбар өртөх эмзэг оронд багтдаг.

Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэр нь байгаль, газарзүйн байршлаараа ялгавартай экологийн орчинд хамрагдахын сацуу эмзэг тогтоц бүхий экосистемийн төрөл болдгоороо онцлогтой юм.

Сүүлийн жилүүдэд Монгол орны говь, цөлийн бүсийн олонхи төв суурин газрын орчин тойронд цөлжих үйл явц идэвхжиж, ургамлан нөмрөг сийрэгжих, бүрмөсөн устаж үгүй болох, шороон шуурга шуурах, элсний нүүлт хөдөлгөөн ихсэх, элсэн хунгар тогтох зэргээр илрэх боллоо.

Говь нутгийн экосистемд суурингийн болон техникийн, үйлдвэрлэлийн ба ахуйн гаралтай угаа тортог, хог хаягдал орчны бохирдлын гол эх үүсвэр болдог.

Суурин газруудад үндсэндээ амьд хөрс байхгүй болжээ. Хот ба бусад сууринг тойрсон зам харгуй, суурингийн ногоон зурвасгүй нүцгэн газрууд, гэр хорооллын дунд байх халцгай нь үер усны үед хөрс урсах, гуу жалга үүсэх маягаар гадаргын төлөв байдал өөрчлөгдөхөд хүргэж, угаас ядуу ургамал бүрхэвч өдрөөс өдөрт багасаж байна.

Монголчуудын уламжлалт мал аж ахуй эрчимжиж, хагас суурьшмал хэлбэрлүү орох тутам (бэлчээр сэлгэхээ больж нэг нутгаа талхлах) өвөлжөө бууц орчмын хүний үйл ажиллагаа, малын гаралтай бохирдол элбэгшин хөрсний эвдрэлд хүчтэй нөлөөлөхийн хамт ургамал бүрхэвчийг талхлан хөл газрын ургамал түрж орох боломж өгч орчны бохирдлыг улам их болголоо.

Суурин газрын мал хөрсний эвдрэлд хүчтэй нөлөөлдөг. Тэд цухуйсан ургамал болгоныг идэхийн зэрэгцээ дов сондуулыг мэрэх, мод бут зулгаах, хугалах зэргээр хөрс тогтоох боломжид сөрөг нөлөө үзүүлдэг. Ялангуяа ямаа энэ жишээний гол бай болно.

Тус аймгийн Хөхморьт сумын төв, Баянтоорой тосгонд энэ үзэгдэл хэдийнээ эхэлсэн байна. Ялангуяа Хөхморьт сум цөлжилтийн нэн хүчтэй зэрэглэлд орох болжээ.

Хөх морьт сумын нийт нутгийн 38,3 хувь буюу 242,0 мян.га талбайг Монгол элс эзэлдэг. Бэлчээр нутаг дутагдалтайн улмаас уг элсний өмнөд хаяаны ялимгүй ширэгжсэн газрын бэлчээрийг ялангуяа хавар, зун, намрын улиралд ээлж дараалалгүй ашигласнаас элсний гадаргуу малын хөлөөр суларах, ингэснээр сул элс ихсэх нөгөө талаар мал суларсан элсэн хөрснөөс ургамлыг үндсээр нь сугачих зэрэг нь элсний нүүлт эрчимжих үндсэн нөхцөл болжээ. Түүнчлэн ус ундандаа татагдаж бага хэмжээний газар олон мал бөөгнөрөх нь хөрсний бүтэц болон ургамлын бүрхэвчийг доройтуулах сул элс үүсэхэд хүргэсэн байна.

Ингэснээр сүүлийн 40-50 жилийн дотор Монгол элсний өмнөд хаяа даган 140 км урт, 10-35 км өргөн зурвас газрын бэлчээр элс, элсэн манханд дарагджээ.

Монгол элсний дунд урьд нь элсгүй байсан арал чөлөө бүхий 28,5 мян.га нутаг бэлчээр үүнд өртөж олон арван хашаа, бууц, худаг, уст цэгүүд элсний нүүдэлд дарагдаж үгүй болжээ.

Элсэрхэг хөрстэй газрын бэлчээрийн даацыг хэтрүүлэн ээлж сэлгээ, улирлын хуваарьгүй хэт давтан ашиглах, харгана, шаваг зэрэг элсийг сайн барьж бэхжүүлдэг бутлаг ургамлыг түлшний зориулалтаар хэт ихээр түүж устгах нь сул элс үүсэх улмаар экологийн тэнцвэр алдагдан элс хөдөлгөөнд орж, зонхилох салхины дагуу эрчимтэй нүүхэд хүргэсэн байна.

Тус аймаг 1941 га талбай атаршуулж, жил бүр 1943,9-1972,1 га талбайг өнжөөх нэрийн дор тариалалт хийхгүй орхигдуулдагийн зэрэгцээ нийт бэлчээрийн 60 гаруй хувь нь цөлжилтөнд ямар нэг хэмжээгээр өртсөн гэсэн мэдээ байдаг.

II.2.8 ХАА-н барилга байгууламжийн газар

Хөдөө аж ахуйн зориулалтын газрын доторхи ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газарт хот тосгон бусад суурины тэг гортигийн гадна орших бэлчээр усжуулалтанд зориулагдсан төрөл бүрийн худаг (гүн өрмийн, богино яндант, бетон хашлагат, энгийн уурхайн) болон өвөлжөө, хаваржааны зэрэг газрууд хамрагдана.

Тус аймгийн ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газарт 1704 га талбай бүртгэгдсэн байна. Үүний 305.2 га нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай

газар (өвөлжөө хаваржааны доорхи газар), газар тариалангийн үйлдвэрлэлийн зориулалттай газар 1398.8 га-г эзэлж байгаа юм.

Халиун, Дэлгэр, Эрдэнэ, Чандмана, Дарви сумдууд 20,1-35,7 га мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтын газартай бол Алтай, Тонхил сумууд 7,7-9,1 га газартай ажээ, Мөн Шарга, Дэлгэр, Эрдэнэ сумууд 108,1-133,8 га газар тариалангийн үйлдвэрлэлийн зориулалтын газартай байна.

Дүгнэлт

Говь-Алтай аймгийн хөдөө аж ахуйн эдэлбэр газрын ашиглалт, хамгаалалтын одоогийн байдлыг судалсны үндсэн дээр дараахи дүгнэлтүүдийг гаргаж байна. Үүнд:

1. Өмнө нь ашиглаж байсан усалтын системүүдийг сэргээн засварлан ашиглалтанд оруулах замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг өргөтгөх шаардлагатай.

2. Жимс жимсгэний талбайн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, урьд өмнө нь хэрэгжүүлж байсан “Жимс” хөтөлбөрийг өнөөгийн нөхцөлд тохируулан шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх.

3. Хадланд ашиглаж байгаа газрыг тодорхой хариуцсан эзэнтэй болгох, хашиж хамгаалах, бууцаар бордох услах замаар бололцоотой талбайгаас жилд 2 ургац авах, нөгөө талаар хадах хугацааг ургамлын вегетацийн хөгжлийн үе шатуудад тохируулан хадах, улмаар ургамлын төрөл зүйл цөөрөх, тусгаг бүрхэц багасах зэрэг сөрөг нөлөөлөл гарахаас сэргийлэх, бэлтгэсэн өвсийг зах зээлд борлуулах нөхцлийг бүрдүүлэх.

4. Аймаг сумын төвийн орчимд ялангуяа зун намрын улиралд олон айл өрх зах зээлд ойртох нэрээр хуваарь сэлгээгүй нутагладгаас бэлчээрийн даац хэтрэх, талхлагдах явдал даамжрах болов. Мөн гол горхи, булаг шанд, худаг зэрэг уст цэгүүдийн ойролцоохи бэлчээр нэгэн адил талхлагдах болжээ.

Иймд ашиглалтгүй болсон худгийг гадаад, дотоодын төслийн хөрөнгөөр засварлаж буй явцыг улам эрчимжүүлэх, бололцоотой газарт шинээр хөв байгуулах, хуучныг сэргээх шаардлагатай.

II.3 ХОТ ТОСГОН БУСАД СУУРИНЫ АНГИЛЛЫН ГАЗАР, ТҮҮНИЙ АШИГЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

II.3.1 Хот тосгон бусад суурины ангиллын газрын бүтэц

Тус аймгийн хот, тосгон бусад суурины ангиллын газарт аймгийн төв Алтай хот, 18 сум, 2 тосгон, 83 багийн төвүүд болон нүүрсний уурхайн газар, тэдгээрийг түшиглэсэн суурингууд, орон нутгийн чанартай амралт, рашаан сувилал, жуулчны баазын газрууд хамрагдаж байна.

Суурин газар нь үйлдвэр аж ахуйн үйл ажиллагаа явуулах, хүн амын ая тухтай зөв боловсон амьдрах байгаль эдийн засгийн цогц нөхцөл болох төдийгүй аймаг, сум тосгоны засаг захиргаа, соёл боловсрол, эрүүл мэнд, ахуй үйлчилгээ зам харилцааны зангилаа төв нь болсоор ирсэн. Хот суурин нь нийгмийн хөгжил, байгалийн нөөц, зах зээл, үйлчилгээний хүрээнээс хамааран хөгжлийн түвшин харилцан адилгүй байдаг.

Хүн ам суурьшин үйл ажиллагаа явуулж буй хот суурингийн доорхи газрын суурьшлын бүс газарт хамруулдаг. Газрын сангийн ашиглалт хамгаалалтын менежентийн үзүүлэлтээр 15000-аас дээш оршин суугчидтай төвлөрсөн суурин Алтай хотын нутаг дэвсгэр нь хотын газрын ангилалд багтаж байна. Сумын төв болон бусад жижиг төвүүд нь оршин суугч хүн амын тооноос хамааран нутаг дэвсгэрийн хувьд тосгоны болон суурин газарт, ихэнхдээ хөдөөний тосгонд хамрагдаж байна.

Хүснэгт 24

Хот тосгон бусад суурины газрын бүтэц (га-гаар)

Ангиллын нэр	2006 оны тайланд	Эзлэх хувь (%)
Хот тосгон бусад суурины газар -бүгд (га)	14157,3	100,0
Барилга байгууламжийн доорхи газар (иргэд аж ахуйн нэгжүүдийн эзэмшилд)	443,12	3,1
Нийтийн эдэлбэрийн газар	12649,69	89,4
Үйлдвэр уурхайн, газар - бүгд	721	5,1
Гэр хорооллын газар - бүгд	343,49	2,4

Дээрхи хүснэгтээс харахад хот тосгон бусад суурины ангиллын газрын 89,4 хувь буюу 12649,69 га газрыг нийтийн эдэлбэр газар эзэлж байна. Гэр хорооллын газар, хот, тосгон бусад суурины ангиллын нийт газрын 2,4 хувийг эзэлдэг.

Сүүлийн жилүүдэд сумын төвүүдээс нүүсэн иргэдийн (гэр хорооллоос) эзэмшил газрын хэмжээг жил жилд нь хасаж бүртгэх асуудал хангалтгүй явагдаж иржээ.

Нийтийн эдэлбэрийн газраас 86,7 га хасагдсан нь эзэмшил, ашиглалтанд олгогдоогүй сул чөлөөт газраас бусад ангиллын газар шилжүүлсэнтэй холбоотой юм.

Говь-Алтай аймаг нь газар чичирхийллийн идэвхтэй бүсэд оршдог. Иймд газар чичирхийллийн нөхцлийг нутаг дэвсгэрийн үнэлгээнд чухалчлан авч үзлээ. Хот

байгуулалтын хувьд газар чичирхийллийн хүчин зүйлийг 0-6 баллын нөхцөлд нэн тохиромжтой, 7-8 балл хязгаарлагдмал тохиромжтой, 9-өөс дээш баллын ангилалд тохиромж муутайд тооцдог.

Хот тосгон, суурин газрын төлөвлөлтөнд газар чичирхийллийн үнэлгээний ангиллаар дундаас дээш өндөр уулархаг нутаг тухайлбал Алтай, Хангай болон газар хөдлөлөөс үүссэн эртний гүний хагарлын дагуухи газар нутгийг тохиромж муутайд тооцдог. Түүнчлэн газар чичирхийллийн идэвх тектоникийн хүчтэй хөдөлгөөнт бүс дэх Монгол-Алтайн нурууны нутаг дэвсгэр бүхэлдээ, Алтайн өвөр говийн нутаг дэвсгэрийн 60.0-90.0 хувь нь хот байгуулалтанд тохиромжгүй ангилалд хамрагддаг.

Хүснэгт 25

Хот, суурин газруудын хот байгуулалтын үнэлгээ

д/д	Хот суурины нэр	Усан хангамж	Олон жилийн цэвдэг хөрс	Газар чичирхийлэл /балл/	Ул хөрс		Хөрсний усны түвшин /м/	Үерг автагдсан байдал	Газрын гадаргын налуу %/	Барилгын уур амьсгалын бүс	Далайн түвшнээс өргөгдсөн байдал /м/	Бусад
					Хөрсний төрөл	Норматив ачаалал (кг/см ²)						
1	Алтай хот	+		9-10	хөөлт	3.5	1.4		0.1	III	1400	
2	Баян - Уул	+		9		3.0	-			II	1800	
3	Бигэр	+		8	хөөлт	3.0	5.6		1.6-4.5	II	1500	
4	Бугат	+		9	хөөлт	3.0	2.6-7.3		5.0	II	2100	
5	Дарви	+		8			0.5-5.0		2.0	II	1600	
6	Дэлгэр	+		7		3.0-4.0	2.8		0.9	II	1200	
7	Жаргалан	+		7		3.0	5.0-9.5		1.0	III	1300	
8	Тайшир	+		7		3.5	-		1.5-2.0	III	1600	жалгатай
9	Тонхил	+		8		3.0	-		3.0	II	2200	
10	Төгрөг	+		8		5.0	-		3.0	II	2900	
11	Халиун	+		9		-	-		1.0	II	1400	
12	Хөх морьт	+		7	хөөлт	-	1.5-2.7		0.09	II	1400	
13	Цогт	+	+	9		3.0	-			II	2300	жалгатай
14	Цээл	-		8		3.5	5.6		3.0	II	1500	
15	Чандмань	+		9		3.0	1.5-3.1		0.6	II	2200	намагтай
16	Шарга	+		7		-	-			II		
17	Эрдэнэ	+		8-9		-	2.8-5.0		10.0	II	2400	
18	Алтай	хяз	+	9	хөөлт	-	0.8		2.0	II	2100	

Хүснэгтээс үзэхэд Тайган, Буянбат, Цагаан-Олом, Сайн-Уст, Шарга, Жаргалант, Дарви, Зүйл, Төгрөг, Цээл тосгонуудад газар чичирхийллийн хязгаарлагдмал тохиромжтой, Алтай хот, Баян, Баянгол, Халиун, Тахилт, Галшанд, Сангийн-Далай, Баян-Овоо тосгод газар чичирхийллийн тохиромж муутай үнэлгээний бүсэд оршдог болно.

Ундны цэвэр усаар тогтвортой хангагдаж байх нь иргэдийн эрүүл энх явах эн тэргүүний хэрэглээ нийгэм эдийн засгийг тодорхойлогч хамгийн чухал үзүүлэлт юм.

Тус аймгийн ихэнх тосгон суурин төвүүдэд ундны усан хангамж дутагдалтай, одоогийн хэрэглэж буй ус нь эрдэсжилт ихтэй, ундны усны хэрэгцээ шаардлага хангахгүй явж иржээ.

Хүснэгт 26

**Ундны цэвэр усны хангамж дутагдалтай зарим сумд,
тэдгээрт авах арга хэмжээний жагсаалт**

	Сумын нэр	Усны эх үүсвэрийг шийдвэрлэх (2010 он хүртэл)	Ундны ус		
			Зөөлрүүлэх	Эрдэсжилтийг бууруулах	Магнийг бууруулах
1	Есөн булаг (Алтай хот)	+	+		+
2	Хөх морьт	+			+
3	Цээл	+			
4	Дарви		+		+
5	Төгрөг		+		+
6	Бигэр		+		
7	Чандмань		+	+	+
8	Тонхил		+		
9	Эрдэнэ		+	+	+
10	Цогт		+		+
11	Алтай		+		
12	Халиун	+			+
13	Баян уул				+
14	Дэлгэр				+
15	Жаргалан				+
16	Шарга				+
	Дүн	4	9	2	12

Халиун, Тахилт зэрэг тосгоны иргэд өнөөг хүртэл ил задгай усыг ундандаа хэрэглэсээр байна. Төв суурин газрын ундны усны дээрх сөрөг нөлөө нь суурьшигч иргэдийн эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй юм.

Ихэнх сумдын ундны ус эрдэсжилттэй. Есөнбулаг, Хөх морьт, Цээл, Халиун зэрэгт одоо хүртэл ундны усны эх үүсвэрийг шийдвэрлэгдээгүй явж ирсэн байна.

Дээрх хүснэгтээс үзэхэд 4 сум усны эх үүсвэрийг шийдвэрлэх бусад 23 сумын /давхардсан тоогоор/ ундны усыг зөөлрүүлэх, эрдэсжилтийг бууруулах шаардлагатай байна. Газар зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө боловсруулах явцад усны эрдэсжилт их, газрын чичирхийллийн магадлал өндөртэй зэрэг нь хот байгуулалтын үнэлгээнд сөрөг нөлөө үзүүлдэг.

II.3.2 Хот тосгон бусад суурины тэг гортигийн доторхи газрын ашиглалт хамгаалалтын байдал

Хот тосгон бусад суурины ангиллын газарт хамгийн их талбай эзлэх хэсэг нь хот тосгон бусад суурины тэг гортигийн доторхи газар бөгөөд энд хүн ам ихээр суурьшин төвлөрч бүх төрлийн үйлчилгээ явагддаг тул маш эрчимтэй ашиглагддаг онцлогтой юм. Тус аймгийн хэмжээнд хот тосгонд тэг гортиг доторхи талбай (Алтай хот болон сум тосгоны төвүүдийн эзэмшил) нь 13436,3 га бөгөөд энэ ангиллын газрын 94,9 хувийн эзэлж байна. Дээрх ангиллын газрыг дотор нь барилгажсан

талбай, гэр хорооллын газар, нийтийн эдэлбэр газар гэсэн 3 үндсэн дэд ангилалд хуваадаг.

Хүснэгт 27

Хот суурин газруудын тэг гортиг доторхи газрын дотоод бүтэц

Ангиллын нэр	Нийт талбай (га)	Бүтэн %
Хот суурины тэг доторхи нийт газар	13436.3	100.0
Барилга байгууламжийн дэвсгэр газар	443.12	3.3
Нийтийн эдэлбэр газар	12649.69	94.14
Гэр хорооллын газар	313.49	2.56

Хүснэгтээс үзэхэд хот суурины тэг гортиг доторхи газрын 3.3 хувийг барилга байгууламжийн дэвсгэр газар, 2.56 хувийг гэр хорооллын газар, 94,14 хувийг нийтийн эзэмшлийн газар тус тус эзэлж байна. Эдгээр 3 ангиллын газрын ашиглалтыг тус тусад нь салангид авч үзэх боломжгүй бөгөөд учир нь эдгээр газрууд хороондоо нягт холбоотой ашиглагдаж байдаг онцлогтой юм.

а) Барилга байгууламжийн дэвсгэр газар

Тус аймгийн төв Алтай хот болон бүх сумын төвийн нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжууд нь хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдсан байна.

Барилга байгууламжийн дэвсгэр газар буюу одоо барилгажиж буй талбайг газар хуваарьлалт, ашиглалтын үүднээс авч үзвэл ноцтой зөрчилгүй хэвийн явагдаж байна.

Нийгмийн дэд бүтцийн (соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, нийгэм-ахуйн үйлчилгээ, үйлдвэр, төр захиргаа, олон нийтийн зориулалттай барилга байгууламжууд) барилга байгууламжууд нь хоорондоо тодорхой орон зайтай, тэр нь үндсэндээ нийтийн эзэмшлийн газар болж байдаг.

Барилга байгууламжийн дэвсгэр газрын ашиглалтыг тодорхойлохдоо түүний орчмын нийтийн эдэлбэр газрын ашиглалтын байдлыг тодорхойлох хэрэгтэй юм. Энэ утгаар авч үзвэл тус аймгийн барилга байгууламжын дэвсгэр газрын орчны газар ашиглалт хангалтгүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд эдгээр газруудыг тохижуулах (хатуу хучилттай зам талбай, явган хүний зам зэргийг гаргаж цэцэрлэгжүүлэх, амралт, зугаалга, спорт тоглоомын газрууд бий болгох гэх мэт)-аар төлөвлөсөн байдаг ч эдгээр төлөвлөсөн тохижуулалтын арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүйн улмаас энэхүү нийтийн эзэмшлийн газар нь (барилга байгууламжийн дэвсгэр газрын орчмын) антропогени болон автогенийн үүсэлтэй физик элэгдэлд хамгийн ихээр нэрвэгдсэн газрууд болжээ.

Говь-Алтай аймгийн төв Алтай хот болон ихэнх сумууд таримал мод зүлэг арчилгаа тордолтгүйгээс устаж үгүй болох хандлагатай болсон бөгөөд үүний тод

жишээ нь Цогт, Эрдэнэ зэрэг сумдыг дурьдаж болно. Харин, Бигэр, Алтай Халиун, Тонхил сумдууд, төв гудамжны замуудаа тэмдэгжүүлэн, ногоон байгууламжыг сэргээх, шинээр байгуулах усалгаа, арчилгааг сайжруулах хашиж хамгаалах талаар санаачлагатай ажиллаж байна.

Алтай хотын хувьд ихэнх төв гудамж, талбайн зарим хатуу хучилттай болгон тэмдэглэлт ой, түүхт хүмүүст зориулан дурсгал босгох, явган хүний зам гаргах зэргээр тохижуулалтын ажлыг хийсэн байна. Гэвч урьд өмнө нь байгуулсан ногоон байгууламжийг өргөтгөх, таримал мод зүлгийг арчилж тордох талаар хангалтгүй ажиллаж иржээ.

Арчилгаа тордолгоог орхигдуулснаас таримал зүлэг халцарч устах, улиас мод нь хатаж хувхайрах, хайст хашаа нь эвдэрч алдагдах явдал хэвийн үзэгдэл болсон байна.

б) Нийтийн эдэлбэр газар

Тус аймгийн нийтийн эдэлбэр газар нь хот суурин газруудын тэг гортиг доторхи газрын 94,14 хувь буюу 12649,69 га талбайг эзэлдэг. Дээрхи нийтийн эдэлбэр газар нь ашиглалтын хувьд жигд бус, барилгажсан болон гэр хорооллуудын орчмын хэсэг нь ашиглалтын ачаалал ихтэй, элэгдэл эвдрэлд ихээхэн нэрвэгдсэн байхад (энэ хэсэг нь үндсэндээ суурьшлын бүс дотор байдаг) суурьшлын бүсийн гадна хотын тэг гортигийн зах хаяа хэсэг нь ачаалал харьцангуй бага ихэвчлэн бэлчээрт ашигладаг тул хөрсний элэгдэл, эвдрэлд төдийлөн өртөөгүй хэдий ч ургамлан нөмрөг нь ихээхэн талхлагдсан байна.

Алтай хотын нийтийн эдэлбэр газрын баруун талаар үерийн хамгаалалтын далантай бөгөөд түүний дотор талаар давхар далан байгуулжээ.

Дээрхи далан нь өнгөрсөн хугацааны явцад элэгдэлд орж сэргээн засварлах шаардлагатай болжээ.

в). Гэр хорооллын газар

Хот суурин газруудын тэг гортиг дотор, гэр хорооллын газар 2,56 хувь буюу 343,49 га-г эзэлдэг. Гэр хорооллын газрын хувиарлалт, байршил нь, Бигэр, Цогт, Эрдэнэ, Жаргалан, Алтай зэрэг сумуудын хувьд цомхон байрлалтай, газрыг харьцангуй жигд хуваарилсан гудамжууд нь тэгш, хаягжуулахад хялбар, цахилгаан эрчим хүчний шугамын алдагдал багатай байх нөхцөл бүрдсэн зэрэг эерэг талуудтай. Өөрөөр хэлбэл эдгээр сумуудын гэр хорооллуудын газрын хуваарилалт, байршуулалт сайн болжээ.

Халиун сумын төвийн айл өрх шилжих хөдөлгөөн ихтэйгээс урьд байсан гэр хорооллын зохион байгуулалт бүхэлдээ өөрчлөгдөн гудамж, хаяг үгүй болжээ. Сумын төв нь элсжиж, эвдрэл элэгдэлд гүнзгий өртсөн байна.

Говь-Алтай аймгийн төв, хот суурин газруудын гэр хорооллын газар ашиглалтын нийтлэг нэг дутагдал нь орчны нийтийн эдэлбэр газарт хөрсний эвдрэл хүчтэй явагдаж байна. Тэнд тохижуулалтын элементүүд бараг байхгүй (ногоон байгууламж, сайжруулсан зам, спорт тоглоомын талбай гэх мэт) байгааг тэмдэглэх нь зүйтэй гэж үзлээ.

Хот тосгон суурин газрын байгалийн тэнцвэрт байдлыг хангах, чийглэг нуга, ундны усны эх үүсвэр болж буй булаг, шанд, гол горхинд эрүүл ахуйн бүс байгуулах талаар хийгдсэн ажил хомс байв. Зөвхөн Алтай, Тонхил сумуудын төвийн булаг орчимд хамгаалалтын бүс тогтоож, хашаажуулсан байна.

Газрын экологийн хязгаарлах хүчин зүйлсийн бүс, ялангуяа үерийн зам газар, сул болон хагас бэхжсэн элсэн хөрстэй газарт хязгаарлах бүс байгуулаагүйгээс үерт орох, элсний нүүдэлд өртөх явдал Алтай хот, Сайн-Уст, Баянтоорой тосгонд тохиолдож байна.

Тус аймгийн ихэнх тосгон, суурин газрын орчны эргэн тойрон 2-3 км зайд ургамлан нөмрөг толботон нүцгэрэх улмаар хөрсний бүтэц элэгдэлд орж эхэлжээ.

Үндэсний ёс заншилд шууд хамааралтай тодорхой хэмжээний газар нутаг хотын тэг гортигт хамаарагддаг нь наадмын талбай юм. Алтай хот болон тосгон, суурин бүрд баяр наадмын үндсэн үйл ажиллагаа болох морин уралдааны гараа, барианы газар, уралдах зам, нум сум, шагай харвах, бөх барилдах, төрөл бүрийн спортын тэмцээн болон худалдаа үйлчилгээ явуулахад тохиромжтой орон зай бүхий уламжлалт ёс заншлын газар, наадмын талбайн бүсийг тогтоосон байна. Хот, тосгон суурингийн төвд нэр алдарт иргэд, түүхэт ой, бүтээн байгуулалт, ололт амжилт, тэмдэглэлт үйл явдалд зориулсан хөшөө дурсгал, таримал цэцэрлэг нэлээдгүй боловч түүнийг сэргээх өнгө будгийг сайжруулах, тордох, хамгаалах ажил хоцрогдонгүй байна.

Тус аймгийн төвлөрсөн газруудад хог хаягдлын цэгтэй. Эдгээр нь нийт 289.5 га, ихэнх нь зонхилох салхин доор байрлалтай. Гэвч эмх цэгц, ариун цэврийн үзүүлэлт өнөөгийн шаардлага хангахгүй байна. Хог хаягдлын цэгийг тэмдэгжүүлсэн, шан хүрээ татан хил зааг тогтоосон нь цөөн, хог өргөжин тэлэх нь ердийн үзэгдэл болжээ.

Алтай хотын хогийн цэг нь төвөөсөө нилээд зайтай боловч зохион байгуулалт, хяналт сулаас хотруу улам бүр ойртох болжээ. Түүнчлэн нийлэг уут зэрэг хөнгөн чанарын хог хаягдал салхины дагуу хийсч ихээхэн хэмжээний газрын бохирдуулсаар байна.

Алтай хот болон хөдөөгийн тосгон, суурингийн бүсэд оршуулгын 303 га газар бий. Нас барагсадад хүндэтгэл үзүүлэх, үлдэгсэдийн хагацал, гашуудлыг хуваалцах

үүднээс оршуулгын газрын ариун дагшин, цэвэр цэмцгэр байлгахад тавих анхаарал дутмаг байна. Зарим оршуулгын газарт эмх цэгц хангалтгүй, хөшөө бунхан нь эвдэрч гэмтсэн, мэрэгчид цоолж хөндсөн, байгалийн сөрөг нөлөө, цаг хугацааны эрхээр цөмөрч нурсан, бичиг дурсгал нь баларсан зэрэг сэтгэл эмзэглүүлсэн зүйл мэр сэр тохиолдож буйг анхааруштай.

II.3.3 Аялал жуулчлал, амралт рашаан сувилалын газрын ашиглалт хамгаалалтын одоогийн байдал

Тус аймаг нь аялал жуулчлал, амралт, рашаан сувилал хөгжүүлэх нөөц нөхцөл ихтэй, өргөн уудам нутаг дэвсгэртэй юм.

Байгалийн содон тогтоц, үзэсгэлэнт сайхан нуур, цөөрөм, уул хад, алдартай их говиуд, түүний дунд орших тоорой, заг, Сухайн шугуйт баян бүрдүүд, дэлхийд ховор ан амьтад, ургамал нь гадаад, дотоодын аялагч жуулчдын анхаарлыг татсаар ирсэн билээ. Завхан голын сав газар Эрээн нуур, Хасагт хайрханы дархан цаазат газар, Шарга-Манхан, Бурхайнбуудай уулын байгалийн нөөц газар, Ээж хайрханы байгалийн дурсгалт газар, Говь-цөлийн өвөрмөц ландшафт, хадны сүг зураг, хүн чулуу булш бунхан, эртний хот балгасын туурь, гэрэлт хөшөө зэрэг түүх соёлын өв, дурсгалт зүйлүүд, рашаан булаг, эмчилгээний элс зэрэг нь амралт жуулчлал, рашаан сувилал хөгжүүлэх үндсэн нөөц болж байна.

Тус аймгийн засаг дарга түүний тамгын газраас амралт рашаан сувилал, жуулчлал болон байгалийн аялалын чиглэлтэй нийт 3 үндсэн маршрут гаргаад байгаа юм. Тухайлбал Бигэрийн таван элс бөөрний сувилал-цагаан хаалга-Ээж хайрхан уул, Эрээн нуур-Хүнхэрийн амралт, Алтайн өвөр говь,-Тахийн тал-Хонин усны говь-Сутай уулын чиглэлийн маршрутыг нэрлэж болно. Тус аймагт “Жуулчин Алтай” ХХК-ийн жуулчны бааз Алтай хотоос баруун хойш 7 км зайтай Баянтохойд байрладаг. Жуулчин хүлээн авах зориулалтаар тохижуулсан таван гэрт нэг ээлжинд 25 хүн хүлээн авч үйлчлэх хүчин чадалтай.

II.3.4 Үйлдвэр уурхайн газрын ашиглалт хамгаалалтын байдал

Тус аймагт 2005 оны байдлаар 7 нүүрсний, 1 давсны, 1 алтны нийт 9 уурхай ашиглагдаж байгаа талаар тайлан мэдээнд тусгагдсан боловч ихэнх нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байна. Тус аймгийн нутаг дэвсгэр нь хүрэн нүүрсээр баялаг олон орд, илэрцүүдтэй. Цахиур, Зээгт, Мааньт, Хүрэн голын ордуудын нийт нүүрсний нөөц нь 38,2 сая тн юм. Эдгээр орд, уурхайнууд нь аймгийн түлш эрчим хүчний эх үүсвэр төдийгүй зэргэлдээ аймаг сумдын түлшний хэрэгцээг хангах боломжтой. Дээрх уурхайгаас Алтай хотруу олон жилд нүүрс тээвэрлэх явцад олон салаа зам гарч, хөрс физик эвдрэлд хүчтэй нэрвэгдэж, тэндээс хийссэн элс, шороо салхины доод талын олон мянган га бэлчээрийг доройтуулж байна. Мөн эдгээр уурхайнууд хөрс хуулж овоолго хийж нүүрсийг нь ил аргаар олборлодог учраас их хэмжээний газар овоолгонд дарагдаж ашиглалтаас гарах, түүнчлэн уурхайгаас нүүрс тээврийн зам дагуу ачаагаа хөнгөлөх зорилгоор буулгаж хаясан шавар, чулууны хольц нь хөрсийг бохирдуулдаг.

Нүүрсний уурхайн газар ашиглалтыг дараахь зургаас үзнэ үү.



Зураг 2. “Хужиртын ам” -ны нүүрсний уурхайн газрын хөрс хуулсан ерөнхий байдал

Төгрөг сумын Хүрэн голын Хужирын ам, Хужирын булаг болон Ацын амны нүүрсний ордуудыг ашигладаг. Ашиглалт, олборлолтын хэмжээ төдийлэн сайн биш байхад ийнхүү олон жижиг уурхай нээж буй нь бэлчээр талхлах, олон салаа зам гаргах зэргээр байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна.

Алтны уурхай нь дээрхийн нэгэн адил технологиор ажиллахын зэрэгцээ алт агуулсан шороогоо гол горхийн ус ашиглан угааж байгаа нь гол горхийн усыг ихээхэн бохирдуулах болов.

Тус аймагт олзворлолт хийж буй аль ч уурхай нь нөхөн сэргээлтийн талаар ямар ч ажил хийлгүй өнөөг хүртэл явж иржээ.

II.3.5 Геологи ашигт малтмал, хайгуулын лиценз олголтын одоогийн байдал

Алтайн уулс нь Хангай, Хэнтийн уулсыг бодоход харьцангуй хожуу үүссэн эгц налуу хажуутай өндөр уулс юм. Энд цахиурлаг болон шаварлаг занар конгломерат, хүрмэн, боржин чулуулаг зонхилдог. Цэвэр чулуулаг бага хэмжээгээр, зөвхөн чулуулаг газраар тохиолдлын төдий алаг цоог байдалтай тархжээ. Ихэнх нам дор газар нь улирлын цэвдэгтэй нутагт хамрагдана. Алтайн өвөр говиор Цэрдийн галвын шаварлаг хурдас, Шарга, Бигэрийн хотгоруудад гуравдагч галвын улаан алаг хурдас тархжээ.

Геологийн мэдээнээс үзвэл Ажбогдын нуруу 7.1-8.0 балл, Алаг хайрхан, Хасагт хайрхан Хантайшир, Гичгэний нуруунд 5.0-6.0 баллын хүчтэй газар хөдлөлийн төвүүд оршдог ажээ. Эдгээр уулсын орчны нутаг нь газар чичирхийллийн идэвхитэй бүсэд багтдаг. Тус аймгийн нутаг дэвсгэрт геологи хайгуулын судалгааг бусад

аймгуудтай харьцуулахад төдийлөн нарийвчлан хийгдээгүй боловч ашигт малтмал, эрдэс түүхий эдийн нилээд нөөцтэй орд, илэрцүүд бий.

Хүснэгт 28

Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын орд газрын ашиглалтын лиценз авсан газрууд (2005 оны байдлаар)

д/д	Лицензийн дугаар	Эзэмшигчийн нэр	Олгосон огноо	Талбайн байршил	Талбайн хэмжээ /га/	Планшетын дугаар	Тайлбар
1	905	Түлш-Алтай ХХК	1997.12.30	Чандмань сумын Зээгт	25		нүүрс
2	1715	Илч-Алтай ОНӨҮГ	1999.07.01	Төгрөг сумын Хужиртын ам	42	L-47-88	нүүрс
3	1741	Шар ус гол ХЭАА	1999.07.14	Цээл сумын Буур гол	34	L-46-83	давс
4	5043	Таянгийн жолоо ХХК	2002.10.28	Төгрөг сумын Хужир булаг	51		нүүрс
5	5097	Сэрвэн ХХК	2002.11.11	Төгрөг сумын Хужиртын булаг	27	L-46-83	нүүрс
6	5552	Хишиг-Алтай ХХК	2003.03.28	Дэлгэр сумын Бумбат худаг	33	L-46-83	
7	5898	Хан тайшир хайрхан ХХК	2003.06.07	Тайшир сумын Уртын ам	25		
8	6387	Голын боргио ХХК	2003.10.04	Төгрөг сумын Огторгын худаг	26		
9	8286	Түлш-Алтай ХХК	2004.08.31	Дэлгэр сумын Хөвбулаг-1	25		
10	7672	Аксу-Алтай ХХК	2004.06.09	Тайшир сумын Сүхийн хоолой	26		
11	9102	Монгол хатгамал ХХК	2005.01.10	Төгрөг сумын Ацын ам	25		
12	9115	Номин орд ХХК	2005.01.10	Есөнбулаг сумын Нарийн овгор	26		
	Дун				365		

Хүснэгт 29

Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрт хайгуулын лиценз авсан газрууд (2005 оны байдлаар)

д/д	Лицензийн дугаар	Эзэмшигчийн нэр	Олгосон огноо	Талбайн байршил	Талбайн хэмжээ /га/	Планшетын дугаар
0	1	2	3	4	5	6
1	1423	Гацуурт ХХК	1999.02.25	Шарга сумын дунд шарын ам	1383	
2	1585	Монголын алт МАК	1999.05.18	Бигэр сумын Сэрх уул	885	
3	1643	АМГТХЭГ-ын Геологийн газар	1999.06.02		9685	
4	1643	АМГТХЭГ-ын Геологийн газар	1999.06.02	Бугат сумын Эрдэчулуут		
5	1644	АМГТХЭГ-ын Геологийн газар	1999.06.02	Алтай сумын Майхан толгой	135073	
6	1644	АМГТХЭГ-ын Геологийн газар	1999.06.02	Бугат сумын Майхан толгой		
7	1647	АМГТХЭГ-ын Геологийн газар	1999.06.02	Алтай сумын Баян-Овоо	26330	
8	2080	Гацуурт ХХК	2000.02.14	Шарга сумын дунд шарын гол	685	
9	2280	П. Баярцог	2000.05.08	Алтай сумын Жинсийн нуруу	242	
0	1	2	3	4	5	6
10	2781	Монгол-Алт ХХК	2000.12.06	Тонхил сумын		

				Хулмын нуур		
11	2786	Г. Саранцэцэг	2000.12.07	Алтай сумын Жинсийн нуруу-2	674	
12	3453	Эрдэнэ Монгол ХХК	2001.06.28	Есөнбулаг сумын Хэц уул	2143	
13	3561	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2001.07.30	Халиун сумын Наран	31881	
14	3561	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2001.07.30	Тайшир сумын Наран		
15	3918	Х. Цэцгээ	2001.12.10	Төгрөг сумын Хужиртын улааны ар	81	
16	4132	Батс-Өргөө ХХК	2002.02.07	Цогт сумын Холбоо толгой	2359	
17	4210	Д. Пүрэвдорж	2002.03.21	Тонхил сумын Шандын нуруу	1064	
18	4375	Шагаа ХХК	2002.05.08	Цогт сумын Сагсайн төгрөгийн	31049	
19	4525	Адамасмайнинг ХХК	2002.06.12	Чандмань сумын Бор хайрхан	3024	L-47-88
20	4526	Адамасмайнинг ХХК	2002.06.12	Цогт сумын Ширтбулаг	36368	L-47-99
21	4526	Адамасмайнинг ХХК	2002.06.12	Эрдэнэ сумын Ширтбулаг		
22	4527	З. Номундарь	2002.06.12	Бигэр сумын Бүтэд	4275	L-47-74
23	4529	З. Номундарь	2002.06.12	Бигэр сумын Могойн шанд	13492	L-47-87
24	4530	З. Номундарь	2002.06.12	Халиун сумдын Туул хяр	5748	L-47-74
25	4530	З. Номундарь	2002.06.12	Тайшир сумдын Туул хяр		
26	4574	Хүрзэт ХХК	2002.06.27	Тайшир сумын Их мандал толгой	10167	L-47-49
27	4575	Хүрзэт ХХК	2002.06.27	Тайшир сумын Өндөр цахир	2365	L-47-35,50
28	4576	Logistic Resources Limited	2002.06.27	Эрдэнэ сумын Шовгор улаан уул	22025	L-47-111
29	4577	Logistic Resources Limited	2002.06.27	Алтай сумын Жинс	21313	L-47-109
30	4578	Logistic Resources Limited	2002.06.27	Цогт сумын Хөх дэл уул	29382	L-47-110
31	4672	Галлантминералз МОНГОЛ ХХК	2002.07.22	Бигэр сумын Бигэр	19753	
32	4679	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2002.07.24	Алтай сумын Бидэрийн ам	32228	L-47-109
33	4679	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2002.07.24	Цогт сумын Бидэрийн ам		
34	4681	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2002.07.24	Цогт сумын Бүрхээрийн ам	35220	L-47- 109,110
35	4681	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2002.07.24	Эрдэнэ сумын Бүрхээрийн ам		
36	4683	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2002.07.24	Эрдэнэ сумын Шавартай-2	45965	L-47-109
37	4747	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2002.08.13	Алтай сумын Ангаахай	28503	L-47-109
38	4747	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2002.08.13	Цогт сумын Ангаахай		
39	4806	Уникум-Алт ХХК	2002.08.29	Шарга сумын Улаан уул-3	13546	L-47-60
40	4806	Уникум-Алт ХХК	2002.08.29	Тайшир сумын Улаан уул- 3		
41	4809	Эдрэн эксплоерейшн ХХК	2002.08.29	Шарга сумын Улаан уул-1	4506	L-47-59, 60
0	1	2	3	4	5	6
42	4810	Эдрэн эксплоерейшн ХХК	2002.08.29	Эрдэнэ сумын Эдрэн- 1	7323	L-47-123

43	4823	Монголресорсес эксплорэйшн ХХК	2002.09.02	Халиун сумдын Ганц модот-А	49956	
44	4823	Монголресорсес эксплорэйшн ХХК	2002.09.02	Тайшир сумдын Ганц модот-А		
45	4824	Монголресорсес эксплорэйшн ХХК	2002.09.02	Бигэр сумдын Ганц модот-Б	16720	
46	4824	Монголресорсес эксплорэйшн ХХК	2002.09.02	Халиун сумдын Ганц модот-Б		
47	4824	Монголресорсес эксплорэйшн ХХК	2002.09.02	Цогт сумдын Ганц модот-Б		
48	4825	Монголресорсес эксплорэйшн ХХК	2002.09.02	Халиун сумдын Ганц модот-Б	66042	
49	4825	Монголресорсес эксплорэйшн ХХК	2002.09.02	Цогт сумдын Ганц модот-Б		
50	4887	Эдрэн ХХК	эксплорейшн 2002.09.17	Эрдэнэ сумын Эдрэн- 2	2749	L-47-124
51	4888	Эдрэн ХХК	эксплорейшн 2002.09.17	Эрдэнэ сумын Эдрэн- 3	2484	L-47-124
52	4894	Эдрэн ХХК	эксплорейшн 2002.09.17	Шарга сумын Улаан уул-2	8624	L-49-60
53	4895	Эдрэн ХХК	эксплорейшн 2002.09.17	Шарга сумын Улаан уул-2	7357	L-49-60
54	4975	Сэрвэн ХХК	2002.10.08	Төгрөг сумын Хужиртын булгийн ар	83	L-46-83
55	5014	Балчулуу ХХК	2002.10.17	Тайшир сумын Уртын нуруу	535	L-46-60, 72
56	5090	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2002.11.07	Эрдэнэ сумын Шавартай	17087	
57	5142	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2002.11.22	Тонхил сумын Алаг уул		L-46-79
58	5285	Хурын эх ХХК	2002.12.30	Тонхил сумын Дунд хулдын гол “ хүрд хад”	1917	
59	5380	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2003.02.04	Тонхил сумын Халзан бүргэтэйн	52642	
60	5381	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2003.02.04	Тонхил сумын Хөндлөн уул	47178	
61	5463	Баатарын Түмэндамбэрэл	2003.03.06	Тайшир сумын Алтан гадас	368	
62	5522	Цагааны Лодой	2003.03.17	Халиун сумын Цахир энгэр	55613	
63	5543	Номин орд	2003.03.27	Тайшир сумын Нарийн овгор	715	
64	5556	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2003.04.01	Хөхморьт сумын Их хайрхан		L-46-47, 48
65	5729	АМГТХЭГ-ын Геологийн газар	2003.05.10	Баян-уул сумын Хасагт хайрхан	205908	
66	5729	АМГТХЭГ-ын Геологийн газар	2003.05.10	Жаргалан сумын Хасагт хайрхан		
67	5729	АМГТХЭГ-ын Геологийн газар	2003.05.10	Шарга сумын Хасагт хайрхан		
68	5730	АМГТХЭГ-ын Геологийн газар	2003.05.10	Баян-Уул сумын Дөш хайрхан	209463	
69	5730	АМГТХЭГ-ын Геологийн газар	2003.05.10	Жаргалан сумын Дөш хайрхан		
70	5794	Л. Отгонбаяр	2003.05.21	Шарга сумын Дунд шарын ам	1877	
71	5950	Майн-Инфо ХХК	2003.06.19	Эрдэнэ сумын Шавар уул	2933	L-47-111
72	6064	Сурмаажавын Баясгалан	2003.07.17	Тонхил сумын Хатан нутаг	10517	L-46-69

0	1	2	3	4	5	6
73	6246	АМГТХЭГ-ын Геологийн газар	2003.08.28	Чандмань сумын Замтын нуруу	398781	
74	6246	АМГТХЭГ-ын Геологийн газар	2003.08.28	Эрдэнэ сумын Замтын нуруу		
75	6275	Монминерал ХХК	2003.09.04	Шарга сумын Улаан	79	L-46-60
76	6304	Эрдэнэ монгол ХХК	2003.09.11	Тайшир сум Цэх уул	1242	L-47-49
77	6332	Хөх тэнгэр тур ХХК	2003.09.19	Чандмань сумын Эрдэнэ уул	1394	L-47-88
78	6484	Монголросцветмет нэгдэл	2003.10.28	Дарви сумын Дарвийн нуруу-1	17034	
79	6594	Адамасмайнинг ХХК	2003.11.27	Цээл сумын Их худгийн сайр	442	L-46-96
80	6662	Бумбат ХХК	2003.12.17	Чандмань сумын Алаг уул	2424	
81	6663	Бумбат ХХК	2003.12.17	Чандмань сумын Алагийн гол	1777	
82	6663	Бумбат ХХК	2003.12.17	Эрдэнэ сумын Алагийн гол		
83	6702	Эдрэн эксплоейшн ХХК	2003.12.24	Эрдэнэ сумын Балин толгой	399	L-47-124
84	6790	Ж. Жамсран	2004.01.26	Тайшир сумын Суураагийн гол	7151	L-47-61, L-46-72
85	6841	Эдрэн эксплоейшн ХХК	2004.01.27	Эрдэнэ сумын Эдрэнгийн нуруу	2702	L-49-123
86	6935	Раднаагийн Пүрэв	2004.02.10	Цээл сумын Ямаан уст	1129	L-47-73
87	6996	Монголын алт МАК ХХК	2004.02.25	Чандмань сумын Харуул уул	3376	L-47-88
88	7048	Эдрэн эксплоейшн ХХК	2004.03.11	Шарга сумын Өндөр хайрхан уул	263	L-46-60
89	7120	Адамасмайнинг ХХК	2004.03.23	Тайшир сумын Талбулаг	6179	L-47-38
90	7121	Адамасмайнинг ХХК	2004.03.23	Тайшир сумын Шивээт толгой	11615	L-47-50
91	7121	Адамасмайнинг ХХК	2004.03.23	Дэлгэр сумын Шивээт толгойт		
92	7188	АМГТХЭГ-ын Геологийн газар	199.05.28	Бугат сумын Эрдэнэсулуут	48556	
93	7202	Дэмчигсүрэнгийн Төрбат	2004.04.04	Цогт сумын Дэл уул	42400	L-47-97, 85
94	7202	Дэмчигсүрэнгийн Төрбат	2004.04.04	Цээл сумын Дэл уул		
95	7203	Гүржавын Оюунчимэг	2004.04.04	Цогт сумын Төгрөг гол	10111	L-47-97
96	7203	Гүржавын Оюунчимэг	2004.04.04	Цээл сумын Төгрөг гол		
97	7367	Когес корпараци	2004.04.30	Төгрөг сумын Төгрөг-2	39045	L-46-82
98	7368	Когес корпараци	2004.04.30	Бугат сумын Төгрөг- 1	135505	L-46-81, 82
99	7368	Когес корпараци	2004.04.30	Тонхил сумын Төгрөг-1		
100	7368	Когес корпараци	2004.04.30	Төгрөг сумын Төгрөг-1		
101	7369	Когес корпараци	2004.04.30	Бугат сумын Шар хоолой	26791	L-46-81
102	7369	Когес корпараци	2004.04.30	Тонхил сумын Шар хоолой		
103	7426	Чулуунбатын Сарантуяа	2004.05.10	Алтай сумын Сэнжит	801	L-47-109
104	7438	Хадбаасангийн Бат- Эрдэнэ	2004.05.11	Эрдэнэ сумын Суман хад	28761	L-47-136

0	1	2	3	4	5	6
105	7559	Алтан Дорнод Монгол ХХК	2004.05.24	Алтай сумын Тэрэгтийн нуруу	110584	
106	7560	Алтан Дорнод Монгол ХХК	2004.05.24	Алтай сумын Тэрэгтийн нуруу	376925	L-46-106, 107, 118, 119, 130, 131
107	7560	Алтан Дорнод Монгол ХХК	2004.05.24	Бугат сумын Тэрэгтийн нуруу		
108	7581	Зоригтбаатарын Номундарь	2004.05.27	Дэлгэр сумын Хүрхрээ	1676	L-47-76
109	7596	Жамбалын Жамъяандавга	2004.05.28	Дэлгэр сумын Овоот толгой	2690	L-47-63
110	7602	Улаан начин ХХК	2004.05.31	Тонхил сумын Зүйлийн гол-2	2216	L-46-56
111	7603	Улаан начин ХХК	2004.05.31	Тонхил сумын Зүйлийн гол-3	878	L-46-56
112	7612	Зоригтбаатарын Номундарь	2004.06.02	Дэлгэр сумын Сэрх уул	1077	L-47-76
113	7613	Зоригтбаатарын Номундарь	2004.06.02	Чандманьсумын Эрдэнэ уул	2170	L-47-88
114	7614	Зоригтбаатарын Номундарь	2004.06.02	Дэлгэр сумын Буурал уул	927	L-47-64
115	7615	Зоригтбаатарын Номундарь	2004.06.02	Чандманьсумын Чандмана	2749	L-47-88
116	7616	Зоригтбаатарын Номундарь	2004.06.02	Дэлгэр сумын Баянбуурал	6252	L-47-64
117	7617	Зоригтбаатарын Номундарь	2004.06.02	Чандманьсумын Мянган-1	2893	L-47-88
118	7618	Зоригтбаатарын Номундарь	2004.06.02	Чандманьсумын Мянган	1809	L-47-88
119	7619	Зоригтбаатарын Номундарь	2004.06.02	Чандманьсумын Мянгат-2	1206	L-47-88
120	7643	Хаан гарьд ХХК	2004.06.04	Тайшир сумын Хөх толгой	91	L-47-38
121	7766	Жи Эм И ХХК	2004.06.24	Тонхил сумын Олон бул	1800	L-46-80
122	7854	Зоригтбаатарын Номундарь	2004.07.02	Халиун сумын Ар зүүн гол	19640	L-47-73
123	7860	Зоригтбаатарын Номундарь	2004.07.02	Цогт сумын Ширт булаг-1	8075	L-47-99
124	7861	Зоригтбаатарын Номундарь	2004.07.02	Эрдэнэ сумын Хушийн өндөр	1617	L-47-100
125	7862	Зоригтбаатарын Номундарь	2004.07.02	Цогт сумын Ширт булаг-2	3074	L-47-99
126	7866	Гэндэндармаагийн Энхбат	2004.07.06	Есөнбулаг сумын Улаан уул	7209	L-47-64
127	7866	Гэндэндармаагийн Энхбат	2004.07.06	Шарга сумын Улаан уул		
128	7867	Эдрэн эксплорейшн ХХК	2004.07.06	Шарга сумын Улаан уул-7	2376	L-46-60
129	7870	Дамбын Хулан	2004.07.06	Эрдэнэ сумын Дэвэрхийн Цахир уул	7799	L-47-112
130	7954	Золтон ХХК	2004.07.21	Цээл сумын Цанхир	13512	
131	7954	Золтон ХХК	2004.07.21	Цогт сумын Цанхир		
132	7989	Чулуунбаатарын Очирхуяг	2004.07.23	Шарга сумын Баянбулаг	4105	L-46-60
133	8044	Цэнконстракшн ХХК	2004.08.03	Алтай сумын Алтай	25711	L-46-120
134	8045	Цэнконстракшн ХХК	2004.08.03	Цээл сумын Цахирын булаг	21197	L-46-84, 96
135	8081	Хан шижир ХХК	2004.08.04	Дэлгэр сумын Бурхант		
0	1	2	3	4	5	6

136	8136	Зоригтбаатарын Номундарь	2004.08.06	Цээл сумын Шивээ-1	6426	
137	8247	Хүрзэт ХХК	2004.08.26	Эрдэнэ сумын Улаан толгой	67427	
138	8250	Цэнконстракшн ХХК	2004.08.26	Дэлгэр сумын Бумбат худаг	2701	L-47-64
139	8273	Цэвгээгийн Алтангэрэл	2004.08.31	Чандманьсумын Асгат	189	
140	8274	Цэвгээгийн Алтангэрэл	2004.08.31	Чандманьсумын Шар хоолой	486	
141	8303	Жасрайн Жамсран	2004.09.07	Халиун сумын Бургасын орой	31604	L-47-61
142	8315	Пүрэвдагвын Булга	2004.09.07	Халиун сумын Сээрийн гол	2161	L-47-73
143	8333	Могол интэрнэйшнл ХХК	2004.09.09	Эрдэнэ сумын Эрдэнэ	63458	L-47-100
144	8340	Могол интэрнэйшнл ХХК	2004.09.09	Бугат сумын Хиягтын Сэрвээ уул	87417	L-46-105
145	8401	АМГТХЭГ-ын Геологийн газар	2004.09.09	Шарга сумын Зост Өндөр-3	28241	L-46-48, 60
146	8401	АМГТХЭГ-ын Геологийн газар	2004.09.09	Тайшир сумын Зост Өндөр-3		
147	8404	АМГТХЭГ-ын Геологийн газар	2004.09.15	Тонхил сумын Ембүү уул-1	62499	L-46-66, 67
148	8405	АМГТХЭГ-ын Геологийн газар	2004.09.15	Хөхморьт сумын Буянт-2	1220	L-46-32, 44
149	8406	АМГТХЭГ-ын Геологийн газар	2004.09.15	Жаргалан сумын Зост Өндөр-2		
150	8406	АМГТХЭГ-ын Геологийн газар	2004.09.15	Шарга сумын Зост Өндөр-2	83556	
151	8406	АМГТХЭГ-ын Геологийн газар	2004.09.15	Тайшир сумын Зост Өндөр-2		
152	8407	АМГТХЭГ-ын Геологийн газар	2004.09.15	Жаргалан сумын Зост Өндөр-1	33994	L-46-48
153	8408	АМГТХЭГ-ын Геологийн газар	2004.09.15	Шарга сумын Зост Өндөр-2	1762	L-46-48
154	8434	Мандал хас ХХК	2004.09.16	Цогт сумын Шар түрүү	996	L-47-86
155	8437	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2002.08.18	Хөхморьт сумын Ар заг-1		
156	8445	Их яам ХХК	2004.09.17	Жаргалан сумын Цахиурт	130	L-46-48
157	8466	Золтон ХХК	2004.09.23	Есанбулаг сумын Хүнхэрийн сайр	2857	L-47-61
158	8471	Амгаланбаатарын Нандинцэцэг	2004.09.27	Шарга сумын Алаг уул	15327	L-46-58
159	8524	Эрдэсхолдинг ХХК	2004.10.05	Бигэр сумын Тээлийн хөндий	27776	L-47-63
160	8524	Эрдэсхолдинг ХХК	2004.10.05	Дэлгэр сумын Тээлийн хөндий		
161	8584	Л. Чинбат	2004.10.13	Тонхил сумын Хулман нуур-1	39540	L-46-68, 80
162	8585	Л. Чинбат	2004.10.13	Бугат сумын Гурванхайрхан	107962	L-46-104, 116
163	8599	Л. Чинбат	2004.10.15	Тонхил сумын Хулман нуур-2	162426	L-46-68, 80
164	8604	Деронгмонголиа ХХК	2004.10.19	Эрдэнэ сумын Дэрсний хоолой		
165	8605	Деронгмонголиа ХХК	2004.10.19	Чандманьсумын Бор үзүүр		L-47-77, 78
166	8683	Кью Жи Экс Монгол Лимитед ХХК	2004.11.03	Есөнбулаг сумын Наран-2	3978	
0	1	2	3	4	5	6

167	8687	Интернейшнл-Юраниум монголиа ХХК	2004.11.03	Дэлгэр сумын Говь- Гуулин	87957	
168	8687	Интернейшнл-Юраниум монголиа ХХК	2004.11.03	Есөнбулаг сумын Говь-Гуулин	5	
169	8717	З. Номундарь	2002.06.12	Халиун сумын зүүн гол	6000	
170	8734	Ж. Жамсран	2004.11.10	Тайшир сумын Тайширын талбай	393	
171	8763	АМГТХЭГ-ын Геологийн газар	2004.11.15	Тонхил сумын Ембүү уул-3		
172	8892	Ц. Чимидцэрэн	2004.12.09	Цогт сумын Хүрэнтолгой	40066	
173	8892	Ц. Чимидцэрэн	2004.12.09	Эрдэнэ сумын Хүрэнтолгой		
174	8893	Ц. Чимидцэрэн	2004.12.09	Алтай сумын Майхан толгой	24419	
175	8893	Ц. Чимидцэрэн	2004.12.09	Бугат сумын Майхан толгой		
176	8894	Ц. Чимидцэрэн	2004.12.09	Алтай сумын Лхаа хайрхан	265012	
177	8894	Ц. Чимидцэрэн	2004.12.09	Цээл сумын Лхаа хайрхан		
178	8896	Ц. Чимидцэрэн	2004.12.09	Эрдэнэ сумын Суман хад	196498	
179	8897	Ц. Чимидцэрэн	2004.12.09	Алтай сумын Эрдэнэчулуут	133504	
180	8897	Ц. Чимидцэрэн	2004.12.09	Бугат сумын Эрдэнэчулуут		
181	8897	Ц. Чимидцэрэн	2004.12.09	Төгрөг сумын Эрдэнэчулуут		
182	8897	Ц. Чимидцэрэн	2004.12.09	Цээл сумын Эрдэнэчулуут		
183	8967	З. Номундарь	2004.12.17	Цээл сумын Шивээ	962	
184	8968	З. Номундарь	2004.12.17	Төгрөг сумын Цагдуулт уул	28223	
185	8968	З. Номундарь	2004.12.17	Цээл сумын Цагдуулт уул		
186	8973	Б. Баярцэцэг	2004.12.17	Дэлгэр сумын Улаан Чулуут	49666	
187	8973	Б. Баярцэцэг	2004.12.17	Тайшир сумын Улаан чулуут		
188	8974	Б. Баярцэцэг	2004.12.17	Тонхил сумын Хатуу	31806	
189	8989	Ш. Баттүвшин	2004.12.17	Есөнбулаг сумын Наран	23486	
190	8989	Ш. Баттүвшин	2004.12.17	Халиун сумын Наран		
191	8990	Ш. Баттүвшин	2004.12.17	Есөнбулаг сумын Нарангийн-1	13506	
192	8991	Ш. Баттүвшин	2004.12.17	Есөнбулаг сумын Нарангийн-3	9924	
193	8991	Ш. Баттүвшин	2004.12.17	Тайшир сумын Нарангийн-3		
194	9004	З. Дашдэмбэрэл	2004.12.23	Төгрөг сумын Сэрээгийн өндөр	14423	
195	9051	Интернейшнл-Юраниум монголиа ХХК	2004.12.31	Дэлгэр сумын Говь гуулин-2	24228	
196	9052	Интернейшнл-Юраниум монголиа ХХК	2004.12.31	Дэлгэр сумын Говь гуулин-3	24228	
197	9067	Бурхан халдун групп	2005.01.03	Есөнбулаг сумын Баянгол	8099	
0	1	2	3	4	5	6
198	9086	Трой монголиа-Алт Ресорсиз	2005.01.03	Дарви сумын Гозон буурал	26538	

199	9086	Трой монголиа-Алт Ресорсиз	2005.01.03	Шарга сумын Гозон буурал		
200	9087	Трой монголиа-Алт Ресорсиз	2005.01.03	Дарви сумын Дарви	12697	
201	9087	Трой монголиа-Алт Ресорсиз	2005.01.03	Шарга сумын Дарви		
202	9147	Д. Батболд	2005.01.14	Дарви сумын Хайчийн талбай	11385	
203	9147	Д. Батболд	2005.01.14	Тонхил сумын Хайчийн талбай		
204	9180	Х. Шинэ-Од	2005.01.21	Тайшир сумын Бор нуур	8530	
205	9422	Тефис майнинг ХХК	2005.03.14	Чандманьсумын Зээгт-2	26573	
206	9423	Тефис майнинг ХХК	2005.03.14	Цээл сумын Хүүшийн булаг	15877	
207	9514	Тефис майнинг ХХК	2005.03.30	Халиун сумын Салаа гол	13843	
208	9514	Тефис майнинг ХХК	2005.03.30	Цээл сумын Салаа гол		
209	9518	Тефис майнинг ХХК	2005.03.30	Чандманьсумын Сүүжийн булаг	8795	
210	9518	Тефис майнинг ХХК	2005.03.30	Бигэр сумын Сүүжийн булаг		
211	6333	Хөх тэнгэр тур ХХК	2003.09.19	Чандмань сумын Хүнхэр	858	L-47-100
	Дүн				4699349	

Үүнээс үзэхэд тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын орд газрын ашиглалтын лиценз авсан 12 аж ахуйн нэгж, байгууллагад нийт 365 га, хайгуулын лицензийг 211 аж ахуйн нэгжид 4699349 га газрыг олгожээ.

Сүүлийн жилүүдэд Шар хоолой, Талын мэлтэс зэрэг алтны том жижиг олон орд илэрцүүд тэмдэглэгдсэний дотор Талын мэлтэсийн алтны үндсэн ордыг нь 200 тн орчим нөөцтэй хэмээн урьдчилсан байдлаар тогтоогоод байна.

Тус аймагт нөөц нь тогтоогдож ашиглалтын лиценз олгогдсон 12 орд газраас 4 нь нүүрсний орд газар юм. Эдгээр нь одоогоор аймгийн түлш эрчим хүчний эх үүсвэр болж байна.

Дээрх ордуудын нийт нөөц 38.2 сая.тн бөгөөд үүнээс зөвхөн Жаргалан сумын нутаг дахь Цахиурт уртын орд 28.3 сая-тн-оор тогтоогджээ.

Алтайн өвөр говь, Шаргын хотгор зэрэг газрууд нь нефть, шатдаг хийн нөөц байж болзошгүй хэмээн судлаачид үздэг.

Монгол улсын нефть байж болзошгүй 22 талбайг олон улсын тендерт зарласнаас Шарга III (39950 ам км) талбай нь тус аймагт байдаг.

Дүгнэлт

Говь-Алтай аймгийн хот тосгон бусад суурины ангиллын газрын ашиглалт, хамгаалалтын байдалд дэд ангилал бүрээр нь хийсэн тодорхойлолт, тайлбараас дараахи дүгнэлтүүдийг гаргаж болох байна.

1. Энэ ангиллын газрын барилга байгууламжийн дэвсгэр газрын хуваарилалт, байршилтаас бусад бүх дэд ангиллын газрын, ашиглалт хамгаалалт хангалтгүй байна.
2. Суурьшлын бүсийн барилгажсан хэсэг болон гэр хорооллын тохижилт хангалтгүй тул бүх хот суурин газруудын суурьшлын бүсэд тодорхой зураг төслийн дагуу тохижуулалтын арга хэмжээг эрчимжүүлж ялангуяа ногоон байгууламжийг өргөтгөн тордож, хамгаалах асуудалд онцгой анхаарах шаардлагатай байна.
3. Алтай хотыг үер усны аюулаас хамгаалах даланг засаж сэлбэх, суваг шуудууг сэргээх замаар учирч болзошгүй гэнэтийн аюулаас найдвартай сэргийлэх нөхцлийг бүрдүүлэх нь чухал байна.
4. Уурхайн газруудыг нөхөн сэргээх, зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, жил бүрийн төсөлд нөхөн сэргээлтэнд шаардагдах хөрөнгийг тусгаж хэрэгжүүлэх ажлыг хууль зүйн хүрээнд гүйцэтгэх хэрэгтэй.
5. Говь-Алтай аймгийн хэмжээнд “Аялал, жуулчлал хөгжүүлэх” дэд хөтөлбөртэй холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран боловсруулж реклам зар сурталчилгааг өргөн далайцтай явуулахын зэрэгцээ материаллаг баазыг бэхжүүлэх ажлыг өргөжүүлэх нь чухал байна.
6. Талын мэлтсийн алтны үндсэн ордны геологи, хайгуулын ажлыг гүйцэтгэх, улмаар ашиглалт явуулах үед ИГДЦ- газрын ховор, нэн ховор амьтан, ургамлын экосистемд үзүүлэх сөрөг нөлөөллийг мэргэжлийн байгууллагын хүчээр нарийвчилсан судалгаа явуулж дүгнэлт гаргуулах нь зүйтэй.

II.4 ЗАМ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ АНГИЛЛЫН ГАЗАР ТҮҮНИЙ АШИГЛАЛТ

II.4.1 Зам шугам сүлжээний ангиллын газрын бүтэц

Зам шугам сүлжээний ангиллын газарт хот тосгоны бусад суурины тэг гортигийн гадна талд буй улс, орон нутгийн чанартай замууд, эрчим хүч, холбооны шугамууд, ус дамжуулах хоолой, агаарын тээврийн газар гэх мэт инженерийн шугаман байгууламжуудын доорхи газар тэдгээрийн хамгаалалтын зурвас газрууд хамаарагддаг:

Хүснэгт 30

Зам шугам сүлжээний газрын бүтэц (га)

Зам шугам сүлжээний газар		Хэмжээ (га)	%
Бүгд (га)		5683.7	100.0
Авто замын доорхи газар бүгд		4462.9	78.5/100
Үүнээс	Улсын чанартай авто зам бүгд	434.5	9.7
	Орон нутгийн чанартай зам	3978.0	89.1
	Аж ахуйн дотоод зориулалттай	48.0	1.1
	Авто тээврийн барилга	2.4	0.1
Инженерийн шугам сүлжээний газар бүгд		1040.7	18.3/100
Үүнээс	Эрчим хүчний шугам	387.0	37.2
	Холбооны шугам	621.7	59.7
	Ус дулаан дамжуулах хоолой	25	2.4
	Ус шахах, өргөх байгууламж	2	0.2
	Үерээс хамгаалах далан, суваг	5	0.2
Агаарын тээвэр		180	3.2

Дээрх хүснэгтийн үзүүлэлтээс үзэхэд зам шугам сүлжээн ангиллын газрын ихэнх хэсэг болох 78.5 хувийг авто замын зурвас газар, 18.3 хувийг нь шугам сүлжээний зурвас газар, үлдэх 3,2 хувийг агаарын тээврийн нислэгийн зурвас болон нислэгийн аюулгүй байдлыг хангах байгууламжууд эзэлж байна.

II.4.2 Авто замын зурвас газар

Говь-Алтай аймгийн 2005 оны Газрын нэгдсэн сангийн ангиллын тайланд тусгаснаар аймгийн нутаг дэвсгэрт авто замын ангиллын 4462,9 га газраас 424,5 га нь улсын чанартай замтай бөгөөд түүний ихэнх нь Дарви, Дэлгэр, Есөн булаг, Тайшир, Шарга зэрэг хойд хэсгийн сумдын нутгаар дамжин өнгөрдөг. Аймгийн нийт замын 89,1 хувь буюу 3978,1 га нь орон нутгийн чанартай зам юм. Жаргалан, Баян-уул, Тайшир, Алтай, Бугат сумдад орон нутгийн зам 303,9-420 га-гаар тогтоогдсон нь аймагтаа эхний хэсэгт орж байна. Аймгийн дотоодын сум хоорондын болон нутгийн чанартай шороон замуудад нь улсын чанартай шороон замуудаас онц ялгарах зүйлгүй сайжруулах арга хэмжээ бараг хийгдээгүй байна.

Мянганы замын босоо тэнхлэгт хамаарах Бургастайн чиглэлийн зам Алаг нуурын говийн зарим хэсэгт 2005 онд засаж сайжруулан Тайшир, Естийн төмөр бетон гүүрийг ашиглалтанд оруулсныг дурьдах хэрэгтэй юм.

Цогт сум өөрсдийн хүчээр дотоодын чанартай замын бартааг арилгах, засаж сайжруулах замаар аймаг, баг бүрд хүрэх замыг хэдэн арван км-ээр дөт болгожээ. Гэвч аймгийн хэмжээнд тэгш тал газартаа зэрэгцээ олон салаа зам гарган хөрс, ургамал, бэлчээрийг доройтуулах явдал урдын адил гарсаар байна.

Агаарын тээврийн нислэгийн зурвас болон нислэгийн аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмж, байгууламж бүхий нисэх буудал нь стандартын дагуу байгуулагдсан учраас ашиглалт, хамгаалалт нь хэвийн явагдаж байна. Цаашид нислэгийн зурвасыг бетон хучилттай болгох нь тулгамдсан асуудал болоод байгаа юм.

II.4.3 Инженерийн шугам сүлжээний зурвас газар

Говь-Алтай аймгийн шугам сүлжээний дэд ангилалд хамаарах 1040,7 га газар бүртгэгдсэнээс 59,7 хувь буюу 6241,7 га нь холбооны шугамын газар юм. Холбооны шугам нь өндөр шонгуудын оройгоор газраас дээш агаараар татагдсан тул түүний зурвас газар нь хөдөө аж ахуйд ялангуяа бэлчээрт голчлон ашиглагдаж байна.

Шугам сүлжээний газрыг ийнхүү бэлчээрт ашиглаж буй нь тэндхийн хөрс элэгдэж, эвдрэх зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй боловч тухайн шугам сүлжээний газрын байрлалаас хамааран зурвас газрын ургамлын бүтэц, бүрэлдэхүүн, бүрхэвчинд тодорхой хэмжээний өөрчлөлт гарах нөхцөлтэй гэж үздэг.

Шугам сүлжээний дэд ангиллын 37,2 хувь буюу 387 га газрын эрчим хүчний шугам сүлжээ эзэлж байгаа нь өнгөрсөн оныхоос 116,65 га буюу 43,1 хувиар нэмэгджээ. Тайшир сумын, Улаан боомын усан цахилгаан станцаас Завхан аймгийн Улиастай хотын чиглэлд татах өндөр хүчдлийн шугамын зурсваст 113,7 га газар олгосон нь энд тооцогдсон байна. Мөн Чандмань сум эрчим хүчний дотоодын өргөтгөлд 0,5 зурвас газар нэмж эзэмшсэн нь тайлан бүртгэлд тусгагдсан байна.

Өндөр хүчдлийн шугам нь хоорондоо 200 м зайтай 8 м өндөртэй тулгууруудын хооронд татагдах учраас эрчим хүчний шугам зурвас газрын нэрээр бүртгэгдсэн дээрх газрыг бэлчээрт ашиглаж байна.

Дүгнэлт

Зам шугам сүлжээний газрын ашиглалтын тодорхойлолтоос дараахи дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Улсын чанартай автозамын сүлжээнд хатуу хучилттай зам тавигдаагүй.
2. Улсын чанартай шороон замуудад арчилгаа, тордолт бараг хийгдээгүй, тэмдэгжилт хангалтгүй. Төв суурин газраас олон чиглэлд зам гарснаас хот суурин газрын орчны газар автогений үүсэлтэй физик элэгдэлд хүчтэй орж байна.
3. Аймгийн газрын нэгдмэл сангийн тайлангийн зам шугам сүлжээний газрын ангилалд автозамын газрын хэмжээг алдаатай тооцсон.
4. Агаарын тээврийн нислэгийн зурвасыг бетон хучлагатай болгох, нислэгийн аюулгүй байдлыг хангах байгууламж, үйлчилгээний байрыг тохижуулах, инженерийн шугам сүлжээг шинэчлэн солих шаардлагатай гэж үзэж байна.

II.5 ОЙН САНГИЙН АНГИЛЛЫН ГАЗАР, ТҮҮНИЙ АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН БАЙДАЛ

Ойн сан нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ургадаг бүх төрлийн мод, заг, сөөг, таримал ойгоос бүрдэнэ. Ой бүхий газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн захаас гадагш 100 метр хүртэлх газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай нь ойн сан бүхий газарт хамаарна.

Говь-Алтай аймгийн хэмжээгээр 1970,659 га ойн сан бүхий газартайгаа улсын тусгай хамгаалалттай газарт 799396 га ойн сан бүхий газар байдаг. Иймээс аймгийн газрын нэгдсэн сангийн ангиллын тайланд 1221262 га ойн сан бүхий газар тусгагдсан байна.

Ойн бүс

Говь-Алтай аймгийн ойн санг бүсэд хуваахдаа “*Ойн тухай хууль*”-ийн 1-р бүлгийн 4-р зүйлийн 2-р заалтыг үндэслэн дараах бүсүүдэд ангиллаа.

Үүнд: 1. *Онцгой бүсийн*

- ❖ Цармын бүслүүрийн ой
- ❖ Дархан цаазат газрын онгон бүс

2. *Хамгаалалтын бүсийн*

- ❖ 30 хэмээс дээш налуу газрын ой

▪ Онцгой бүсийн ой

Онцгой бүсийн ойд цармын бүслүүрийн ой, дархан цаазат газрын онгон бүс, хамгаалалтын бүс, байгалийн цогцолборт газрын онцгой бүсийн ой хамаарна. Онцгой бүсийн ойд унанги, гишүү бэлтгэх, төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жагсаалтын дагуу тодорхой төрлийн ойн дагалт баялаг ашиглахаас бусад төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

▪ Хамгаалалтын бүсийн ой

Хамгаалалтын бүсийн ойд ойн тухай хуулийн 8-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тусгай хамгаалалттай газрын ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баян бүрд, 100 га хүртэл төгөл ой, зураа мод, сөөг, ширэнги, уулын өвөр энгэрийн төгөл ой, 30 хэмээс дээш налуу газрын ой хамраана.

Хамгаалалтын бүсийн ой нь байгаль орчны тэнцэл, хүн амын эрүүл ахуйн нөхцлийг хангах, хөрсний эвдрэлээс сэргийлэх, гадаргын болон газар доорх усны горимыг зохицуулах ач холбогдолтой.

Хамгаалалтын бүсийн ойн экологи-эдийн засгийн ач холбогдлыг харгалзан үзэж аж ахуйн төрөл 30 хэмээс дээш налуу газрын ой 2510 га буюу 28.4 хувь нь хамрагдаж байна.

Хамгаалалтын бүсийн ойд түүнийг хамгаалах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг сайжруулах зорилгоор арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ахуйн зориулалтаар түлээ бэлтгэх, ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглодог.

Аж ахуйн төрлүүд, түүний тодорхойлолт

- **30 хэмээс дээш налуу газрын ой**

“Ойн тухай хууль”-ийн гуравдугаар бүлгийн 10-р зүйлд “Хамгаалалтын бүсийн ойд 30 хэмээс дээш налуу газрын ой хамаарна” гэсэн заалтыг үндэслэн хүрч ашиглах боломжгүй хэт эгц газрын ойг аж ахуйн төрөлд оруулан ялгав. Энэ аж ахуйн төрлийн ой нь ихэвчлэн ус хагалбарын шугам дагуу байрлах учраас хөрсийг салхи, усны элэгдэл эвдрэлээс хамгаалах, гол үүрэг ач холбогдолтой бөгөөд ургах орчных нь тохиромжтой нөхцлийг алдагдуулахгүй байх, ойн хэвийн өсөлт, өөрөө аясаараа сэргэн ургах нөхцлийг хангах үүднээс дээрх аж ахуйн төрлийг тогтоодог.

- **100 га хүртэлх төгөл ой**

Энэ төрөлд бага хэмжээтэйгээр төгөл хэлбэрээр тархсан жижиг зураа, ширэнгэ, уулын өвөр энгэрийн төгөл ойг хамруулдаг. Эдгээр ой нь ойн талбайн цаашид тэлж ургах явцад ихээхэн ач холбогдолтой ихэнх нь залуу ой байдаг учраас хамгаалалтын бүсэд оруулдаг.

Ойн сангийн үндсэн үзүүлэлт

- **талбай**

Ойн санг ойн талбай, ойн бус талбай гэсэн үндсэн хоёр хэсэгт ангилах ба ойн талбай нь дотроо ойгоор бүрхэгдсэн талбай, ойгоор бүрхэгдээгүй талбай гэж хоёр хуваагддаг. Ойн бус талбайд ойн сан доторх цагаан энгэр, таг царам, хадлан, бэлчээр, гол, нуур, намаг, элс, мод үржүүлгийн талбай зэрэг газрууд ордог.

Говь-Алтай аймгийн ой нь гарал үүслийн хувьд өөрөө аясаараа сэргэн ургасан байгалийн ой бөгөөд ойн хэлбэрийн хувьд ихэвчлэн энгийн ой байх ба хөгшин моддын доогуур залуу модод ташинга үүсгэж ургаснаас нийлмэл ой үүссэн байдаг. Ойн бүрэлдэхүүний хувьд Шинэс ихэнх талбайд зонхилох ба улиас голын дагуу харьцангуйгаар бага талбайд тархан ургасан байна.

**Байгалийн ойн талбай нооц, насны анги, налуугийн бүлгээр
аж ахуйн төрөл тус бүрээр хуваарилагдах нь**

Модны төрөл	Насны анги										Дундаж өсөлт	нас	
	1	2	3	4	5	6	7	8	9	10-с их			Дүн
Аж ахуйн төрөл Жаргалант Онцгой бүсийн - Цармын бүслүүрийн ой													
Шинэс				12	8		8		6		34		
2-р				720	1280		880		600		3480	31.7	109.8
Шинэс			5	16			19	41	826	105	1012		
3-р			150	870			2090	4280	92420	13650	113460	667.5	170.0
Улиас							36				36		
1-р							2520				2520	38.8	65.0
Дүн	0	0	5	28	8	0	63	41	832	105	1082		
	0	0	150	1590	1280	0	5490	4280	93020	13650	119460		
Аж ахуйн төрөл Дархан цаазат газрын онгон бүс													
Шинэс									20		20		
2-р									1800		1800	10.6	170.0
Шинэс				83				342	1194	304	1923		
3-р				5810				37650	141070	34520	219050	1,311	167.1
Дүн	0	0	0	83	0	0	0	342	1214	304	1943		
	0	0	0	5810	0	0	0	37650	142870	34520	220850		
Аж ахуйн төрөл Есөн-булаг Хамгаалалтын бүсийн ой-Ногоон бүс													
Шинэс									54		54		
2-р									3780		3780	22.2	170.0
Шинэс									1139	80	1219		
3-р									135620	10400	146020	851.8	171.4
Дүн	0	0	0	0	0	0	0	0	1193	80	1273		
	0	0	0	0	0	0	0	0	139400	10400	149800		

Аж ахуйн төрөл Шарга Хамгаалалтын бүсийн ой-Ногоон бүс													
Шинэс					6			34			40		
2-р					480			4420			4900	34.0	144.1
Шинэс					32			95	213		340		
3-р					2560			12030	24230		38820	244.9	158.5
Дүн	0	0	0	0	38	0	0	129	213	0	380		
	0	0	0	0	3040	0	0	16450	24230	0	43720		
Аж ахуйн төрөл Халиун Хамгаалалтын бүсийн ой-Ногоон бүс													
Шинэс									42		42		
2-р									5460		5460	32.1	170.0
Шинэс									1277		1277		
3-р									162850		162850	958	170.0
Дүн	0	0	0	0	0	0	0	0	1319		1319		
	0	0	0	0	0	0	0	0	168310	0	168310		
Аж ахуйн төрөл Халиун Хамгаалалтын бүсийн ой-30 хэмээс дээш													
Шинэс									39		39		
2-р									4530		4530	25.2	179.6
Шинэс									2241	230	2471		
3-р									322100	29900	352000	2,261	155.7
Дүн	0	0	0	0	0	0	0	0	2280	230	2510		
	0	0	0	0	0	0	0	0	326630	29900	356530		
Аж ахуйн төрөл Онцгой бүсийн ой- Цармын бүслүүрийн ой													
Шинэс									128		128		
3-р									13940		13940	82	170.0
Дүн	0	0	0	0	0	0	0	0	128	0	128		
	0	0	0	0	0	0	0	0	13940	0	13940		

Аймгийн нийт дүн													
Шинэс	0	0	0	12	14	0	8	34	161	0	229		
2-р	0	0	0	720	1760	0	880	4420	16170	0	23950		
Шинэс	0	0	5	99	32	0	19	478	7018	719	8370		
3-р	0	0	150	6680	2560	0	2090	53960	892230	88470	1046140	6,163.6	169.7
Дүн	0	0	5	111	46	0	27	512	7179	719	8599		
	0	0	150	7400	4320	0	2970	58380	908400	88470			
Улиас	0	0	0	0	0	0	36	0	0	0	36		
1-р	0	0	0	0	0	0	2520	0	0	0	2520	38.8	65.0
Дүн	0	0	0	0	0	0	36	0	0	0	36		
	0	0	0	0	0	0	2520	0	0	0	2520	38.8	65.0
Нийт дүн	0	0	5	111	46	0	63	512	7179	719	8635		
	0	0	150	7400	4320	0	5490	58380	908400	88470			

Говь-Алтай аймгийн заган ойн тархалт

Баруун бүсийн ойн сан бүхий газрын 68 хувийг заган ой эзэлдэг. Үүний 75 хувь нь Говь-Алтай аймгийн Алтай, Бигэр, Бугат, Цээл, Шарга, Цогт, Төгрөг, Халиун, Эрдэнэ, Тонхил зэрэг 10 сумын нутгаар харилцан адилгүй хэмжээтэй тархан ургажээ.

Заган ойн тархалтын хойд хязгаар нь Шарга сум, Шаргын хоолой, урд талаараа Цогт, Эрдэнэ сумын нутаг, Хятад болон Монгол улсын хилийн дагуу, баруун хязгаар нь Тонхил сумын нутаг Товхон хүрэн толгой, Загийн элс, зүүн хязгаар нь Эдрэнгийн нурууны хойд тал, урд биеээр Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутагтай хил залгана.

Заган ойн нийт талбай нь түүний дагалдах бүрэлдэхүүнд багтах бут сөөгийн хамт 1970658 га талбайг эзэлж байгаа юм.

Заган ойн ургах орчин нөхцөл, хэв шинж

1975 оны судалгаагаар заган ойн хэв шинжийг гадаргын хэлбэр, хөрсний механик бүрэлдэхүүн, ургамлын бүрхэцээр тодорхойлжээ. Харин 1991 оны судалгаагаар энэ байдлыг харгалзан зонхилж байгаа дараах хэв шинжүүдийг сонгон авав. Үүнд:

1. Хайргат элсний
2. Шал тойрмын
3. Элсний элсэрхэг гүвэнт
4. Сайр садаргын зэрэг болно.

Загаар бүрхэгдсэн талбайг хэв шинжээр ангилан сум тус бүрээр хүснэгт 32-д үзүүлэв.

Хүснэгт 32

**Загаар бүрхэгдсэн талбайг хэв шинжээр,
сум тус бүрээр ангилах нь**

Сумын нэр	Заган ойн хэв шинж				Дүн
	Хайргат элсний	Шал тойрмын	Элсэрхэг гүвэнт	Сайр садаргын	
Бугат	38224				38224
Цээл		896			896
Эрдэнэ	56640	2176	51216	44840	154872
Шарга	7085	4354		18786	30225
Халиун		16901	716		17617
Алтай	24432	1872	3288	65792	95384
Цогт	95224	656		38936	134816
Тонхил			63040		63040
Аймгийн хэмжээгээр	221605	26855	118260	168354	535074
Эзлэх хувь, %	41.4	5.0	22.1	31.5	100

Заган ойн таксацын дундаж үзүүлэлт

Аймгийн хэмжээнд заган ойн дундаж нас 20 жил, дундаж чансаа III, өтгөрөл 0.3 байна. Тус аймгийн заган ойд явуулсан сүүлчийн давтан судалгаагаар заган ойн

нийт нөөцийг 522.3 мянган шоо метр, нас гүйцсэн загийн нөөц 392.5 мянган шоо метр, загаар бүрхэгдсэн ойн 1 га талбайн нөөцийг 1.0 шоо метр, заган ойн ерөнхий дундаж өсөлт 21.7 мянган шоо метр гэж тогтоожээ.

Хүснэгт 33

Говь-Алтай аймгийн заган ойн талбайн өөрчлөлт (га)

Нэр	Загаар бүрхэгдсэн	Загаар бүрхэгдээгүй	Тармаг	Огтлогдсон
1975 оны хайгуул судалгаагаар				
Аймгийн хэмжээгээр	353910		951785	48460
1991 оны хайгуул судалгаагаар				
Аймгийн хэмжээгээр	535074	126340	1155664	107976
Зөрүү	+181164		+203879	+59516

Хүснэгт 33-аас харахад тус аймгийн загаар бүрхэгдсэн ойн талбай 181164 га-гаар, тармаг заг 203879 га-гаар, огтлогдсон талбай 59516 га-гаар тус тус нэмэгдсэн байна. Загийн огтлогдсон талбай нэмэгдсэн нь сөрөг үзэгдэл юм.

Дүгнэлт

Ойн сангийн ангиллын газруудад ашиглалт хамгаалалын байдлын тодорхойлолтоос дараахи дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Алтай өвөр Эж хайрхан, Балгацтай, Хар үзүүр, Зайхуй-Зармангийн говь, Эдрэнгийн нурууны ар бэлээр сүүлийн жилүүдэд заг байгалийн жамаар нөхөн ургаж байна. Орчны тохиромжтой нөхцөл бүрдсэний улмаас нөхөн ургаж буй зулзган загийн ургах нөхцлийг бүрдүүлэх, элдэв механик гэмтлээс хамгаалах зохион байгуулалтын тал бүрийн арга хэмжээ авах нь зүйтэй.
2. Шинэсэн ба заг ойтой газруудын ашиглалтын нийтлэг нэг дутагдал нь түлшний хэрэгцээ болон бусад ахуйн зориулалтаар шинэс, загийг огтлох явдал юм. Нөгөө талаар шинэсэн ойн захаар хадлан авдаг нь ой тэлж ургахад сөрөг нөлөөлөл үзүүлж байна.
3. Ойн санг хамгаалах, түүний нөхөн ургах нөхцлийг бүрдүүлэхэд түлшинд хэрэглэх модны хэрэглээг багасгах, аймгийн нутаг дэвсгэрт өргөн тархсан нүүрсний орд газрыг түшиглэн шахмал түлш бэлтгэх, түүний ач холбогдлыг сурталчилж, улмаар иргэд малчдын өдөр тутмын хэрэглээ болгох нь чухал байна.

II.6 УСНЫ САНГИЙН АНГИЛЛЫН ГАЗАР, ТҮҮНИЙ АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН БАЙДАЛ

Говь-Алтай аймгийн усан сангийн ангиллын газарт 14254 га газар бүртгэгдсэний дотор гол мөрний эзлэх газар 2167 га буюу 15,2 хувь, нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар 12087 га буюу 84,8 хувийг тус тус эзэлж байна.

Дээрх үзүүлэлтээс дүгнэлт хийхэд тус аймгийн нутаг дэвсгэр, нуур цөөрөм элбэгтэй болох нь харагдаж байна.

Тус аймгийн гадаргын усны тооллогыг нийт сумдын нутаг дэсвгэрийг хамруулан 2003 онд аймгийн БОА-ны дарга Л. Түвдээр удирдуулан явуулжээ. Уг материалаас үзэхэд 219 гол горхи, 78 нуур цөөрөм, 771 булаг шанд, нийт 1078 ил задгай уст цэг тоологдсон байна.

Хүснэгт 34

Говь-Алтай аймгийн гадаргын усны тооллогын нэгдсэн дүн (2003 он)

Сумын нэр	Нуур, цөөрөм		Гол, горхи		Булаг, рашаан		Нийт		
	устай	хатсан	устай	хатсан	устай	хатсан	нуур	гол	булаг
Алтай	1		4		19	7	1	4	26
Баян уул	3		6		64		3	6	64
Бигэр	2		5		40	8	2	5	48
Бугат	6		17		115		6	17	115
Дарив	3		7		40		3	7	40
Дэлгэр	17		4				17	4	61
Есөн булаг	5		18		43		5	18	43
Жаргалан	5		17		15		5	17	15
Тайшир	1		7		28		1	7	28
Тонхил	5		15		77	2	5	15	79
Төгрөг			27		50	2		27	52
Халиун	1		25		23	3	1	25	26
Хөх морьт	4		5		11		4	5	11
Цээл	2		2	2	6	2	2	4	8
Чандмань	11		18		40		11	18	40
Цогт	1		4		31	4	1	4	35
Шарга	4		27		51		4	27	51
Эрдэнэ	7		9		22	7	7	9	29
Дүн	78		217	2	736	35	78	219	771

Цээл сумын Татал, Хужиртын голууд, Алтай, Бигэр, Эрдэнэ зэрэг 8 сумын нутагт 35 булаг шанд хатаж ширгэсэн тооцоо гарчээ. Эдгээрийн зарим нь хур тунадас элбэгтэй жил сэргэдэг ажээ.

Улсын нэгдсэн бүртгэлд буй гадаргын усны тоо баримтаас дээрх тооллогын материал нилээд зөрүүтэй гарчээ. Тухайлбал: Нуур цөөрөм 50, гол горхи 133, булаг шанд 141-ээр тус бүр илүү тоологдсон байна.

Уг материалыг нэгтгэх явцад Баян-уул, Дарви, Төгрөг, Дэлгэр сумуудын булаг шандны тоог зөрүүтэй гаргасан, Халиун сумын Ёлтонгийн услалтын системийн хиймэл цөөрмийг орхигдуулсныг энд тооцож оруулсан болно.

Энд 0,5 км²-аас (50 га) дээш талбайтай нэр бүхий 29 нууруудын үндсэн үзүүлэлтийг оруулав. Эдгээр нууруудын нийт талбай нь 125,1 км² болно.

Мөнх цаст Сутай хайрханы /4090 м/ оргилд бага хэмжээний хур цас байдаг. Энэ гөлчир мөстөл нь 13,9 км² талбайг эзлэх бөгөөд жилд 296 мм хэмжээний мөс хайлж урсдаг онцлогтой.

Хасагт хайрхан, Бурхан буудай зэрэг уулсын оройн хэсгийн цас зуны дунд сар хүртэл тогтож удаан хайлдаг бөгөөд зарим жилд хайлж дуусахгүй өнжих явдал ч үзэгддэг.

Хүснэгт 35

Говь-Алтай аймгийн нууруудын үндсэн үзүүлэлтүүд
/0.5 км² -аас дээш талбайтай/

Д/д	Нууруудын нэр	Үнэмлэхүй өндөр /м/	Гадаргын талбай /км ² /	Урт /км/	Өргөн /км/		Гүн /м/		Усны эзэлхүүн /км ³ /	Ерөнхий эрдэсжилт /г/л/
					Дундаж	их	Дундаж	их		
1.	Алаг нуур	1036	6.8	5.1	1.3	4.0	0.7	1.6	0.0040	
2.	Тонхил нуур	2026	6.2	4.6	1.4	2.6	1.0	1.6	0.0059	115.200
3.	Хулма нуур	2234	8.5	4.2	2.0	3.4	0.7	2.0	0.0061	282.970
4.	Улааны нуур	1750	0.5	1.7	0.3	1.4	0.7	1.3	0.0003	
5.	Давсан нуур	1750	0.5	1.7	0.3	1.4	0.5	1.8	0.0003	226.600
6.	Тайган /баясан/ нуур	1780	4.1	1.7	1.4	1.5	0.9	1.9	0.0036	15.600
7.	Бигэр нуур	1287	7.4	5.7	1.2	2.3	0.9	2.0	0.0010	173.910
8.	Буур нуур	1149	10.6	5.7	1.8	2.2	0.6	1.5	0.0060	
9.	Хутаг нуур	2108	8.1	6.5	1.2	1.9	0.3	0.8	0.0020	
10.	Шавартын нуур	2185	0.6	1.5	0.4	0.8	0.5	1.4	0.0003	
11.	Ихэс нуур	1604	19.3	6.4	3.0	3.9	0.6	1.7	0.0110	155.360
12.	Шаргын цагаан нуур	2964	15.7	5.0	3.0	4.8	0.5	1.5	0.0080	
13.	Тамча нуур	2446	6.6	1.5	0.4	1.0	0.6	1.3	0.0004	
14.	Амтгайн нуур	2176	0.5	1.5	0.3	0.8	0.7	1.5	0.0003	
15.	Сангийн далай нуур	2681	0.5	1.6	0.3	0.4		1.8		
16.	Төхөм нуур	1456	0.6	1.7	0.3	0.7	0.4	12.0	0.0002	
17.	Бага нуур	2110	1.7	1.8	0.3	1.3	0.3	1.1	0.0005	
18.	Баруун үзүүрийн олгой нуур	2110	1.9	3.0	0.6	1.1	0.5	1.6	0.0009	
19.	Доод нуур	1289	0.6	1.5	0.4	0.6	0.5	1.5	0.0003	
20.	Дунд нуур	1290	0.5	1.9	0.2	0.3	0.5	1.3	0.0002	
21.	Хулангийн тойром нуур	920	0.5	1.8	0.2	0.3	0.4	1.1	0.0002	
22.	Сангийн далай нуур	1355	15.5	7.9	1.8	2.6	1.6	3.8	0.0250	45.900
23.	Эрээн нуур	1451	4	3.8	1.2	1.7	2.1	4.0	0.0084	
24.	Бударганат дөрөө нуур	1442	0.5	1.1	0.8	0.8	1.0	1.5	0.0005	
25.	Дөрөө нуур	1420	1.7	1.6	1.0	1.4	1.7	3.0		
26.	Цоохор нуур	1120	1.1	3.6	0.4	0.9	0.3	1.0	0.0003	
27.	Гүн нуур	1311	0.5	1.2	0.3	0.8	1.2	3.0		
28.	Ногоон нуур	2085	0.5	1.3	0.3	0.3	0.4	1.2	0.0020	
29.	Дагналтай /Тагналт/ нуур	1778	0.6	1.5	0.4	0.4	1.2	3.0	0.0007	

Аймгийн хэмжээнд томоохонд тооцогдох Завхан гол нутгийн хойт захаар урсдаг, түүний ус цуглуулах талбайг 71210 ам.км гэж тооцсон байдаг. Завхан голын хөвөөгөөр Гуулин тосгон, Тайшир сумын төвүүд байрлах хэдий ч голын усыг бохирдуулах нөлөө үзүүлдэггүй. Завхан голын усыг Гуулингийн услалтын системээр дамжуулан газар тариаланд ашигладаг. Сүүлийн жилүүдэд Тайширын Улаанбоомд далан байгуулан усан цахилгаан станц барьж байна. Өндөр уулсаас эх авсан Төгрөг, Сагсай зэрэг голуудад далан боолт барьж усалгаатай тариалан, төмс хүнсний ногоо, таримал тэжээл, жимс жимсгэнэ тариалахад өргөн ашиглаж иржээ.

Сүүлийн жилүүдэд услалтын системүүдийн ихэнх толгойн барилга, ус дамжуулах суваг шуудуу хоолойнууд нь эвдэрсэн, усалгааны тоног төхөөрөмжүүд тоногдож үрэгдсэн зэргээс шалтгаалан зөвхөн гар аргаар услах болжээ. Энэ нь усалгаатай газар тариалан эрхлэх үйл явцад гарсан хамгийн харамсалтай ухралт юм. Алтай, Тонхил сумын төвд орших рашаан болон булгийг хашаажуулан мал амьтан орж булгийн эхийг бохирдуулах явдлаас хамгаалжээ.

Дүгнэлт

- 1) Говь-Алтай аймгийн гол горхи, нуур цөөрөм булаг шандыг ихэнхдээ бэлчээрийн усан хангамжинд зориулан ашигладагаас байгалийн унаган төрхөө хадгалж үлдсэн байна.
- 2) Өмнөх жилүүдэд инженерийн хийцтэй 17 услалтын систем, олон арван энгийн усалгааны суваг шуудуу татан гол горхийн голдирлыг өөрчилсөн боловч тэдгээрийн ашиглалт, хамгаалалт хангалтгүй багахан хэмжээний талбайд тохиромжтой гар усалгааны аргаар инженерийн хийцтэй байсан томоохон услалтын системийн талбайг усалж буй нь усны алдагдлыг ихэсгэх болон үр ашиггүй зарцуулахад хүргэж байна.
- 3) Аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудын нуур цөөрөм, гол горхиуд, булаг шанд орчмын газруудад ил задгай түлсэн галын нурам үнс, ахуйн хог хаягдлаар бохирдохын зэрэгцээ газрыг ухаж хөндөх, автомашин, техникээр талхлагдах зэрэг доройтлын шинж тэмдгүүд илрэх болжээ.

II.7 ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ АНГИЛЛЫН ГАЗАР, ТҮҮНИЙ АШИГЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ОДООГИЙН БАЙДАЛ

II.7.1 Тусгай хэрэгцээний газрын бүтэц

Говь-Алтай аймгийн тусгай хэрэгцээний газар нь улсын тусгай хамгаалалттай газар нутаг, хилийн зурвас газар, улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгогдсон газар, шинжлэх ухаан техникийн сорилт, туршилт болон байгаль орчин цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай гэсэн ангиллуудад хуваагддаг. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 29,5 хувийг тусгай хэрэгцээний ангиллын газар эзэлж байна.

Хүснэгт 36

Тусгай хэрэгцээний газрын ерөнхий бүтэц /га/

Тусгай хэрэгцээний газрын ерөнхий бүтцийн дэд ангиллуудын нэр		Хэмжээ га	%
Тусгай хэрэгцээний газар бүгд		4175270.2	100.0-
Үүнээс	Тусгай хамгаалалттай газар нутаг	3745444	89.7
	Улсын хилийн зурвас газар	315705	7.6
	Аймаг дундын отрын бэлчээрийн газар	114000	2.7
	Бусад газар	121.2	0.003

Дээрх хүснэгтийн үзүүлэлтээс үзвэл тус аймгийн тусгай хэрэгцээний газрын ихэнх хэсэг буюу 87,7 хувийг улсын тусгай хамгаалалттай газар эзэлдэг. Эдгээрт ДЦГазар 2, БНГазар 4, БДГ 1 багтдаг. Улсын хилийн зурвас газар 7,6 хувийг эзэлж байна. Харин аймаг дундын отрын бэлчээрийн газар 2,7 хувийг эзэлдэг бөгөөд Дэлгэр, Чандмань, сумдуудын нутагт байдаг. Бусад газар гэсэн хэсэгт улсыг батлан хамгаалахад зориулагдсан 26,2 га, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 95 га газрууд тус тус хамрагддаг. Тусгай хэрэгцээний газарт эдгээрийн эзлэх хувийн жин өчүүхэн бага юм.

Аймгийн газрын 2005 оны тайланд байгалийн нөөц газар болох Шарга-Манхан, Алагхайрхан уул, Бурхайнбуудай уулын дэвсгэр газрыг байгалийн цогцолборт газрын ангилалд оруулан алдаатай тооцсон байна.

Мөн шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбайн хэмжээг 2004 оны аймгийн газрын тайланд 0,5 га газар бүртгэгджээ. Гэтэл 2005 оны тайланд 95 га болон өсгөж тооцсон нь эргэлзээтэй юм.

II.7.2 Тусгай хамгаалалттай газар, түүний ашиглалт хамгаалалтын өнөөгийн байдал

Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрт нийтдээ 3745444 га талбай бүхий 6 тусгай хамгаалалттай газар байгаа нь аймгийн нутаг дэвсгэрийн 26,5 %-ийг эзэлнэ.

Эрдэмтдийн судалгаанаас үзэхэд Монгол орны ургамал, амьтны аймгийн 200 орчим төрөл зүйл устаж үгүй болох аюул тулгараад байгаа бөгөөд нэн ховор, ховор амьтны ангилалд 100 гаад төрөл зүйл, нэн даруй хамгаалах шаардлагатай 128 төрөл зүйлийн ургамал байдаг нь Монгол улсын улаан номонд орсон байна. Эдгээр ховор амьтан ургамлын дотор Говь-Алтай аймагт, цаашилбал Говийн их дархан цаазат газарт Монгол Улсын ан агнуурын тухай хуулиар нэн ховор амьтны бүртгэлд орсон 11 зүйл хөхтөн амьтдын 6 зүйл (54.5%), Засгийн газрын 1995 оны 152-р тогтоолоор баталсан ховор амьтны бүртгэлд орсон 12 зүйл хөхтөн амьтдын 8 зүйл (66,6%), Монгол Улсын улаан номонд /1997/ устаж, ховордож буй амьтны ангиллаар бүртгэгдсэн 30 зүйл хөхтний 17 зүйл (57.6%), 30 зүйл шувуудын 5 зүйл (16.6%), 5 зүйл мөлхөгчдөөс 4 зүйл (80%), 4 зүйл хоёр нутагтнаас 1 зүйл (25%), Олон улсын улаан ном /IUNC/-д бүртгэгдсэн монгол орны 8 зүйл хөхтний 6 зүйл (75%), Зэрлэг амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц /CITES/ -ийн 1-р хавсралтанд бүртгэгдсэн манай орны 12 зүйл хөхтөн амьтны 4 зүйл (33.3%), 2-р хавсралтанд бүртгэгдсэн 6 зүйл хөхтөн, 11 зүйл шувуу, 1 зүйл мөлхөгч нийт 17 зүйл амьтан тус дархан газрын нутагт тархан амьдарч байна. Тус дархан газарт эрдэмтдийн судалгаагаар 49 овог, 195 төрөлд хамаарах 410 зүйлийн дээд ургамал бүртгэгдсэн. Үүнээс Алтайн өвөр говийн “А” хэсэгт 266 зүйл ургамал тэмдэглэгджээ. Энэ бүхэн нь тус аймгийн байгалийн нөхцөл, нөөц, дархан газрын үнэ цэнийг илэрхийлж байна.

Энэ бүх ховор амьтан, ургамал, унаган төрхөө харьцангуй сайн хадгалсан экосистемээ хамгаалахаар дархан цаазтай газар 2 (Говийн их дархан цаазат газар, Хасагт Хайрхан), байгалийн нөөц газар (Бурхан буудай, Алаг хайрхан, Шарга-манхан), байгалийн дурсгалт газар 1 (Ээж хайрхан уул) байгуулсан байна.

Хүснэгт 37

Говь-Алтай аймгийн тусгай хамгаалалттай газрууд

д/д	ТХГН-ийн нэр ангилал	Талбайн хэмжээ /га/	Хамгаалалтад авсан он	Аль сумын нутаг болох
Дархан цаазат газар				
1	Говийн их дархан цаазат газар	5311730	1975	Говь-Алтай аймгийн Алтай, Тонхил, Бугат, Цогт, Эрдэнэ, Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст, Ховд аймгийн Үенч, Алтай,
2	Хасагтхайрхан	27448	1965	Говь-Алтай аймгийн Тайшир, Шарга, Жаргалант сум
	Байгалийн нөөц газрын дүн	5339178		
3	Алагхайрхан уул	36400	1996	Говь-Алтай аймгийн Бугат сум
4	Бурханбуудай уул	52110	1996	Говь-Алтай аймгийн Бигэр, Цогт, Халиун сумд
5	Шарга-Манхан	390071	1993	Ховд аймгийн Буянт, Манхан, Говь-Алтай аймгийн Тонхил, Дарви, Төгрөг, Халиун сумд
	Дурсгалт газар дүн	478581		
6	Ээж хайрхан	22475	1992/1995	Говь-Алтай аймгийн Цогт, Алтай сумд
	Нийт дүн	5840234		

Дархан цаазат газруудын товч тодорхойлолт

Дархан цаазат газар нь олон төрлийн хамгаалалттай нутаг дэвсгэрүүдийн дотроос хамгийн дээд хэлбэр нь бөгөөд байгалийн унаган төрхийг хэвээр нь хадгалах, удаан хугацаагаар хамгаалж судлахаар аж ахуйн үйл ажиллагаанаас чөлөөлөгдсөн, тухайн нутгийнхаа шинж байдал, онцлогийг төлөөлж чадахуйц загвар нутаг юм. Байгалийн унаган төрхийг хэвээр нь хадгалах, байгалийн үзэгдэл, үйл явцыг өөрийн нь хөгжил хөдөлгөөн дунд нь судлах, байгаль хамгаалах шинжлэх ухааны үндэслэл боловсруулах зорилгоор дархан цаазат газрыг байгуулдаг тул дархан цаазат газарт аж ахуйн ямар нэг объект байх ёсгүй бөгөөд тэнд байгаа байгалийн баялгийг ашиглах, ан амьтдыг үргээж байршлыг нь алдагдуулах үйл ажиллагаа байж болохгүй. Нэг үгээр хэлбэл дархан цаазат газар нь байгаль хамгааллын дээд хэлбэр учраас байгалийн унаган төрхийг хэвээр хадгалж буй ямар ч өөрчлөлтгүй байгалийн жишүүр хэсэг юм. Түүнээс гадна дархан цаазат газрыг байгуулах зайлшгүй нэг нөхцөл нь эрдэм шинжилгээний ажил явуулах асуудал болно. Дархан цаазат газрын гол чиглэл нь хамгаалалтын горимыг чанд мөрдөж байгалиа судлах, ан амьтан, ургамлыг нь өсгөж үржүүлэх, хамгаалах явдал юм.

Тус аймгийн төдийгүй Монгол улс, цаашилбал дэлхийн хэмжээнд томоохонд орох Говийн их дархан цаазат газарт БОЯ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн газар, Даян дэлхийн байгаль орчны сан хамтран хэрэгжүүлж буй “Их говийн экосистем, түүний шүхэр зүйлийг хамгаалах” төсөл 2003 оны 7 сараас хэрэгжиж эхэлсэн бөгөөд дархан цаазат газрын хамгаалалтын менежментийг сайжруулахад тодорхой ажлууд хийгдэж байна. Цаашид Говь-Алтай аймгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах, нутгийн иргэдийн амьдралын нөхцлийг сайжруулахад тодорхой нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

- ***Говийн их дархан цаазат газар***

Төв Азийн их цөлийн хойд хэсэг, говь цөлийн эмзэг экосистемийг хамгаалах, Монгол оронд төдийгүй дэлхийд ховордож Олон улсын болон Монгол улсын улаан номонд орсон хавтгай, хулан, хар сүүлт, мазаалай, ирвэс, аргаль, янгир зэрэг ан амьтан, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах, тогтвортой өсөлтийг хангах зорилгоор 1975 онд БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 84 дүгээр зарлигаар дархан цаазат газар болгожээ. 1990 онд Олон улсын шим мандлын нөөц газраар батлагдаж эрдэм шинжилгээний өргөн мэдээлэл харилцан солилцох, Төв Азийн цөлийн экосистемийг олон улсын түвшинд судлах, хамгаалах өргөн боломж нээгджээ. Тусгай хамгаалалттай газар нутгийн шинэ ангиллын дагуу дархан цаазат газрын шалгуурт бүрэн тохирч байгаа учраас хэвээр нь үлдээсэн бөгөөд УИХ-ын

1995 оны 26 дугаар тогтоолоор батлагджээ. Говийн их дархан цаазат газар нь Монгол орны баруун өмнөд хэсэг Алтайн нурууны өвөрт оршино. Говийн их дархан газарт Говь-Алтай аймгийн Цогт, Эрдэнэ, Алтай, Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумдын нутгийн Шарагдайн хөндийн сайр, Шивээт улаан, Юмт уулс, Эдрэнийн нуруу, Атас Чингис, Ингэс уул, Таргын ус, Хуцын шанд, Буурал дэлийн овоо, Ховд аймгийн Үенч, Алтай, Говь-Алтай аймгийн Бугат, Тонхил сумдын нутаг Бага Хавтаг, Тахийн шар нуруу, Эрээн толгой, Тахийн ус, Хөндлөн, Дуут уул, Хатавчийн булагийн улсын хилээр хязгаарласан 2 тусдаа нутаг хамрагдана. Үүнийг дархан газрын “А”, “Б” хэсэг гэж нэрлэх бөгөөд нийтдээ 5.3 сая га талбайг эзэлдэг бөгөөд талбайн хэмжээгээр дэлхийн хэмжээнд 15-рт ордог. Говийн их дархан газрын А, Б хэсэг нь хоорондоо Аж богд, түүний өвөр бэлийн 150 гаруй км өргөн зурвасаар тусгаарлагдах тул эдгээр нь ландшафтын төрх, байгалийн муж, бүсийг төлөөлөх шинжээрээ харилцан адилгүй юм. Төв Азийн их цөлийн хойт хил болох Говийн их дархан цаазат газар нь байгалийн нөхцлийн хувьд Баруун хуурайн хотгор, Алтайн өвөр говийн биеэ даасан 2 мужийг төлөөлөх цөлийн бүсэнд орших жинхэнэ цөлийн дүр төрхтэй нутаг билээ.



Зураг 3. Говийн Их дархан цаазат газар

Дархан цаазат газрын А хэсэг болох Алтайн цаадах говийн амьд байгаль нь хэдийгээр тодорхой хэмжээгээр хомс боловч Төв Азийн гандуу бүсэд хэт гандуу цөлийн онцлогийг төлөөлсөн өөрийн өвөрмөц онцлог бүхий амьтан ургамалтай. “А” хэсгийн гадаргад хотгор, хонхор, говь хоолой түгээмэл, мөн хадат уулс, цавчим эгц хажуутай оорцог, уул толгод ихтэй. Алтайн цаадах говьд эртний үлдмэл болон унаган амьтан, ургамал тархсан нь гандуу уур амьсгалтай энэхүү нутагт зонхилсон эх газарлаг уур амьсгал энэхүү нутгийн хөгжлийн үе шатанд эх газрын үеийн үргэлжлэх хугацаагаар тодорхойлогддог. Энэ нь дархан газрыг шим мандлын эталон

хэсэг болохыг тодорхойлно. Нөгөө талаар Алтайн цаадах говийн экосистем хүн ам сийрэг суурьшдагаас аж ахуйн үйл ажиллагааны нөлөөнд өртөөгүй, унаган төрхөө харьцангуй хадгалсан, удаан хугацааны хөгжлийн түүхэнд бий болсон байгалийн үйл явцын унаган загвар нутаг юм. Түүнээс гадна дэлхийд ховордсон томоохон хөхтөн амьтдын тархац нутаг бөгөөд Олон улсын улаан номонд орсон хавтгайн тархац нутаг зөвхөн энд байдгаараа онцлогтой.



Зураг 4. Говийн мазаалай



Зураг 5. Тахь

Дархан цаазат газрын Б хэсэг нь Зүүнгар-Казахстаны цөлийн мужийн зүүн хэсгийг төлөөлөх бөгөөд Дундад Ази, Казахстан, Төв Азийн цөлийн нөлөөн дор үүсч хөгжсөн өөрийн өвөрмөц онцлогтой. Газарзүйн энэхүү байрлал нь байгаль нөхцлийн хувьд ч, амьтан, ургамлын хувьд ч завсрын шинж төрхийг бий болгодог. Зүүнгарын говьд харьцангуй “зөөлөн” уур амьсгалтай бөгөөд тэр нь амьтан, ургамлын аймагт тусгалаа олсон байдаг. Иймээс дархан цаазат газрын Б хэсэг өөр хэв шинжийн цөлийн эталон нутаг болдог.

Говийн их дархан цаазат газрын “А”, “Б” хэсгийн дэвсгэрт ашигт малтмал, эрт галавын амьтан болон ургамлын чулуужсан үлдэц, түүхийн дурсгалт зүйлс гэх мэт байгалийн болон түүхийн холбогдолтой баялаг багагүй бий. Мөн эртний амьтны чулуужсан үлдэц, “Б” хэсгийн Халзан уулын баруун өвөр Өвдөг гүнгэд хуучин шинэ чулуун зэвсгийн үеийн чулуун зэвсэг, булш ихтэй.

Говийн их дархан цаазат газрын хөрс, ургамал уур амьсгалын онцлог байдалтай шууд холбоотой, хөрс нимгэн, элсэрхэг, хайрхаг, хужир элбэгтэй, хуурайдуу, шим тэжээл дутмаг. Энд монгол өвст, монгол өвс-хазаар өвс, монгол өвс-таанат, монгол өвс-бударганат, монгол өвс-агьт цөлөрхөг хээр зонхилно. Цөлийн ургамалшлаас зүйл бүрийн бударгана, дэрс, шар мод, буйлс, харгана, заг голлохоос гадна булаг, шанд, баянбүрд зэрэг газраа тоорой, жигд, хайлаас, сухай, хармаг, гоёо, таана, боролзой, зээргэнэ, шаваг, шарилж, ортууз зэрэг элдэв модлог, бутлаг, өвслөг ургамлаар нилээд баялаг. Шал тойром, элс манхан зэрэг огт ургамалгүй газар ч мэр сэр тохиолдоно.

Амьтны аймгийн хувьд дархан газрын “А” хэсэгт 192 зүйл, “Б” хэсэгт 204 зүйл амьтан байдаг. Говийн их дархан газарт Олон улсын болон Монгол улсын улаан номонд орсон хавтгай, хулан, хар сүүлт, хулан, мазаалай, ирвэс, аргаль, янгир зэрэг ховор амьтад, хойлог, ёл, тас, сар, ууль, бэгбаатар, шар шувуу зэрэг шувууд бий. Эдгээр амьтдаас мазаалай, хавтгай, бөхөн, аргаль, янгир, ирвэс зэрэг амьтад ховордсоор байна.

- ***Хасагт Хайрханы дархан цаазат газар***

Хасагт Хайрхан уул Говь-Алтай аймгийн Шарга, Жаргалан, Баян-Уул, Тайшир сумдын нутагт Их Нууруудын хотгор руу гүн түрж орсон Алтайн салбар уулсын нэгэн билээ. Энэ уулсын хамгийн өндөрлөг төв хэсэг болон ар хажуу дагуухи модтой хэсгийг хамруулан буга зэрэг ховор ан амьтан, байгалийн үзэсгэлэнт байдлыг хамгаалах зорилгоор 1965 онд дархан газар болгожээ. Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн шинэ ангиллын дагуу дархан газарт бүрэн тохирч тэр ч байтугай талбайг нь өргөтгөх шаардлагатай учраас УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолоор дархан газраар нь хэвээр үлдээжээ. Нийт талбай нь 27.4 мян.га болно.

Хасагт Хайрханы шохойн чулуу, гантиган уулсад том жижиг агуй хонгил цөөнгүй бий. Хасагт Хайрханы хилийн дотор гадна нийтдээ 30-40 агуй байна. Эрт цагт Хасагтхайрхан нь Алтайн нурууны бусад өндөр уулсын адил мөнх цас мөсөөр бага зэрэг хучигдаж байсан бөгөөд орчин үеийн хур цастай оргилуудад мөстлийн хунх, хуниас, мөстлөөр гулсан буусан мөлгөр чулуу бага зэрэг тохиолдоно.

Хасагт Хайрханы ноён оргилууд их төлөв кемберийн түрүү, хожуу үеийн хувирмал занар, цахиурлаг занар, хувирмал элсэн чулуу, мөлгөр хөрзөн, доломит, алевролит, андезит, цагаан занар зэрэг эртний хурдас чулуулгаас голлон тогтжээ.

Хасагт Хайрхан уул нь ус зүйн сүлжээгээр баян. Гол ноёлогуудаас эх авсан олон гол горхи гүн хавцал хөндийгөөр урсах ба уулсаас буухдаа бэлийнхээ хурдсанд шурган замхрана.



Зураг 6. Хасагт хайрхан

Хасагт Хайрхан уул нь амьтны аймгаар баян. Энэ ууланд Монгол Алтайд тархсан ховор амьтад нутагшсан. Монгол улсын улаан номонд орсон буга, суусар, аргал, янгир, хойлог, ирвэс, ёл бий. Мөн ой хад асгаар шилүүс, цагаан үен, жирх, тагуудад цагаан ахууна элбэг.

Говь-Алтайн нурууны салбар болох Хасагт Хайрхан уул нь дархан цаазтай олон зүйл амьтантай, ландшафтын олон янз хослол бүхий байгалийн мужийн төлөөлөл сайтай дархан цаазат газар юм.

Байгалийн нөөц газрууд

Энэхүү ангилал нь ОУБХХ-ны ҮІ ангилалтай тохирдог. Нөөц газар, нөөцийг зохицуулалттай ашиглах газар зэрэг ангиллууд нь байгалийн тодорхой нөөцийг хамгаалах зорилготой билээ. Тэгэхээр өргөн утгаар нь авч үзвэл тусгай хамгаалалттай газар нь байгалийн нөөцийг хамгаалж байна гэж үзэж болно.

Одоо манай улсад нийтдээ 18 нөөц газар байгаа нь нийт тусгай хамгаалалттай газар нутгийн 9.1 хувийг эзэлж байна. Эдгээрийн 3 нь Говь-Алтай аймагт байна.

- ***Шарга-Манханы байгалийн нөөц газар***

Говь-Алтай, Ховд аймгуудын нутагт орших дархан цаазтай амьтан болох бөхөнг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилгоор 1993 онд УИХ-ын 83 дугаар тогтоолоор байгалийн нөөц газар болгон тусгай хамгаалалтад авсан байна. Нийтдээ 390.0 мян. га талбайг эзэлнэ. Дэлхий дээр одоо байгаа хоёр зүйл бөхөнгийн нэг болох монгол

бөхөн нь өөр хаана ч байхгүй монголын унаган амьтан бөгөөд сүүлийн жилүүдэд нэлээд ховордож байгаа учраас дархан цаазтай болгосон байна.



Зураг 7. Бөхөнгийн янзага

Нөөц газарт Говь-Алтай аймгийн Төгрөг, Тонхил, Дарви, Халиун сумдын нутагт Шаргын говийн Төгрөгийн тал, Далан түрүү, Төхөм, Тунгалаг, Хүрэнгол, Бумбат, Өгөөмөрийн тал, Бугуйн далан, Хацавч, Харгахын худгийн тал, Эрээн, Ихэс нуурын хотгор, Бага Дарвийн бэл, Цангилахын сайрын зүүн баруун тал, Бөөрийн хотгор, Ховд аймгийн манхан сумын Онц толгойн гүдэн, Цэнхэрийн голуудын адгийн хөндий, Хөдөө, Цагаан бургасны ам зэрэг газрууд хамрагдана.

Бөхөнгийн байршилттай уялдан нөөц газрын дэвсгэр нутаг тал, хотгор гадаргатай, геологийн тогтоцын хувьд дөрөвдөгчийн нас бүхий пролюви, делюви-пролюви, нуурын гаралтай хурдас чулуулгаас тогтоно. Уг нөөц газрын нутаг дэвсгэрийн ихэнх хэсгийг Шаргын хотгорын төвөөс урагш хэсэг эзэлнэ. Шаргын хотгор нь ерөнхийдөө өргөрөгийн дагуу суналтай, баруунаас зүүн тийшээ 150-160 км урт, хойноос урагшаа 70-80 км өргөн нилээд гүн хотойсон хаагдмал хотгор юм. Энэ хотгор нь урд талаараа Алтайн гол нуруугаар хүрээлэгдэх тул нөөц газрын гадарга нь уулсаас буусан хуурай сайраар ихээхэн хэрчигдсэн байдаг. Эндэхийн хамгийн нам цэг нь 948 м, хамгийн өндөр цэг нь д.т.д 1700 м болно.

Шаргын хотгор нь ерөнхийдөө цөлийн ландшафттай, харин хотгорын төв хэсэгт Молцог элс, далагнасан молцог, довцог элс бүхий элсэн тарамцагууд оршино. Мөн энд Шаргын цагаан нуур орших ба түүний эргэн тойронд хужир мараа бүхий ландшафттай.

Хөрсний хувьд нөөц газрын цөлийн бор саарал, хээржүү цөлийн бор, хэт гандуу цөлийн борзон хөрс тархана.

Ургамлын бүрхэвчинд Шаргын хотгорт загт, баглуурт, хялгана-боролжит, дэрст, улаан бударганат бүлгэмдэл тархсан байна.

- ***Алаг хайрханы байгалийн нөөц газар***

Говь-Алтай аймгийн Бугат сумын нутагт орших Алагхайрхан уул нь аргаль, янгир зэрэг агнахыг хуулиар хориглосон амьтан, ховор эмийн ургамал бүхий үзэсгэлэнт сайхан нутаг юм. УИХ-ын 1996 оны 43 дугаар тогтоолоор ландшафтын иж бүрдлийг хамгаалах нөөц газар болгожээ. Нийтдээ 36.4 мян.га талбайтай.

Монгол Алтайн нурууны дунд хэсгийн өндөр уулын нэг нь болох Алагхайрхан түүний орчмын уулс нь ихэнхдээ тэгш хавтгай оройтой боловч өгөршлийн нөлөөгөөр тэгш гадаргуу нь эвдэрч шовх, эсвэл нарийхан зурвас хэлбэртэй болсон байдаг. Тус уулын хажуу эгц бөгөөд эртний мөстлийн үеийн мөсөн голын нөлөөгөөр үүссэн хунх, тэвшин хөндий элбэгтэй. Энэ нутаг нь Алтайн уулт өндөрлөгийн мужид багтдаг бөгөөд Дунд Хайрхан, Бага Хайрхан зэрэг салбар уулсаас тогтоно. Алагхайрхан уулын ноён оргил нь 3738 м өндөр, мөнх цастай, жилийн аль ч улиралд 30-90 мм хүртэл хур тунадас унадаг. Алагхайрхан уулнаас Хөх сайр, Цахир, Босго, Хатуу, Улиастай зэрэг олон голууд эх авч урсдаг. Энд өндөр уулын олон зүйлийн амьтад байдгаас ховорт тооцогдох аргаль, янгир, ирвэс, суусар, шилүүс, хойлог зэрэг хөхтөн, жигүүртэн болон вансэмбэрүү, сэржмядаг, эрээ гомбо, юмдүүжин, бамбай, нохойн хошуу зэрэг эмийн ховор ургамал элбэгтэй.



Зураг 8. Алаг хайрхан

- ***Бурхан буудайн байгалийн нөөц газар***

Говь-Алтай аймгийн Бигэр, Цогт, Халиун сумдын нутгийг хамарна. Бурхан буудай уулын өвөрмөц үзэсгэлэнт тогтоц, эртнээс бишрэн шүтэж ирсэн уламжлалыг хадгалан үлдээх, ашиглалт, хамгаалалтыг зүй зохистойгоор явуулах зорилгоор УИХ-ын 1996 оны 43 дугаар тогтоолоор тусгай хамгаалалтад авчээ. Талбайн хэмжээ 52.1 мян. га.

Бурхан буудай уул нь Монгол Алтайн хөмбөн цулдам уулт өндөрлөгийн мужийн уулын нуга, уулын хээрийн дэд мужид багтдаг бөгөөд ноён оргил нь 3765 м өндөр мөнх цастай уул юм. Бурханбуудай уулын ам хөндийд эртний мөстлийн ул мөр болох хотгор гүдгэрийн тавцан дэнж, хунх нилээтэйн зэрэгцээ асга нуранги ихтэй. Монгол Алтайн нурууны үндсэн хэв шинжийг төлөөлөх бөгөөд өндөр уул, уулын хээрийн ландшафт зонхилно. Бурхан буудай уулнаас Урд гол, Дунд гол, Хойт гол, Уст чацран зэрэг голууд эх авч урсдаг. Монгол Алтайн нурууны салбар энэхүү үзэсгэлэнт ууланд аргаль, янгир, ирвэс, хойлог, ёл, тас зэрэг амьтан, шувууд элбэгээс гадна вансэмбэрүү, алтангагнуур, гандигар, цэнхэр цагаан манчин зэрэг олон зүйлийн эмийн ховор ургамал ургадаг. Чацаргана, тошлой зэрэг жимс жимсгэнэтэй. Бурханбуудай уулын Хярын нуурын мянган булш, Үертийн цагаан хаалга зэрэг өвөрмөц тогтоцтой цавчим өндөр сүрлэг байц хад, хадан хавцал хясаагаар хүрээлэгдсэн аль ч талаараа очиход нуувар “таг” хэмээн нэрлэгдсэн байгаль эхийн бүтээл дурсгал ихтэй. Бурхан буудай уулын Нам богдын орой дахь буудай хэлбэрийн улаан чулууг нутгийн ардууд эрт дээр үеэс тахин шүтэж ирсэн нь одоог хүртэл хадгалагдаж байна.



Зураг 9. Бурхайн буудай уул

Бурхан буудай уул нь байгалийн нөөц газар болохын зэрэгцээ байгалийн дурсгал болсон үзэсгэлэнт газрууд ихтэй. Тухайлбал, Бурхан буудай уулын хамгаалалтын бүсэд байгалийн дурсгал болох өвөрмөц сонин тогтоцтой явар байх нь нэн үзэсгэлэнтэй. Ууланд ховор, эмийн ургамал ихтэйгээс гадна ан амьтан элбэг. Сүүлийн жилүүдэд хулгайгаар ховор амьтдыг агнах, эмийн ургамлыг ихээр түүж ашигласнаас гадна бургас, яргай зэрэг модлог ургамлыг түлшинд замбараагүй хэрэглэснээс байгалийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлж байна.

Дурсгалт газрууд

Тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллуудын дотроос эрдэм шинжилгээ, түүх, соёл, гоо сайхны зориулалтаар төрх байдлаар нь өвлөн үлдээх шаардлагатай, байгалийн үзэсгэлэн бүрдсэн, өвөрмөц тогтоцтой, дурсгалт газрууд тус аймагт олон байдаг. Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 22 дугаар зүйлд дурсгалт газрыг “Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын ул мөрийг уламжлагдан хадгалсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор тусгай хамгаалалтад авсан газар нутаг” (ТХГН-ийн тухай хууль, 1994) хэмээн тодорхойлжээ. Дурсгалт газрыг дотор нь байгалийн, түүх соёлын гэж 2 хуваана.

Байгалийн дурсгалт газарт өвөрмөц тогтоц, илэрц бүхий газар, хүрхрээ, хясаа, хавцал, агуй, хад цохио, явар, цонж, төгөл мод, рашаан булаг, баянбүрд, элсэн манхан, солир, солирын цар, өрх, галт уулын тогоо зэргийг хамруулж болно.

Түүх соёлын дурсгалт газарт эртний хүний оромж, отог бууц, агуй, сүг зураг, хадны бичээс, буган ба хүн чулуун хөшөө, булш, бунхан, эртний хот суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз, суваг шуудуу, далан, эртний зэр зэвсэг хийж байсан орд, уламжлалт зан үйлтэй холбоотой уул, овоо, тахилга бүхий болон түүхэн чухал үйл явдал болсон газар зэргийг хамруулж болно. Тусгай хамгаалалттай газруудын 0.4 хувь буюу 6 нь *дурсгалт газар* юм. Говь-Алтай аймагт байгалийн үзэсгэлэнт Ээж хайрханы дурсгалт газар бий.

- ***Ээж хайрханы байгалийн дурсгалт газар***

Ээж Хайрхан уул нь манай орны баруун өмнөд хязгаарт орших өвөрмөц тогтоцтой байгалийн үзэсгэлэнт газрын нэг бөгөөд Говь-Алтай аймгийн Цогт сумын нутгийн өмнөд хэсэгт оршино. Алтайн өвөр говийн хязгаар дахь үзэсгэлэнт уул нуруудын дотор өөрийн өвөрмөц дүр төрхөөрөө Ээж Хайрхан уул тод ялгардаг билээ.

Байгалийн дурсгал болохоос гадна түүхийн дурсгал болсон Ээж хайрхан уул 1995 оны Монгол Улсын Их Хурлын 26 дугаар тогтоолоор байгалийн дурсгалт газар болж улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээнд хамрагджээ. Нийтдээ нь 22.5 мян га. Талбайг эзэлнэ.

Ээж хайрхан уул нь уулс хоорондын цөлөрхөг хотгорт орших пермийн галавын настай цайвардуу ягаан өнгийн дунд ба жижиг ширхэгт боржин чулуунаас тогтсон нүцгэн цулдам, хад чулуурхаг өнчин ганц уул юм. Ерөнхий төрх нь хойноос урагш өндөршиж сунасан майхан хэлбэртэй, цац суварган оргилтой. Хамгийн өндөр оргил нь далайн түвшнээс дээш 2274 м өндөрт өргөгдсөн. Дундаж өндөр нь 1600 м болно. Уулын аль ч өндөрлөгийн хажуу дунджаар 50 орчим градусын налуу бөгөөд элгэн улаан хаднаас тогтжээ. Ялангуяа гол оргилын урд тал ихээхэн шовх, түүний орой нь 50 м орчим өндөр хэсэгт жигүүртнээс өөр амьтан гарах боломжгүй эгц

цавчим халил цохиотой. Мөн цөлийн гандуу хуурай нөхцөлд орших тул гадарга нь цөлийн гандааст автаж бараан өнгөтөй болсон байна.



Зураг 10. Ээж хайрхан

Ээж хайрхан уулын үзэсгэлэнт байдал, өвөрмөц тогтоц нь боржин чулуулгийн өгөршлийн хэлбэрүүдтэй ихээхэн холбоотой юм. Ээж хайрхан уулын хамгийн гол онцлог нь хөрсөн бүрхэвч бараг хөгжөөгүй учраас чулуулгийн өгөршил нь маш хүчтэй явагддагт оршино. Ийм учраас Ээж уулын суурь чулуулгийн цулдам гадарга өвөр талдаа нүцгэн хадан цохиотой байдалтай. Харин ар хажуу нь өгөршлийн том жижиг сул хэмхдэс чулуу, шорооны нимгэн үеэр хучигдсан байх нь элбэг ажээ. Иймээс Ээж уулын агуй, хонгил, нүх, сүв, хөмрөг унжлага, цооног элдэв сонин дүрс байдал нь боржин чулуулгийн бүтэц найрлага, нүх сүвэрхэг шинж, гадаргын тэгш бус байдал, байрлал, ан цав зэргээс ихээхэн хамаардаг байна.

Ээж уулын байгалийн үзэсгэлэнг нэмсэн өвөрмөц сонин тогтоц бол түүний зүүн өмнөд хажууд чулуулгийн гав судал дагаж цувран тогтсон ногоон хүрээтэй 9 чулуун тогоо билээ. Энэ нь аялагч жуулчдын сонирхлыг их татдаг түүгээрээ ч Ээж уулыг ихэд алдаршуулжээ. Тогоонуудын амсрын дундаж өргөн 2-3 м бөгөөд хоорондоо 40-50 см өндөр чулуун босгоор нэг нь нөгөөтэйгээ холбогдоно. Эдгээрээс дээрээсээ дөрөв дэх хамгийн том нь бөгөөд түүний гүн 4 м орчим юм. Харин ес дэх тогоо нь эхний наймаас нэлээд тусгаарлагдмал, жижиг хадан мөрөгцөг өнгөрч байж тааралдана. Түүнээс доош дээрх тогоонуудын урсгалын замд гүн биш жижиг тогоо 2-3 бий. Эдгээр тогоонуудын төгсгөл болох газраас булаг маягтай шүүрдэс ус гарч байдаг. Тогоонууд цөм нэг үүсэлтэй бөгөөд түүний байрлал, орчны гадаргын бичил хэлбэрийг судлаачид боржин чулууны ан цавыг дагаж үүссэн гэж үздэг. Тогоонуудын нэг онцлог бол гантай жил ч ус элбэгтэй байдагт оршино. Үүнд өөрийн байрлал зохих ёсоор нөлөөлөх ажээ Тийм ч учраас өдрийн турш

нарны хурц тусгал таарах нь хязгаарлагдмал юм. Нөгөө талаар эдгээр тогоонуудын хэмжээ, гүнээс шалтгаалан ус нь тодорхой хэмжээгээр дундарч цааш амсрын хананы сүүдэрлэлтээс болж төдий л халдаггүй учир ууршилт бага явагдан ширгэчихдэггүй байна. Түүнээс гадна эдгээр тогоонууд байрлаж буй ховил маань өөрөө томоохон ус цуглуулах талбайн төгсгөл болж байдаг тул энд бороо л орвол эдгээр тогоонууд усаар дүүрч байх нөхцөлтэй ажээ. Тогоонуудын ус ямар нэг хэмжээгээр гадагш алдагдах бөгөөд үүнийг гэрчлэх баримт нь эдгээр тогоонуудын төгсгөл дэх шүүрдэс ус юм. Энэ мэт сөрөг нөлөөллүүд байлаа ч гэсэн ямарч цагт устай байдаг нь ихээхэн сонирхолтой. Гэхдээ энэ нь гүний усны тэжээлтэй төдий л холбоогүй ажээ.

Энэ бүхнээс үзэхэд Ээж уул нь байгалийн хувирал өөрчлөлт, тэр дотроо өгөршлийн үйл явцыг судлах нэг ёсны байгалийн бэлэн лаборатори болох тул нарийвчлан судлах шаардлагатай өвөрмөц объект билээ. Ялангуяа гарал үүсэл нь тодорхойгүй байгаа физик өгөршлийн өвөрмөц хэлбэрүүд үүсэх механизмыг нээн илрүүлэх, тогоо нүх үүсэх, түүний усны тэжээлийн эх булгийг нарийвчлан тогтоох явдал онол практикийн хувьд ихээхэн ач холбогдолтой юм.

Ээж хайрхан уул нь байгалийн төдийгүй түүхийн дурсгалт газар юм. Энэ ууланд хүн амьдарч байсан ул мөр бүхий сонирхолтой агуй бий. Эдгээрийн нэг нь 9-н тогооны ойролцоо орших нүүрэн талыг нь битүүлж хаалга, гэгээвч гарган тохижуулсан ламын агуй юм. Нутгийн хүмүүс энэ агуйд “Ээж уулын ижий лам” амьдарч байсан юм гэсэн домог ярьдаг. Түүхийн ухааны дэд доктор Д.Очирбат удаан хугацааны турш сурвалжлан байж Ээж уулын агуйд Ховог сайрын торгууд гаралтай Равдан гэгч лам 1923 оноос эхлэн нилээд хэдэн жил амьдарч байсныг олж тогтоожээ. Равдан лам Маажинсан ууланд бүгж байсан Дамбийжанцангийн нөхөр хамсаа байсан бөгөөд Жа ламыг алагдсаны дараа Ээж уулын агуйд орогнон улмаар энэ нутгийн Түдэвийн охин Цэгмидтэй ханилан 1928 оны намар хүртэл амьдарч байжээ.

Ээж уул нь байгаль, түүхийн гайхамшиг болсон давтагдашгүй, тайлагдашгүй түмэн нууцыг нуун хадгалсан үзэсгэлэнт сайхан уул билээ.

Олон улсын шим мандлын нөөц газрын сүлжээнд орсноор:

Монгол улс нь 1992 онд дэлхийн 172 улс орны тэр засгийн тэргүүн нар оролцсон Рио-Де-Жанейрогийн бага хуралд Монгол Улсын Засгийн газрын ерөнхий сайд оролцож Монгол орныг дэлхийн шим мандлын бүс нутаг болгох зорилтыг дэвшүүлсэн билээ. Монгол орон нь тэр чигээрээ дэлхийн шим мандалд өндөр ач холбогдол бүхий биогазарзүйн томоохон муж болох палеарктикийн мужийг төлөөлдөг бөгөөд шим мандалд гарч буй хувьсал өөрчлөлтийг судлах, мэдээлэл солилцох өргөн боломж бүхий нутаг юм.

Өнөөдөр Монгол улсад 4 шим мандлын нөөц газар байгаагийн нэг нь Говь-Алтай аймагт байна.

Говийн их дархан цаазат газар нь 1990 онд Олон улсын шим мандлын нөөц газрын сүлжээнд хамрагдаж Төв Азийн цөлийн экосистемийг олон улсын түвшинд судлах, хамгаалах эрдэм шинжилгээний өргөн мэдээлэл харилцан солилцох өргөн боломж нээгджээ.

II.7.3 Улсыг батлан хамгаалах зориулалтын газар

Тус аймгийн тусгай хэрэгцээний газрын 7,6 хувийг эзэлдэг хилийн зурвас газар нь Тонхил, Бугат, Алтай, Цогт, Эрдэнэ сумуудын нутгийн өмнөд зах, хилийн торгон шугамаас дотогш 5 км өргөн зурвас газар эзлэн оршдог. Уг зурвас газарт хилийн цэргийн суман улсын хил хамгаалалтын үүрэг гүйцэтгэдэг.

Дээрх хилийн зурвас газрын 62,1 хувь нь ГИДГ-ын А, Б хэсэгт давхар хамаарах бөгөөд үлдэх хэсэг нь Бугат, Алтай сумын нутгийн улсын хилийн дагуухи 37,9 га хилийн зурвас газар юм.

Улсын хилийн зурвас газар нь аж ахуйн зориулалтаар бараг ашиглагддаггүй. Зөвхөн зуд турхан зэрэг цаг агаарын бэрхшээл тохиолдсон үед Бугат, Алтай сумын иргэд, малчид хилийн зурваст ойртон богино хугацаагаар нутаглах явдал гардаг.

Улсын хилийн зурвас газарт орших Гурван хайрхан, Чандмань богд, Шар тоорой зэрэг бэсрэг уулсын ар хөндийд зориудын худаг, ус гаргах, өвөлжөө, хаваржаа бариагүй боловч хөрсний ус ойрхон, харьцангуй дулаавтар, бэлчээр талхлагдаагүй зэрэг нь мал сүрэг оторлоход хүндрэл учруулдаггүй байна. Тус аймгийн Алтай сумын нутагт Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар 26,2 га газар олгожээ.

Дүгнэлт

Говь-Алтай аймгийн тусгай хэрэгцээний газруудын ашиглалт, хамгаалалтын одоогийн байдлын тодорхойлолтоос дараахи дүгнэлт хийж болох байна. Үүнд:

1. МУ-ын хилийн зурвас газрын Говь-Алтай аймгийн нутагт орших хэсгийн ихэнх хэсэг нь ГИДЦГазарт хамрагддаг, үлдэх багахан хэсэг Алтай, Бугат сумдын нутаг дэвсгэрийн өмнөд хэсгээр байдаг. Энэ зурваст аж ахуйн үйл ажиллагаа бараг явагддаггүй тул элдэв сөрөг зөрчилгүй зохих түвшинд байна.
2. Тусгай хамгаалалттай газар нутгийн ашиглалт хамгаалалтын асуудалд байгаль хамгаалагчдын тоо цөөн, хөрөнгө мөнгөний боломжгүйн улмаас хулгайгаар мод, заг бэлтгэх, ан амьтан агнах зэрэг зөрчил мэр сэр гарч буйг зогсоох, нөгөө талаар ТХГ нутагт төрөл бүрийн чиглэлийн аялал жуулчлалыг нягт уялдаа холбоотой зохион байгуулах, реклам сурталчилгааг өргөн явуулах нь зүйтэй.

III БҮЛЭГ. ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН БҮСҮҮД, ТҮҮНИЙ НӨӨЦ, НӨХЦЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

III.1 ХАА-Н ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН БҮСҮҮД, ТҮҮНИЙ НӨӨЦ НӨХЦЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

III.1.1 Тариалангийн газрын нөөц, нөхцлийн төлөвлөлт

Тариалангийн газрын нөөц нөхцлийн төлөвлөлт хийхэд хүн амыг гурил, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнээр, мал аж ахуйг тэжээлээр, үйлдвэрлэлийн зориулалтаар энгийн болон ашигт ургамал тариалах зорилгыг биелүүлэхэд оршино.

Аймгийн газрын нэгдсэн сангийн тайлангаар 3609 га тариалангийн газартай боловч үүнээс 1665 га талбайг ашиглаж, 1944 га талбайг 2-3 жилээр өнжөөсөн байна. Мөн тариалан эрхлэхэд тохиромжтой боловч ямар нэг учир шалтгааны улмаас 1941 га газар атаржсан байна.

2006-2010 он

Зорилт

1. Инженерийн хийцтэй услалтын систем болон энгийн усалгаатай тариалангийн газрыг сэргээн засварлаж үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал, жимс жимсгэнэ, энгийн болон ашигт ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх
2. Хамгаалагдсан хөрсний тариалалтыг нэмэгдүүлэх

Хийгдэх ажлууд

1. Инженерийн хийцтэй услалтын систем, энгийн усалгаатай тариалангийн талбай болон өнжөөсөн ба атаржуулсан газарт төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил хийлгэх.
2. Биж гол, Шаргын урд гол, Тээл, Хүрхрээ, Гуулин, Дагналтайн инженерийн хийцийн услалтын системүүдэд их загвар хийх.
3. Харгана түрүү, Хүрэн харганат, Шаргын 14 зэрэг системүүдийн талбайг өргөтгөж, Алтай хот болон бусад тосгон суурингийн иргэдэд эзэмшүүлэх.
4. Услалтын системүүдэд хамгаалалтын /салхины/ зурвасыг Улиас+Харгана, Сухай+Шаваг шарилж+Харгана гэсэн босоо үелэлтэйгээр байгуулах.
5. Үр тарианы үрийн чиглэлээр Баянтоорой, Бигэр, Чандмана, Халиун, Гуулин, Бугат, Тайшир, Шарга сумдад, хүнсний ногооны үрийн чиглэлээр Чандмань, Халиун, Гуулин, Бугат, Тайшир, Шарга сумдад төмсний үрийн чиглэлээр Чандмана, Бигэр, Шарга, Тайшир зэрэг сумдад эмийн болон ашигт ургамлын чиглэлээр Баянторой, Алтай, Бигэр, Халиун, Шарга зэрэг сумдын услалтын системд үржүүлж бусад ам ахуйн нэгж, иргэдийг үрээр хангах.
6. Малын тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх ажлыг ургамлыг нэмэгдүүлж 7.5 мянган тэжээл нэгжид хүргэх.

7. Тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалах зорилгоор 1.1 мянган га-д нөхөн сэргээлтийн ажлыг эхлэх.
8. Ургац нэмэгдүүлэх зорилгоор байгаль экологид хоргүй органик ба химийн бордоо хэрэглэх.
9. Тариалангийн газрын экологи, эдийн засгийн үнэлгээг боловсруулж гаргах
10. Хүлэмжийн тариаланг хөгжүүлэх ажлыг сэрүүвтэр уур амьсгалтай сумдад эхлүүлэх,
11. Тариалангийн талбайг фермерийн аж ахуй, хоршооны хэлбэрээр эзэмших явдлыг дэмжих.

2011-2015 он

Зорилт

1. Хүн-амын өсөн нэмэгдэж байгаа газар тариалангийн бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах
2. Орон нутгийн онцлогт тохирсон, өндөр ургац өгдөг нутагшсан сортуудыг тариалах
3. Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, тогтвортой хөгжлийг хангана.

Хийх ажил

1. Тариалангийн газрын төлөв байдал чанарын хянан баталгааны ажил хийх
2. Орон нутгийн онцлогт тохирсон, өдөр ургац өгдөг нутагшсан сортуудыг тариалах
3. Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, тогтвортой хөгжлийг хангана.

Хийх ажил

1. Хүрхрээ, Хаяа, Мянгай, Хуримт, Ёолтон зэрэг ихээхэн эвдрэлтэй услалтын системийн их засварын ажил хийх болон Гуулингийн услалтын системийн өргөтгөлийг ашиглалтанд оруулах.
2. Услалтын систем болон усалгаатай тариалангийн талбайд хамгаалалт /салхины/ ойн зурвас барих ажилыг үргэлжлүүлэн хийнэ.
3. Малын тэжээл тариалалтыг өргөжүүлж, нэгжээс өндөр ургац өгдөг тарималыг тариалах замаар фермерийн аж ахуйнуудыг тэжээлээр хангах ажлыг эхлэнэ. Нийт үйлдвэрлэлийн хэмжээг урд таван жилийнхээс 15 %-иар нэмэгдүүлнэ.
4. Тариалангийн газрын элэгдэл, эвдрэлийг зогсоох зорилгоор 1.1 мян/га газарт нөхөн сэргээлтийн ажил хийнэ.
5. Услалтийн системүүдэд урсгал засвар хийх, тэдгээрийн хүчин чадлыг өргөтгөх боломжийг судлан талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

2016-2023 онЗорилго

1. Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээг хангах, экоспортын ба дотоодын худалдаанд гаргах бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.
2. Тогтвортой ургацын үрийн сортуудыг олшруулах газар тариалангийн үйлдвэрлэлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар нэгжээс авах ургацыг 25%-иар нэмэгдүүлэх.

Хийгдэх ажлууд

1. Улаан боомын усан сангийн усны нөөцийг ашиглах замаар 800 хүртэл га хэмжээтэй услалтын шинэ системийг барих ажлын судалгаа хийж, зураг төсөл зохиох.
2. Одоогийн ашглагдаж байгаа услалтын системүүдийн усны нөөц, тариалах талбайн хэмжээг өргөтгөх.
3. Алтай хотын болон сумдын хүн ам эрчимтэй өсч байгааг харгалзан Завхан голын усны нөөцийг түшиглэн хуучин ашиглаж байсан услалтын системүүдийг засварлан ашиглалтанд оруулах.
4. Шинжлэх ухааны ололт, амжилт, иргэдийн туршлага, дадлагад тулгуурлан ургацыг усалгаатай нөхцөлд 30-50 % хүртэл нэмэгдүүлэх.
5. Услалтын системүүдын тариалж буй талбайд газрын төлөв байдал чанарын хянан баталгааны ажлыг экологи-эдийн засгийн үнэлгээтэй хамтатган гүйцэтгэж, байр зүйн ба чанар байдлын кадастр хийлгэх.

Төлөвлөж байгаа жилүүдэд услалтын ситемийн хүчин чадлыг өргөтгөхийн тулд хамгийн үр өгөөжтэй хөрсний ялзмаг агууламжаар баялаг /1 %-иас дээш/ хагалгааны үе зузаан газрыг сонгон ашиглалтанд оруулах шаардлагатай.

Услалтын систем болон усалгаатай тариалангийн газруудын усны нөөцийг нэмэгдүүлэх бүх боломжийг ашиглах арга хэмжээ авна.

Услалтын систем болон усалгаатай тариалангийн барилга байгууламж, суваг шуудууны урсгал засваруудыг цаг алдалгүй гүйцэтгэж байх хэрэгтэй.

Усалгаатай тариалангийн ба далд хөрсний /хүлэмжийн/ үйлдвэрлэлд тариалангийн агротехникийн арга ажиллагааг зөв зохион байгуулж шинэ технологийг хэрэглэх нь өндөр ургац авах боломжийг бүрдүүлнэ.

Тариалангийн талбайг аж ахуйн нэгж, иргэдэд 100 % эзэмшүүлж, газар ашиглалтанд тавих төрийн хяналтыг хүчтэй болгоно.

Газар ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, хүн амын орлого, амьжиргааны түвшинг дээшлүүлэхийн тулд нөр их хөдөлмөр зарж эзэмшсэн газрыг аль болох ашиглалтанд байлгах бодлого баримтлан ашиглах шаардлагатай.

1. Их нууруудын хотгор, Алтайн нурууны усалгаат тариалангийн бүсийн хуурай дулаан дэд бүсэд Бигэр, Халиун, Гуулин, Дэлгэр, Тайшир, Чандмана, Шарга, Хөх морьт, Жаргалан сум.
2. Хуурай сэрүүн дэд бүсэд Тонхил, Баян уул, Цээл, Төгрөг, Есөнбулаг, Бугат, Дарви.
3. Говь-цөлийн усалгаат тариалангийн бүсэд Цогт, Алтай, Баянтоорой, Эрдэнэ сумад багтана.

Говь-Алтай аймаг нь усалгаатай газар тариалан эрхэлдэг бөгөөд тариалангийн газрын чанарын ба экологийн үнэлгээг өгөхөд шаардагдах зарим нөлөөллийн үзүүлэлтүүдийг Ч.Цэрэнбалжир, Б.Наранчимэг нарын боловсруулсанаар хавсаргав /Хүснэгт 38/.

Хүснэгт 38

Тариалангийн газрын хөрсний чанарын үнэлгээний хүрд

Шинж чанар	Оношлох шинж чанарын үнэлэхүй тоон утга	Үнэмлэхүй тоон утгын 100 онооны харьцаагаар үнэлвэл	Нийлбэр оноонд харьцуулсан жиших оноо
Ялзмагийн агууламж /хувиар/	5	100	56
	4	90	50
	3	80	45
	2	70	39
	1	60	34
	0.5	55	30
Ялмаг үеийн зузаан /см/	50	100	30
	45	92	28
	40	83	25
	35	75	23
	30	67	20
	25	58	18
	20	50	15
	15	42	13
Механик бүрэлдэхүүн /Физик шаврын эзлэх хувь/	60<	60	3
	45-60	71	4
	31-45	100	6
	21-30	67	5
	10-20	40	2
Шингээгдсэн сууриудын нийлбэр /100 гр хөрсөнд мг, экваар/	10>	13	1
	55<	100	6
	40-55	79	5.5
	30-39	58	5
	30>	42	3

Дээрх үзүүлэлтүүдийг ашиглан аймгийн тариалангийн талбайн чанарын ба экологийн үнэлгээг боловсруулахад хангалттай.

Энэхүү үнэлгээг гаргахын тулд тариалангийн газрын төсөв байдал, чанарын хянан баталгааний ажил хийгдсэн байх шаардлагатай.

-Говь-алтай аймгийн тариалангийн газрууд нь талбайн гадаргуугийн хувьд тэгш, тэгшивтэр, говийн бор хөрс ноёрхсон, ялмаг агууламж бага, усалгаатай нөхцөлд тариалдаг, давсжилт, чулуужилт ихтэй хөл газрын ургамлын тархац ихтэй, арчилгаа, хөдөлмөр ихээхэн шаардагддаг онцлогтой.

Хүснэгт 39

Хөрсний чанарын үнэлгээний дагалдах үзүүлэлтийн нөлөө

Хөрсний орчин PH		Нүүрс хүчлийн хий, CO ₂		Шингээх багтаамж дахь натри %		Шингээгдсэн сууриудын нийлбэр кальцийн каионы хэмжээ%	
Тооны утга	Засварын итгэлцүүр	Тооны утга	Засварын итгэлцүүр	Тооны утга	Засварын итгэлцүүр	Тооны утга	Засварын итгэлцүүр
7.6-8.5	0.76	4	1.0	1.0	1.0	60<	1.0
6.6-7.0	0.86	6	0.65	3-5	0.25	50-60	0.83
6.1-6.5	1.0	8	0.50	5-10	0.14	40-50	0.67
5.6-6.0	0.85	10	0.40	10<	0.0	30-40	0.50
5.1-5.5	0.78	12	0.33	-	-	20-30	0.33
5>	0.69	15	0.26	-	-	10-20	0.17
-	-	-	-	-	-	10>	0.08

Хүснэгт 40

Тариалангийн газрын био-цаг уурын чадавхийн үнэлгээний итгэлцүүр

Үнэлгээний бүс	Дэд бүс	Буч-ын итгэлцүүр
Их нууруудын хотгор, Алтайн нурууны тариалангийн бүс	Хуурай сэрүүн	0.57-0.82
	Хуурай дулаан	0.40-0.56
Говь цөлийн тариалангийн бүс		0.2-0.3

Хүснэгт 41

Хөрсний үржил шимийн өөрчлөлт элэгдлийн зэргээс хамаарах

Эвдрэлийн зэрэг	Ялмаг агууламжийн өөрчлөлт %	Механик бүрэлдэхүүний өөрчлөлт хувиар	Га-гийн ургацын бууралт хувиар
Элэгдэж эвдрээгүй	5	2	-
Бага	6-20	3-7	12-15
Дунд зэрэг	21-40	6-12	30-35
Хүчтэй	40<	12<	50-70

Хүснэгт 42

Талбайн налуулаг үр тарианы ургацад хэрхэн нөлөөлөх

Налуу хэмээр	Талбайн тоо	1 га-гийн дундаж ургац	Газрын үнэлгээнд нөлөөлөх илтгэлцүүр
1 ⁰ -аас бага налуутай буюу тэгш	18	17.0	1.0
1-3 ⁰	26	15.2	0.9
3-5 ⁰	10	12.3	0.8
5-7 ⁰	7	9.0	0.7

Хүснэгт 43

**Тариалангийн талбайн чанарын үнэлгээнд
чулуулгын үзүүлэх нөлөөлөл**

Чулуулгын зэрэг	Хөрсөн дээрх чулуулгын нэгж талбайд эзлэх хувь	Хөрсний 0-30 см-ийн зузаанд байх чулуулаг м ³ /га/	Нөлөөлөлийн илтгэлцүүр
Бага чулуутай	10 хүртэл	5-20	0.9
Дунд зэрэг	11-20	21-50	0.85
Их чулуутай	21-40	51-100	0.7
Маш их	40-өөс их	100-аас их	0.6

Чулуулагтай хэсэг нь томоохон талбайд нийтдээ тархсан байх нь ховор тул нөлөөллийг зөвхөн тэр чулуутай хэсэгт тооцох нь зүйтэй.

Хүснэгт 44

Талбайн чанарын үнэлгээнд бартаа саадын үзүүлэх нөлөө

Бартаа, саадын зэрэглэл	Бартаа саадын бүх талбайд эзлэх %	Механик бүрэлдэхүүний өөрчлөлт хувиар
I	Бартаа саадгүй	1.0
II	5 хүртэл	0.96
III	5-10	0.93
IV	10-15	0.90
V	15-20	0.85

Хүснэгт 45

Таримлын ургац, газрын үнэлгээнд хот ургамлын нөлөөлөл байдал

Хогтолын зэрэг	Тарималд эзлэх хог ургамлын %	Ургацын алдагдал, %	Газрын үнэлгээнд нөлөөлөл итгэлцүүр
I	10 хүртэл	-	1.0
II	11-25	21.0	0.8
III	26-35	44.1	0.6
IV	36-50	56.5	0.55
V	50	63.6	0.4

Хүснэгт 46

Тариалангийн талбайн үнэлгээнд мэрэгчидийн нөлөөлөл

1-гад байх оготны тоо	Хөнөөлийн хэмжээ ургацын хувиар	Газрын үнэлгээнд нөлөөлөл итгэлцүүр
30 хүртэл	10 хүртэл	0.9
50-60	40-50	0.5
100<	85-90	0.2

Хүснэгт 47

Таримлын усалгаанд хэрэглэх усны чанарын нөлөөлөл

Усны чанарыг тодорхойлох үзүүлэлт /итгэлцүүр/	Тохиромжтой байдал	Таримлын ургацад нөлөөлөл итгэлцүүр
18	Илүү тохиромжтой	1.1
6-18	Тохиромжтой	1.0
1.2-5.9	Тохиромж муутай	0.7
1.2>	Тохиромжгүй	0.0

Говь-Алтай аймаг нь усалгаат газар тариаланг хөгжүүлэх талаар нилээд дэвшил олсон газар юм. Энэ туршлага дээр түшиглэн 1990 он хүртэл идэвхжиж усалттай газар тариалан 1962,8 га-д хүрсэн юм.

Сүүлийн үед цаг уурын өөрчлөлт, хур тунадасны уналт, булгийн усны доройтол зэргээс шалтгаалан одоогийн ашиглаж байгаа талбай 1665 га-д хүртэл буурчээ.

Цаашид цаг агаарын өөрчлөлт, иргэдийн идэвхи санаачлага, газар хувьчлалын үйл явц зэрэг бодит үйл явдлаас шалтгаалан газар тариалан эрхлэх сонирхол нутгийн иргэдийн дунд өрнөсөн зэргийг харгалзан тариалангийн газрыг өргөтгөхөөр төлөвлөж байна.

Инженерийн хийцтэй усалтын системүүд, энгийн усалгаатай талбайд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил хийлгэх, тооллого явуулах, Ёлтон, Дагналтай, Хуримт, Мянгай, Гуулин, Хаяа, Шугуй, Хүрхрээ, Тээл, Шаргын уртын гол, Бургас, Бижийн усалтын системүүдэд их засвар хийх шардлагатай. Хүрэн харганат, Харгана түрүү, Шаргын 14-тийн усалтын системүүдэд урсгал болон техник үйлчилгээний засваруудыг хийхээр төлөвлөж байна. Үүний тулд

1. Өндөр бүтээмжтэй техник технологи нэвтрүүлэх
2. Газрыг эзэмших, ашиглах, хувьчлах, эздэд нь олгох талаар сурталчилгааны ажил явуулах.
3. Бага оврын техник нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж ургац нэмэгдүүлэхийн тулд эрдэс болон органик бордоог өргөн хэрэглэх хэрэгтэй.

Хүснэгт 48

Аймгийн тариалангийн газрын төлөвлөлт (га)

№	Сумын нэр	Түрүүчийн хянан баталгаагаар тогтоогдсон талбай	Балансаар	Төлөвлөлтийн жилүүд		
				2006-2010 он	2011-2015 он	2016-2023 он
0	1	2	3	4	5	6
Жаргалан сум						
1	Тээл-1 (дээд хэсэг)	3.0	3.0	3.0	3.0	3.0
2	Тээл-2 (дунд хэсэг)	99.5	99.5	99.5	99.5	99.5
3	Тээл-3 (доод хэсэг)	72.0	36.5	36.5	72.0	72.0
4	Цахирын тал	206.0	-	-	-	206.0
	Дүн	380.5	139.0	139.0	174.5	380.5
Шарга сум						
1	Гатлагын булан	148.0	148.0	148.0	148.0	148.5
2	Тэгшийн гол	40.0	40.0	40.0	40.0	50.0
3	Модон гэр	30.0	30.0	30.0	30.0	30.5
4	Далан эв овооны суга	12.0	12.0	12.0	12.0	12.0
5	Харганат	5.0	5.0	10.0	55.0	105.0

6	Бор бургас	2.0	2.0	2.0	2.0	2.0
0	1	2	3	4	5	6
7	Алаг хайрхан	15.0	15.0	15.0	15.0	15.0
8	Шарын ам	5.0	5.0	5.0	5.0	5.5
9	Урд шарын ам	2.0	2.0	2.0	2.0	4.0
10	Урд гол	80.0	80.0	80.0	80.0	80.0
11	Цутгалан	2.0	2.0	2.0	2.0	2.5
12	14-тийн газар	194.0	194.0	194.0	200.0	194.0
13	14-тийн газар					141.0
14	Гүжгэнэ	1.0	1.0	1.0	1.0	1.0
	Дүн	536.0	536.0	541.0	592.0	801.0
Халиун сум						
1	Хурын булан	25.0	25.0	25.0	25.0	25.0
2	Шар усны гол	2.0	2.0	2.0	2.0	2.0
3	Гүү бариац	3.0	3.0	3.0	3.0	3.0
4	Халиун	12.0	12.0	47.0	47.0	47.0
5	Сүүжийн баг	2.0	2.0	2.0	2.0	2.0
6	Чацран	5.0	5.0	-	-	-
7	Ёлтон	315.0	315.0	315.0	315.0	315.0
8	Хуримт	6.0	6.0	10.0	10.0	10.0
9	Намалзах	-	-	75.0	75.0	75.0
	Дүн	370.0	370.0	479.0	479.0	479.0
Чандмань сум						
1	Хүрхрээ	228.0	228.0	230.0	230.0	230.0
Төгрөг сум						
1	Далан түрүү	4.0	4.0	4.0	4.0	4.0
2	Өгөөмөр	22.0	22.0	22.0	22.0	22.0
3	Үерийн ам	3.0	3.0	3.0	3.0	3.0
4	Төгрөгийн ам	4.5	4.5	4.5	4.5	4.5
5	Бор булаг	1.5	1.5	1.5	1.5	1.5
6	Тал булаг	5.0	5.0	5.0	5.0	5.0
	Дүн	40.0	40.0	40.0	40.0	40.0
Эрдэнэ сум						
	Дүн	4.0	4.0	4.0	5.0	8.0
Баян-уул сум						
1	Нуур могой	1.0	-	1.0	2.0	3.0
Алтай сум						
1	Ганган булаг	4.0	4.0	4.0	4.0	-
2	Сургууль	1.0	1.0	1.0	1.0	-
3	Цэргийн анги	1.0	1.0	1.0	1.0	-
4	Тариалан	4.0	4.0	4.0	6.0	6.0
5	Үзүүр ухаа	1.0	1.0	1.0	1.0	1.0
6	Ар булаг	1.0	1.0	1.0	1.0	1.0
7	Хадат булаг	-	-	3.0	4.0	5.0
	Дүн	12.0	12.0	15.0	17.0	17.0
Есөнбулаг сум						
1	Могой	22.0	22.0	22.0	22.0	22.0
2	Рашаант	4.0	4.0	4.0	4.0	4.0
3	Хүрээгийн ам	5.0	5.0	5.0	5.0	5.0
4	Цахир булаг	7.0	7.0	7.0	7.0	7.0
5	Цагаан ам	39.0	39.0	-	1.0	1.0
6	Элэгний булаг	10.0	-	10.0	10.0	10.0
	Дүн	39.0	39.0	39.0	49.0	49.0
Дарви сум						
	Харгана түрүү	2.0	2.0	12.0	50.0	145.0
Тайшир сум						
1	Хуримт	60.0	60.0	60.0	60.0	60.0
2	Баюуны булан	22.0	22.0	27.0	27.0	27.0
3	Шар булаг	7.0	7.0	7.0	12.0	12.0
4	Ондил	-	-	10.0	10.0	10.0
5	Мөрөн булаг	-	-	7.0	7.0	7.0
	Дүн	89	89	111.0	116.0	116.0

Цээл сум						
0	1	2	3	4	5	6
1	Сумын төвд	4.0	4.0	4.0	4.0	4.0
2	Цанхилахын гол	1.0	1.0	1.0	1.0	1.0
3	Дэрсг гол	1.0	1.0	1.0	1.0	1.0
4	Баянгол	2.0	2.0	2.0	2.0	2.0
5	Сүүл булаг	1.0	1.0	1.0	1.0	1.0
	Дүн	9.0	9.0	9.0	9.0	9.0
Дэлгэр сум						
1	Гуулин	1000.0	1000.0	1000.0	1200.0	1500.0
2	Дагналтай	-	-	60.0	60.0	60.0
	Дүн	1000.0	1000.0	1060.0	1260.0	1560.0
Бигэр сум						
1	Өөш	3.0	3.0	3.0	10.0	10.0
2	Бургас	34.0	34.0	41.0	41.0	41.0
3	Мянгай	21.0	21.0	34.0	34.0	39.0
4	Сүүж булаг	6.0	6.0	6.0	6.0	8.0
5	Ургын гол	2.0	2.0	2.0	2.0	4.0
6	Хоёр байшинт	-	-	-	50.0	104.0
	Дүн	66.0	66.0	86.0	136.0	206.0
Цогт сум						
1	Хаяа	460.0	460.0	460.0	460.0	460.0
2	Шугуй	300.0	300.0	300.0	644.0	644.0
3	Шал	100.0	100.0	100.0	100.0	100.0
4	Хаяа	15.0	15.0	15.0	15.0	15.0
5	Тэгш	-	-	7.0	7.0	7.0
6	Тэгш	1.0	1.0	-	-	-
	Дүн	876.0	876.0	1088.0	1226.0	1226.0
Тонхил сум						
1	Өвчүү	2.0	2.0	2.0	3.0	4.0
Бугат сум						
1	Баянгол-1	3.0	3.0	3.0	4.0	5.0
2	Баянгол-2	3.0	3.0	3.0	4.0	5.0
3	Баянгол-3	3.0	3.0	4.0	5.0	6.0
4	Цагаан гол	2.0	2.0	2.0	4.0	6.0
5	Биж гол	191.0	191.0	191.0	200.0	208.0
6	Биж систем	-	-	-	378	378
	Дүн	202	202	203	595	608
	Аймгийн дүн	3609	3609	4059	4982.5	5880.5

Тайлбар:

1. Өнжөөсөн газруудыг эхний жилүүдэд түлхүү ашиглахаар оруулав.
2. Услалтын системийн усан сангийн усны нөөцийг нэмэгдүүлж талбайг өргөтгөхөөр тусгалаа.
3. Жимс, жимсгэний талбайг тариалангийн газарт нэмж орууллаа. Балансад тоо нь орсон боловч өнжөөсөн талбайгаас хасагдаж явсан бүгд 67 га газар жимс, жимсгэнэ байв.
4. Зарим атаршсан газруудыг эзэмшихээр тусгав.
5. Зарим ургац муутай, дулааны нийлбэр дутмаг талбайг хадланд шилжүүлэхээр оруулав.
6. Тайшир суманд Улаанбоомны УЦС-ын усан сангийн илүүдэл усыг ашиглах замаар шинээр систем барихаар төлөвлөж байсныг газрын судалгаа хийгдээгүй учир балансад тусгаагүй.

Тариалангийн талбайг өргөтгөж, ашиглалтыг сайжруулан, ургацыг нэмэгдүүлснээр 2010 он гэхэд нийт гурилын хэрэгцээний 15 % төмс, хүнсний ногооны хэрэгцээний 40 %, 2015 онд гурилын хэрэгцээний 20 %, төмс, хүнсний ногооны хэрэгцээний 80 %-ийг аймаг өөрийн үйлдвэрлэлээр хангана.

2003 он гэхэд гурилын хэрэгцээний 50 %-ийг, төмс, хүнсний ногооны хэрэгцээний 90 %-ийг хангах болно.

III.1.2 Хадлангийн газрын төлөвлөлт

Сүүлийн жилүүдэд хуурайшилтаас шалтгаалж хадлангийн ургац эрс муудаж байна. Иймээс өвөлжөө, хаваржаа орчмын болон бусад талбайг малчдад түрээсээр эзэмшүүлэх, хашиж хамгаалах, услах, олон наст ургамлын үрээр сайжруулалт хийх, масс ихтэй ургамлын үр тариалах, нэмэлт тариалалт хийх зэргээр сайжруулалтын ажлыг хийх шаардлагатай.

Говь-Алтай аймгийн нөхцөлд усалгаагүй хадлангийн газраас ургац авах боломжгүй. Өвөл цас мөс тогтоох, тошин халиах, бууцаар бордох хэрэгтэй.

Аль болох малын хөлөөс хамгаалах зайлшгүй шаардлагатай.

Сэрүүн нөхцөлд тэсвэртэй, арвин ургац өгдөг олон наст ургамлын үр тариалах арга хэмжээг авах хэрэгтэй байна.

Жил дараалан ган тохиолдож байгаа нөхцөлд ХАА-н газар дотроос хамгийн их сөрөг өөрчлөлтөнд нэрвэгдэж байгаа нь хадлангийн газар юм.

Иймээс нөхөн сэргээлтийн ажил зайлшгүй чухал юм.

Нөхөн сэргээх ажлын өөрийн өртөг өндөртэй тул аль болох бага зардал гаргаж орон нутгийн нөөц бололцоог өргөн ашиглах шаардлагатай. Үүнд: талбайг услахдаа заавал малын бууцаар нилээд хэмжээгээр бордох шаардлагатай. Хадлангийн талбайн гадаргуу нь аль болох тэгшивтэр байх шаардлагатай байдгийг харгалзан үзэх хэрэгтэй.

Хүснэгт 49

Хадлангийн газрын төлөвлөлт

№	Сумын нэр	Түрүүчийн хянан баталгаагаар тогтоогдсон талбай	Балансаар	Төлөвлөлтийн жилүүд		
				2006-2010 он	2011-2015 он	2016-2023 он
0	1	2	3	4	5	6
Жаргалан сум						
1	Завхан гол	-	-	25.0	50.0	70.0
Шарга сум						
1	Шаргын гол	1500.0	1500.0	1500.0	2000.0	3000.0
2	Шаргын гол	300.0	300.0	500.0	500.0	800.0
	Дүн	1800.0	1800.0	2000.0	2500.0	3800.0
Халиун сум						
1	Улаан дугуй	7.0	7.0	7.0	10.0	12.0

2	Цагаан дугуй	8.0	8.0	8.0	10.0	12.0
3	Олон булаг	40.0	40.0	40.0	42.0	42.0
4	Хуримт	12.0	12.0	12.0	18.0	18.0
5	Цацран	-	-	5.0	10.0	15.0
	Дүн	67.0	67.0	72.0	90.0	99.0
Чандмань сум						
1	Хүрхрээ	30.0	30.0	30.0	35.0	40.0
Эрдэнэ сум						
1	Бага зарман	10.0	10.0	10.0	15.0	15.0
2	Их зарман	25.0	25.0	25.0	30.0	30.0
3	Гудар	10.0	10.0	10.0	15.0	15.0
	Дүн	45.0	45.0	45.0	60.0	60.0
Баян-уул сум						
1	Нуур могой	-	-	2.0	3.0	4.0
Алтай сум						
1	Тал булаг	-	-	4.0	4.0	6.0
Есөнбулаг сум						
1	Рашаант	4.0	4.0	4.0	4.0	8.0
2	Цахир булаг	2.0	2.0	4.0	6.0	10.0
3	Элэгний булаг	-	-	2.0	5.0	15.0
4	Цагаан толгой	-	-	2.0	5.0	18.0
	Дүн	6.0	6.0	12.0	20.0	51.0
Дарви сум						
	Харгана түрүү	-	-	5.0	20.0	50.0
Тайшир сум						
1	Баюуны булан	12.0	12.0	12.0	12.0	27.0
2	Шар булаг	10.0	10.0	15.0	15.0	20.0
3	Мөрөн	-	-	5.0	6.0	8.0
4	Дээд гол	-	-	5.0	7.0	10.0
	Дүн	22.0	22.0	37.0	40.0	65.0
Цээл сум						
1	Сухайтын булаг	50.0	50.0	15.0	30.0	50.0
2	Буур	5.0	5.0	5.0	5.0	5.0
	Дүн	55.0	55.0	6.5	35.0	55.0
Бигэр сум						
1	Бор гол	12.0	12.0	15.0	20.0	20.0
2	Бор газар	3.0	3.0	5.0	7.0	10.0
3	Бургас	1.0	1.0	1.0	2.0	3.0
4	Мянгай	75.0	75.0	75.0	80.0	80.0
	Дүн	91.0	91.0	96.0	109.0	113.0
Тонхил сум						
1	Өвчүүний гол	50.0	50.0	50.0	60.0	70.0
Бугат сум						
1	Хонхот булан	20.0	20.0	20.0	20.0	20.0
2	Айлын цагаан	30.0	30.0	30.0	50.0	60.0
3	Төхөмийн хөндий	50.0	50.0	50.0	55.0	55.0
	Дүн	100.0	100.0	100.0	125.0	135.0
Хөх морьт сум						
	Завхан гол	-	-	-	2.0	5.0
	Аймгийн дүн	2266.0	2266.0	2484.5	3963.0	4613.0

Хүснэгт 50

Нөхөн сэргээлт хийх хадлангийн газар төлөвлөлтийн үе шат

№	Сайжруулалтын төрөл	2006-2010 он	2011-2015 он	2016-2023 он
1	Үндсэн сайжруулалт	-	200.0	500.0
2	Өнгөн сайжруулалт	571.0	1495.0	1852.0
	Дүн	571.0	1695.0	2352.0

Сайжруулалт хийсэн талбайгаас жилд хоёр ургац авах шаардлагатай.

Одоогийн ашиглагдаж байгаа болон хадланд ашиглах нийт талбайд ургамал нөмрөгийг сэргээх, усжуулах зэрэг өнгөн сайжруулалтын бүх арга хэмжээг авна.

Хүснэгт 51

Хадлангийн газрын төлөвлөлтийн хураангуй

№	Төлөвлөлтийн үе шат	Талбай (га)
1	Одоогийн байдлаар	2266
2	2006-2010 он	2484.5
3	2011-2015 он	3963.0
4	2016-2023 он	4623

III.1.3 Бэлчээрийн менежментийн бүсүүд, тэдгээрийн нөөц нөхцлийн төлөвлөлт**III.1.3.1 Бэлчээрийн менежмент**

Говь-Алтай аймгийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөнд бэлчээрийн менежментийн асуудлыг тусгайлан авч үзэх шаардлагагүй гэж үзлээ. Учир нь 2004 онд “Бэлчээрийн менежментийн тогтвортой хөгжлийн төсөл”-ийн хүрээнд Халиун зэрэг сумдуудад “Бэлчээрийн мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах менежментийн төсөл” хэрэгжүүлж эхэлсэн юм. Энэхүү бэлчээрийн менежментийн төслөөр бүх өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны газруудын байршлын солбилцлыг GPS багажаар тодорхойлж зураглал үйлдсэнээс гадна бүх худаг, уст цэгүүдийг ажилтай ажилгүйгээр нь зааглан солбилцолыг тодорхойлж зурагт оруулсан байна. Ийнхүү өндөр нарийвчлалтай явуулсан судалгаанд тулгуурлан бэлчээр нутгийг хамтран ашиглах, хөдөлмөрөө хоршиход чиглэсэн “малчдын бүлгүүд” зохион байгуулж, бүлэг бүрийн бэлчээрийн газар ашиглах хуваарийг гарган өгч мөрдүүлж байна.

Энэ ажлыг зохион байгуулахдаа бүх багийн засаг дарга, сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжлийн хүмүүс болон малчдыг татан оролцуулсан нь уг ажлыг бодит үр дүнд хүрэх боломжит нөхцлийг бүрдүүлжээ. Мөн 2004 оны хээрийн судалгаа, зохион байгуулалтын ажилд үндэслэн бэлчээрийн менежментийн нарийвчилсан зураг, төсөл зохиож сумдуудад хүргүүлснээс гадна уг төслийн хэрэгжилтийг газар дээр нь зохион байгуулах үүрэг бүхий төлөөлөгчийг сум бүрт томилон ажиллуулж байна.

Иймд Говь-Алтай аймгийн бүх сумдын бэлчээрийн менежментийн асуудлыг дээрх төслийн хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

III.1.3.2 Бэлчээр хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх талаар

Говь-Алтай аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тайлбар бичгийн II бүлэгт бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын одоогийн байдал бэлчээрийн талхлагдал, түүний учир шалтгааныг тодорхой авч үзсэн.

Бэлчээрийн талхлагдсан үндсэн шалтгаан нь хуваарь сэлгээгүй даацыг хэтрүүлэн, олон жил давтан ашигласан, бог малын тоо толгой хэт нэмэгдсэн зэрэг зохион байгуулалтын холбогдолтой асуудал байх боловч уст цэгийн дутагдалтай байдал, хуурайшилт, цөлжилтийн нөлөө багагүй хувийг эзэлж байна.

Цаашид бэлчээрийн талхлагдалыг бууруулж, ургацыг нөхөн сэргээх гол нөхцөл нь бэлчээрийг хуваарь сэлгээтэй ашиглах, бэлчээрээс түр хугацаагаар чөлөөлөх, даацыг нь хэтрүүлэхгүй байх зэрэг тал бүрийн арга хэмжээнүүдийг ойрын үед авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 52

Бэлчээрийн талхлагдлыг зогсооход чиглэгдсэн арга хэмжээний төсөл (сумаар)

д/ д	Сумын нэр	Талхлагдсан бэлчээр /га/	Авах арга хэмжээ					
			Түр чөлөөлөх			Сэлгэн ашиглах		
			2006- 2010 он	2011- 2015 он	2016- 2023 он	2006- 2010 он	2011- 2015 он	2016- 2023 он
1	Алтай	124659	-	-	-	20400	54259	40000
2	Баян - Уул	156999	10000	10000	1500	60000	60000	15499
3	Бигэр	39657				19000	10657	10000
4	Бугант	100670	5000	5700	-	40000	40000	9970
5	Дарви	102906	10000	10000	5000	30000	37000	10906
6	Дэлгэр	68073	1000	1000	-	30000	20000	16073
7	Есөнбулаг	28388				15000	11388	2000
8	Жаргалан	42867				20000	18867	4000
9	Тайшир	94840	800	200	-	50000	30000	13840
10	Тонхил	109194	20000	10000	9000	40000	20000	10194
11	Төгрөг	80968	-	-	-	40000	30968	10000
12	Халиун	110395	-	-	-	60000	40000	10395
13	Хөх морьт	85510	20000	10000	9000	40000	20000	10194
14	Цогт	50285	5000	4000	1044	20000	10000	10241
15	Цээл	81515	3000	1080	1000	40000	26345	10000
16	Чандмана	62739	4000	5000	1800	30000	20000	1939
17	Шарга	128281	-	-	-	10000	50000	8281
18	Эрдэнэ	63796	-	-	-	40000	20000	3796
		1531742	78800	56980	28344	604400	519484	197328

Тус аймгийн бэлчээрээс 1531.7 мян.га буюу нийт бэлчээр 17,6 хувь нь талхлагдсан болох нь тогтоогджээ. Дээрх нийт талхлагдсан бэлчээрээс 9,2 хувь буюу 140.6 мян.га бэлчээрийг түр хугацаагаар чөлөөлөх, 90,1 хувь буюу 1391,1 га бэлчээрийг сэлгэн ашиглахаар төлөвлөлтөнд тусгав.

Бэлчээрийн талхлагдлыг зогсооход чиглэгдсэн арга хэмжээний төсөл (бүсээр)

д/д	Сумын нэр	Талхлагдсан бэлчээр /га/	Авах арга хэмжээ					
			Түр чөлөөлөх			Сэлгэн ашиглах		
			2006-2010 он	2011-2015 он	2016-2023 он	2006-2010 он	2011-2015 он	2016-2023 он
1. Төвийн бүс								
1	Дэлгэр	68073	1000	1000	-	30000	20000	16073
2	Есөнбулаг	28388				15000	11388	2000
3	Жаргалан	42867				20000	18867	4000
4	Тайшир	94840	800	200	-	50000	30000	13840
5	Халиун	110395	-	-	-	60000	40000	10395
6	Цээл	81515	3000	1080	1000	40000	26345	10000
7	Шарга	128281	-	-	-	10000	50000	8281
2. Бигэрийн бүс								
8	Бигэр	39657				19000	10657	10000
9	Цогт	50285	5000	4000	1044	20000	10000	10241
10	Чандмана	62739	4000	5000	1800	30000	20000	1939
11	Эрдэнэ	63796	-	-	-	40000	20000	3796
3. Төгрөгийн бүс								
12	Бугат	100670	5000	5700	-	40000	40000	9970
13	Төгрөг	80968	-	-	-	40000	30968	10000
4. Тонхилын бүс								
14	Дарви	102906	10000	10000	5000	30000	37000	10906
15	Тонхил	109194	20000	10000	9000	40000	20000	10194
5. Баян-Уулын бүс								
16	Баян - Уул	156999	10000	10000	1500	60000	60000	15499
17	Хөх морьт	85510	20000	10000	9000	40000	20000	10194
6. Алтайн бүс								
18	Алтай	124659	-	-	-	20400	54259	40000
		1531742	78800	56980	28344	604400	519484	197328

Бэлчээрээс түр хугацаагаар чөлөөлөхөөр төлөвлөсөн бэлчээрүүд нь үндсэндээ талхлагдалд хүчтэй өртсөн сумын төв, уст цэгийн орчмын газрууд юм. Бэлчээрээс түр хугацаагаар чөлөөлөх асуудлыг 2 үндсэн арга хэлбэрээр хийгдэнэ. Үүнд тухайн бэлчээрийг тодорхой хугацаагаар (2 жилээс доошгүй хугацаагаар) малын хөлөөс бүрэн чөлөөлөх, хаврын сүүлчээс намрын дунд үе хүртэл (бэлчээрийн ургамлын вегетацийн бүрэн хугацаанд) бэлчээрээс чөлөөлж зөвхөн хүйтний улиралд даацыг нь хэтрүүлэхгүй ашиглах явдал юм.

Бага ба дунд зэрэг талхлагдсан бэлчээрийг сэлгэн ашигласнаас талхлагдлыг зогсоож ургамлын бүрэлдэхүүн, ургацыг нь сэргээх боломжтой. Үүний тулд уг бэлчээрийг дээрхийн адил хаврын сүүлчээс намар хүртэл ашиглахаас аль болох зайлсхийж, зайлшгүй ашиглах шаардлага гарвал богино хугацаанд даацыг 50-60 хувиас хэтрүүлэхгүйгээр ашиглах хэрэгтэй.

Бэлчээрийг ашиглалтаас түр чөлөөлөх, сэлгэн ашиглах асуудлыг тухайн бэлчээр, нутагт нутагладаг малчидтай тохиролцож, хамтран шийдвэрлэх нь илүү үр дүнд хүрэх болно. Бэлчээрийг талхлагдалд хүчтэй өртүүлдэг нэг хүчин зүйл бол үлийн цагаан оготно, тархах явдал юм. 2005 онд Газар зохион байгуулалтын ерөнхий

төлөвлөгөөний хээрийн судалгаагаар Есөнбулаг, Дэлгэр, Цогт, Цээл, Чандмань сумдын говь хээрийн бүсийн зааг газраар үлийн цагаан оготно тархсан байна.

Хүснэгт 54

Үлийн цагаан оготно устгах ажлын зардлын тооцоо

д/д	Сумын нэр	Оготно утгах талбай (га)	Нэгжийн зардал (1 га.мян.төг)	Нийт зардал (сая.төг)
1	Алтай	38424	2,5	96,1
2	Бигэр	9945	2,5	24,8
3	Дэлгэр	1618	2,5	4,1
4	Есөнбулаг	14691	2,5	36,7
5	Цогт	9164	2,5	22,9
6	Цээл	4963	2,5	12,4
7	Чандмань	3877	2,5	9,7
	Аймгийн дүн	82682	2,5	206,7

Тус аймгийн дээрх 7 сумын нутагт нийт 82682 га бэлчээрт тархсан үлийн цагаан оготно устгахад нийт 206,7 сая.төг шаардагдаж байна (ШУА-ийн УХЦ-ийн хүрээлэнгээс нэгжийн зардлын дундаж хэмжээг авав).

Дээрх зардал нь авиа химийн аргаар устгал хийх зардал бөгөөд нэгжийн зардалд газар дээр нь гүйцэтгэх ажилд зориулагдах зардлыг 25 хувиар өсгөж авсан болно. Хортон мэрэгчид устгах ажлын хэсэг нэг сумнаас нөгөө суманд шилжин байрлах зардлыг энд тусгаагүй юм. Үлийн цагаан оготно устгахад биологийн болон механик аргыг өргөн хэрэглэх боломжтой. Үүний тулд үнэг, хярсны ангах явдлыг хориглох, сар, шонхор зэрэг шувуудад суулт хийж оготно тархсан газарт байрлуулахын зэрэгцээ өвлийн улиралд оготны үлийн нүхнүүдэд ус цутгаж хөлдөөх зэрэг аргуудыг орон нутгийн хүч бололцоонд түшиглэн хэрэглэхийг санал болгож байна. Ямар нэг хэмжээгээр талхлагдалд өртсөн бэлчээр газар нь үлийн цагаан оготны амьдрах зохистой орчин болдог тул бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, урьдчилан сэргийлэх явдал чухал юм.

Тус аймгийн Хөхморьт, Баян-Уул, Жаргалан сумдуудын нутгийн хойд хэсгээр Их Монгол элсний элстэй бэлчээр тархсан байдаг. Энэ бэлчээр нь маш эмзэг бүтэцтэй тул хялбархан талхлагдаж эвдрэлд орсноор элсний нүүлт үүссэн явдал Хөхморьт суманд үзэгдэж байна. Иймээс элсний бэлчээрийг зөвхөн өвлийн улиралд цасан бүрхүүл тогтсон үед буюу 1-р сараас 3-р сарын хооронд богино хугацаагаар даацыг хэтрүүлэхгүй ашиглах, бусад улиралд малын хөлөөс чөлөөлж өгөх хэрэгтэй юм.

Бэлчээрийн талхлагдалаас сэргийлэх өөр нэг нөхцөл нь бэлчээр ашиглалтын даацыг тохируулах явдал юм. Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд бэлчээрийн даац ашиглалтын түвшин хэвийн хэмжээнд байна. Харин Есөнбулаг сумын бэлчээрийн даац ашиглалтын түвшин хэтэрхий өндөр байгааг анхаарах хэрэгтэй юм.

Алтай хотын ойролцоох сумдын иргэд, малчид зах зээлд ойртон тус сумын нутагт зун, намрын улиралд нутаглан бэлчээрийг талхлах явдал жил бүр гарч буйг зохицуулах нь зүйтэй. Цаашид аймгийн хэмжээнд малын тоо толгойг хэт өсгөх явдалд зохицуулалт хийх, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх чанарыг сайжруулан сүргийн бүтцийг оновчтой болгоход анхаарах шаардлагатай. Сүргийн дотор ямааны эзлэх хувийн жин хэт их байх нь бэлчээрийн ургамал хомсдож, улмаар цөлжилт үүсэх нэгэн хүчин зүйл болдгийг анхаарах нь зүйтэй.

Тус аймгийн хэмжээнд заг, шаваг, харгана зэрэг элсийг барьж бэхжүүлдэг, модлог бутлаг ургамлыг түлшинд их хэмжээгээр хэрэглэж байгаа нь хөрс суларч, улмаар элсний нүүлт үүсэх, бэлчээр элсэнд дарагдан цөлжих, талхлагдах нөхцлийг бүрдүүлж байна. Иймд Зээгт, Хүрэн гол, Цахиурт зэрэг нүүрсний орд газруудыг түшиглэн шахмал түлшний жижиг үйлдвэрүүдийг байгуулах, аж ахуй нэгж, иргэдийн санаачлагыг дэмжих нь зүйтэй. Ингэснээр бэлчээрийн талхлагдалаас хамгаалах цөлжилтийг сааруулахад нэгэн томоохон алхам, хөдөө нутагт гарах шинэ дэвшил болно гэж тооцож байна.

Ашиглалтгүй болсон булаг шанд, хөв, худгийг сэргээх, засаж тохижуулах зэргээр алслагдсан болон ус дутагдалтай бэлчээр ашиглах санаачлага гаргасан иргэд, малчдын бүлгийг дэмжих, тэдэнд хөнгөлттэй зээл олгох, гадаад дотоодын төсөл, сургалт тусламжинд хамруулах, бага оврын техник, холбооны хэрэгслэлээр хангах замаар урамшлуулан дэмжиж, талхлагдсан бэлчээрийг чөлөөлөх, сэлгэн ашиглах зэргээр эргэлтэнд оруулж түүний нөхөн сэргэх дотоод чадавхыг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Нөгөө талаар бэлчээрийн мал аж ахуйн байршил, тэдгээрийн зохистой зөв хослолыг тооцоход байгаль-нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлүүд нэгэн зэрэг нөлөөлдөг эдрээтэй асуудал билээ.

Хүснэгт 55

Малын тоо толгойн өсөлтийг бэлчээрийн чадавхитай харьцуулсан үзүүлэлт

№	Бүсийн нэр	Бэлчээрийн чадавхи (мян.хонь.толгой)	2005 оны бүх мал (мян.хонь.толгой)	2006-2010 он		2011-2015 он		2016-2023 он				
				Нийт мал (мян.хонь.толгой)	Үүнээс		Нийт мал (мян.хонь.толгой)	Үүнээс		Нийт мал (мян.хонь.толгой)	Үүнээс	
					Төлөвлөлтийн эхэн үед (мян.хонь.толгой)	Нэг хонин толгойд ноогдох бэлчээр (га)		Төлөвлөлтийн эхэн үед (мян.хонь.толгой)	Нэг хонин толгойд ноогдох бэлчээр (га)		Төлөвлөлтийн эхэн үед (мян.хонь.толгой)	Нэг хонин толгойд ноогдох бэлчээр (га)
1	Төвийн бүс	950.0	857.2	877.2	20	3.4	907.2	30.0	3.3	940.2	33.0	3.2
2	Бигэрийн бүс	1072.7	434.7	479.7	45.0	3.8	564.7	85	3.2	658.5	93.8	2.8
3	Баян-Уулын бүс	445.8	264.2	299.2	35.0	4.0	354.2	55.0	3.4	422	67.8	2.9
4	Тонхилын бүс	474.5	342.5	372.5	30.0	2.2	417.5	45.0	2.2	472.4	54.9	1.7

5	Төгрөгийн бүс	451.2	245.8	280.8	35.0	3.6	340.8	60.0	3.0	420.8	80.0	2.4
6	Алтайн бүс	301.9	101.1	111.1	10.0	7.8	151.1	40.0	5.7	216.1	65.0	4.0
	Дүн	3696.4	2245.5	2420.5	175.0	-	2735.5	315.0	-	3130.0	394.5	-

Говь-Алтай – Их нууруудын хотгорын дэд мужид нийт малын дотор ямаа 50 хувь, тэмээ 20 хувь, хонь 20 хувь, үхэр, адуу нийлээд 10 хувь орчин байх нь зохистой хэмээн судлаачид үздэг. Бэлчээрийн мал аж ахуйн энэхүү дэд мужийн байгалийн нөөц, нөхцлийг нийгэм эдийн засгийн онцлогтой хамтатган тооцсон тул амьдралд хэрэглэх боломжтой юм.

Дээрх хүснэгтээс үзэхэд төлөвлөлт хугацааны эцэст тус аймгийн мал сүрэг хонин толгойд шилжүүлснээр нийт 3130 мянга болох юм.

Аймгийн нутаг, бэлчээрийн даац, малын тоо толгойн харьцааны тэнцвэртэй байдлын үзүүлэлт болж байгаа юм.

Бэлчээрийг бүрэн усжуулах, алслагдсан бэлчээрийг ашиглахын зэрэгцээ бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, ээлж сэлгээтэй ашиглах, малчдын бүлэгт эзэмшүүлэхтэй холбогдсон асуудлыг шийдвэрлэх шаардлагатай юм.

III.1.3.3 Бэлчээр усан хангамжийн асуудал

Тус аймаг 1989 оны байдлаар нийт бэлчээрийн 63,9 хувь буюу 5691,6 мянга нь усжуулагдан, 2425 худаг хэвийн байдлаар ажиллаж байв.

Гэвч сүүлийн 10 гаруй жилийн дотор 936 худаг эвдэрч тоногдох зэргээр ашиглалтаас хасагджээ. Ингэснээр усжуулагдсан бэлчээрээс 2164,9 га талбай хасагдахад хүргэсэн зохисгүй явлад болжээ. Бэлчээрийн ачаалалд сөргөөр нөлөөлдөг нэгэн хүчин зүйл нь бэлчээрийн усан хангамжийн асуудал юм. Усжуулагдаагүй бэлчээр үндсэндээ ашиглагддаггүй учраас түүний ачаалал нь усжуулагдсан хэсэгтээ ирж бэлчээрийн усжуулагдсан хэсгийн ачаалал хэтэрч талхлагдах нөхцлийг бүрдүүлдэг.

Уст цэгийн тоо ийнхүү буурсан нь өөрөөр хэлбэл нутаг бэлчээрийг цаг улирал, өвс ургамлын онцлог байдалд зохицуулан ээлж сэлгээтэй ашиглаж ирсэн нүүдлийн уламжлалт дэг жаяг алдагдаж цөөн тооны худаг ус, булаг шандыг тойрон хумигдан эргэлдэнэ гэсэн үг юм. Тус аймгийн эдийн засгийн үндэс болох мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангах нэгэн гол асуудал нь усан хангамж юм. Сүүлийн жилүүдэд гадаад дотоодын төсөл, иргэд малчдын оролцоо дэмжлэгтэйгээр худаг сэргээн засварлах, усан сан хөвийг тохижуулан сэргээх ажил далайцтай явагдаж байна. ГИДГ-ын санаачлагаар дархан газрын орчны бүсэд худаг гаргах болсон нь малчдын талархлыг хүлээх болов.

III.2 ХОТ ТОСГОН БУСАД СУУРИНЫ СУУРЬШЛЫН БҮСҮҮД, ТҮҮНИЙ НӨӨЦ, НӨХЦЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

III.2.1 Хүн амын суурьшлын бүс газрын төлөвлөлт

1. Бүс нутгийн тогтолцоо

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд (УИХын 2001 оны 57 дугаар тогтоол). Говь-Алтай аймгийг баруун бүсэд багтаасан.

Баруун бүсийн төв хотуудад Ховд, Улиастай хотууд гэж тогтоогдсон. Иймээс Алтай хотыг эдгээр хотуудтай найдвартай сайжруулсан авто зам, холбоо, мэдээллийн сүлжээгээр хангах шаардлага нэн тэргүүнд тавигдана.

Говь-Алтай аймаг нь баруун бүсийн нүүрс болон бусад ашигт малтмал, түүхий эдийн голлох нөөцтэй нутагт багтана.

2. Сүм дундын буюу бүлэг суурингийн тогтолцоо

Улсын хэмжээнд бүсчилсэн хөгжлийн нутаг дэвсгэрийн тогтолцоо нь бүс нутаг, аймаг, бүлэг суурин, сум гэсэн хэлбэртэй байна.

Нийгэм, соёлын үйлчилгээний түвшин хангалтгүй үйлдвэрлэл, аж ахуйн уялдаа холбоо сул, зөвхөн засаг захиргааны үүрэг давамгайлсан сумдыг зах зээлийн харилцааны нийтлэг шаардлагын үүднээс нутаг дэвсгэрээр бүсчлэн, эдийн засгийн хувьд үр ашигтай, нийгмийн чиг баримжаатайз болгох асуудал хөдөөгийн хөгжлийн бодлогын тулгамдсан зорилт болж байна.

Хүн амын нутагшилт, хөгжлийн ерөнхий төслийн хүрээнд хүн амын нутагшилт, суурьшилт, бүсчлэл, нутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалтын оновчтой тогтолцоо бүрдүүлэх асуудлыг түүхэн хөгжлийн явц, өнөөгийн байдал, тулгамдсан зорилтуудтай харьцуулан цогцолбороор авч үзлээ.

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг орон нутагт бодитойгоор хэрэгжүүлэх зорилгоор ойр зэргэлдээ сумдтай нь харьцуулахад хөгжлийн түвшин, ирээдүйн төлвөөр давуу, байршлын хувьд үйлчилгээний зохистой хүрээнд эрүүл мэнд, соёл боловсрол, банк, санхүү, бизнесийн бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой сумдуудын талаар орон нутгаас санал авч, бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх шатны зорилттой уялдуулан бүлэг суурингийн төвүүдийг тогтоосон болно.

Хүснэгт 56

Нийт бүлэг суурингийн тогтолцоо

Бүсийн нэр	Бүлэг суурингийн тогтолцоо	Үүнээс	
		Хот аймгийн төв	Сум дундын төв
Баруун бүс	6	1	5

Буур, Талын мэлтэс, Улаан боом, Шар хөтөл, Хүрэн гол суурингууд шинээр байгуулагдана. Эдгээр суурингуудаас 2006-2010 онд Улаан боом, Бургастай, Шар хөтөл, 2011-2015 онд Буур, 2016-2023 онд Талын мэлтэс гэдэг суурингууд байгуулагдана.

Одоогоор бараг бүх сумд зарим сум дундын эмнэлэг, сургуулийг эс тооцвол бусад төрлийн үйлчилгээг аймгийн төвөөс авч байгаа тогтолцоог өөрчилж, эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагааны үр ашигтай шаталсан хэлбэрт оруулах шаардлага нийгмийн шинэчлэлт өөрчлөлтийн өнөөгийн амьдралаас урган гарч байна.

Ийм ч учраас сумдыг бүсчлэн хөгжүүлэх талаар аймаг, орон нутаг санаачилга гаргаж, зарим сумдыг нэгтгэж бүсчилсэн хөгжлийн бодлогын зарчмын шийдлийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Аймгийн төвийн хотуудыг сум болгосныг олон улсын жишиг, хотуудын нийгмийн дэвшилд эзлэх байр суурийг харгалзан хотын зэрэглэлтэй болгон аймгийн төвийн засаг захиргааны үүрэг давхацсан Есөнбулаг сумыг татан буулгах нь зүйтэй гэж үзэж байна.

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг төгс хэрэгжүүлэх үүднээс үйлчилгээний зохистой хүрээнд эдийн засаг, аж ахуйн уялдаа холбооны үр ашгийг дээшлүүлэх, засаг захиргааны давхардлыг багасгахын тулд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүтцийг боловсронгуй болгох нь зүйтэй.

Ингэснээр хөгжлийг түргэтгэж төвлөрлийг хөдөөд шилжүүлэх боломж бүрдэнэ.

а. Аймгийн төв хот

Алтайн хот нь 1970-1980 оны үед боловсруулсан төлөвлөгөөний хэрэгжилтийн судалгаанаас үзэхэд дунджаар орон сууцны барилгын 30 хүрэхгүй хувь, үйлдвэр үйлчилгээний барилгын 40 орчим хувь нь баригдсан байна.

Нөгөөтэйгүүр газар улсын өмч гэсэн хандлага давамгайлж, газрын харилцаанд эрх зүйн орчин бүрдээгүй байсан зэргээс шалтгаалан чөлөөтэй орон зайг хамруулсан төсөл хэрэгжүүлж байснаас барилгажилтын нягтрал бага байсан байна.

Алтай хотын барилгажилтын нягтралыг сайжруулах, орон зайн шийдлийг боловсронгуй болгох замаар зохицуулах шаардлагатай.

Хот суурины суурьшлын бүс газрыг үндэслэлгүй тэлэх асуудлыг хязгаарлах, барилгажилтын нягтралыг сайжруулах, газрын харилцааг боловсронгуй болгох үүднээс тэг гортигийн газрыг нэмэгдүүлэхгүйгээр нягтруулах зарчмыг баримталсан болно.

Алтай хотын хөгжлийн түвшин ойрын 20 жилд тэг гортигийн хилийн цэст өөрчлөлт орохгүй. Харин экологийг хувьд хот байгуулалтын чиглэлээр үерийн хамгаалалтын арга хэмжээ авах, цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ундны усны эх үүсвэр, цэвэрлэх байгууламжийн ариун цэвэр, хамгаалалтын бүсийг зохих норм, стандартын шаардлагын дагуу тогтоож хэрэгжүүлэх, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан хот байгуулалтын кадастр, бүртгэл хөтлөх ажлыг эрчимжүүлж, газрын харилцаа, хот байгуулалтын мэдээллийн оновчтой тогтолцоо бүрдүүлэх шаардлага тулгарч байна.

б. Бусад хот тосгон

Бусад суурин газруудыг хот маягийн тосгон, хөдөөгийн тосгон гэсэн үндсэн 2 ангилалд багтааж, хот бүрэлдүүлэгч үүргийг нь тодорхойлсон байна.

Хот маягийн тосгонд уул уурхай, олборлох, боловсруулах үйлдвэрийн чиглэлтэй Цахиурт, Зээгт, Хүрэн гол, Буур, Талын мэлтэс, амралт сувилал, зам тээвэр, ХАА чөлөөт бүс, хилийн боомт зэрэг Шар сайр, Шар хөтөл, Бургастай, Эвэн, Улаан боом, Гуулин, Баянтоорой зэрэг тосгоныг хамруулж, хөдөөгийн тосгонд сум, багийн томоохон төвүүдийг хамруулсан.

Шинээр бий болох хот маягийн тосгон, хөдөөгийн тосгоны тухайд суурьшлын бүс газрын хилийг тогтоох шаардлагатай.

3. Суурьшлын бүс газрын бодлогын бүсүүд

Төв суурин газрын суурьшлын бүсийн хил заагийг тогтоохдоо газрын нэгдмэл сангийн ангиллын газрын судалгааг үндэслэсэн ба суурьшлын бүсийн орон зайн нөхцөл, нийгмийн хөгжлийн явцад аяндаа цэгцрэн, суурьшсан төвлөрөл, экологи эдийн засгийн чадавхи боломжийн талаарх үнэлгээг үндэслэн тогтоож, тоон мэдээлэлд шилжүүлэн ARC/VIEW программаар эзлэх талбайн хэмжээг тооцсон болно. Өргөн уудам нутаг дэвсгэртэй манай орны хувьд хүн амын нутагшилт, суурьшил нь ландшафт экологийн нөхцөлөөс шалгаалж газар ашиглалт харилцан адилгүй шинж чанартай байна.

Газар нутгийн ашиглалт ерөнхий утгаараа бэлчээрийн газар эртнээс хүн “НУТАГЛАЖ” ирсэнтэй уялдаатай бөгөөд энэ нь газрын менежментээр ХАА-н бүс нутгийн асуудал болох юм. Харин хүн амын нийгэм, эдийн засгийн шардлага, хөгжлөөс урган хүн амын төвлөрөл, суурьшил бий болсон бөгөөд ихэвчлэн үүнтэй холбоотой эрүүл мэнд, дэд бүтэц, соёл, боловсролын салбарууд хөгжиж төвлөрч байна.

Хүн амын суурьшлын бүс, тэдгээрийн орчны газрыг ерөнхийд нь эрх зүйн зохицуулалт, ашиглалт хамгаалалтын хувьд дараах үндсэн бүсүүдэд хуваана.

- Хотожсон болон хотжин өргөжих бүс
- Хүн амын социаль нөхөн сэргээлтийн бүс
- Экологийн тэнцлийн болон газрыг хязгаарлах нөхцөлийн үүднээс ашиглалтыг зогсоож хамгаалах бүс
- Хот суурин орчмын байгалийн ховор үзэсгэлэнт ландшафтыг хадгалан үлдээх бүс
- Хот орчмын эрчимт хөдөө аж ахуйн бүс
- Хот орчмын уламжлалт хөдөө аж ахуйн бүс

а. Хотожсон болон хотжин өргөжих бүс

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд суурьшлын бүс газар нь хот, хотожсон хэв шинжийн болон, үйлдвэр, уурхай даган хөгжсөн суурин, хөдөөгийн суурин газрын хэлбэрээр байна.

Суурьшлын бүс газар нь хот, тосгон, суурин газрын хэлбэрээр илэрдэг.

- 15000-аас доошгүй оршин суугчидтай төвлөрсөн суурин газар оршин буй нутаг дэвсгэрийг ***хотын газар***
- 500-14999-н оршин суугчидтай төвлөрсөн суурин газар оршин буй нутаг дэвсгэрийг ***тосгоны газар***
- 500 хүртэл хүн ам байнга төвлөрөн суудаг, суурьшлын бүс бүхий нутаг дэвсгэрийг ***суурингийн газар*** гэж ангилав.

(Газар сангийн ашиглалт, хамгаалалт менежмент Г.Пүрэвцэрэн 1995 он)

Говь-Алтай аймгийн хэмжээнд 2005-2023 онд баригдах төмөр замын дагуу 10 зөрлөг баригдах бөгөөд тэдгээрийн зарим нь бие даасан шинжтэй, зарим нь сумын төвийн ойролцоо байрлах учир бие даасан суурин тосгон болон хөгжих боломжгүй, тухайн сумын төвтэй нэгдэн хөгжинө.

Хүн амын өсөлтийг дагаад төв суурин газрын суурьшлын бүс газар нэмэгдэх нь гарцаагүй боловч хот байгуулалтын төлөвлөгөөгөөр аймгийн төвийн барилга байгууламжийн дөнгөж 40 %, сумдын төвд баригдах барилга байгууламжийн 20 % баригдсан байгаад дүгнэлт хийж, харин төв суурин газрын газар ашиглалтын нягтралыг зохистой хэлбэрээр нэмэгдүүлэх бодлого баримтлах нь зүйтэй юм. Ялангуяа байшин барилга, гэр хороолол нь таруу сийрэг суурьшсан, сумдын төвийн суурьшлын бүсийн тэг гортигийг нэмэгдүүлэх талаас нь бус зохистой орон зайг харгалзан цэгцтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан талаас менежмент хийх нь зүйтэй.

Хөдөөгийн сумын төв суурингууд нь хүн амын тоогоор ихэнхдээ цөөн, хотын шинж төрх болох үйлдвэр худалдаа, соёл боловсрол, эмнэлэг үйлчилгээ, нийтийн

ахуйн үйлчилгээ, дэд бүтцийн хөгжил зэрэг хотын хөгжлийн шинж төрх дутмаг байна. Иймд хүн амын тоогоор хот суурин газрыг зэрэглэх нь учир дутагдалтай болохыг харуулж байна.

Хот, суурин газрын тэг гортиг нь эртнээс нааш төлөвлөлтгүй, нутаг сонгох уламжлалт аргаар явж ирсэн ба харин хот, суурин газрыг барьж байгуулах, тэдгээрийн өргөжин тэлэх нь хот байгуулалтын төлөвлөлтөөр хийгдэж ирсэн байна. Иймд газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр төв суурийн газрын тэг гортигийг тогтоох нь зүйтэй бөгөөд ингэснээр Газрын тухай хуулийн газрын нэгдмэл сангийн ангиллыг нэгээс нөгөөд шилжүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагын шийдлвэрээр гүйцэтгэх зарчим хэрэгжиж, хотын тэг гортиг үндэслэл муутай тэлэх явдлыг хязгаарлах боломжтой юм.

Аймгийн төв-хотууд, суурингуудын газар ашиглалтын нягтрал харьцангуй доогуур байгааг харгалзан орон зайн нөөцийг зохистой ашиглах үүднээс дараахи үндсэн зарчмыг баримтлах нь зүйтэй юм. Үүнд:

- Аймгийн төв, хотын одоогийн байгаа суурьшлын бүсийн хил заагийг аль болохоор тэлэн өргөжүүлэхгүйгээр харин орон зайн нягтралыг дээшлүүлэх замаар зохистой ашиглах.
- Хотын тэг гортиг дотор байгаа шаардлагагүй сул чөлөөтэй, зориулалтын бүс газруудыг хотжих үйл явцад ашиглах.
- Хот суурингийн барилга байгууламжид орчин үеийн барилгын дизайн баримталахын зэрэгцээ, давхарын тоог нэмэх.
- Төв суурин газар гэр хорооллын эмх цэгцийг эрс сайжруулах, мал бүхий иргэдийг төв суурингийн гадна хот орчмын эрчимт хөдөө аж ахуйн бүс болон хот орчмын уламжлалт хөдөө аж ахуйн бүсэд суурьшуулах.

Хот, суурины тэг гортигт гарах зайлшгүй өөрчлөлтүүд буюу хот, суурин газруудын өргөжин тэлэх бүсэд газар ашиглалтад шууд нөлөөлөх газар чичирхийлэл, мөнх цэвдэг, хөрсний суулт, хөрсний ус зэргийг эн тэргүүнд харгалзан энгэр бэл, дэнж дагуу сонгох нь зүйтэй.

б. Хүн амын социаль нөхөн сэргээлтийн бүс

Суурин газрын хүн амын социал хэрэгцээний нэг хэсэг нь цэвэр агаартай задгай газар амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцлөөр хангагдсан байх шаардлага тавигдана.

Одоогийн байдлаар суурин газрын оршин суугчид төвлөрсөн суурингийн тэг гортигийн гадна гол, горхи, булаг шанд бүхий газар ихэвчлэн дулааны улиралд зусланд гардаг. Эдгээр зуслангийн газруудыг цаашид бүс болгон одоогоор

тэдгээрийг бараадсан зориулалтын бус үйл ажиллагаа, гэр хороолол, мал бүхий иргэдийн өвөлжөө, хаваржаанаас чөлөөлж, амралт зугаалгын үйлчилгээ үзүүлэх нөхцөл /сүүдрэвч, ширээ, сандал, хогийн сав, бие засах газар гэх мэт/ бүрдүүлж амралт, зугаалгын бүс газар болгох нь зүйтэй.

Суурин газрын барилга байгууламж бүхий газар, гэр хороолол, нийтийн ашиглалтын газрууд нь тодорхой орон зайд ногоон бүс бүхий заагтай байх нь хот суурингийн эрүүл ахуй, байгаль экологийн тэнцвэртэй байдал, хот суурингийн үзэмжийг улам тохилог болгоно.

Суурин газрын тэг гортигийн орчны бүсийн мал бүхий иргэдийн малын бэлчээрт шууд ашиглагдаж байгаа нь мод, ургамал байгалийн жамаар үрээ хаяж, нөхөн төлжих боломжийг ихээхэн алдагдуулж буйд дүгнэлт хийж, ашиглалтын зөрчлийг арилгах тусгай дэглэмийг тухайн сумдын иргэдийн хурал боловсруулж мөрдөх нь зүйтэй.

Хамгаалалтын бүсийн мод бүхий газар нь байгаль орчны тэнцэл, хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг хангах, хөрсний эвдрэлээс сэргийлэх, гадаргын болон газрын доорх усны горимийг зохицуулах ач холбогдолтой. Төв суурин газрын орчны бүсийн экологийн тэнцвэрийг хадгалах, суурин газрын гоо үзэмж, байгалийн унаган төрхийг хадгалах үүднээс тордож, сэргээх, хамгаалалтын арга хэмжээг чанд мөрдөх шаардлагатай.

Суурин газруудын ойр байх гол горхи, булаг шанд худаг нь тухайн төвийн хүн амын усан хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн бүсэд хамрагдах учир газар ашиглалтын онцгой дэглэм шаарддаг. Суурин газруудын орчны бүсийн хамгаалалтын бүсэд шууд байрласан айл гэрүүд болон аж ахуйн нэгжүүдийн бүх төрлийн объектийг нүүлгэн хамгаалалтын бүсийн гадна гаргах арга хэмжээ авах хэрэгтэй.

Булаг шандны эх, голын хөндий, тэдгээрийн зах эрэг орчмын газруудын ашиглалтын дэглэмийг онцгой анхаарч хамгаалах нь зүйтэй.

в. Экологийн тэнцлийн болон газрыг хязгаарлах нөхцөлийн үүднээс ашиглалтыг зогсоож хамгаалах бүс

Суурин газрын орон зайд төвлөрсөн газартай холбоотой олон янзын зориулалтын ашиглалтуудаас гадна зориулалтын бус ашиглалт, дагалдах шинжтэй ашиглалт нэг хэсэг тодорхой газарт байнга давхардаж байдаг шалтгаанаар газрын нөөц, орон зайн хувьд хомсдох, нөөц баялаг нь доройтох, шавхагдах, экологийн хувьд бохир орчин буй болох зэрэг үзэгдэл хот суурин газрыг байнга дагалдаж байдаг.

Суурины орчмын нутаг дэвсгэрт газар ашиглалтыг оновчтой зохион байгуулах замаар экологийн тэнцвэрийг хангах, хадгалах зорилт тулгарч байна.

Суурин газрын зах хаяа, тэдгээрийн ойр зэргэлдээ газруудад газар эзэмших, ашиглах дэг горим, журмыг хуулийн дагуу мөрдлөг болгохгүй байгаагаас экологи, хот байгуулалтын болон иргэд, байгууллагын ашиг сонирхол зөрчилдөж газрын харилцааны төвөгтэй асуудлууд гарах боллоо. Энэ байдлаас гарахын тулд газрын менежментийн төрөлжсөн бүсүүдийг тогтоож баримтлах нь зүйтэй.

А. Байгалийн тэнцвэржилтийг хангах бүсүүд

1. Гол горхи эх авсан газрын орчимд 5 км радиустай усны эх газрын бүс
2. Гол горхины урсгалын дагуу хоёр тийш 50 м өргөнтэй усны эргийн бүс
3. Чийглэг нуга хөндийн эргэн тойрон 100 м өргөнтэй эрэг орчмын бүс
4. Ундны усны эх үүсвэрийн үүрэг гүйцэтгэж буй гол горхи, булаг шандад 100 м өргөнтэй эрүүл ахуйн бүс
5. Төвлөрсөн усан хангамжийн гүний усны тэжээлийн нөөцийн гол талбарыг хамгаалах ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс
6. Газрын экологийн хязгаарлах хүчин зүйлсийн бүс

-Хөрсөн бүрхэвчийн тогтворжилт муутай хэт налуу газар

-Үерийн зам газар

-Хөрс нь намагжиж, давсжих нөхцөлтэй газар

-Сул болон хагас бэхэжсэн элсэн хөрстэй газар

-Салхи усны элэгдэл эвдрэлд амархан өртөмхий хөрстэй газар

Төв суурин газрын нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд газрын өөрийнх нь экологийн шинжтэй хязгаарлах хүчин зүйлсийн бүсийг зөв тогтоож, тэдгээр бүсүүдэд хориглох, хязгаарлах, болзолтойгоор зөвшөөрөх үйл ажиллагааны жагсаалтыг гаргаж хэрэгжүүлэх нь чухал.

Одоогийн байдлаар аль ч төв суурин газрын орчны эргэн тойрон 2-3 км зайд ургамалын нөмрөг сийрэгжиж, цөлөрхөг хээр, говь нутгийн зарим газар ургамлын нөмрөг толботсон болон нүцгэрсэн, хөрсний бүтэц алдагдсан зэрэг нь төв суурин газрын орчим дурын чөлөөт ашиглалтын дор нэрвэгдсэн төлөв байдалтай байгаа учраас тодорхой хугацаанд ашиглалтаас чөлөөлөх, одоогийн ачааллыг 2-3 дахин бууруулж хамгаалах нь зүйтэй.

-Цаашид газар зохион байгуулалт, хот тохижилтын жилийн төлөвлөгөөнд суурин газруудад ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнг тордох, сэргээх өргөтгөх, хамгаалах талаар заавал тусгаж хэрэгжүүлж байх шаардлагатай.

Б. Уламжлалт ёс заншлын газар

Үндэсний ёс заншилд шууд хамааралтай тодорхой хэмжээний газар нутаг хотын тэг гортигт хамрагддаг нь наадмын талбай юм.

Наадмыг чөлөөтэй явуулахад морин уралдааны гараа барианы газар, уралдааны зам, нум, сум, шагай харвах, бөх барилдах орон зай бүхий газар шаардлагатай.

Энэ үүднээс төв суурин газрын ойр уламжилж ирсэн уралдааны зам газрыг хамгаалах, наадмын талбайг өөр зориулалтаар ашиглахгүй байх дэг журам тогтоох нь зүйтэй.

В. Хог хаягдлын газар

Одоогийн байдлаар аль ч төвлөрсөн газар хог хаягдлын цэг байдаг боловч хөдөө, хотгүй эмх цэгц ариун цэврийн шаардлага хангахгүй байна.

Суурин газрын орчны хогийн цэг нь тэмдэгжүүлсэн, ухаж шан хүрээ татсан, торлосон, ангилан ялгах талбайтай байх зүй ёсны шаардлага гарч байгаа ба хогийн цэгийг суурин газрын зонхилох чиглэлийн салхины доор байхаар бодож зохион байгуулах нь зүйтэй байна.

Өнөөгийн байдлаар хогийн цэг нь зарим газарт салхины зонхилох чиглэлийн дээр байрласан, эргэн тойрон зурвас шангүй үргэлжилсэн харьцангуй их талбайг эзэлж байгааг цэгцэлж, энэ асуудалтай холбоотой журам, зааврыг хатуу мөрдүүлж байх нь зүйтэй.

Г. Оршуулгын газар

Том хотуудад оршуулгын газрын асуудлыг хөгжилтэй орнуудын суурин соёл, иргэшлийн хэв шинжийн хэлбэрт оруулан өөрчлөн шийдвэрлэх цаг нэгэнт болсон бөгөөд мэдээж энд иргэдийн санал, хүсэлт, уламжлалыг харгалзан, өөр өөрөөр шийдвэрлэх боломжууд байх нь дамжиггүй. Энэ талаар энэхүү газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд бага тусгалаа.

4. Хот суурин орчмын байгалийн ховор үзэсгэлэнт ландшафтыг хадгалан үлдээх бүс

Хотжих үйл явцад нэгэнт орсон хэдий ч хотын хаяа газруудын байгалийн өвөрмөц унаган ландшафтыг хотжих үйл явцаас сэргийлж хадгалан хамгаалах нь байгаль орчин, түүх соёл, эрүүл ахуй ёс заншлын зэрэг олон талын ач холбогдолтой юм. Манай орон өргөн уудам, ландшафтын олон хэв шинжтэй тул суурин газруудын эргэн тойрон ямар нэг түүх, дурсгал, байгалийн сонин цогцолборууд байдаг онцлогтой. Үүнийг хамгаалах арга хэмжээ авч хамгаалалтын бүс тогтоох, хашаа хамгаалалт барих шаардлагатай байна.

5. Суурьшлын бүсийн орчны ХАА-н газрын эзэмшилт,

ашиглалтын төрөлжилтийн бүсүүд

Суурин газруудын суурьшлын бүсийн зэргэлдээ мал бүхий иргэдийн бэлчээрийн газар, төмс хүнсний ногоо тариалах жижиг тариалангийн газруудын эзэмшилт, ашиглалтыг боловсронгуй болгох үүднээс ерөнхийдөө дараах төрөлжсөн бүсүүдийн хэлбэрийг сонгон зохион байгуулах нь зүйтэй. Үүнд:

1. Хувиарт эдлэн эзэмшилтэй эрчимжсэн аж ахуйн бүс
2. Хосолмол аж ахуйн суурьшлын бүс
3. Өрхийн аж ахуйн суурьшлын бүс
4. Чөлөөт ашиглалтын бүс гэсэн хот орчмын төрөлжсөн бүсүүдтэй нутаг дэвсгэрийн систем байх шаардлагатай байна.

Хот тосгон бусад суурины газрын төлөвлөлт

№	Сумын нэр	Газрын нэгдсэн сангийн ангиллаар					Хянан баталгаагаар				
		Бүгд	үүнээс				Бүгд	үүнээс			
			Барилга байгууламжийн дэвсгэр	Нийтийн эдэлбэр	Үйлдвэрийн газар	Гэр хороолол		Барилга байгууламжийн дэвсгэр	Нийтийн эдэлбэр	Үйлдвэрийн газар	Гэр хороолол
1	Алтай	1158.6	40.7	1110.2	-	7.7	355.58	3.6		0.5	5.9
2	Баян-уул	1010.0	33.2	970.5	-	6.3	1,082.76	3.0		0.1	9.0
3	Бигэр	472.0	4.8	456.0	-	11.2	355.67	7.0		2.5	9.2
4	Бугат	620.0	10.58	602.0	-	7.4	655.76	2.8		0.1	10.1
5	Дарви	491.0	8.74	474.1	-	8.19	322.14	3.0		0.1	9.6
6	Дэлгэр	257.0	7.6	223.2	-	26.2	213.43	7.7		0.1	7.2
7	Есөнбулаг	5377.0	220.8	5030.2	-	126	5,209.62	17.9		27.5	126
8	Жаргалан	499.0	5.2	487.4	-	6.4	540.85	3.0		0.1	5.9
9	Тайшир	640.0	3.8	621.3	-	14.9	634.21	3.4		0.1	26.0
10	Тонхил	818.5	33.2	744.8	-	40.5	530.90	3.3		0.1	9.6
11	Төгрөг	283.0	11.6	261.4	-	10.0	364.65	1.6		0.1	10.04
12	Халиун	150.0	12.0	123.5	-	14.5	182.94	3.6		0.1	4.4
13	Хөхморьт	366.0	5.7	356.4	-	3.9	223.87	1.7		0.1	6.4
14	Цогт	420.3	22.7	376.1	-	21.5	470.94	3.3		0.1	9.6
15	Цээл	235.0	6.1	224.7	-	4.2	221.34	3.3		0.1	9.6
16	Чандмань	144.0	9.5	117.0	-	17.5	229.90	3.0		0.3	8.8
17	Шарга	350.0	3.0	343.0	-	4.0	242.46	2.9		0.1	2.8
18	Эрдэнэ	144.9	3.9	127.9	-	13.1	182.55	3.2		0.1	8.0
	Дүн	13436.3	443.12	12649.69		343.49	12,019.55	77.3		32.2	278.14

үргэлжлэл

№	Сумуудын нэр	Үйлдвэрийн газар			Гэр хороолол			Барилгажсан талбай			Нийтийн эдэлбэр			Дуудлага худалдаа		
		2006-2010	2011-2015	2016-2023	2006-2010	2011-2015	2016-2023	2006-2010	2011-2015	2016-2023	2006-2010	2011-2015	2016-2023	2006-2010	2011-2015	2016-2023
1	Алтай	3.6	5.9	6.9	4.0	5.0	3.0	5.0	6.0	7.0	342.98	338.68	338.68	5.0	10.0	20.0
2	Баян-уул	8.2	9.8	10.2	5.0	6.0	8.0	4.0	5.0	9.0	1066.56	1062.96	1064.56	4.0	8.0	10.0
3	Бигэр	10.5	12.0	16.0	4.0	4.4	6.2	0.5	0.9	1.0	340.67	338.37	332.47	4.0	6.0	10.0
4	Бугат	1.7	2.3	6.3	1.6	1.8	2.0	0.6	0.8	1.0	651.86	650.86	646.46	2.0	3.0	4.0
5	Дарви	2.0	3.0	8.0	1.6	1.6	1.8	0.4	0.6	0.8	318.14	316.94	311.54	1.0	1.0	1.0
6	Дэлгэр	2.4	3.6	6.0	6.0	6.5	8.5	1.2	1.5	2.0	203.83	201.83	196.63	2.0	3.0	5.0
7	Есөнбулаг	61.0	59.0	69.2	4.0	5.0	6.0	6.6	7.7	8.8	5138.02	5137.92	5125.62	4.5	8.0	40.0
8	Жаргалан	2.2	3.3	3.2	2.1	2.2	3.7	5.0	6.0	9.0	501.55	529.35	524.95	4.0	5.0	7.0
9	Тайшир	12.0	4.0	6.0	2.0	3.0	7.0	0.5	0.7	0.9	619.71	626.51	620.31	1.0	3.0	5.0
10	Тонхил	4.8	7.2	7.0	4.0	4.5	5.0	2.0	2.5	2.8	520.10	516.70	516.10	4.0	5.0	7.0
11	Төгрөг	4.4	6.6	15.6	1.9	2.1	2.0	0.5	0.7	0.8	357.85	355.25	346.25	1.6	1.8	2.0
12	Халиун	2.8	4.2	6.0	1.6	2.0	2.8	0.6	6.9	1.2	177.94	119.84	172.94	2.0	2.5	3.0
13	Хөхморьт	2.0	3.0	4.0	1.2	1.8	2.1	1.0	1.3	1.5	219.67	217.77	216.27	2.0	2.2	2.8
14	Цогт	6.8	10.2	13.2	0.7	0.8	1.0	0.4	0.6	0.8	463.04	459.34	455.94	0.4	0.8	1.2
15	Цээл	4.9	5.1	8.1	0.6	0.7	0.8	0.3	0.4	0.6	215.54	215.14	211.84	0.2	0.6	1.4
16	Чандмань	2.8	4.2	5.0	2.0	4.0	6.5	1.6	1.8	2.0	223.50	219.90	216.40	2.0	3.0	5.0
17	Шарга	1.6	2.4	5.0	1.2	1.6	2.0	0.4	0.8	1.2	239.26	237.66	234.26	1.0	2.0	4.0
18	Эрдэнэ	1.2	2.8	4.0	0.9	1.2	1.6	1.4	1.6	1.8	179.05	176.95	175.15	2.0	4.0	6.0
	Дүн	134.0	148.6	194.3	44.4	97.8	70.0	32.0	39.8	52.3	11809.15	11733.35	11702.95	42.7	68.9	134.4

III.2.2 Үйлдвэрлэлийн бүс газрын ба газрын эрдэс баялагийн түүхий

эдийн нөөц, нөхцлийн төлөвлөлт

Тус аймгийн нутаг дэвсгэр геологи хайгуулын судалгаа төдийлэн нарийвчлан хийгдээгүй боловч ашигт малтмал эрдэс түүхий эдийн нилээд нөөцтэй орд илэрцүүд элбэг байдаг.

III.2.2.1 Газрын эрдэс баялаг, түүхий эдийн нөөц

1. **Нүүрс:** Говь-Алтай аймагт одоогоор нөөц нь тогтоогдоод ашиглаж байгаа нүүрсний 4 орд байна. Эдгээр орд аймгийн түлш эрчим хүчний эх үүсвэр төдийгүй зэргэлдээх аймгийн сумдын түлшний хэрэгцээг хангах боломжтой.
2. **Алт:** Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрт Монгол-Алтайн алтны металлогены бүсийн Шар хоолойн/ Бугатын голын эх, Дэрстийн хөндий, Бургаст гол, Хулстын гол, Шаргын гол, Төгрөгийн голын орд илрэл/ Баянлэг-Баянговийн алтны металлогены бүсийн Эдрэнгийн Сагсай гол, Төгрөгийн гол, Жавхлант голын орд илрэл/, Эдрэнгийн нурууны алтны металлогены бүсийн Эдрэнгийн /Нэргүй, Хошуут, Хур уул, Хар уулын орд илрэлүүд/ хамаарагдана. Говь-Алтайн шугаман төвөн өргөгдлийн мужийн алтны таамаг үнэлгээний нийт нөөц С-2, Р-3 зэргээр 872 кг байна.
Одоогоор Шар хоолойн алтны ордыг ашиглаж байгаа бөгөөд цаашид дээрх орд, илрэлүүдэд нарийвчилсан хайгуул судалгааны ажил явуулснаар алтны олборлолтын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломжтой.
3. **Асбест:** Тус аймагт одоогоор Алаг уул, Тайширын орд илэрсэн. Энэ хоёр ордын нийт нөөц ойролцоогоор 215 мян.тн орчим юм. Энд асбест олборлолтын үйлдвэрлэл явуулж орон нутгийн хэрэгцээг хангах боломжтой.
4. **Магнезит:** Говь-Алтай аймгийн магнезитын орд нөөц ихтэй. Энд жилд 50 мян. тн хүдэр олборлож 20 мян.тн нунтаг шатаан бэлтгэх үйлдвэрийг ажиллуулах боломжтой.
5. **Давс:** Тус аймагт давсны 3 ордод хайгуулын ажил хийгдсэн. Эдгээр ордын нийт нөөц 971.5 мян.тн, Цоохор нуур, Буур нуур, Бигэрийн ордууд нь сульфат натрийн ордууд юм. Иймд сульфат натрийн давсыг ашиглах чиглэлийн олборлолтыг явуулах.
6. **Шохойн чулуу шохой:** Говь-Алтай аймаг Цагаан-Оломын шохойн чулуу чандманы шохойн ордууд байдаг. Энэ 2 ордын нийт нөөц 3543.9 мян.м³ аймгийн хэрэгцээг хангах үйлдвэрлэл явуулах бүрэн боломжтой.
7. **Пироксенит:** Хадаасны пироксенитийн ордын нийт нөөц нь А+В+С-1 зэргээр 1736 мян.м³

8. **Альмадин:** Тус аймагт альмандины Алтан худгийн үндсэн ба шороон орд илэрсэн бөгөөд эдгээр ордын нийт нөөц 30881 кг юм. Энэ ордыг түшиглэн гоёл чимэглэлийн түүхий эдийн олборлолт явуулах.
9. **Шавар:** Говь-Алтай аймагт хийгдсэн янз бүрийн үе шатны хайгуулын судалгаагаар Цагаан-Олом, Тайшир, Сүхийн хоолой, Шаварт, Шарга, Цогт зэрэг шаврын ордууд судлагдсан байна. Ордын нийт нөөц 12596 мян м³. Эдгээр орд нь барилгын үйлдвэрлэлийн орон нутгийн хэрэгцээг хангах гол эх үүсвэр юм.
10. **Хайрга:** Одоогийн байдлаар Завхан гол, Гуулингийн ордод хайгуулын судалгаа хийгдэж нийт нөөцийг 2098 мян м³ гэж тогтоосон байна.
11. **Эрдсийн будаг.** Говь-Алтай аймагт Буу барнагийн эрдсийн будгийн ордод хайгуул хийгдсэн бөгөөд нөөцийг 2004 мян.тн гэж тодорхойлжээ. Аймгийн эрдсийн будгийн үйлдвэрлэл явуулах гол үүсвэр нь одоогоор зөвхөн энэ орд болж байна.

Аймгийн нутагт хийгдсэн геологи хайгуулын судалгаанаас үзэхэд:

- Нүүрсээр орон нутгийн хэрэгцээг хангах бүрэн боломжтой
- Баянголын хүдрийг хүйтэн, дулаан цахилгаан үл дамжуулагч материал болгон хэрэглэнэ.
- Талын мэлтэсийн орд нь 200 тн алтны нөөцтэй юм. Энэ орд нь улсын тусгай хамгаалалттай нутагт байрладаг.
- Шар хоолой, Эрдэнэ, Эдрэнгийн нурууны дүүрэг дэх алтны орд илрэлүүдийг нарийвчлан судлаж алт олборлолтын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бүрэн боломжтой.
- Асбестыг орон нутгийн хэрэгцээнд зориулан жижиг олборлолт явуулж ашиглаж байгааг өргөтгөх.
- Бидэрийн голын магнезитын ордыг дулаан дуу чимээ бага дамжуулдаг барилгын хана барих, галд тэсвэртэй сайн чанарын тоосго хийхэд зориулан ашиглана.
- Тус аймаг нь гоёлын өнгөт чулуугаар нэлээд баян аймгийн тоонд орно. Орчин үеийн гоёл чимэглэлийн зүйлд өргөн хэрэглэдэг дэлхийн зах зээлд өндөр үнэ хүрдэг Алтан худгийн анараль мандины үндсэн ба шороон ордыг зах зээлийн өнөөгийн нөхцөл зохицуулан ашиглах бүрэн боломжтой.

Бусад нөөц баялаг, нөхцлийн талаар энэхүү төлөвлөгөөний өнөөгийн байдал гэсэн хэсэгт тодорхой тусгагдсан.

Хүснэгт 58

Эрдэс түүхий эдийн нөөц

д/д	Орд	Ордын нэр	Нөөц
1	НҮҮРС	Цахиур	28.3 сая тн
2		Мааньт	0.4 сая тн
3		Хүрэн гол	5 сая тн

4		Зээгт	4.5 сая тн
5	АЛТ	Нэргүй	50 кг
6		Хошуут	75 кг
7		Хур уул	25 кг
8		Хар уул	80 кг
9		Шар хоолой	70 кг
10	АСБЕСТ	Алаг уул	100 мян.тн
11		Тайшир	115 мян.тн
12	МАГНЕЗИТ	Бидэрийн гол	50 сая тн
13	ХҮЛЭР	Баян гол	
14	ДАВС	Цоохор нуур	470.9 мян.тн
15		Бор нуур	437.7 мян.тн
16		Бэгэр	62.9 мян.тн
17	ШОХОЙН ЧУЛУУ	Цагаан олом	2885.6 мян.м ³
18	ШОХОЙ	Чандмань	658.3 мян.м ³
19	ПИРОКСЕНИТ	Хадаасан	173.6 мян.м ³
20	АЛЬМАНДИН	Алтан худаг /үндсэн/	30 тн
21		Алтан худаг/шороон/	880.9 кг
22	ШАВАР	Цагаан олом	1744 мян.м ³
23		Тайшир	2114 мян.м ³
24		Сүхийн хоолой	8738 мян.м ³
25		Шаварт	-
26		Шарга	-
27		Цогт	-
28	ХАЙРГА	Завхан гол	1959 мян.м ³
29		Гуулин	139 мян.м ³
30	ЭРДЭСИЙН БУДАГ	Буу барнаг	200.4 мян.тн

III.2.2.2 Үйлдвэрийн хөгжүүлэх гол чиглэл

1. Мал ахуйн гаралтай түүхий эд, материалаар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бага, дунд оврын үйлдвэр
 - А. Эсгий, эсгий гутал, оёдлын үйлдвэр.
 - Б. Цагаан идээг боловсруулах үйлдвэр.
 - В. Хивс, Хивсэнцэрийн үйлдвэр.
 - Г. Арьс шир боловсруулах гутал, болон савхин бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр.
2. Газар тариалангийн түүхий эд, материалд түшиглэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бага, дунд оврын үйлдвэр.
 - А. Жимс, жимсгэнэ боловсруулах лаазлах жижиг үйлдвэр.
 - Б. Арвайн болон бусад төрлийн тариагаар гурил, талх болон талхан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр.
 - В. Архи, дарсны үйлдвэр.
3. Байгалийн баялагт түшиглэсэн үйлдвэр
 - А. Иоджуулсан ба эрдэс бодисоор баялаг хүнсний ба үйлдвэрийн зориулалтаар давс, малын тэжээл үйлдвэрлэх үйлдвэр.
 - Б. Модон материалын үйлдвэр.

4. Ашигт малтмалд түшиглэсэн үйлдвэр.

- А. Алтны орд.
- Б. Шөрмөсөн чулууны үйлдвэр.
- В. Нүүрсний ба хийн үйлдвэр.
- Г. Шахмал түлшний үйлдвэр.
- Д. Барилгын материалын үйлдвэр.
- Е. Гоёл чимэглэлийн үйлдвэр.

Суурин газруудыг түшиглэн дараахь үйлдвэрүүдийг хөгжүүлэх дэс дараатай арга хэмжээ авна.

Хийгдэх ажил /2006-2010он/

1. Говь-Алтай аймагт магнезит, каросизит, төмөр, бетон эзлэхүүний болон өнгөлгөөний чулуу, шохойн үйлдвэрлэлийг хөгжүүлэх.
2. Давсны ордуудыг түшиглэн химийн болон бусад төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулах, хүнсний улсын хэрэглээний 30 %-ийг хангах.
3. Зээгт, Хүрэн голын нүүрсний уурхайн, нүүрс олборлолтыг нэмэгдүүлэх, аймаг ба бүсийн хэрэгцээг хангах.
4. Нүүрсний уурхайг түшиглэн хийн болон шахмал түлшний үйлдвэр байгуулж, аймгийн төв, бүсийн төв, бусад суурин газрын айл өрхийг хангах.
5. Говь-Алтай аймагт газрын тосны хайгуулын ажлыг эхлүүлэх.
6. Эрдэс, баялагийн нөөцөд геологи хайгуулын иж бүрэн судалгаа хийх мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх
7. Гурил, гурлин бүтээгдэхүүн, загас, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо боловсруулах, арвай, Алтайн билэгдэл болсон сулийн гурилын үйлдвэрлэлийг өргөтгөх, рашаан, шингэн сүү, ундаа савлах үйлдвэрүүдийг байгуулах ажиллуулах.
8. Сүү, сүүн бүтээгдэхүүн, мах боловсруулах, савлах, экспортлох ажлыг өргөтгөх.
9. Бургастайн боомтын материаллаг баазыг бэхжүүлэх, Шар хөтөлд чөлөөт бүс байгуулах.

Хийгдэх ажил /2011-2015/

1. Талын мэлтэсийн алтны орд газрын хайгуулыг дуусгаж, ашиглалтанд оруулахад шаардагдах бэлтгэл ажил хийх.
2. Алтай хотод шингэрүүлсэн шатдаг хийн дулааны станц барих.
3. Алаг хайрханы алт, зэс, мольбидены ордыг ашиглах.
4. МАА-н гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийг түшиглэн арьс, ширэн ба савхин эдлэл, гутал, хувцас, тоноглол хэрэгслийн үйлдвэр, цех байгуулах замаар үйлдвэрүүдийг өргөтгөх.

5. Ноос, ноолуурын экоспортын баримжаатай үйлдвэрүүдийг хөгжүүлэх.
6. Шахмал түлшний үйлдвэрлэлийг эрчимжүүлэх.

Хийгдэх ажил /2016-2023/

1. Хүнсний жижиг үйлдвэрийг хөгжүүлэх.
2. Жимс, жимсгэний боловсруулах үйлдвэр барих.
3. Мал аж ахуйн гаралтай түүхий эд болон сүү, сүүн боловсруулах үйлдвэр барих.
4. Иоджуулсан давсны үйлдвэр барих.
5. Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.
6. Нүүрсний хийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.
7. Чөлөөт бүс байгуулах.
8. Авто засвар үйлчилгээний төв байгуулах.
9. Шахмал түлшний үйлдвэрийг өргөтгөх ажлыг хийнэ.

Шинээр баригдах жижиг, дунд үйлдвэрүүдийн төлөвлөлт

№	Баригдах үйлдвэрийн нэр	Одоо байгаа хот суурингийн нэр (2006-2015 он)																								Төлөвлөсөн суурин (2015-2020 он)									
		Алтай хот	Алтай	Баян-Уул	Бигэр	Бугаг	Дарви	Дэлгэр	Жаргалан	Тайшир	Тонхил	Төгрөг	Халиун	Хөх морьт	Цогт	Цээл	Чандмана	Шарга	Эрдэнэ	Цахиурт	Гуулин	Зээгт	Баянтоорой	Биж	Алтангадас	Эйвин	Улаан боом	Буур	Тальнмэлтэс	Бургастай	Шар цайр	Шар хөтөл	Хүрэн гол		
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33		
1	Хүнсний жижиг үйлдвэр	+	+	+	+						+	+												+											
2	Талх, нарийн боовны цех					+	+	+	+	+			+	+	+	+	+	+	+	+	+	+			+	+	+	+	+	+	+	+	+		
3	Ундааны цех								+				+	+	+																				
4	Гурилын үйлдвэр	+										+	+	+																					
5	Жимс, жимсгэнэ боловсруулах цех		+		+		+						+																						
6	Цагаан идээний үйлдвэр	+	+	+	+					+					+								+	+	+	+	+							+	
7	Хуурай сүүний үйлдвэр	+	+		+																														
8	Хүнсний ногоо боловсруулах, консервлах, хатаах цех							+	+						+	+					+			+											
9	Хоол амтлагчийн үйлдвэр	+																+	+																
10	Ингэний сүү боловсруулах үйлдвэр		+									+			+																				
11	Дарсны үйлдвэр				+																														
12	Сулхирын гурилын цех							+					+																						
13	Хөргүүлтэй махан зoorь, хиамны цех	+		+	+						+	+													+										
14	Иоджуулсан давсны үйлдвэр	+			+										+												+								
15	Арьс ширний анхан шатны боловсруулалтын үйлдвэр			+							+						+																		
16	Оёдлын үйлдвэр	+	+	+	+						+	+																							
17	Гутлын үйлдвэр	+													+																				
18	Эсгий, эсгий гутлын үйлдвэр	+		+	+						+																								
19	Нэхмэлийн	+		+	+	+					+					+																			

0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	
20	Нэхмэлийн цех									+				+				+			+	+												
21	Гар хивсний цех					+		+	+			+			+		+		+															
22	Савангийн үйлдвэр	+	+	+	+		+	+	+		+	+	+		+		+		+															
23	Гэрийн мод, модон эдлэлийн үйлдвэр	+		+	+						+					+						+												
24	Загасны тэжээл боловсруулах үйлдвэр		+												+																			
25	Лааны үйлдвэр			+	+	+					+	+						+																
26	Шохойн цех																+																	
27	Гоёлын чулуу боловсруулах цех															+																		
28	Эрдсийн будгийн цех												+		+																			
29	Магnezитийн үйлдвэр	+																																
30	Цементийн үйлдвэр	+																																
31	Савхин эдлэлийн үйлдвэр	+																																
32	Тоосгоны цех									+					+																			
33	Нүүрсний хийн үйлдвэр																				+		+											+
34	Чөлөөт бүсийн бааз																																+	
35	Авто засвар үйлчилгээний төв																									+						+		
36	Шахмал түлшний үйлдвэр																						+											+
37	Бетон хийцийн үйлдвэр									+																								
	Шаардагдах талбай (га-аар)	122.0	9.5	18.0	22.4	4.0	5.0	6.0	5.5	16.0	12.0	11.0	7.0	5.0	17.0	10.0	7.0	4.0	4.0	6.0	6.0	10.0	4.0	3.0	3.0		2.0	3.0	3.0	1.0	4.0	100	9.0	

Газар сонголт

Дээрх үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд зохих хэмжээний нутаг дэвсгэр шаардагдана.

Жижиг, дунд үйлдвэрүүдийг хот, тосгон, суурингийн төвд байрлах учир газар сонголт нь хот, тосгон, бусад суурин газрын ангиллаас тэдгээрийн тэг гортиг дотор хийгдэнэ.

Говь-Алтай аймгийн ихэнх хот, тосгон, суурин газар нь 7-9 баллын газар чичирхийлэлтэй, зарим сум нь ул хөрсний хөөлттэй, гадаргуу нь 0.5-5.0%-ийг налуужилттай, далайн төвшнөөс дээш 1400-2000 м өргөгдсөн, барилгын уур амьсгалын бүсээр 2-р зэрэгт хамрагддаг юм.

Одоогийн хот тосгон суурин газруудын тэг гортиг 1974 онд нилээд их хэмжээний газар олгогдсон учир дээрхи үйлдвэрийн газруудыг байршуулахад хангалттай нутаг дэвсгэртэй.

Үйлдвэрийн газруудад нутаг дэвсгэр олгохдоо тэдгээрийн газар зүйн байрлал, зохиогдсон зураг төсөл, байгаль-экологид үзүүлэх нөлөөлөл зэргийг харгалзан үзэх нь зүйтэй.

Говь-Алтай аймгийн хот, тосгон, суурин газруудын усан хангамж муутай учир усны хэрэгцээг зөв тооцож газар сонголт хийх шаардлагатай.

Шинээр суурин газар хэд хэд үүсэх бөгөөд эдгээрт газар олголт хийхдээ хот байгуулатын үнэлгээг сайтар харгалзах хэрэгтэй. Шинээр үүсэх хот тосгон нь ойролцоогоор 200-500 хүн амтай байх учир 25-50 орчим га газар шаардагдана.

Эрчим хүчний эх үүсвэрийг нар, салхины хүчийг ашиглах замаар хангана.

Хүснэгт 60

Уул уурхайн дэвсгэр газрын төлөвлөлт

№	Төлөвлөлтийн үе шат	2006-2010		2011-2015		2016-2023	
		Ашигт малтмал олзворлох талбай	Үйлдвэрлэлийн ба суурьшлын бүс	Ашигт малтмал олзворлох талбай	Үйлдвэрлэлийн ба суурьшлын бүс	Ашигт малтмал олзворлох талбай	Үйлдвэрлэлийн ба суурьшлын бүс
1	Алтай 15.0 нүүрс	16.0	1.0	18.0	1.2	25.0	1.5
2	Бигэр 288.0 давс	288.0	-	288.0	-	288.0	-
3	Дэлгэр 33.0 нүүрс	35.0	2.0	38.0	2.2	40.0	2.5
4	Жаргалан 200.0 нүүрс	200.0	-	200.0	-	200.0	-
5	Тонхил 42.0 алт	42.0	1.0	42.0	1.2	42.0	2.0
6	Төгрөг 118.0 нүүрс	120.0	10.0	125.0	16.0	140.0	20.0
7	Чандмань 25.0 нүүрс	27.0	3.0	29.0	4.0	31.0	6.0
8	Цогт алт	-	-	-	-	50.0	25.0
9	Шарга	30.0	1.0	42.0	1.5	50.0	2.0
10	Цээл буур	125.0	20.0	435.0	25.0	1035.0	35.0
11	Жаргалант цахиуртын уурхай	35.0	1.0	45.0	1.0	115.0	2.0
12	Цээл анар	20.0	-	25.0	-	30.0	-
13	Бугат молибден	25.0	1.0	30.0	1.5	35.0	2.0
14	Тонхил шөрмөсөн чулуу	10.0	-1.0	15.0	1.5	20.0	2.0
15	Тайшир шохойн чулуу	20.0	-	30.0	-	45.0	-
16	Тоосгоны шавар	10.0	-	15.0	-	30.0	-
17	Хайрга	15.0	-	25.0	-	45.0	-
18	Магнезит	20.0	-	35.0	-	40.0	-
19	Эрдэс будаг	15.0	1.0	20.0	1.5	25.0	-
	Барилга байгууламж, гэр хороолол	1053.0	42.0	1457.0	56.6	2186.0	100.0
	Бүгд	1095.0		1513.6		3899.6	

Үйлдвэрийн газрын төлөвлөлт

№	Сумуудын нэр	Үйлдвэрийн газар		
		2006-2010	2011-2015	2016-2023
1	Алтай	3.6	5.9	6.9
2	Баян-уул	8.2	9.8	10.2
3	Бигэр	10.5	12.0	16.0
4	Бугат	1.7	2.3	6.3
5	Дарви	2.0	3.0	8.0
6	Дэлгэр	2.4	3.6	6.0
7	Есөнбулаг	61.0	59.0	69.2
8	Жаргалан	2.2	3.3	3.2
9	Тайшир	12.0	4.0	6.0
10	Тонхил	4.8	7.2	7.0
11	Төгрөг	4.4	6.6	15.6
12	Халиун	2.8	4.2	6.0
13	Хөхморьт	2.0	3.0	4.0
14	Цогт	6.8	10.2	13.2
15	Цээл	4.9	5.1	8.1
16	Чандмань	2.8	4.2	5.0
17	Шарга	1.6	2.4	5.0
18	Эрдэнэ	1.2	2.8	4.0
	Дүн	134.0	148.6	194.3

III.3 ЗАМ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

Дэд бүтцийг хөгжүүлэх бүс газрын төлөвлөлт нь экологийн зохистой байдлыг хадгалах, газрыг хамгаалах арга хэмжээний эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, нийгмийн хөгжлийг түргэтгэх, хүн амын ая тухтай амьдрах, эдийн засгийн боломжийг бүрдүүлж, элдэв сөрөг нөлөөллийг бууруулах явдал юм.

Энд улсын чанартай болон орон нутгийн чанартай авто зам, төмөр зам, агаарын тээврийн болон нисэх онгоцны буудал, эрчим хүчний цахилгаан дамжуулах агаарын ба газрын доорхи шугам сүлжээ, холбооны агаарын ба газрын доорхи шугам сүлжээ, радио релейний станц зэргүүдэд олгогдох газруудыг төлөвлөж оруулав.

Аливаа зам, шугам сүлжээ нь орчиндоо таагүй нөлөөлөл үзүүлж болох, нөгөө талаар эдгээр байгууламжинд үзүүлж болох таагүй нөхцлөөс урьдчилан сэргийлэхэд оршино.

Газрын төлөв байдал, чанарт гарах сөрөг үзэгдлүүд ихэсч байгаа өнөөгийн нөхцөлд зам шугам сүлжээг зөв байршуулан бүс нутгийн байгаль орчны даац, чадавхийг бүрэн зохистой ашиглах, газар нутгийн өөрөө сэргэх дотоод чадвартай нь уялдуулан тэдгээрийн байрласан газрыг ландшафтынх нь хувьд үнэлж түүний ойролцоох элсийг тогтоох, ургамлан нөмрөгийн тусламжтайгаар нуралт, гулсалтаас хамгаалах, шаардлагатай газруудад инженерийн байгууламжуудыг барих, ус, усны эх үүсвэрийг хамгаалах шаардлагатай.

Дэлхийн уур амьсгалын ба байгалийн өөрчлөлт, ган гачиг цөлжилт болон даац чадавхийг тооцоололгүй ашигласнаас буюу, олон салаа зам гаргах, зам шугам сүлжээг байгуулахад газрыг ухаж, сэндийчлэх, ашиглаж талхлах зэрэг хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хуурайвтар, чийг дутмаг бүс нутгийн газар элэгдэл эвдрэлд түлхүү орж нуур, гол, горхи ширгэх, ургамлын гарц муудах, хөрс давсжин үржил шимээ алдаж цөлжих үйл явц эрчимжихэд нэрмээс болдог.

Зам, шугам сүлжээг барьж байгуулахдаа газар хамгаалах арга хэмжээг орхигдуулснаас газарт учрах хохирол янз бүрийн хэлбэрээр илэрч, тэр орчмын зурвас газарт ургамал нь гэмтэн талхлагдаж, хөрс нь зулгаран нүцгэрэх, ашигласан карьерийн ухсан нүх үлдэх зэрэг сөрөг үр дагаврууд гарах ба эдгээрийг нормативын дагуу фитомелориац, ойн мелориацын аргуудыг хослон буюу дангаар нь хэрэглэж нөхөн сэргээх нь хөрсний салхины хүчийг тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлнэ.

Ухсан газар, элэгдэж эвдэрсэн хөрс, талхлагдсан ургамлын нөмрөгийг сэргээн сайжруулах, норм, норматив, стандартыг хатуу мөрдөх нь байгаль экологид бага хохирол учруулж байгаагийн илэрц бөгөөд байгалийн унаган төрхийг хадгалах, түүний тэнцэл алдахаас сэргийлэхээр авч буй арга хэмжээ юм.

Газар нь зөвхөн үйлдвэрлэлийн хэрэгсэл дэвсгэр биш өргөн утгаараа, нутаг гэдэг ойлголтоороо хүн болон амьд организмын оршин тогтнох орчин нөхцөл нь болдог. Энэ орчин нь байгалийн болон энд орших амьд организмын нөлөөллөөр эерэг, сөрөг тал руугаа өөрчлөгдөж байдаг учир эдгээрийг тооцоолж зохицуулж, хамгаалж чадах ухамсарт үйл ажиллагаа нь зөвхөн иргэн хүнд ноогдоно.

Хамгаалах гэдэг нь байгалийн сөрөг үзэгдлээс болон хүмүүсийн аж ахуйн үйл ажиллагаа, тэрхүү үйл ажиллагаа явагдаж буй газар нутгийн байвал зохих зохистой харилцаа, үйлчлэлийг хангах, тэтгэхэд чиглэсэн арга хэмжээний цогцолборыг хэлнэ.

Өөрөөр хэлбэл байгалийн баялгийг хадгалан үлдээх, нөхөн сэргээх, зохистой ашиглах, хүмүүс болон нийгмийн зүгээс байгаль амьд организмд сөргөөр нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэхийг бодон судалгаа шинжилгээ хийж, оновчтой төлөвлөлтийг үндэсний стратегийн зорилт болгон хэрэгжүүлэхийг хэлнэ.

III.3.1 Дэд бүтцийг хөгжүүлэх шаардлага, үндэслэл

Улс орноо хөгжүүлэх нийтлэг асуудлыг авч үзэхдээ:

- ⊕ Хэтийн
- ⊕ Дэд бүтцээ оновчтой төлөвлөн, хөгжүүлэх чадвар зэргээр тодорхойлдог хандлага дэлхий нийтэд байдаг.

Манай улс нь дэлхийн энэ жишигт суурилан дэд бүтцээ эмх цэгцтэй, түргэн хурдтай, экологийн тэнцвэртэйгээр хөгжүүлэх нь таруу сийрэг суурьшил, өргөн их газар нутаг зэрэг бидний амьдралын хэвшил онцлогоос урган гарч буй хэрэглээ, хэрэгцээ билээ.

Эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх аргаар улс орны хөгжлийг түргэтгэхэд дэд бүтцийн хөгжил ирээдүй тулгуур үүрэг гүйцэтгэнэ. Дэд бүтэц нь улс орны хувь заяанд гүйцэтгэдэг үүргийнхээ хувьд дараах шаардлагуудыг хангаж байх ёстой. Үүнд:

- Төв суурингуудын холбоос байхын дээр тэдний хөгжлийн хэмжигдэхүүн болох.
- Нүүдэл, суурьшлын, соёл иргэншлийн орон зайг хадгалж, зохистой хосолсон нэгдлийг хангах.
- Эдийн засгийг нийгэм, экологийн баримжаалалтай болгох.
- Олон улс, тив хоорондын сүлжээнд оновчтой холбогдох.

Эдгээр нь дэд бүтцийн гол чиглэл буюу гол тэнхлэг, сүлжээний шугамуудыг тавихад баримтлах үндсэн зарчим болно.

Орон нутгийн хөгжлийн хоцронгуй байдал нь Монгол улсын эдийн засгийг газар зүйн байрлалынх нь дагуу гадаад орнуудтай холбон хөгжүүлж, гадаад хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжийг ч хязгаарлаж байна.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн нутаг дэвсгэрийн тэнцвэргүй байдлыг бууруулах явдал Монгол улс тогтвортой хөгжлийн замд дэвшин орох нэн чухал угтвар нөхцөл бөгөөд бүс нутаг, хот байгуулалтын тогтолцоог өөр хооронд нь болон улс орны дотоод, гадаад орчинтой холбогч гол шижим нь дэд бүтцийн сүлжээг өргөтгөн сайжруулах явдал мөн.

Монгол улсын хөгжлийн хэмжүүр нь тогтвортой хөгжил, байгаль орчны зохицолдоо бөгөөд эдийн засаг нийгмийн бодлого нь байгаль орчныг тэтгэх, түүний даацын хүрээнд нөөцийг нь зохистой ашиглахад түшиглэсэн, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж, экологийн тэнцлийг хангах шаардлагад нийцсэн хүн амын нутагшил, соёл боловсролын тогтолцоо, дэд бүтцийн зохистой сүлжээг бүрдүүлэх асуудал юм.

Энэ бодлогыг хэрэгжүүлэхдээ газар зүйн байрлалын боломж, байгаль эдийн засгийн чадавхи сайтай бүс нутгуудыг сонгон тогтоож үйлдвэрлэл үйлчилгээг дэд бүтцийн нь хамт түргэн хурдацтай хөгжүүлэх зорилтыг голлон, эдийн засгийн аюулгүй байдалдаа анхаарлаа хандуулахыг шаарддаг.

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан Монгол улсын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д:

Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж дэд бүтцийг түлхүү хөгжүүлэх, тогтвортой хөгжил экологийн тэнцвэрт байдлыг хангах, байгаль орчны бодлогыг бүс нутгийн нийгмийн эдийн засгийн хөгжлийн чиглэлтэй уялдуулан хэрэгжүүлэх, бүс нутаг, хөдөөгийн эрчим хүч, түлш, усан хангамжийг сайжруулж, зам харилцаа холбоо ахуйн үйлчилгээг өргөжүүлнэ.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын эрхэм зорилго нь тус улсын газар, түүний баялаг, газар тариалан, МАА-н гаралтай түүхий эдийн нөөц, чадавхийг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг бүс нутаг хоорондын тэгш бус тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшинг ойртуулах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх, дотоод гадаад таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

Тус орны тээвэр газарзүйн байрлалын дагуу бүс нутгуудыг олон улсын худалдаа, эдийн засгийн сүлжээнд зохистой холбож, аймаг орон нутгийн болон үндэсний хөгжлийг түргэтгэх гадаад харилцааны боломжийг бүрэн дүүрэн ашиглах нөхцлийг хангана.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилго, зорилтыг эдийн засгийн бүс, бүс нутаг, хот хөдөөгийн хөгжлийн нэгдмэл тогтолцооны хүрээнд хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага нь байгаль орчны даац чадавхи, түүнд зохицуулан нүүдлийн мал аж ахуйн соёлын өв уламжлалыг хадгалан хөгжүүлэх үндэсний хэрэгцээ, хот суурин, дэд бүтцийн оновчтой сүлжээнд орчин үеийн соёл иргэншлийн ололтыг бүтээлчээр хөгжүүлэн, нийгмийн дэвшлийг түргэтгэх дэлхийн нийтлэг хандлага зэргийг хамтад нь бодолцсон Монгол улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөр стратегээс урган гарч байна.

Эдийн засгийн үр ашиг багатай, дэд бүтцийн хөгжил сул манай улсын хувьд нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийн байгаль орчин, хүн ам, түүхий эдийн нөөц, газарзүйн байрлал, зам харилцааны боломжийг зохистой ашиглан, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх нь чухал. Үндэсний эдийн засагт түлхэц өгөхүйц, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын шаардлагад чанд нийцсэн дэд бүтцийн сүлжээ, эдийн засгийн чөлөөт бүс байгуулах нь стратегийн чухал ач холбогдолтой.

Тэргүүн ээлжснд:

1. Дэд бүтцийн хөгжлийг эрчимжүүлэх замаар эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгох юуны өмнө эрчим хүч, харилцаа холбоо, иргэний агаарын тээвэр, төмөр зам, авто зам зэрэг дэд бүтцийн салбарт тэргүүлэх ач холбогдол өгч хөгжүүлэх.
2. Хөдөөд эрчим хүч, зам тээвэр, холбоо мэдээлэлжүүлэлтийн салбарыг эрчимтэй хөгжүүлэх үндсэн дээр дэд бүтцийн нэгдсэн сүлжээ бий болгох, бүс нутгийг дотоод гадаад зах зээлтэй дэд бүтцийн сүлжээгээр холбож, нутаг дэвсгэрийн хөгжлийн таталцлын төв, тэнхлэгүүдийг бий болгох.
3. Зам байгуулалт, байгаль орчны удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох, экологийн тэнцлийг хангах, хүн амын эрүүл мэндийг хамгаалах шаардлагад зохицуулан тээврийн хэрэгсэл, шатахууны төрлийг зөв сонгон тогтоох, бүс нутгийн байгаль цаг уурын онцлог, хөрсөн бүрхэвчийн элэгдэл эвдрэлээс хамгаалах шаардлагыг харгалзан ашиглалтын үеийн зардал хамгийн бага байхаар зам гүүрийн төрлүүд, хучилтын бүтэц, зам байгуулалтын технологи, зам сүлжээний чиглэл байршлыг зохистой тогтоох, үр ашигтай, зардал хямдтай, бохирдол багатай тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх, зам харилцааны оновчтой нэгдсэн сүлжээ хөгжүүлэх замаар зам тээврийн хөгжингүй дэд бүтцийг бий болгох зорилтыг хэрэгжүүлнэ.

Манай улсын эрчим хүчний салбар нь хөгжлийн хэрэгцээнээс хэр хоцорсныг нийгмийн хөгжил, хүн ардын амьдрал харуулж байна.

Манай улсад эрчим хүчний найдвартай нэгдсэн систем хөгжиж амжаагүй. Ийм учраас эрчим хүчний салбарыг энэ хямралт байдлаас бүрэн гаргах, өөрийн орны цахилгаан эрчим хүчний хэрэгцээг бүрэн дүүрэн хангаж чадах, техникийн үзүүлэлт өндөртэй, өр зээлээ төлөх чадвартай, үр ашигтай, найдвартай ажиллагаа бүхий салбар болгох, үүний тулд усны эрчим хүчний нөөцийг нэн тэргүүнд ашиглаж цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн, зөв бүтэц бүрдүүлж, бүс нутгийн эрчим хүчний систем үүсгэж бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Өргөн удам нутагтай манай орны хувьд эрчим хүчээр хангах асуудал ихээхэн хөрөнгө оруулалт шаардагдаж байна. Төвлөрсөн эрчим хүчний системд бий болсон хүчин чадлыг бүрэн ашиглах зорилгоор, түүнд сумдын төвийг холбох, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төслүүдийн дотоод эх үүсвэрүүдийг санхүүжүүлэх эрчим хүч дутагдалтай, төвөөс алслагдсан бүс нутагт усан цахилгаан станц барих, малчдыг сэргээгдэх эрчим хүчээр хангах зэрэг арга хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтын нилээд хэсэг нь чиглэгдэж байна.

Эрчим хүчний салбар нь улс ардын аж ахуйн бусад салбарын үйлдвэр аж ахуйн газар хот суурин үүсэж хөгжихөд үндэс суурь нь болдог бөгөөд ихээхэн хөрөнгө оруулалт шаарддаг тул түүнийг ирээдүйд улам үр ашигтай найдвартай ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх үүднээс эртнээс нэгдсэн бодлого хөтөлбөртэйгөөр хөгжүүлэх шаардлага зүй ёсоор гардаг. Иймд эрчим хүчний нөөцийг аль болох үр ашигтайгаар ашиглаж өсөн нэмэгдэж буй улс орны нийт эрчим хүчний хэрэгцээг тасралтгүй найдвартай хангах үүднээс шат дараатай арга хэмжээ авч Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системд холбох явдал чухал үүрэг гүйцэтгэнэ.

Эрчим хүчний нэгдсэн системийг байгуулснаар эрчим хүчний үйлдвэрлэлийг үр ашигтай бүтцэд шилжүүлэх, зардлыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, ядуурлыг бууруулах, хөдөөгийн цахилгаан хангамжийг дээшлүүлэн, найдвартай болгосноор орон нутагт бизнес, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэх, бүс нутгийн хөгжлийг дэмжих, хот хөдөөгийн ялгааг багасгах, хөдөөгөөс хотод нүүн шилжих хөдөлгөөнийг зохицуулах олон талын ач холбогдолтой.

Эрчим хүчний салбарыг цаашид хөгжүүлэх бодлого нь:

- ❖ Өөрийн орны сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглан УЦС-ууд барьж, ЭХС-ийн эх үүсвэрийн бүтцийн шинэчлэлт хийх
- ❖ Найдвартай, үр ашигтай шинэ технологи өргөн нэвтрүүлэх
- ❖ Бүс нутгийн цахилгаан хангамжийн найдвартай аюулгүй байдлыг баталгаатай болгох
- ❖ Цахилгаан станцуудыг зөв оновчтой байршуулах

- ❖ Баруун бүсэд эрчим хүчний нэгдсэн систем байгуулах
- ❖ Алс ирээдүйд Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем байгуулах дэс дараалалтай байна.

“Монгол Улсын Эрчим хүчний нэгдсэн систем” хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1. Ойрын хугацаа 2006-2010 онд бүс нутгийн эрчим хүчний хангамжийг найдвартай болгох, эрчим хүчний эх үүсвэр болон цахилгаан дамжуулах шугамуудыг шинээр барих
 2. Дунд хугацаа 2011-2023 онд бүс нутгийг эрчим хүчээр найдвартай хангах зорилгоор эрчим хүчний эх үүсвэр болон цахилгаан дамжуулах шугамуудыг шинээр барьж баруун, зүүн болон төвийн эрчим хүчний системийг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаар холбож, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах нөхцлийг бүрдүүлэх явдал болно.
- ❖ Ингэснээр зах зээлийн нөхцөлд тохирсон хууль эрх зүй, бүтэц зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгох, цахилгаан станцууд, түгээх сүлжээг үе шаттай хувьчлах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, ашиглалтын бага зардалтай үйлдвэрлэлийн бүтцийг бий болгох, усан цахилгаан станц шинээр барьж өндөр хүчдэлийн шугамаар холбох замаар бүс нутгийн эрчим хүчний систем байгуулж цаашид эдийн засгийн үр ашигтай горим, үйл ажиллагааг бүрдүүлэн эрчим хүчний нэгдсэн систем байгуулах эрхэм зорилгод хүрнэ.
 - ❖ Олборлох, боловсруулах, жижиг дунд үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарыг нэмэгдүүлж, шинэ ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлэх юм.
 - ❖ Хүн амын зохистой нягтрал бий болоход хөгжлийн орчин нөхцлийг бүрдүүлж, хот хөдөөгийн ялгааг багасгаж, төв рүү тэмүүлсэн нүүдлийг зохицуулахад нөлөөлнө.
 - ❖ Усан цахилгаан станцыг дулааны цахилгаан станцтай хослон ажиллуулах нь их хэмжээний нүүрсний нөөцийг хэмнэх, байгаль орчныг хамгаалах, дулааны цахилгаан станцуудыг өвлийн их ачаалалд нүүрс нөөцлөх боломжийг бүрдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэлийн ашиглалтын зардлыг бууруулна.
 - ❖ Эрчим хүчний системийн төдийгүй нийт хэрэглэгчдийг эрчим хүчээр хангах үйл ажиллагааг шуурхай удирдах автомат удирдлагатай систем нэвтрүүлэх нөхцөл бүрдэнэ.

Эрчим хүч, харилцаа холбооны шугам сүлжээний газар нь өөрийн хэлбэр дүрсээс үл хамааран бүхэлдээ зурвас газар гэсэн хэвшмэл нэрийг авсан бөгөөд зурвас газрын зориулалтад шугам сүлжээний аюулгүй байдал хэвийн ажиллагааг хангахад шаардагдах орон зай багтдаг.

Эрчим хүчний шугамын зурвас газар нь ариун цэвэр хамгаалалтын зурвасын үүргийг мөн гүйцэтгэдэг тул энэ зурвасад арчилгаа тордолгоо их ордог.

Эрчим хүч, харилцаа холбооны шугам сүлжээг барьж байгуулахдаа тухайн газар нутагт бүрэлдэн тогтсон газар ашиглалт, түүний хил, заагийн тогтолцоо, шугам сүлжээ өнгөрч буй газрын эргэн тойрны ландшафтын хэв галбир, өнгө үзэмж, байгаль орчныг хадгалан хамгаалах шаардлага зэрэгтэй нягт уялдуулж аль болохоор ашиглалтанд буй зам, шугам сүлжээ, эдлэн газрын хилийн дагуу тариалан, хадлангийн газрын хил заагаар, өнгөрөөхөөр бодож байрлуулах нь ашигтай.

III.3.2 Говь-Алтай аймгийн зам шугам, сүлжээний босоо тэнхлэгийн чиглэл

Ханх боомтоос Мөрөн, Улиастай, Алтайг дамжин Бургастайн боомтоор гарах тэнхлэг хөгжлийн гол тулгуур болно.

Энэ чиглэлд Жаргалан, Алтай хот, Шарга, Төгрөг, Алтай, Бургастай зэрэг аймгийн төв, суурин газрууд хамрагдах юм.

Дэд бүтцийн босоо тэнхлэгүүдийг одоо байгаа болон цаашид бий болох магадлалтай улс, орон нутгийн чанартай авто зам, эрчим хүч, холбоо мэдээлэлийн сүлжээнд түшиглэн тогтоосон бөгөөд эдгээр тэнхлэгүүд тухайн бүсийн хөгжилд тэргүүлэх үүрэг гүйцэтгэнэ.

Энэ тэнхлэг нь дотооддоо төдийгүй гадаад хүчин зүйл тухайлбал хойд, урд хөршүүдтэйгээ зах зээлийн нэгдсэн гарцтай байх, түүнчлэн Ази-Европийн дэд бүтцийн үндсэн сүлжээнд Монгол улсын хөгжилд нөлөөлөхүйц байдлаар холбогдох боломж, орчин үеийн шинжлэх ухаан, техник, технологи холбоо мэдээлэлийн өргөн цар хүрээг хамарсан даяарчлалын хандлагад хамрах боломж зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан үзсэнээр улсын хэмжээнд тогтвортой хөгжлийг хангах, бүс нутгийн түвшинд тэнцвэртэй хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Улсын дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэг мянганы замд нягт уялдсан бүсийн хөгжлийг тэтгэх дэд бүтцийн босоо тэнхлэгүүдийн хөдөөгийн хүн амд үйлчлэх зохистой хүрээ нь бүс нутгийн тогтолцоо бүрдэх гол шалгуур болно.

Босоо тэнхлэгийн үйлчлэлийн зохистой хүрээний радиус нь тухайн бүсийн нутаг дэвсгэрийн хэв шинж, зам харилцааны төлөвшил чадвараас хамааран дунджаар 150-200 км байна.

Энэ зай нь орон нутгийн хүн амд эрүүл мэнд боловсрол, нийгэм соёл бизнесийн зэрэг бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх өртөг зардал, цаг хугацааг хэмнэх, чөлөөт цагаа нэмэгдүүлэх тохиромжтой зай юм.

Төмөр замын үндсэн сүлжээ бүрдэх гол хүчин зүйлүүд

Далайд гарцгүй орны хувьд өргөн уудам газар нутагт харьцангуй жигд тархсан ашигт малтмалын орд газруудыг ашиглах, барилгын материал болон бусад мал аж ахуйн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, хоорондоо алслагдсан хот суурингуудыг төмөр замаар холбох, улсын ачаа, зорчигч тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх улсын экспортын нөөцийг нэмэгдүүлэх, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зорилтыг хэрэгжүүлэх арга замыг төмөр замгүйгээр төсөөлөх аргагүй.

Төмөр замын үндсэн сүлжээ бүрдэх гол хүчин зүйлүүдийг Хүн амын нутагшилт, хөгжлийн ерөнхий төслийн хүрээнд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хийсэн байгалийн нөхцөл, нөөцийн цогцолбор үнэлгээг үндэслэн төмөр замын ачаа зорчигч тээврийг аль болох өргөн ашиглах боломжийг харгалзан боловсруулав. Үүнд:

- Ашигт малтмалын голлох орд газруудын байршил, нөөц, /нүүрс, газрын тос, зэс молибдин, фосфорит, өнгөт металл гэх мэт/ ашиглах боломж
- Газрын гадаргын хэв шинж, бартаажилт, уул даваа, ус гол горхи, элс, инженер-геологийн голлох нөхцөл /Газар хөдлөлтийн балл, мөнх цэвдэг/
- Аялал жуулчлалыг олон улс, үндэсний түвшинд хөгжүүлэх нөхцөл, нөөц аялал жуулчлал, амралт сувиллын гол бүс нутгийн байршил
- Байгаль орчныг хамгаалах нийтлэг зарчим, тусгай хамгаалаттай газар нутгийн байршил, ашиглалтын горим
- Хүн амын нутагшилтын тогтолцоо, хот суурины байршил, ирээдүйн хөгжлийн төлөв
- Эрчим хүч, холбоожуулалтын нэгдсэн систем, тэдгээрийн хэтийн хөгжлийн төлөв.
- Олон улсын болон хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагааны хэтийн төлөв

Эдгээр үндсэн хүчин зүйлүүдэд тулгуурлан төмөр замын тасралтгүй жигд ажиллагаа, харьцангуй өндөр хурд, нэвтрүүлэн өнгөрүүлэх өндөр хүчин чадал, хямд үнэ зэрэг давуу талыг өргөн ашигласнаар төвийн болон хязгаар нутгийн хөгжлийг жигдрүүлэх, их нүүдлийг сааруулах, хүн амын хэт төвлөрөл, хотжих үйл явцаас үүдэн гарах сөрөг нөлөөллийг хязгаарлах, хөдөөгийн хүн амд үйлчилгээг ойртуулах, орон

нутаг нийгэм эдийн засаг, бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд чухал хөшүүрэг бий болгоно.

Төмөр замын үндсэн сүлжээний бүтэц, гол чиглэлүүд

Төмөр замын үндсэн сүлжээ бүрдэх гол хүчин зүйлд тулгуурлан сүлжээний бүтэц, гол чиглэлүүдийг дараахи байдлаар тогтоов. Үүнд:

-Сүлжээний чиглэл бүрд гол хүчин зүйлүүдийг аль болох өргөн хүрээтэй харилцан уялдаатай хамруулах, тухайлбал. Зүүн талаасаа Дорнод аймгийн нутгаас эхлэн манай орны өмнөд хэсгийг бүхэлд нь хамран Их нууруудын хотгороор дамжин баруун талд Ховд аймгийн нутаг хүртэл өргөн зурвас нутагт харьцангуй жигд тархсан газрын тосны баялгыг ашиглах

- Байгалийн баялаг нүүрсний томоохон орд, барилгын материалын орд газруудыг ашиглах.

- Аялал жуулчлалыг олон улс, бүс нутгийн түвшинд эрчимтэй хөгжүүлж болох нөөц, чиглэл нь тогтоогдсон нутаг дэвсгэрийг хамруулах

- Одоо байгаа болон ирээдүйд бий болох хот сууриныг хамруулахаар тооцов.

Төмөр замын үндсэн сүлжээний шинээр буй болох чиглэлүүд нь дараахи чиглэлүүдээс бүрдэнэ.

1. Гуулингаас-Хүйсийн говь хүртэлх хөндлөн тэнхлэгийн чиглэл
2. Улиастайн чиглэл /Говь-Алтайн Жаргалан сумын төвөөс Завханы Арцсуурийн боомт хүртэл/

Төмөр замын тэнхлэг нь Халх голоор зүүн хил гарч улмаар хилээс 25 км-ийн цаана орших Рашаантын нарийн төмөр замаар дамжин Түмэн голын төмөр замтай нийлэх ба Тамсагбулаг-Чойбалсан-Баруун урт-Дундговь-Өвөрхангай-Баянхонгор-Говь-Алтай-Ховд-Баян-Өлгийгээр дамжин баруун хил гарч хилээс 300 км зайтай орших Зырновск хотын төмөр замтай холбогдоно.

Ийнхүү төмөр замын хөндлөн тэнхлэг нь говь хээрийн бүсэд зонхилон тархсан төмөр зам зайлшгүй шаардагддаг нүүрс, нефть, хар болон өнгөт металл, жонш, давс зэрэг ашигт малтмалын байршил, мал аж ахуйн гаралтай түүхий эд, газрын нам зэрэг хүчин зүйлд тулгуурласан хүн амын нутагшилт, суурьшлын хувьд Чойбалсан хотоос баруун бүсийн төв Ховд хот хүрэх төмөр замын үйлчилгээнд Алтай хот хамарч болох зайнд байгаагаараа онцлог юм.

Эдгээр аймгуудын төмөр замын дагуух сум суурин газруудын төдийгүй хөдөөгийн хүн амын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, бүх төрлийн үйлдвэр, үйлчилгээ, худалдаа арилжаа бизнесийн орчин бүрдүүлэхэд асар их нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Хэдийгээр сүүлийн жилүүдэд авто зам, эрчим хүч, холбооны мастер төлөвлөгөө хийгдэж эхний үе шатны зорилтууд хэрэгжиж байгаа боловч төмөр замын сүлжээ бүрдүүлэхэд ихээхэн хугацаа алдаж байгаагаас улсын нийгэм эдийн засгийн хөгжлийг тогтвортой хангах, стратегийг цогц байдлаар шийдвэрлэгдэхгүй байна.

Иймд өргөн уудам нутагт харьцангуй жигд тархсан нефть, нүүрс, зэс, молибдени зэрэг ашигт малтмалын гол орд газруудыг ашиглахаас гадна хоорондоо алслагдсан хот сууриныг төмөр замаар холбох асуудал нийгмийн чиг баримжаатай хөгжлийн стратеги зорилтоос үүдэн гарч байна.

Хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоо бүрдэх тулгуур хүчин зүйлийн салшгүй хэсэг нь төмөр зам байна.

Хүн амын нутагшилт хөгжлийн ерөнхий төслийн хүрээнд нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгэм, эдийн засгийн хөгжилд нөлөөлөх нөхцөл, нөөцийн иж бүрэн үнэлгээнд түшиглэн төмөр замын тэнхлэг нь нийт 9 аймаг, тэдгээрийн суурин газрууд хамрагдаж байгаа нь хөдөөгийн хүн амын нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, их нүүдэл, төвлөрлийг сааруулах, хязгаар бүс нутгийн хөгжлийг тэнцвэржүүлэх тулгуур хүчин зүйл болно.

III.3.4 Зам, шугам сүлжээний газрын төлөвлөлт

А. Авто зам

2006-2010 онд гол хийгдэх ажлууд

1. “Мянганы зам”-ын Улиастай-Алтайн чиглэлийн босоо тэнхлэгийн замыг барина. Үүнээс Говь-Алтай аймгийн нутагт 69 км урттай зам баригдана. Энд хайрга, шороо авдаг 14 карьер ажиллана. Үүнд: 28 га газар хамрагдана.
2. Алтай-Ховдын чиглэлд 68 км газарт хайрган зам тавигдана. Хайрга, шорооны 10 карьерт 16 га газар шаардагдана.
3. Аймгийн төвийн зам, гүүрийг ашиглах, засварлах, шинээр тавих ба барина. Энд шаардагдах хайрга, шороо авах байнгын ажиллагаатай карьер ажилуулна.
4. Аймгийн авто замын сүлжээний зураглалыг шинэчлэн боловсруулах ажил хийгдэнэ.
5. Алтай-Бургастай чиглэлийн хайрган хучилтай замыг барьж эхлэнэ.
6. Аялал, жуулчлалын маршрутын дагуу авто замын бэрхшээлтэй бартаатай хэсгийг сайжруулсан хайрган зам барина.
7. Аймгийн төвд орчин үеийн шаардлагад нийцсэн авто үйлчилгээний төв барина.

2011-2015 онд хийгдэх ажлууд

1. Мянганы замын босоо тэнхлэгийн Алтай-Бургастайн чиглэлийн замыг үргэлжлүүлэн барих ба зарим хэсгийг хатуу хучилттай болгоно.
2. Алтай-Баянхонгорын чиглэлийн хайрган замыг барьж эхлэнэ.
3. Алтай хотыг бүлэг суурингийн бусад төвүүдтэй хайрган замаар холбогдох ажил эхэлнэ.
4. Бүлэг суурингийн төвүүдийн тосгоны замыг хайрган ба хатуу хучилттай болгоно.
5. Аялал жуулчлалын маршрутын дагуу хайрган хучилттай замыг барьж эхлэнэ.

2016-2023 онд хийгдэх ажлууд

1. Алтай хот-Бүсүүдийн төв суурингуудтай холбох хайрган замуудыг барьж дуусгана.
2. Алтай-Баянхонгорын чиглэлийн замыг барьж дуусгана /хайрган хучилттай/.
3. Алтай-Талын мэлтэс, Чандмана сум, Зээгийн уурхай Улаан боом-Тайширын гүүр-Алтай-Гуулин тосгон, Цээл сум, Буурын үйлдвэр, Бигэр сум-Давсны үйлдвэрүүдийн замуудыг хайрган хучилттай замаар холбоно.
4. Бүсүүдийн төвийг бусад суурингуудтай холбосон хайрган зам барина.

Эдгээр замуудыг барихад хайрга, шорооны 350 орчим карьер буюу 700 га газарт нөхөн сэргээлт хийх шаардлагатай.

Дээр дурьдсан баригдах замуудад газар сонголт хийхийн зэрэгцээ, аймгийн төвийн замын сүлжээний зураг зохиоход оролцох, түүнийг хэрэгжүүлэх, карьерын нөхөн сэргээлт хийлгэх ажлыг зохион байгуулна.

Б. Төмөр зам

2016-2023 онд гол хийгдэх ажлууд

Баянхонгор-Ховдын чиглэлд тавигдах төмөр замыг Гуулингаас-Ховдын Дарви хүртэл 424.7 км газар нь Говь-Алтай аймгийн нутагт хамрагдана. Төмөр зам тавихад 4856.4 га газар, 10 өртөө барихад 600 га бүгд 5456.4 га газар шаардагдана.

В. Эрчим хүч

2006-2010 онд гол хийгдэх ажлууд

1. Тайшир сумын Улаан боомын УЦС ашиглалтанд орж, түүний орчны бус нутгийн тохижилт, нөхөн сэргээлтийг 120,0 га талбайд хийж, Улаан боом тосгоны тохижилтын ажил хийгдэнэ.
2. Говь-Алтай аймгийн Дэлгэр, Жаргалан, Халиун, Шарга, Бигэр, Тайшир сум хүртэл Улаан боом, Алтай хотоос цахилгаан дамжуулах 35 кВт-ын хүчин чадалтай шугам тавигдана.
3. Алтай суманд нарны цахилгаан станц. Төгрөг суманд нүүрсний хийн цахилгаан станц барина.

4. Улаан боом-Завханы чиглэлд цахилгаан дамжуулах 100 кВт шугам тавигдана.
5. Өмнөд хэсгийн алслагдсан суурин, тосгонд сэргээгдэх эрчим хүч, бусад эх үүсвэрийг түлхүү ашиглана. Энэ замаар эрчим хүчний эх үүсвэр бий болгоно.

2011-2023 онд гол хийгдэх ажлууд

1. Газрын гүний дулааныг ашиглах ба дунд чадлын сэргээгдэх эрчим хүчний цогцолборыг эрчим хүчний сүлжээнд хамрагдаж чадахгүй нутгуудад барина.
2. Ашиглах нөөцийг тогтоогдсон газруудад бага, дунд чадлын салхин паркууд байгуулна.

Г. Мэдээлэл-Харилцаа холбооны хүрээнд

2006-2010 онд хийгдэх ажлууд

1. Зарим сумдад мэдээлэл дамжуулах шилэн кабелин хот хоорондын сүлжээ бий болгоно.
2. Алтай хотын телевизийн дахин дамжуулах станцыг шинэчлэж, өргөтгөнө.

2011-2023 онд хийгдэх ажил

Сумын төвүүд болон суурийн газруудыг шилэн кабелийн сүлжээнд холбоно.

Д. Агаарын тээвэр

2006-2010 онд хийгдэх ажлууд

1. Алтай хотын нисэх буудлын барилга байгууламж, нисэх буух зурвасыг сайжруулах, хатуу хучилттай болгох, элс, цасны хамгаалалтын ногоон зурвас байгуулах
2. Бүсүүдийн төвүүдэд жижиг оврын онгоц буух, нисэх зурвас байгуулах, түүний хамгаалалтын зурвас барьж байгуулах

2016-2023 онд хийгдэх ажлууд

1. Алтай хотоос 100 км-ээс алслагдсан бүсийн төвүүдэд бага оврын онгоц буух, нисэх буудал барьж тохижуулна.
2. Бүсийн төвүүдийн онгоцны нисэх буух буудлуудыг элс цаснаас хамгаалах ойн зурвас байгуулах
3. Аялал жуулчлалын баазын болон рашаан амралтын газруудад онгоц буух, нисэх зурвасууд байгуулна.
4. Тэдгээрийн хамгаалалтын (салхинаас) зурвас барих

Г. Хоолойн тээвэр

2006-2010 онд хийгдэх ажлууд

Алтай хотын усан хангамжийг сайжруулах зорилгоор цэвэр ус тээвэрлэх ган хоолой барина.

Автозамын сүлжээний төлөвлөлт

№	Төлөвлөлтийн үе шат Сумдуудын нэр	2006-2010				2011-2015				2016-2023			
		бүгд	үүнээс			бүгд	үүнээс			бүгд	үүнээс		
			Улсын чанартай	орон нутгийн чанартай	Аж ахуйн нэгж, байгууллагын логоолын зам		улсын	орон нутгийн	а.а.н.б.		улсын	орон нутгийн	а.а.н.б.
1	Алтай	2941.1	710.0	2136.0	95.1	2941.1	710.0	2136.0	95.1	2941.1	710.0	2136.0	95.1
2	Баян-уул	1127.1	-	1080.0	47.1	1127.1	-	1080.0	47.1				
3	Бигэр	892.5	-	8520.0	40.5	892.5	-	8520.0	40.5				
4	Бугат	1989.1	820.0	1134.0	35.1	1989.1	820.0	1134.0	35.1				
5	Дарви	2933.9	1220.0	1656.0	57.9	2933.9	1220.0	1656.0	57.9				
6	Дэлгэр	595.0	160.0	420.0	15.0	595.0	160.0	420.0	15.0				
7	Есөнбулаг	600.7	-	583.0	17.7	600.7	-	583.0	17.7				
8	Жаргалан	1699.7	1001	684	14.7	840.7	-	823	17.7	840.7		823	27.7
9	Тайшир	1595.1	-	1524	71.1	1595.1	-	1524	71.1				
10	Тонхил	1058.0	320.0	726.0	12.0	1058.0	320.0	726.0	12.0				
11	Төгрөг	1683.2	830.0	822.0	31.2	1683.2	830.0	822.0	31.2				
12	Халиун	1288.8	-	1260.0	28.8	1288.8	-	1260.0	28.8				
13	Хөхморьт	993.6	-	942.0	51.6	993.6	-	942.0	51.6				
14	Цогт	1671.3	-	1638.0	33.3	1671.3	-	1638.0	43.3	3033.8	-	2988.0	45.8
15	Цээл	1270.5	-	1254.0	16.5	1270.5	-	1254.0	16.5				
16	Чандмань	1068.0	-	1050.0	18.0	1444.0	-	1410.0	34.0	1444.0	-	1410.0	34.0
17	Шарга	2064.4	1510.0	534.0	20.4	2064.4	1510.0	534.0	20.4				
18	Эрдэнэ	820.8	-	780.0	40.8	820.8	-	780.0	40.8				
	Дүн	26292.8	6571.0	19075	646.8	26919	6571.0	19675	673	28271.3	6571.0	21027.3	675.3

Автозамын сүлжээний төлөвлөлт (бүсээр)

Бүсийн нэр	2006-2010				2011-2015				2016-2023			
	бүгд	үүнээс			бүгд	үүнээс			бүгд	үүнээс		
		Улсын чанартай	орон нутгийн чанартай	Аж ахуйн нэгж, байгууллагын логоолын зам		улсын	орон нутгийн	а.а.н.б.		улсын	орон нутгийн	а.а.н.б.
1. Төвийн бүс	10453.0	3891.0	6391.0	171.0	10693.0	3891.0	6391.0	171.0	10693.0	3891.0	6391.0	171.0
2. Бигэрийн бүс	4452.6	-	4320.0	132.6	4838.6	-	4680	158.6	5804.9	-	5670.0	134.9
3. Баян-Уулын бүс	2120.7	-	2022.0	98.7	2120.7	-	2022.0	98.7	2120.7	-	2022.0	98.7
4. Тонхилын бүс	2653.1	320.0	2250.0	83.1	2653.1	320.0	2250.0	83.1	2653.1	320.0	2250.0	83.1
5. Төгрөгийн бүс	3672.3	1650.0	1956.0	66.3	3672.3	1650.0	1956.0	66.3	3672.3	1650.0	1956.0	66.3
6. Алтайн бүс	2941.1	710.0	2136.0	95.1	2941.1	710.0	2136.0	95.1	2941.1	710.0	2136.0	95.1
Бүгд	26292.8	6571	19075	646.8	26918.8	6571.0	19435	672.8	27885.1	6571.0	20425	649.1

Агаарын тээврийн газрын газар олголтын төлөвлөлт

а. Тээврийн зориулалтаар										
№	Бүсийн төвийн нэр	2006-2010 он			2011-2015 он			2016-2023 он		
		Олгох талбай (га)			Олгох талбай (га)			Олгох талбай (га)		
		Бүгд	Үүнээс		Бүгд	Үүнээс		Бүгд	Үүнээс	
Нисэх буух талбай	Буудлын барилга байгууламж		Нисэх буух талбай	Буудлын барилга байгууламж		Нисэх буух талбай	Буудлын барилга байгууламж			
1	Бигэр	200	198.5	1.5	-	-	-	-	-	-
2	Баян-Уул	-	-	-	-	-	-	-	-	-
3	Тонхил	-	-	-	200	198.5	1.5	-	-	-
4	Төгрөг	-	-	-	200	198.5	1.5	-	-	-
5	Алтай	200	198.5	1.5	200	198.5	1.5	-	-	-
6	Баянтоорой	-	-	-	-	-	-	200	198.5	1.5
	Дун	400	397.0	3.0	600	595.5	4.5	200	198.5	1.5
б. Аялал жуулчлалын зориулалтаар										
№	Бүсийн төвийн нэр	2006-2010 он			2011-2015 он			2016-2023 он		
		Олгох талбай (га)			Олгох талбай (га)			Олгох талбай (га)		
		Бүгд	Үүнээс		Бүгд	Үүнээс		Бүгд	Үүнээс	
Нисэх буух талбай	Буудлын барилга байгууламж		Нисэх буух талбай	Буудлын барилга байгууламж		Нисэх буух талбай	Буудлын барилга байгууламж			
1	Эрээн нуур	-	-	-	200	199.0	1.0	-	-	-
2	Гуулин	-	-	-	-	-	-	200	199.0	1.0
3	Чандмань	-	-	-	-	-	-	200	199.0	1.0
4	Баянтоорой	-	-	-	-	-	-	200	199.0	1.0
	Дун	-	-	-	200	199.0	1.0	600	597.0	3.0
	Бүгд	400	397.0	3.0	800	794.5	5.5	800	795.5	4.5

Хүснэгт 65

Шугам сүлжээний газрын одоогийн байдал ба хэтийн төлөвлөлт

д/д	Сумдын нэр	Холбооны шугамы шугам /км/	Цахилгааны шугам /км/			Холбооны шугам талбай /га/ Одоогийн байдал	Цахилгааны шугам талбай /га/			
			10кв	35кв	110кв		Одоогийн байдал	2006-2010	2011-2015	2016-2023
1	Алтай	80				64				
2	Баян-Уул	130		25		104			72	
3	Бигэр	100		101		80			210	64
4	Бугат	20				16				
5	Дарви	48		50		38.4				150
6	Дэлгэр	82	53	51		65.6	103	48		
7	Есөнбулаг	67		60		53.6	40	74	141	
8	Жаргалан	60		63		48			189	
9	Төгрөг	72		60		57.6		94		
10	Тайшир	90		60	25	72	140	220	66	
11	Тонхил	11		11		8.8				33
12	Хөхморьт	30				24				
13	Халиун	50		50		40		12	150	
14	Цогт	77		30		61.6			93	
15	Цээл	77		29		61.6			90	
16	Чандмань	63		60		50.4				122
17	Шарга	130		102		104		88		
18	Эрдэнэ	13		13		10.4				26
	Дун	Бүгд	1200	53	765	960	283	536	1011	395

Ш.4 ОЙН САНГИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

Тус аймгийн ойн сан нь шинэсэн ой, заган ой гэсэн хоёр төрлөөс бүрддэг бөгөөд шинэсэн ой нь Хасагт хайрхан, Хар азаргын нурууны ар, баруун хажуугаар 16452,90 га талбайд ургадаг.

Тус аймгийн 10 сумын 1970658,68 га газарт заган ой тархсан.

Заган ойд явуулах аж ахуйн төрөл хэлбэр нь түүний элс бэхжүүлэх, хөрсийг эвдэрлээс хамгаалах, тэжээлийн эх үүсвэрийг бий болгох зэрэг байгалийн харилцан нөлөөллийг бүрэн дүүрэн тасралтгүй явуулахад чиглүүлэх нь зүйтэй.

Заган ойг сэргээн ургуулах, ойжуулалт хийх, байгалийн сэргэн ургалтанд туслах зэрэгт чиглэсэн арга хэмжээг биеэ даасан аж ахуйн нэгжийн хүчээр явуулахын зэрэгцээ төр захиргаа, олон нийтийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх нь чухал юм.

Сүүлийн жилүүдэд Ээж хайрханы эргэн тойрон, Балганат, Баянтоорой, Эдрэнгийн нурууны ар хоолойгоор Монгол заг байгалийн аясаар сэргэн ургаж байгааг судалж түүний ургалтыг түргэтгэх арга хэмжээ авах. Байгалийн аясаар нөхөн сэргэх боломжгүй нутагт хамгаалалтын бүс тогтоож, загийн ашиглалыг зохицуулах шаардлагатай.

Заган ойн хамгаалалтын талаар дараах чиглэлийг баримтлан ажиллах хэрэгтэй юм. Үүнд:

1. Байгалийн нөөц нь цаашид нөхөн сэргээх боломжгүй болсон сэргээн ургуулах ажил хийгдэж байгаа, өсвөр залуу заг ихтэй газарт тухайн орон нутгийн захиргаа, ойн байгууллага түр хугацаагаар хамгаалалтын бүс тогтоон заг ашиглалтыг зохицуулах
2. Загийн ашиглалт хамгаалалтанд нарийн хяналт тогтоож, заган ойн ач холбогдлыг ард иргэдэд өргөнөөр сурталчилах
3. Орон нутгийн байгаль орчны хяналтын алба, аж ахуйн нэгж, байгууллагууд ажлаа уялдуулан заган ойн нөхөн сэргээлт, хамгаалалтыг сайжруулахад гол анхаарлаа төвлөрүүлэх

Заган ой байгалийн аясаар сэргэн ургаж, өсөлт хөгжилт хэвийн явагдахад байгалийн сэргэн ургалтыг тэтгэх, заган ойн хэв шинж, насны онцлогт тохирсон арчилгааны огтлолт явуулах зэрэг зайлшгүй шаардлагатай юм.

Жилд 10 га талбайг загжуулж ойжуулахад 6000 кг загийн үр шаардагдана.

Мод үржүүлгийн газарт загийг үрээр үржүүлж тарьц бэлтгэхэд эхний 1-3 жилд үхэл хорогдол ихтэй эмзэг арчилгаа тордолгоо шаардагдах боловч дараагийн жилүүдэд орчиндоо зохицон ургах чадвар нь дээшилдэг.

Тус аймгийн төв суурин газрууд болон шинээр байгуулах тосгоныг элсний нүүлт, цөлжилтөөс хамгаалах ногоон хэрэм, ойн төгөл байгуулах төлөвлөгөөг дараахи хүснэгтээр гаргав.

Хүснэгт 66

**Бүсийн төв сум суурин газруудад байгуулах
ногоон хэрмийн төлөвлөгөө**

		2006-2010 он		2011-2015 он		2016-2023 он	
		Талбай /га/	Зардал /сая.төг/	Талбай /га/	Зардал /сая.төг/	Талбай /га/	Зардал /сая.төг/
Бүсийн төв							
1	Төвийн	5.0	17.5	7.0	24.5	8.0	28.0
2	Бигэр	1.0	3.5	1.5	5.3	2.5	8.8
3	Төгрөг	1.0	3.5	2.0	7.0	3.0	10.5
4	Тонхил	0.5	1.8	0.5	1.8	1.0	3.5
5	Баян-Уул	1.5	5.3	2.0	7.0	3.0	10.5
6	Алтай	1.5	5.3	2.0	7.0	3.0	10.5
	Дүн	10.5	36.8	15.0	52.5	20.5	71.8
Сумын төв							
7	Бугат	0.5	1.8	0.5	1.8	0.5	1.8
8	Дарив	0.5	1.8	0.5	1.8	1.0	3.5
9	Дэлгэр	0.5	1.8	0.5	1.8	1.0	3.5
10	Жаргалан	0.5	1.8	0.5	1.8	1.0	3.5
11	Тайшир	0.5	1.8	0.5	1.8	1.0	3.5
12	Халиун	0.5	1.8	1.0	3.5	1.0	3.5
13	Хөхморьт	0.5	1.8	0.5	1.8	0.5	1.8
14	Цогт	0.5	1.8	0.5	1.8	0.5	1.8
15	Цээл	0.1	0.4	0.1	0.4	0.1	0.4
16	Чандмань	0.5	1.8	1.0	3.5	1.0	3.5
17	Шарга	0.5	1.8	1.0	3.5	1.0	3.5
18	Эрдэнэ	0.5	1.8	0.5	1.8	1.0	3.5
19	Гуулин	0.5	1.8	1.0	3.5	1.0	3.5
20	Баянтоорой	0.5	1.8	1.0	3.5	1.0	3.5
21	Зээгт	0.5	1.8	0.5	1.8	1.0	3.5
22	Биж	0.5	1.8	1.0	3.5	1.0	3.5
23	Иэвэн	0.5	1.8	0.5	1.8	1.0	3.5
24	Цахиурт	0.5	1.8	0.5	1.5	1.0	3.5
25	Шар сайр	0.5	1.8	1.0	3.5	2.0	7.0
26	Шар хөтөл			1.0	3.5	2.0	7.0
27	Бургастай	0.5	1.8	1.5	5.3	2.5	8.8
28	Улаанбоом	0.5	1.8	1.0	3.5	2.0	7.0
29	Талын мэлтэс			1.0	3.5	2.0	7.0
	Дүн	10.1	36.4	17.5	60.2	25.6	91.6
	Нийт	20.5	73.2	32.5	112.7	46.1	163.4

Тайлбар: 1 га ногоон хэрэм байгуулах зардлын тооцоо: Хамгаалалтын хашаа барихад 700 мян.төг, газар хагалах мод суулгах нүх бэлтгэхэд (3000 ш) 175 мян.төг. Модны тарьц суулгац худалдан авах (3000 ш) 1400 мян.төгрөг. Тарьц суулгацыг тээвэрлэх 175 мян.төг, бордоо бэлтгэх, тарьцыг тарих, арчилгаанд 1050,0 мян.төг гэж тооцоход нэг га-гийн зардал 3500 мян.төг зарцуулах тооцоо гарч байна.

Хүснэгтээс харахад төлөвлөлтийн хугацаанд төв суурин газрын 99,1 га талбайд ногоон хэрэм байгуулах бөгөөд үүнд нийт 349,3 сая төгрөг зарцуулахаар тооцов.

Тус аймгийн шилмүүсэн болон холимог ой, заган ойг ойжуулах, нөхөн сэргээх арга хэмжээ, түүнд шаардагдах зардлын хэмжээг тооцсон болно.

Ойжуулалт, ойг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөлт (га, сая.төг-өөр)

№	Бүсийн нэр	Нийт талбай		2006-2010 он				2011-2015 он				2016-2023 он			
		Ойн төрлөөр		ой		заг		ой		заг		ой		заг	
		ой	заг	талбай	зардал	талбай	зардал	талбай	зардал	талбай	зардал	талбай	зардал	талбай	зардал
1	Төвийн бүс	650	1000	100	10,0	200	27,1	250	25,0	350	47,4	300	30,0	450	60,9
2	Бигэрийн бүс	-	1000	-		200	27,1	-	-	350	47,4	-	-	450	60,9
3	Баян-Уулын бүс	-		-		-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Тонхилын бүс	100	500	20		100	13,5	30	3,0	150	20,3	50	5,0	250	33,8
5	Төгрөгийн бүс		500			100	13,5	-	-	150	20,3	-	-	250	33,8
6	Алтайн бүс		250		2,0	50	6,8	-	-	80	10,8	-	-	120	16,2
	Бүгд	750	3250	120	12,0	600	88,0	280	28,0	1000	146,2	350	35,0	1400	235,6

Тайлбар: 1 га шилмүүст ойг ойжуулах, нөхөн сэргээх арга хэмжээнд 100 мян.төг 1 га заган ойд 135,3 мян.төг зарцуулахаар тооцов.

Ойжуулалт, ойг нөхөн сэргээхэд 4000 га талбайг хамруулан 420,2 сая.төг ТӨЛӨВЛӨВ.

Ойн сан бүхий газрын төлөвлөлт

№	Аймаг, нийслэл, сум дүүргийн нэр	Ойн сан бүхий газрын төлөвлөлт		
		Нэр	Талбайн хэмжээ /га/	Урт /км/
1	Алтай			
2	Баян-уул	Ногоон хэрэм	1,266.41	21.10
3	Бигэр			
4	Бугат			
5	Дарви			
6	Дэлгэр	Ногоон хэрэм	8,482.33	141.40
7	Есөнбулаг			
8	Жаргалан	Ногоон хэрэм	5,655.79	94.28
		Мод үржүүлгийн газар	100.00	
9	Тайшир	Ногоон хэрэм	3,563.80	59.40
10	Тонхил			
11	Төгрөг			
12	Халиун			
13	Хөхморьт	Ногоон хэрэм	7,117.56	118.63
14	Цогт			
15	Цээл			
16	Чандмань			
17	Шарга			
18	Эрдэнэ			
	Дүн		26,185.88	434.81

III.4.1 Тариалангийн талбай хамгаалах ойн зурвас

Тариалангийн талбайн 3-4 хувьд ойн зурвас байгуулсан нөхцөлд уг талбайн хөрс салхины элэгдэлд орох явдал үлэмж багасдаг бөгөөд 1 га талбайгаас авах ургацын хэмжээ дунджаар 20-30 хувиар нэмэгддэг нь судалгаагаар батлагджээ.

Тус аймгийн Гуулинд мод үржүүлгийн газар байгуулан ойн зурваст зориулан тарьц суулгац бэлтгэж байв. Гэвч зах зээлийн харилцаанд шилжсэн үеэс хөрөнгө хүчний хүндрэлээс шалтгаалан үйл ажиллагаа нь зогссон төдийгүй, урьд байгуулсан хамгаалалтын зурвас арчилгаа тордолт дутагдан доройтох болжээ.

Тус аймгийн услалтын системүүдийн тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвасыг шинээр байгуулах, хуучныг сэргээхэд 770 сая.төгрөг зарцуулах тооцоо гарч байна.

Хүснэгт 69

Услалтын системүүдийн тариалангийн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах тооцоо

	Байгуулах ойн зурвас	2006-2010 он		2011-2015 он		2016-2023 он	
		Талбай /га/	Зардал /сая.төг/	Талбай /га/	Зардал /сая.төг/	Талбай /га/	Зардал /сая.төг/
Услалтын системийн тариалангийн талбайн ойн зурвас	220	30	105,0	80	280,0	110	385,0

Тайлбар: Жаргалан сумын Ажиг нуур, Модот хоолой, Улаан эрэг зэрэг услах боломж бүхий газрыг сонгох нь тохиромжтой.

Ойн зурвас байгуулах зардлыг ангилж үзвэл мод сөөгийг худалдан авах, түүнийг тээвэрлэх, суулгах, нүх ухах, мод сөөгийг суулгах, усалж арчлах, хашаа барьж хамгаалах зэрэг ажлуудад зориулсан зардлууд юм.

Тариалангийн талбай хамгаалах ойн зурвас байгуулах ажлыг тариалан эрхэлж буй аж ахуйн нэгж, хувь хүмүүс тэдний хөрөнгө хүчний бололцоонд тохируулан жил бүр тодорхой хэмжээний талбайд ойн зурвас байгуулах боломжтой гэж үзэж байна.

Жаргалан сумдын нутаг Завхан голын сав дагуу бургас үржүүлэх плантаци байгуулах, улмаар гэр ахуйн модон эдлэл, мал аж ахуйн зориулалттай тоног хэрэгслэл үйлдвэрлэхээр төлөвлөв.

Ингэснээр аймаг орны хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, малчид иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангах, нөгөө талаар байгаль орчны хамгаалах нэгэн түлхэц болох юм.

Хүснэгт 70

Жаргалан суманд байгуулах бургас үржүүлэх плантацийн төлөвлөлт (га, мян)

	2006-2010 он		2011-2015 он		2016-2023 он	
	Талбай /га/	Зардал /сая.төг/	Талбай /га/	Зардал /сая.төг/	Талбай /га/	Зардал /сая.төг/
Жаргалан	30	105,0	50	175,0	70	245,0

2023 оны эцэст 150 га бургас үржүүлгийн плантаци байгуулах, үүнд нийт 525 сая төгрөг зарцуулах тооцоо гарч байгаа юм.

III.4.2 “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр

МУ-ын засгийн газраас “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийг 3 үе шаттай, нийт 30 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

“Ногоон хэрэм” хөтөлбөрийн хэтийн төлөв нь цөлжилт, элсний нүүлт, шар шороон шуургыг сааруулахад бүх нийтийн оролцоог сайжруулах, говь, хээр цөлийн бүсэд ойн нөөц, бэлчээр, тариалангийн талбай, авто болон төмөр замыг хамгаалахад “ногоон хэрэм” хөтөлбөрийн үндсэн зорилт чиглэлтэй юм.

Хүснэгт 71

Говь-Алтай аймагт “Ногоон хэрэм” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөлт
(га, сая төг-өөр)

	Сумын нэр	“ногоон хэрэм”-ийн урт, км	Талбайн хэмжээ га	2006-2010 он		2011-2015 он		2016-2023 он	
				Талбай /га/	Зардал /сая.төг/	Талбай /га/	Зардал /сая.төг/	Талбай /га/	Зардал /сая.төг/
1	Дэлгэр	141.4	8482.3	200	176.0	800	704.0	2000	1760.0
2	Тайшир	59.4	3564.0	150	132.0	700	616.0	1000	880.0
3	Жаргалан	94.8	5656.0	150	132.0	500	440.0	1500	1320.0
4	Баян-Уул	21.1	1266.0	150	132.0	300	264.0	400	352.0
5	Хөхморьт	118.6	7118.0	200	176.0	600	528.0	2000	1760.0
	Дүн	435.3	26086.3	850	748.0	2900	2552.0	6900.0	6072.0

Тайлбар: “Ногоон хэрэм” дамжин өнгөрөх нийт талбайд ойн зурвас байгуулах, үүний нэг га тутамд 880 мян.төгрөг зарцуулахаар тооцов.

Үндэсний “ногоон хэрэм” буюу “Экотрасс” хөтөлбөр тус аймгийн хэмжээнд Улаан шалын хоолой, Гуулингийн тал, нууруудын хөндий, Монгол элсний өмнөд зах Хүйсийн говиор дамжин өнгөрөх юм.

Хүснэгт 72

Говь-Алтай аймагт “Ногоон хэрэм” хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүсчилсэн төлөвлөлт
(га, сая төг-өөр)

	Сумын нэр	“ногоон хэрэм”-ийн урт, км	Талбайн хэмжээ га	2006-2010 он		2011-2015 он		2016-2023 он	
				Талбай /га/	Зардал /сая.төг/	Талбай /га/	Зардал /сая.төг/	Талбай /га/	Зардал /сая.төг/
1. Төвийн бүс									
1	Дэлгэр	141.4	8482.3	200	176.0	800	704.0	2000	1760.0
2	Тайшир	59.4	3564.0	150	132.0	700	616.0	1000	880.0
3	Жаргалан	94.8	5656.0	150	132.0	500	440.0	1500	1320.0
	Дүн	295.6	17702.3	500	440	2000	1760	4500	3960
2. Баян-Уулын бүс									
4	Баян-Уул	21.1	1266.0	150	132.0	300	264.0	400	352.0
5	Хөхморьт	118.6	7118.0	200	176.0	600	528.0	2000	1760.0
	Дүн	139.7	8384	350	308.0	900	792.0	2400	2112.0
	Нийт дүн	435.3	26086.3	850	748.0	2900	2552.0	6900.0	6072.0

“Ногоон хэрэм” дагуу Дэлгэр, Тайшир, Жаргалан сумдын нутгаар 295,6 км Баян-Уул, Хөхморьт сумдын нутгаар 139 км, ойролцоогоор нийт 435,3 км урт, 0,6 км өргөнтэйгээр дамжин өнгөрөх юм. Үүнд нийт 26118 га газар хамрагдах бөгөөд ойжуулалт (ногоон хэрэм) байгуулахад нийт 6072.0 сая төгрөг зарцуулахаар тооцов.

Хад асга, ухаа толгод, услах боломжгүй болон автомашин малчин иргэдийн нүүдэл зэрэгт чөлөөтэй үлдэх хэсгийг нарийвчилсан тооцоо техник, эдийн засгийн үндэслэлээр гаргах болно.

Монгол орны говь цөлийн бүсийг элсний нүүлт, цөлжилтөөс хамгаалахад туслах ногоон зурвасын босоо тэнхлэгийг байгуулах ажлыг дээрх хөтөлбөртэй хамтад нь зохион байгуулах бөгөөд тус аймгийн нутаг дэвсгэрийн зарим хэсэг босоо тэнхлэгт хамрагдахаар уг үндэсний хөтөлбөрт тусгасан байна.

Энд тарих мод бут нь говь-цөлийн уур амьсгалын нөхцөлд бойжуулж бэлтгэгдсэн цаашид бие дааж ургах чадвартай Заг, Тоорой, Сухай, Улиас, Чацаргана, Харгана, Шаваг зэрэг говийн унаган ургамлуудыг сонгон үржүүлэх нь зүйтэй.

Заган ойг нөхөн сэргээх, ойжуулах, хамгаалах ажлыг явуулах болон Засгийн газрын “Ногоон хэрэм” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн хэмжээнд бие даасан мод үржүүлэгийн газар байгуулах шаардлагатай, Цогт сумын нутагт Баян тооройн Хаяагийн услалтын системийн үр тариа, төмс, хүнсний ногоо тариалах боломжгүй чулуурхаг талбай, бусад системүүдийн үр тариа, хүнс тэжээлийн ургамал тариалах боломжгүй давсжсан, элсжсэн талбайн услах боломжийг түшиглэн мод үржүүлэгийн газар байгуулахын зэрэгцээ Дэлгэр сумын Гуулингийн мод үржүүлэгийн газрыг сэргээн ашиглах, замаар аймгийн хэмжээнд шаардагдах суулгацыг бэлтгэх, системүүдийн хамгаалалтын зурвас байгуулах боломжтой гэж үзэж байна. Цаашид хөрш зэргэлдээх орнуудаас говь, цөлийн бүсэд ургах чадвартай, өсөлт хөгжилт сайтай мод буцыг сонгон авч нутагшуулан үржүүлэх шаардлагатай юм.

БНХАУ-ын говь-цөлийн бүсэд “ногоон хэрэм” байгуулсан туршлагыг судалж авч хэрэгжүүлэх талаар санаачлагатай ажиллахыг зөвлөж байна.

III.5 УСАН САНГИЙН ГАЗРЫН НӨӨЦ, НӨХЦЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Тус аймгийн усны сангийн ангиллын газрын төлөвлөлтийн талаар МУ-ын ГЗБ ерөнхий төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсаныг товч авч үзье. Сүүлийн жилүүдэд нефтийн бүтээгдэхүүний үнэ хурдацтай өсөж байгаа нь эрчим хүчний төвлөрсөн хангамжаас алслагдсан аймгуудад хүндрэл бэрхшээл учруулах боллоо. Монгол улс эрчим хүчний салбартаа бүтцийн өөрчлөлт хийж хөдөө орон нутагт байгалийн сэргээгдэх эрчим хүчийг (ус, нар, салхи) ашиглах талаар нааштай алхамууд, анхны эхлэл тавигдаж байна. Ялангуяа өндөр уул, усны нөөц бүхий баруун бүсийн аймгуудад энэ ажил урагштай явагдаж байна.

Говь-Алтай аймгийн Бугат суманд салхины эрчим хүчийг ашиглах талаар судалгаа шинжилгээ ажил хийгдэж байна. Мөн Тайширын Улаанбоомд Завхан гол дээр усан цахилгаан станц барих ажил эрчимтэй явагдаж байна. Цаашид тус аймгийн Бугат сумын Бижийн гол, Цогт сумын Төгрөгийн гол дээр усан цахилгаан станц барихаар төлөвлөжээ.

Хүснэгт 73

Говь-Алтай аймагт одоо ашиглагдаж байгаа болон цаашид баригдах усан цахилгаан станцууд

№	Сумын нэр	Голын нэр	Солбилц-лын цэг	УЦС-ын одоогийн хүчин чадал	Хүчин чадал кВт	УЦС одоогийн байдал /га/	Нийт эзэмших газрын талбай /га/	Ашиглалтанд орох он		
								2006-2010	2011-2015	2016-2020
1	Тайшир	Завхан	x=96,5664 y=46,7167	-	18000	-	1098	1098		
2	Бугат	Биж	x=93,94,96 y=45,5997	-	60	-	452			452
3	Цогт	Төгрөг	x=96,5331 y=45,3165	-	90	-	66.8		668	
4	Дэлгэр	Гуулин	x=97,3333 y=46,5999	400	-	2160	-			
	Дүн			400	18150	2160	2218	1098.0	668	452

Хүснэгтээс харахад анх тус аймгийн Дэлгэр сумын Гуулингийн услалтын системийн гол суваг дээр ус авах барилгаас доош 2 км зайд 2001 онд Гуулингийн усан цахилгаан станц барьж ашиглалтанд оруулжээ. Тайшир сумын Улаанбоомын усан цахилгаан станцын барилгын ажлыг 2005 онд эхэлсэн бөгөөд 2007 онд ашиглалтанд өгөх юм. Цаашид Биж, Төгрөгийн гол дээр бага хүчин чадалтай усан цахилгаан станц барих болно. Эдгээр усан цахилгаан станцын суурилагдах, шинээр эзэмших нийт хүчин чадал нь 18150 кВт бөгөөд шинээр эзэмших талбай 9382 га байхаар тооцсон болно.

МУ-ын ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөнд баруун болон төвийн бүсийн аймгуудын зарим услалтын системүүдийг эхний ээлжинд шинэчлэн засварлахад улсын төсвөөс хөрөнгө оруулалт хийх, гадаад дотоодын тусламж зээлийн хүрээнд хамруулахаар заасан бөгөөд үүнд тус аймгийн Гуулин, Хүрхрээ, Шугуй, Хаяа, Ёлтон

зэрэг системүүдийг нэр цохон дурьджээ. Иймд услалтын системүүдийн одоогийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашдын зорилгыг тодорхойлох судалгааны ажлыг ойрын үед явуулах нь зүйтэй байна.

III.6 БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ БА ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

III.6.1 Газрыг тусгай хамгаалалтанд авах үндэслэл

Бид хангай дэлхийгээ хайрлан хамгаалж, түүний өгөөж, буяныг сүсэглэн хүндэтгэдгээрээ дэлхийд хосгүй уламжлалтай.

Сүүлийн үед уур амьсгалын дулаарал, цөлжилт, элсний нүүдэл, хуурайшилт, хүчит салхи, шуурга зэрэг байгалийн сөрөг үзэгдлүүдийн давтамж жил ирэх тусам нэмэгдэж, үүний улмаас нийгэм эдийн засгийн хөгжилд багагүй хохирол үзүүлж байна.

Биологийн төрөл зүйлийг хамгаалах асуудал бол байгаль орчныг хамгаалах арга хэмжээ төдийгүй, амьд байгалийн оршин тогтнох үндэс мөн.

Хүснэгт 74

Тусгай хамгаалалтай газар нутгийн орон зайн сүлжээг бүрдүүлэхэд харгалзах шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлтүүд	Дархан цаазат газар	Байгалийн цогцолборт газар	Байгалийн нөөц газар	Дурсгалт газар
Байгалийн муж, бүс бүслүүрийн төлөөлөл	+	+	+	
Экосистемийн төлөөлөл	+	+	+	
Шинжлэх ухааны ач холбогдол	+	+	+	+
Өвөрмөц ховор, үзэсгэлэнт байдал		+	+	+
Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан систем	+	+	+	
Доройтолд орсон экосистем	+			
Дэлхийн хэмжээнд ховор тохиолдох боловч Монгол оронд хамгийн түгээмэл тархсан экосистем	+		+	
Дэлхийн хэмжээнд элбэг тархацтай боловч Монгол оронд ховор тархалттай экосистем	+		+	
Амьдрах орчны хязгаарын нөхцөлд оршин ядаж буй үлдвэр экосистем	+		+	
Түүхийн үнэт дурсгал		+		+
Нийгэм-Эдийн засгийн ач холбогдол	+	+	+	
Орон нутаг, ард түмний санал	+	+	+	+

Гол мөрний урсац бүрэлдэх бүс

Уур амьсгалын үндсэн үзүүлэлт нь газрын гадаргын чийг дулааны балансыг тодорхойлох учир усны балансын элементүүдийн тархац нь физик газар зүйн ерөнхий зүй тогтол, байгалийн бүсийн шинж төрхийг хадгална. Энэхүү ерөнхий зүй тогтол дээр уулархаг бүс нутагт өндрийн бүс бүслүүр нөлөөлөх бөгөөд аль ч уулархаг нутгийн чийгшлийн байдал нь агаарын чийгийн зонхилох урсгалыг тоссон уулын хажуугын чиглэл, уул нуруудын өндөр нам, геологийн тогтоц, ургамлын бүрхэвч

зэрэг олон хүчин зүйлээс хамаарна. Энэхүү газарзүйн, уур амьсгалын хүчин зүйлсийн нөлөөг агуулах интеграл үзүүлэлт бол голын сав газрын дундаж өндөр юм. Иймд голын сав газрын дундаж өндөр ба урсацын модуль хоорондын хамаарлыг тогтоох үндсэн дээр гол мөрний урсацын тархацыг бүсчлэн тогтоож болно. Хур тундасны хуваарилалтын онцлог, уул зүйн байршил, гадаргын урсац бүрэлдэх хүчин зүйлст үндэслэн урсацын өндрийн хамаарлаар нь Монгол орны нутгийг дараах 15 муж болгон хувааснаас Говь-Алтай аймагт:

1. Монгол Алтайн нурууны арын голуудын сав
2. Монгол Алтайн нурууны өврийн голуудын сав
3. Говь-Алтай нуруунаас усжих голуудын сав газрууд хамрагдана.

Усны экосистемийн шалгуур үзүүлэлтүүд

1. Усны экосистемийн чанар, амьтан ургамлын иж бүрдэл, байгалийн цогцолбор газар, дархан газар, бусад хамгаалалттай газруудтай хоорондоо холбоотой байна.
2. Усны экосистемийн нэн ховор, ховор амьтан ургамлын популяцтай эсэхийг харгалзан үзэж сонгоно.
3. Усны экосистемийн эртний амьтан ургамлын ховор популяцийн удмын санг хамгаалах
4. Хэт доройтсон, бохирдсон экосистемийг сэргээх хамгаалах заргээр шалгуур тогтоох нь зүйтэй юм. Экосистемийн ерөнхий түвшинг үнэлэхэд биологийн шалгуурыг ашигладаг.

Экологийн хязгаарлалт хийх шаардлага

Байгалийн иж бүрдэл тогтолцоо, өвөрмөц онгон төрх байдал, тэнд нутагшсан ховор нандин устаж алга болж болзошгүй биологийн төрөл зүйл, тэдгээрийн биологийн нөөц, төлөв байдал, хүн төрөлхтний үүсэл хөгжлийн явцад газарт шингэсэн мэдээ мэдээлэл, эртний соёл иргэншлийн түүхэн дурсгалт газруудыг хадгалан хамгаалах, тэрчлэн газар нутгийн өөрөө өөрийгөө цэвэршүүлэх, өөрийгөө зохицуулах дотоод чадавхитай байдаг.

Орчин үед газар төлөвлөлтийн хүрээнд тухайн газар нутаг дахь өөрийнх нь экологийн эмзэг байдлыг харгалзан, үйл ажиллагааны хязгаарлалт хийх асуудал чухлаар тавигдаж байна. Иймд газрын хязгаарлах нөхцөл болох өндөрлөг газар, үерийн зам газар, налуу газар, тогтвор муутай хөрстэй газар, ус шингээх чадвар муутай газар зэргүүдийг төлөвлөлтөд харгалзах шаардлагатай.

Өндөрлөг газар. Далайн түвшнээс дээш харьцангуй өндөрт өргөгдсөн ширүүн уур амьсгалтай, хөрс нь нимгэн, ургамал тарчиг, гүний хэрчигдэл болон ташлан ихтэй, эрт хүйтэрч хожуу дулаарах, цасан бүрхүүл удаан тогтдог зэрэг нь өндөрлөг газрын

онцлог юм. Монгол орны нөхцөлд өндөрлөг газарт уулархаг нутгийн бэсрэг уулын дээд хэсэг өндөр уулын дундаас дээш хэсэг ихэвчлэн багтдаг. Өндөрлөг газар ихэвчлэн далайн түвшнээс дээш 2000-2500 метр өндөрт байрласан байдаг. Өндөрлөг газарт аж ахуйн үйл ажиллагаа байнга явуулах, тогтмол, ашиглах барилга байгууламж барих зэрэг нь тохиромжгүй бөгөөд бэлчээрийн мал аж ахуйд хязгаарлагдмал хүрээнд тодорхой хугацааны дотор ашигладаг. Өндөрлөг газар өөрийн ландшафтын тогтолцоо, үзэсгэлэнт сүрлэг байдал зэргээрээ орчноосоо тод ялгарч байдаг тул экологийн аялал жуулчлалын хэлбэрээр ашиглаж боломжтой.

Үерийн зам газар. Үерийн усны зам дээр байнгын орон сууц барих, эсвэл аливаа бохирдуулагч бодис материал ашиглах, үйлдвэрлэл явуулах нь хүний эрүүл мэндийг хохироох, байгаль орчныг бохирдуулах аюултай нөхцлийг бүрдүүлдэг. 100 жилийн давтамжтай үерт нэрвэгддэг газарт орон сууц, үйлдвэрлэл худалдааны зориулалттай барилга барьж ашиглах ёсгүй. 10 жилийн давтамжтай үерт нэрвэгддэг газрыг онгон төрхөөр нь үлдээх буюу сэргээж, ургамал амьтан орших орчин ногоон зурвас, нийтийн амралт зугаалга, загас барих газар болгон хамгаалах нь зүйтэй. Ийм хөрстэй газар нутгийг малын бэлчээрт бага зэрэг ашиглаж болох боловч газар хамгаалах, хашаа барих зэргээр ашиглахгүй байх нь чухал. Мөн химийн аливаа бордоо хэрэглэхгүй байвал зохино.

Налуу газар. Газрын налуу ихсэх тутам барилга байгууламж барих нөхцөл хүндэрч, газар усанд идэгдэн эвдрэх, ус булингартах, лагшрах зэрэг сөрөг нөхцөл ихэсдэг.

Тухайлбал: 30 % /17 хэм/ болон түүнээс дээш налуутай газар амархан элэгдэж эвдрэх ба ашиглах боломжоор тун хязгаарлагдмал: 9 % /5 хэм/-иас 30 % /17 хэм/ хүртэлх налуутай газар дунд зэргийн хүндрэлтэй байдаг тул мод бэлтгэх, цөөн тооны барилга байхаар хязгаарлана. Иймд сайтар боловсруулсан төслөөр барилга барих журмыг мөрдөх ёстой. 15% /9 хэм/-иас илүү налуутай газрыг барилга байгууламжинд ашиглахаас зайлсхийх бөгөөд зам барих ажлыг маш анхааралтай хийх учиртай. 30 % /17 хэм/ -иас илүү налуутай газарт зам тавих боломжгүй зэрэг журмууд бий.

Хөрсний тогтвортой байдал, ус шингээх чадавхи:

Хөрсний тогтвортой байдал ба тэдгээрийн эвдрэх хандлага, сав нутгийн усны нөөц, тунадас ба хагшаасаас шалгаална. Инженер техникийн аргаар газрын эвдрэлийг багасгаж болох боловч хөрс тогтворгүй болох тул ашиг нь багасаж зардал нь ихэсдэг.

Салхинд туугдсан элснээс бүрдсэн хөрс усанд хурдан элэгдэх онцлогтой тул 5 % /3 хэм/-иас лүү налуутайгаар тариалан эрхлэх нь зохисгүй. Ус шингээх чадавхи муу байдаг нь хөрсний бүтцээс буюу хатаах явцыг удаашруулагч ямар нэгэн бодис хөрсөнд буюу хөрсний доор байгаагаас шалгаалдаг.

Мөнх цэвдэгтэй байн байн үерт автагддаг, ус муу шингээдэг нойтон шаварлаг хөрс нь улирлын чанартай агшиж тэлэх тул барилгын суурь хоолой хагарах, зам эвдрэхэд хүрдэг нь тул барилга байгууламж барихад тохиромжгүй.

Эрэг орчмын усны бүс. Гол горхи нуур, тойрмын усны эрэг болон гүн хэсгийн хооронд байнгын хөдөлгөөнтэй солилцоо зурвас хэсэг байдаг. Гол горхи, нуур тойрмын эрэг хөвөө дагуу хэсэг зурвас газар нь экологийн хувьд онцгой ач холбогдолтой бүс байдаг. Ийм бүсийн зурвас орчмыг усны бүс гэх бөгөөд усны болон хуурай газрын биологийн төрөл зүйлийн хувьд харьцангуй баян хэсэг юм.

Усны хөвөө, эрэг орчмын газар, гол горхи, нуур тойром, суваг шуудуу зэрэг байнгын юмуу, түр зуурын урсгалтай тогтмол устай ч байнга сэлбэгдэж байдаг. Гадаргуугын ус бүхий газрын тодорхой хэсэг нь эх газар буюу хуурай газрын экологийн тогтолцоо, түүний бүрэлдэхүүний орчинд сэлгээний системийн үүрэг гүйцэтгэдэг байна. Иймээс газар бүсчлэлийн асуудалд усны эрэг, хөвөө орчмын газар гэдэг бичил бүсийг харгалзан үзэх нь арга зүйн өндөр ач холбогдолтой юм. Урсгал ус нь чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд усны ургамал амьтны оршин амьдрах орчин, хүнс тэжээлийнх нь агуулга болдог.

Тэрчлэн усны ай сав, усан хагалбарын доторхи газар нутгаас угаагдсан туугдас нь биогеохимийн элементүүд усны хөвөө газарт тогтох ба зарим хэсэг уст цэгүүдэд орж улмаар усны болон усны хөвөө газрын биологийн төрл зүйлсийн хүнс тэжээл, амьдрах орчинг баяжуулж, ус сэлгэх явцад найрлага төрөл тоо хэмжээ нь зохицуулагдаж байдаг. Усны хөвөө газар нь зэрлэг ан амьтан, мал сүрэг усанд орох сэрүүцэх үедээ түр саатан тогтох нутаг болдог. Тэрчлэн бэлчээрийн мал аж ахуйн нөхцөл дулааны улирлын нутгийн гол цөм нь болдог онцлогтой. Усны хөвөө газрын ашиглалтын хэлбэр ашиглалтын горим, ялангуяа ургамалжилт нь нуур тойром, гол горхины усны урсгал болон ус сэлгэх чадавхи усны чанар найрлагад нөлөөлдөг бол усны урсгал, ус сэлгэх чадавхи хэлбэр маяг нь усны хөвөө газрын биологийн төрөл зүйлийн нэр төрөл, тоо хэмжээ ялангуяа ургамлын бүрэлдэхүүн, ургамлан нөмрөгийн хэв шинж бүрэлдэхүүн чанар зэрэгт нөлөөлдөг.

Газар бүсчлэлийн бодлогод усны хөвөө газрын хөрс, ургамлын нөмрөг ландшафтын тогтолцоог аж ахуйн эргэлтэнд хэрхэн ямар хэмжээгээр оруулах, яаж хадгалан хамгаалах асуудал гол байр эзэлдэг.

Усархаг чийглэг газар. Газрын экологид чухал зохицуулагчийн үүрэг гүйцэтгэдэг бүс нь усархаг чийглэг газар юм. Усархаг чийглэг газар нь намаг, балчиг шалбааг довонтой зүлэг, бүрд зэрэг хэлбэрээр бидэнд танигдаж байдаг. Усархаг чийглэг газар байгалийн ус шүүгдэж цэвэрших, үерийн үед элдэв механик хольц гол горхи, нуурын ус, усан санд орох боломжийг бууруулах, үерийн усыг боож тогтоох,

өөртөө шингээх зэрэг ус зохицуулах үүрэг гүйцэтгэдэг. Усархаг чийглэг газар нь бие бүтээмжийн хувьд өндөр ургамлын тусгац, бүрхэвч ихтэй, гол төлөв үндсээр үржигч чийглэг ургамал ургадаг зэрэг онцлогтой тул антропоген ачааллыг даах чадвар сайтай байдаг.

Газар бүсчлэлийн бодлогод усархаг чийглэг газрын экологийн нэгэн бүс болгон авч үзэж ашиглах нь экологи, социал болон эдийн засгийн зэрэг олон талын ач холбогдолтой байдаг. Үүний жишээ нь усны шувуу олноор амьдардаг орчны тухай олон улсын Рамасарын конвенци юм. Энэ конвенцид нэгдсэн орон олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газрыг хамгаалх үүрэг хүлээдэг. Эх газрын усархаг чийглэг газар 6 метр хүртэл гүнтэй давсархаг нуур ч энэ конвенцийн заалтад багтдаг. Манай орон 1997 онд энэ конвенцид нэгдэн орсон байна.

Усны эх газар. Гол горхи эхээ авсан болон булаг шандын тархи зэрэг өөрийн орчин тойрны экологийн тэнцвэр болон өөрөөсөө доод хэсгийн ургамал амьтны нутагшил гол горхи, нуурын усны горим зэрэгт шууд нөлөөлж байдаг газрыг усны эх газар гэх бөгөөд усны эх газрыг тусгайлан авч үзэж менежментийг хэрэгжүүлэх нь гадаргуугийн болон гүний усны нөөц, хөрсний чийгшлийн горим зэрэгт шууд нөлөөтэйгээр барахгүй аж ахуйн өндөр ач холбогдолтой байдаг.

Биологийн төрөл зүйлийг хамгаалах ажлыг зөвхөн тусгай хамгаалалттай газар нутгийн хүрээгээр хязгаарлаж болохгүй юм. Улс орны нутаг дэвсгэрийн дийлэнх хэсэг нь тусгай хамгаалалттай газар нутгийн гадна орших учир тэнд хүрээлэн буй байгаль орчинд сөрөг нөлөө бүхий үйл ажиллагааг хянаж байх нь чухал байдаг.

Тусгай хамгаалалттай газар нутгуудад тархсан төрөл зүйлүүдийг хамгаалах нэн чухал ажлаас гадна зарим нэг төрөл зүйлийг хаана тархалттай байхаас үл хамааран хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Хорьдугаар зууны эхэн үед агнуурын нөөц баялаг бараг унаган төрхөөрөө байлаа. Тавиад оны дундуур тахь адуу, соргог бөхөн, 70-аад онд шарнад цөөвөр чоно үзэгдэхээ больж үндсэндээ устав. Мазаалай, Баавгай, хавтгай, тэмээ, Монгол бөхөн зэрэг нэлээд үйл ховордож устах аюул тулгарсан юм. Бас өргөн дэлгэр тархацтэй элбэг байсан нэлээд зүйл амьтны тархац дэлхэц багасах, эсвэл тасархайтан цоохортох, тоо толгой нь цөөрөх үзэгдэл гарч байна.

Ан агнуурын тухай хууль тодорхой хэдэн зүйлийг бүрэн хамгаалах, бусад зүйлийг агнах, барих зөвшөөрөл олгох төлбөр авах, ан агнахыг хориглосон хугацаа тогтоох, хориглох арга, хэрэгсэл зэргийг зохицуулжээ. Мөн хуулиар ан амьтныг өмчлөх, тэжээвэр болгох зэргийн үйл ажиллагааг зохицуулсан.

Уг хуулиар ан амьтдыг дараахи гурван ангилалд хуваажээ:

Нэн ховор зүйл: 11 зүйл хөхтөн, 6 зүйл шувуу, 2 зүйл загас ордог. Тэрээр амьтдыг агнах, барих, тэдгээрийн барьж, бусдад худалдахыг хориглосон. Зөвхөн судалгаа, шинжилгээний зориулалтаар агнах, барих зөвшөөрлийг Байгаль орчны яам онцгой тохиолдолд олгодог. Энэ зэрэглэлд эмзэг, хязгаарлагдмал тархацтай, устах аюул нүүрлэсэн ашиглах нөөцгүй амьтад ордог.

Ховор зүйл: Тархац, тооны хувьд хязгаарлагдмал, устах аюул нүүрлэж болзошгүй 12 зүйлийн хөхтөн, 22 зүйлийн загас орно. Эдгээр амьтдыг шинжилгээ судалгаа, соёл, урлагийн болон бусад тусгай зориулалтаар зөвхөн Байгаль орчны яамны зөвшөөрөлтэйгээр зохих төлбөр төлсөн нөхцөлд агнах, барихыг зөвшөөрдөг.

Элбэг зүйл: Энд түгээмэл тархацтай амьтад орно.

Тархац нутаг нь хумигдаж улсын хамгаалалтанд авах амьтдын нэрс:

1. Цоохондой мий
2. Цоохор ирвэс
3. Эрээн хүрэн
4. Мазаалай баавгай
5. Төгс ятуу
6. Монгол хулан
7. Хавтгай тэмээ
8. Монгол бөхөн
9. Хар сүүлт
10. Аргаль
11. Янгир
12. Таван хуруут атигдаахай
13. Сухайн чичүүл

Шинээр нутагшсан амьтад

1. Тахь адуу

Цаашид өргөтгөн тоо толгой олонтой байгаад ховордсон амьтдыг нутагшуулах, тархац, нутгийн хүрээнд хамгаалах, тоо толгойг өсгөх ажлыг зохион байгуулах хэрэгтэй.

Ургамлын нөөц: Монгол улсын “Байгалийн ургамлын тухай хууль”-иар хэдийгээр зохих шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хязгаарлалтын хил заагийг нь тогтоогоогүй боловч үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал, түүх, ашиглахыг хориглосон бүсэд доорхи онцлог газар нутгийг хамруулдаг. Үүнд:

Хамгаалалтын бүсүүд

1. Нэн ховор ургамлын тархсан нутаг
2. Ургамлын бүрхэвч нь талхлагдсан нутаг

3. Элсний нүүлтээс хамгаалах ач холбогдол бүхий газар
4. Хөрсний элэгдэлээс хамгаалах зурвас газар зэрэг болно.

Үүний зэрэгцээ үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүхийг хориглосон ч ховордсон амьтны оршин амьдрах нутагт мал бэлчээрлүүлэхийг зөвшөөрч байгаа нь ургамлыг хамгаалах зорилготой зөрчилдөж байна.

Сүүлийн жилүүдэд эмийн зарим ургамлын ашиглалт нэмэгдэх хандлагатай боллоо. Нийт ашигт ургамлын 30-40 % нь ховор ховордсон ургамал байгаагийн дээр ихэнхид нь нөөц, нөхөн сэргээлт, орчин зүйн судалгааны материал хомс байгаа явдал, ургамлын ашиглалтанд анхаарал болгоомжтой хандах шаардлагыг зүй ёсоор төрүүлж байна. Ийм учраас аймгаас ургамал ашиглах зөвшөөрөл олгохдоо үндсэн чиглэлийн судалгаа хийдэг байгууллагаас урьдчилсан санал авдаг болох нь зүйтэй юм.

Харьцангуй их талбайд, харьцангуй цөөн төрөл зүйлүүд, нэн хязгаарлагдмал нөхцөлд оршдог.

Бид биологийн аливаа зүйлийг устаж үгүй болж байгаа тэр үзэгдлийн нь хувьд үнэлэхдээ дан ганц тооны хомсдол гэж огт болохгүй. Энэ бол амьд ертөнцийн тогтолцооны түүхэн хөгжлийн явцад тогтоосон холбоог тасдаж, тэр нь яваандаа нийт орчин зүйн тэнцвэрийг алдагдуулан, улмаар урьдчилан хэлэх аргагүй хохиролд хүргэх нөхцөл болдог талаас нь юуны өмнө харах ёстой. Иймээс хүний нийгмийн оршин тогтнох гол нөхцөл болсон биологийн нөөц баялагт онцгой ариг гамтай хандах шаардлага юу юунаас хурцаар тавигдах нь зүй ёсны хэрэг юм.

Хэт талхлагдалд өртөж доройтсон ургамлын нөөц, нөхөн сэргээлтийг эргүүлэн сайжруулахад ашиглалтыг зохистой болгох юмуу, тодорхой хугацаагаар хориглох явдал зохих үр дүнгээ өгдөг нь заган ойн байдлаас тодорхой харагдаж байна. Тухайлбал: 50 жилийн хугацаанд нөөцийн 60 % үгүй болсон Шаргын говь, Эртний нууруудын хөндийн загийн нөөц ашиглалтыг зогсоосноос хойшхи 15 орчим жилд талбайн хувьд эргэн сэргээд зогсохгүй, нөөц нь зохих хэмжээгээр нэмэгджээ. Энэчлэн хот суурингийн болон уст цэгийн орчим бэлчээрийн зорилгоор ургамлыг хэт ашигласнаас гарсан хохирлыг дээрхи аргаар эргүүлэн сэргээж болох нь удаан жил бэлчээрт ашигласан замын дагуух ургамлын бүтэц, бүрэлдэхүүний байдлаас тодорхой харагдаж байна. Гэхдээ энэ нь цаг хугацаа их орох учир ургамлын баялгийг хүний идэвхитэй үйл ажиллагаагаар тодорхой зүйл болон тодорхой нутгийн ургамлын эргүүлэн сэргээх явдал нэгэн адил ач тустай болох нь мэдээж. Үүний тулд юуны өмнө орчиндоо тодорхойлох үүрэг бүхий модлог, бутлаг ургамлыг нэн тэргүүнээ анхаарах шаардлагатай юм. Энэ байдлыг заг, тоорой, жигд, сухай, хайлаас,

чацаргана, буйлс, улиас бургас, харгана зэргийг тариалан туршсан үр дүн харуулж байна.

Ийм учраас ялангуяа хуурай уур амьсгал бүхий нутагт модлог, бутлаг ургамлын томоохон зурвас байгуулах талаар хүч анхаарал тавих юм бол нэгэнт гарсан өөрчлөлтийг эргүүлэн сэргээх төдийгүй орчны тогтолцоог ихээхэн сайжруулах боломжтой юм.

Тусгай хамгаалалттай газрыг хамгаалах асуудлыг авч үзэхдээ тухайн орон нутгийн ургамлын аймгийн өвөрмөц төрх байдлыг авч үзэх шаардлагатай юм. Иймд тусгай хамгаалалттай газрыг сонгон авахдаа ургамлын асуудлыг нэг гол шалгуур болгон авч үзэх нь зүйтэй.

1. Унаган, завсрын унаган, нэн ховор, ховор ургамлын тархалтыг харгалзан үзэх
1. Ургамалжилтын өвөрмөц төрхийг үзүүлэх эвшил, хэвшил буюу ургамалжилтын бүлгэмдэл
2. Хил зэргэлдээх нутаг оронд тохиолдох боловч ховордсон, тасархай тархацтай ургамлуудыг анхаарах
3. Аж ахуйн үйл ажиллагаанд эрчимтэй ашигласнаас эрс ховордож байгаа ашигт ургамлын зүйлүүдийг харгалзан үзэх нь зүйтэй.

Түүхийн дурсгалт газар

Манай орны нутаг дэвсгэр дээр байдаг олон тооны түүх, соёлын дурсгалуудыг хамгаалах нь зөвхөн манай иргэдийн хойч үедээ үлдээх хариуцлагаар зогсохгүй, нийт хүн төрлөхтний түүхийн өмнө хүлээсэн үүрэг юм.

Эдгээр дурсгалуудыг хамгаалахад хөнөөлийн голлох хоёр хүчин зүйлийг анхаарч үзэх нь зүйтэй. Хамгийн их хөнөөл хүргэж болох нь хүний хүчин зүй бөгөөд балгас, суурины үлдэгдэл, булш, бунхан, хөшөөний чулуу бүрдүүлэгч зүйлсийг хашаа байшин болон бусад байгууламжид хоёрдогч түүхий эд болгон ашиглахаас сэргийлэх шаардлагатай юм. Мөн тээврийн хэрэгсэл, хүний хөлөөр дурсгалууд хуучин хэв дүрсээ алдаж тарах, ашигт малтмал олборлох газар тариалан эрхлэх, барилга байгууламж барих үед гарах сүйтгэл зэргээс сэргийлэн хамгаалах нь зүйтэй юм. Нөгөө хөнөөл нь агаарын температурын хэлбэлзэл, бороо, ус салхи зэрэг байгалийн болзошгүй гамшиг байх тул эдгээрээс хамгаалах мөн л зайлшгүй шаардлагатай юм.

III.6.2 Тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт

Хүн амын хурдан өсөлт, эрчимтэй тэлэн өргөжиж, хүн амын бараг тэн хагас нь хот тосгонд бөөгнөрөн суурьших болсон зэрэг нь дэлхийн хэмжээнд газрын хэрэгцээг эрс ихэсгэснээс гадна онгон болон унаган байдлаараа байгаа нь хүмүүст сэтгэл зүйн таашаал өгөх үзэсгэлэнт болон цэвэр ариун газар ус улам бүр багасч, газрын нөөц

хомсдон улмаар биологийн төрөл зүйл цөөрөх, ядуурах, устаж алга болох үндсэн шалтгаан болж байна. Энэ нь газар нутгийг тусгай хамгаалалтад авах хэлбэрээр дэлхий нийтээрээ унаган байгалийг хадгалан хамгаалах нөхцөлд хүргэсэн билээ.

Газар нутгийг өргөн хүрээгээр хадгалан хамгаалах замаар экологийн тэнцвэрийг хангах, биологийн төрөл зүйлийг устаж алга болох аюулаас хамгаалах, байгалийн онгон унаган төрх, түүнийг дагалдсан баялагийг хүний сайн сайхны төлөө зориулах эрхэм зорилгыг хэрэгжүүлэх үндсэн арга нь шинжлэх ухааны үндэслэлтэй тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ байгуулах явдал юм.

Газар нутгийг тусгай хамгаалалтад авах аргыг өргөн хэрэглэх нь байгаль цаг уурын хуурай, өндөрлөг, хүйтэн сэрүүн нөхцөлд бүрэлдэн буй болсон шим мандлын чадавхи дорой, гадны ачаалалд тэсвэр муу, нөхөн төлжих, сэргээх чадвараар сул газрын бүрхэвч бүхий манай орны хувьд газар нутгаар дамжуулан байгаль, экологийн тэнцвэрийг хадгалахад голлох үүрэг гүйцэтгэнэ.

Монголчууд ан амьтан, ургамал, байгаль, орчноо хамгаалах өнө эртний баялаг түүхтэй билээ. Эрт 13-р зууны (Италийн жуулчин Марко Поло Монгол оронд аялж байсан) үед туулай, буга, согоо, бөхөн, зээр агнах тусгай тогтсон хугацаатай байсан ба Эртний халх журам /1709-1799/ хуулийн дагуу 16 уулийг дархлан тэдгээрт ан гөрөө хийх, газар хагалах, мод бэлтгэх үйл ажилагаа хориглож байжээ. Богд хан уулыг анх 12-13 зууны үед дархлан хамгаалж байсан түүхийн улбаа бий бөгөөд бидний үе хүртэл хамгаалагдан үлдсэн түүх, сурвалж, албан баримтаас үзвэл 1778 онд Монголын анхны албан ёсны дархан цаазат газар болгосон байна. Үүнээс хойш 1957 онд 2, 1965 онд 5, газрыг, 1976 онд говийн их дархан цаазат газрыг тусгайлан хамгаалахаар албан ёсоор шийдвэрлэж байжээ.

Манай улс 1990 оныг хүртэл газар нутгийг тусгай хамгаалалтад авах асуудлыг дан ганц дархан цаазат газрын хэлбэрээр авч байсан бөгөөд 1993 оноос Байгаль Хамгаалах Олон Улсын Холбоо, Дэлхийн Байгаль Хамгаалах Мониторингийн Төвөөс хамтран тогтоосон ангиллыг өөрийн орны онцлогт тохируулан Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар гэсэн ангилалд хамруулжээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний үнэлгээний шалгуур арга зүй, индикатарууд

Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг үнэлэх нь шаардагдах хүчийн зүйлийн мэдээ мэдээллийг /индикаторыг/ сонгох, үнэлгээний шалгуурыг сонгох, үнэлгээ хийх арга зүйг сонгох зэрэг асуудлаас ихээхэн шалгаална.

Шинжлэх ухааны экспертүүд

- Экосистем, байгалийн бүс бүслүүрийн төлөөлөл

- Дэлхийн хэмжээнд ховор тохиолдох боловч Монгол оронд хамгийн түгээмэл тархсан өвөрмөц экосистем
- Амьдрах орчинд хязгаарын нөхцөлд оршин ядаж буй үлдвэр экосистем
- Байгалийн мужийн төлөөлөл
- Өвөрмөц тогтоц, үзэсгэлэнт байдал /ландшафт, геологи, геоморфлогийн онцлог, байгалийн иж бүрдлийн хослол
- Унаган төрхөө хадгалсан байдал
- Биологийн төрөл зүйлийг хамгаалах шаардлага /Ой, ургамлын нэн ховор, унаган үлдвэр төрөл зүйл ховор ховордсон амьтан, ургамлын удмын санг хамгаалах шаардлага/
- Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол
- Нийгэм эдийн засгийн ач холбогдол /улс орон, бүс нутгийн эдийн засаг, орчны нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө/
- Аж ахуйн үйл ажиллагааны нөлөөлөл /Аж ахуйн үйл ажиллагаанд байнга болон улирлын чанартай автагддаг байдал хэтийн төлөв/
- Орон нутаг ард иргэдийн санал

Зонхилох хүчин зүйл. Газар нутгийн хэмжээнд зонхилох хүчин зүйл нь экосистемүүдийн горимыг бүрдүүлж буй ургамал ба уулын экосистем юм. Энэ хоёр хүчин зүйл тус тусдаа болон хосолсон хэлбэрээр аль аль нь байгаа бөгөөд гол төлөв өөрийн болон түүний нөлөөн доор бусад экосистемүүд оршин тогтох, цаг агаар, чийгшил, хур тундасны хэвийн горим, байгалийн цэвэр усны буюу гол мөрний усан хангамж бүрдэх, дагаад амьтан ургамлын орших нөхцөл хангагдахын хувьд чухал ач холбогдолтой юм.

Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний үнэлгээнд зайлшгүй байх шалгуур үзүүлэлтүүдийг дараах хэдэн чиглэлээр авч үзсэн байна.

- Экосистемийн иж бүрдэл, ихээхэн хэмжээний талбайг эзэлсэн ойтой газар нутгийг хамгаалалтанд авах
- Ургах орчны хязгаарлалтын нөхцөлд ургаж ядан байгаа ой түүнд тохиолдох ховор бүлгэмдэл нь нэгэн илтгүүр болдог.
- Тухайн нутаг дэвсгэрт ургамлын бүлгэмдэл, хэв шинж нэн чухал үнэлэх илтгүүр болно.
- Эсвэл өөр улс оронд элбэг байдагч Монгол оронд ховор тохиолддог бүлгэмдэл, хэв шинж байвал онцгой анхаарч үзвэл зохино.
- Тухайн нутаг дэвсгэрт Монгол орон болон өөр газарт ховор болон нэн ховор тохиолддог мод, сөөг, өвслөг ургамал ургаж буй эсэхэд онцгой анхаарч үзэх

- Тухайн нутаг дэвсгэрт нэн ховор болон ховор жимс, жимсгэнийн, эмийн ба бусад ашигт ургамал байгаа эсэхэд анхаарах
- Тухайн нутаг дэвсгэрийн ургамалшилд үнэлгээ өгөхөд тухайн газар нутгийн чадавхаар нь биш зөвхөн өнөөдрийн оршин байгаа /актуальны/ ургамалжилтаар нь тооцох нь зүйтэй.

Мөн байгалийн нөөц баялагийн хувьд доройтсон газар нутагт нөхөн сэргээлтийн чиг хандлагыг зайлшгүй тооцож үзэх нь чухал. Доройтсон газрууд байгалийн аясаар нь хамгаалаад байвал тодорхой хугацааны дараа эргэж сэргэдэг зүй тогтол бий.

III.6.3 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, нөхцлийн төлөвлөлт

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн зэрэгцээ бага хэмжээтэй газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч түүний хамгаалалтыг орон нутгийн иргэд, малчдын идэвхи санаачилгын дэмжлэгтэйгээр хамгаалах нь байгаль эх нутгаа хайрлан хамгаалж ирсэн сайхан уламжлалтай манай орны хувьд дэвшилтэд арга юм.

Эх нутгаа гэсэн сэтгэлээр нутгийн иргэн бүхэн санаа тавих, эх оронч үзэл баримтлалтай байх, залуу хойч үеэ хүмүүжүүлэхэд дэм тусламж болно.

Нутгийн хүмүүсийн эрт дээр үеэс тахиж шүтэж ирсэн уламжлал бүхий 20 гаруй газрыг орон нутгийн хамгаалалтад авахаар төлөвлөв.

Нийт 567.8 мянган га талбай бүхий 22 газрыг орон нутгийн хамгаалалтад 2006 оноос эхлэн 2023 он хүртэл авч судалгаа, шинжилгээний ажил явуулах, сургуулийн сурагчдын байгаль экологийн мэдлэгийг дээшлүүлэх, түүний биологийн чадавхийг судлах, байгалийн нөөц баялагийг хадгалан хамгаалах ажлыг зохион байгуулах хэрэгтэй.

Хүснэгт 75

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, нөхцлийн төлөвлөлт

Д/д	Сумын нэр	Орон нутгийн тусгай хамгаалалтад	
		Газрын нэр	Талбайн хэмжээ /га/
1	Алтай	Баян цагаан	5974.869
		Халбат хайрхан	7573.643
		Аж богд	50188.129
2	Бугат	Алаг хайрхан	49374.187
3	Бигэр	Баян-Аараг	59124.765
4	Дарив	Сутай	3259.541
5	Дэлгэр	Лйн-Есен өнгөт	9955.391
		Зараа толгой	16252.916
		Хантайшир-Баянбуурал-Сэрх	73908.279
6	Есенбулаг	Баянхайрхан	19233.322
7	Жаргалан	Жаргалан уул	7503.637
8	Тайшир	Нарванчин уул	8791.034
9	Төгрөг	Очир хайрхан	14649.406
		Цагаан хайрхан	15941.626
		Шарга	46948.083
10	Халиун	Баян хайрхан	29176.553

		Хар азаргын нуруу	60398.261
11	Цээл	Их Таянгийн нуруу	51767.218
12	Чандмань	Хірээгийн энгэр	736.991
		Ботгоны гол	2817.46
		Хутаг нуур	5896.448
		Чандмань уул	11619.181
		Самдан Дамбын нуруу	13450.517
13	Тонхил	Сутай	3259.541
	Дүн		567800.998

III.6.4 Аялал жуулчлал, хүн амын байгалийн экологийн нөхөн сэргээлтийн бүсийн төлөвлөлт

Говь-Алтай аймаг 14144.8 мянган га нутагтай 66489 хүн амтай, 2 сая толгой малтай, баян бүрдүүдэд газар тариалан хөгжсөн төмс, хүнсний ногоо үр тариа, малын тэжээл тариалж байна. Алтай хот нь Улаанбаатар хотоос 1001км зайд оршдог онгоцоор 2 цаг нисэж хүрнэ. Говь-Алтай аймгийн дундуур Монгол Алтайн нуруу үргэлжилнэ. Сутай, Хар Азарга, Бурхан буудай, Хасагт хайрхан зэрэг 3000-4000 м өндөр уул нуруудтай. Алтай хотод агаарын жилийн дундаж температур нь -1.8 хэм, 1-р сарынх -18.9 хэм 7-р сарынх 1.4 хэм, жилд дунджаар 176.9 мм тунадас унана. Агаарын даралт 780 гПа байна. Салхины жилийн дундаж хурд 3.3 м/сек бөгөөд хамгийн их салхитай 5-р сард 4.4 м/сек байна. Нутгийн үлэмж хэсгийг говь, цөл эзлэх бөгөөд хойд хэсгээр Завхан гол урсана.

Алтай хотын цахилгааны хэрэгцээг дизель станцаар хангадаг бөгөөд Завхан гол дээр 12 МВт-ын хүчин чадалтай Улаанбоомын усан цахилгаан станцыг барьж Алтай хот хүртэл 35 кВ-ын 47 км шугам барьсан бөгөөд Улиастай хот руу 110 кВ-ын 113.7 км шугам барьж Завхан, Говь-Алтай аймгийг холбосон цахилгаан эрчим хүчний систем байгуулахаар төлөвлөгдөж байна.

Улсын дэд бүтцийн босоо тэнхлэгийн авто замаар хойшоо Улиастай хоттой холбогдож урагшаа Бургастайн боомтоор гарах чиглэл төлөвлөгдөж хэрэгжиж байна.

“Жуулчин Алтай” ХХК-ийн жуулчны бааз Алтай хотоос баруун хойш 7 км Баянтохой гэдэг газар байрлаж 1 га газар ашигладаг.

Аялалын гол чиглэлүүд: Алтай хотоос Тайшир сум 36 км, Хасагт хайрхан уул 50 км, Жаргалан сум 47 км, Хөх морьт сум 130 км, Баян-Уул сум 69 км, Алтай хот 134 км, Замын урт 450 км, аялах хугацаа 2-3 хоног

Энэ чиглэлд үзэх зүйлс:

1-р маршрут

Тайширын хүрмэн чулуу. Тайшир сумын төвөөс 1 км-т Завхан голын хойд эрэгт орших Цонж буюу Хомбого толгойн зургаан талт баганан хүрмэн чулуу багцлан

боосон мэт байдаг. Түүнээс урагш 1 км-т Завхан голын эрэг зургаан талтай хүрмэн баганууд байдаг. Тайширын хүрмэн чулууны урт нь 2 м бөгөөд бүдүүн нарийн нь 10-15 см хүртэл хэмжээтэй. Газар доор байгаа хэсэг нь чулуун шал мэт хээтэн харагддаг.

Жаргалан сумын төвөөс 60 орчим км зайд Монгол элсний захад Эрээн нуур, Ажиг нуур, Дөрөө нуур, Бударгана нуур зэрэг хэд хэдэн цэнгэг устай үзэсгэлэнт нуурууд бий.

Жаргалан сумын Сүмийн дэнжид орших 4 ш хүн чулуутай булш, Тоосготод орших хүн чулуу байдаг. Эдгээр дурсгалыг 1998 онд улсын тусгай хамгаалалтад авчээ.

Хүнхэр зуслангийн рашаан. Говь-Алтай аймгийн Жаргалан сумын нутаг Хасагт хайрхан уулын ард далайн түвшнээс дээш 2350 м өндөрт оршино.

Хойш урсан Хүнхэрийн голын хоёр талаар үргэлжилсэн шохойн чулуун цохионы агуйгаас рашаан оргилон гарна. 0.94 г/л эрдэсжилттэй, хлорид-карбонат-кальци-магни-натрийн найрлагатай, рН 6.6. Нөөц нь хоногт 108 м³, 0.12 г/л нүүрсхүчлийн хийтэй, хүйтэн рашаан.

Алтай хотоос баруун хойш шулуун замаар 65 км, Жаргалан сумын төвөөс зүүн урагш 27 км болно. Машин очих замыг засаж сайжруулсан ч улам сайжруулах шаардлагатай. Амралтын газар нь 1959 онд байгуулагдсан одоо нэг ээлжиндээ 60 орчим хүн хүлээн авах хүчин чадалтай. Жилд 205-300 хүн ирж сувилуулж байна.

Ходоодны архаг үрэвсэл, зүрх, судасны өвчин, мэдрэлийн өвчнийг анагаахад хэрэглэнэ. Амралтын газар, рашаан нийлбэр дүнгээр 5 га газар ашигладаг.

Хасагт хайрхан уулыг 27448 га талбайтайгаар 1965 оноос дархан цаазат газрын ангилалаар улсын тусгай хамгаалалтанд авсан. Ойн сан бүхий газар нь 1984 га, шинэсэн ой нилээд ихтэй, мөн улиас бургастай, тошлой, үхэр нүд зэрэг жимсний бут ихтэй. Буга, аргаль-янгир, ирвэс, шилүүс, тарвага зэрэг ой хөвч, хадат уулс, тал толгодын амьтан холилдон оршдог бөгөөд эгц өндөр хад цохио, гүн хавцал, сүрт шовх сарьдаг оргилууд сүндэрлэсэн говь цөлийн байгалийн үзэсгэлэнт баян бүрд үнэхээр сайхан нутаг юм.

Завхан гол Хангайн нурууны өвөрөөс эх авч баруун тийш 808 км урсаад Айраг нуурт цутгана. Урсгалын эхний хэсэгт уулын мөстлөгийн моренн дундуур урсах бөгөөд доод хэсэгтээ их тал, говь нутаг, элсэн дундуур урсана. Монгол хадран, Алтайн шар загас байдаг.

Улаан боом Тайшир сумаас 15 км орчим зайд 30-50 м өндөр, 100-200 орчим метр өргөн улаан буурал боржин чулуун хавцлаар Завхан гол урсдаг хэсгийг Улаан боом гэх бөгөөд усан цахилгаан станц барьж байна.

Монгол элс Завхан голын дунд хэсгээс адаг хүртэл 330 гаруй км үргэлжилж 2724 мянган га талбайг эзлэх их элс. Хөх морьт сум элсний захад оршдог.

Хүйсийн говь Хөх морьт сум орох, тэндээс буцах замдаа 150 км урт, 50 км өргөн уудам талбайг эзэлсэн Хүйсийн говийг туулна.

2-р маршрут

Алтай хотоос, Гуулин амралт 105 км, Дэлгэр сум 40 км, Чандмань сум 121 км, Бигэр сум 72 км, Халиун сум 95 км, Алтай хот 87 км, Замын урт 550 км аялах хугацаа 2-3 хоног

Энэ чиглэлд үзэх зүйлс

Гуулингийн суваг Завхан голоос ус татан тариалангийн талбайг усжуулдаг байсан Гуулингийн усжуулалтын байгууламж.

Гуулингийн амралт 1975 онд Завхан голын хөвөөн дээр байгуулагдсан. Алтай хотоос 112 км Гуулин тосгоноос 123 км оршдог. 7.2 га талбайг эзэлдэг, нэг ээлжиндээ 60-120 хүн хүлээн авах хүчин чадалтай. Жилд 1412 хүнд үйлчилсэн байна. Ямаат ууландаа янгир, Завхан голдоо монгол хадран, нохой, шар зэрэг загастай, голын эргийн бургасан шугуйд чацаргана элбэг ургадаг.

Нөхөрлөл хүүхдийн зуслан 1983 онд байгуулагдсан. Гуулин амралтаас 1 км зайд оршино. Нэг ээлжиндээ 200 хүүхэд хүлээн авч амруулдаг. Сутай, Оргил, Хүрхрээ, Алтай нэртэй 4 бүлэг, соёлын төв, зоогийн газар, номын сан, эмнэлэг, халуун ус, угаалгын газартайгаас гадна наран шарлагын болон биеийн тамирын задгай талбайтай 3 га газар ашигладаг.

Бурхан Буудай уул Бигэрийн хонхорын баруун урд орших 3765 м өндөр Бурхан Буудай уулыг 52110 га талбайтайгаар 1996 онд байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авчээ.

Бигэрийн хонхорт эртний Түрэг бичээс бүхий хөшөө байдгаас гадна Наранбулагаас эртний үлэг гүрвэлийн яс олджээ.

3-р маршрут

Алтай хотоос Шарга сум 89 км, Дарви сум 107 км, Тонхил сум 31 км, Төгрөг сум 139 км, Алтай хот 138 км, аялах замын урт 510 км, аялах хугацаа 2-3 хоног.

Энэ чиглэлд үзэх зүйлс

Шаргын говь Говь-Алтай аймгийн Шарга зэрэг хэд хэдэн сумын нутгийг хамрах 120 км урт, 90 км орчим өргөн Шаргын говийн төвд Шаргын Цагаан нуур оршино. Энэ нуур руу хүрээлэн байгаа уулсаас хэд хэдэн гол ирдэг бөгөөд зарим нь замдаа ширгэдэг. Энд амьдардаг соргог бөхөн, ховор ургамлыг хамгаалах зорилгоор 1993 онд байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсан.

Шарга сумын Хасаг Жаргалант ууланд янгир агнуулах зорилгоор ангийн отог байгуулсан.

Дарви сумын нутагт байдаг 2000 га талбайтай Ихэс нуурт Олон улсын улаан номонд орсон үлдмэл цахлай зусдаг.

Тонхил сумын орчмоос 4090 м өндөр мөнх цаст Сутай уулыг үзнэ. Энэ уулнаас эх авсан Зүйлийн гол Тонхил сумын төвийг дайрч урсаад Тонхил нуурт цутгадаг.

Уст Чацрангийн рашааныг орон нутгийн хэмжээнд ашигладаг.

4-р маршрут

Алтай хотоос Халиун сум 90 км, Бигэр сум 95 км, Таван манхан 25 км, Чандмань сум 75 км, Алтай хотоос 185 км. Аялах замын урт 500 км, аялах хугацаа 2-3 хоног.

Энэ чиглэлд үзэх зүйлс

Халиун сумын нутаг Цагаан голын эхэнд Цагаан хөтлийн давааны эртний Хүннүгийн үед холбогдох хадны сүг зураг, тамга, тэмдэг, шувуу, мал амьтны зураг 100 орчим байдаг. Морь, үхэр унасан хүний зураг ч байна. Энэ дурсгалыг 1998 онд улсын хамгаалалтанд авсан.

Уст чацрангийн рашаан 0.3 г/л эрдэжилттэй, гидрокарбонат-кальци-натрийн найрлагатай, рН 7.35, Eh 260, МВ. Энд нэг ээлжинд 75 хүн хүлээн авах бололцоотой сувилалын газар байгуулахаар төлөвлөж байгаа.

Бигэр сумын төвөөс холгүй Таван манхан амралтын газар байдаг. 3 га газар ашигладаг. Бигэрийн нуурын рашаан 173.0 г/л эрдэжилттэй, шүү давсны хурдастай, лаг хар шавартай нуур эрэг орчимдоо эмчилгээний элсэн зурвастай.

Доорхи маршрутад заагдсан сумдын аль нэгэнд Улаанбаатар хотоос онгоцоор очих тогтмол нислэгтэй болсон цагт Алтайн цаад говьд аялах сайхан боломж нээгдэнэ.

Алтай сумаас Бугат сум 134 км, Цээл сум 159 км, Цогт сум 93 км, Эрдэнэ сум 188 км, Ээж хайрхан 70 км, Алтай сум 100 км, Аялах замын урт 750 км, аялах хугацаа 4-5 хоног.

Энэ чиглэлд үзэх зүйлс

Бугат сумаас Монгол Алтайн нурууг давахад Бугатын хавцлыг нэвтэрдэг.

Алаг хайрхан уул Бугат сумын нутагт орших 3789 м өндөр Алаг хайрхан уулыг 364 х.д.км талбайтайгаар байгалийн нөөц газрын ангилалаар улсын тусгай хамгаалалтад авчээ. Ойн сан бүхий газар нь 40 га.

Ээж хайрхан уул 2275 м өндөр уулын 22475 га талбайтайгаар байгалийн дурсгалт газрын ангилалаар 1992 онд улсын тусгай хамгаалалтад авчээ. Уулын оройн намгаас буусан ус нүцгэн боржин чулууныхаа хажуу дээр шатлан тогтсон есөн тогоог дамжин боргио үүсгэн жирэлзэн урсдаг. Цөлийн нар салхи энэ уулын хажуу хормойн хад чулууг элдэв сонин дүрстэй болгожээ. Тогоонууд барагцаагаар 2-3 м голчтой нь 2-4 м гүн тогоо хоорондын зай 2-7 м хүрнэ.

Захуйн баян бүрд, Зармангийн баян бүрдүүд залгаа оршдог.

Говийн их дархан газрын А хэсэг нь Баянхонгор, Говь-Алтай аймгийн хамгийн урд захын улсын хилээс нааш 100 орчим км өргөн газрыг хамрах бөгөөд энд Эдрэнгийн нуруу, Атас, Чингэс, Сэгс цагаан богд, Арслан хайрхан, Шивээт улаан, Ланзат, Цувилуур, Харын нуруу, Хуцын шанд зэрэг говь цөлийн уулууд, Номин,

Цэнхэр зэрэг нүд алдам уудам говь хөндийг багтаасан 45149 мянган га талбайтай нутаг. Энд Эхийн голын, Цагаан бургасны, Шар хулсны, Талын Мэлтэсийн зэрэг баян бүрд олонтой. Ойн сан бүхий газар нь 1086141 га, Говийн их дархан цаазат газрын аялал жуулчлалын бүсийг Байгаль орчны сайдын 1994 оны 177 дугаар тушаалаар тогтоосон нь нийт талбайн 57.5% буюу 3054.2 мянган га болж байна.

Говь-Алтай аймагт 622448 га талбайг аялал жуулчлал, хүн амын байгалийн экологийн нөхөн сэргээлтийн бүс болгохоор төлөвлөв. Аялал жуулчлалын баазууд амралтын газруудын эдэлбэр 36.2 га, цаашид 10 га газрыг нэмж ашиглахаар төлөвлөв.

1. Завхан голын сав, Монгол элсний төгсгөл Эрэн нуур орчмын бүс 57500 га
2. Хасагт хайрхан уул 27448 га
3. Захуйн баян бүрд-Ээж хайрхан уул орчмын бичил бүс 295000 га
4. Бурхан буудай уул-Бигэрийн хотгорын бичил бүс 230000 га
5. Гуулингийн бичил бүс 12500 га

Дүн 622448 га

III.7 ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮС

Гаалийн болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдох, хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол улсын нутаг дэвсгэрийн хэсгийг **“Чөлөөт бүс”** гэнэ.

Монгол улс дэлхийн нээлттэй хөгжих чиг шугам барьж, улс орнуудын чөлөөт бүс байгуулж буй туршлагыг судлан харгалзаж Монгол Улсад Эдийн Засгийн Чөлөөт Бүс байгуулах үзэл баримтлалыг 1995 онд баталж, 2002 оны хаврын чуулганаар Чөлөөт бүсийн тухай хууль анх батлагдсан байна.

Монгол Улсад Эдийн Засгийн Чөлөөт Бүс байгуулах үндэслэл нь:

Манай орны тодорхой бүс нутагт хөрөнгө оруулах эрмэлзэл бүхий гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг өөрийн орны эрх ашигтай зөв хослон тухайн бүс нутгийн болон улс орны эдийн засгийн хөгжилд тус дөхөм үзүүлэх явдал юм.

Чөлөөт бүс байгуулах зорилго

Манай орны нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийн байгаль орчин, хүн ам, түүхий эдийн нөөц, газар зүйн байрлал, зам харилцааны боломжийг зохистой ашиглан, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, дэвшилтэт технологи оруулах замаар эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор чөлөөт бүсийг байгуулна.

Чөлөөт бүсийн үйл ажиллагаа нь дараах зорилтыг хангахад чиглэгдэнэ.

- Экспортын үйлдвэрлэл, импортыг орлох бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх.
- Удирдлагын болон үйлчилгээний орчин үеийн арга барил, маркетинг, худалдаа арилжааны туршлага нэвтрүүлэх.
- Хүн амын ажил эрхлэлтийг сайжруулах.
- Валютын чөлөөт хөрвөлтийг хангаж, нөөцийг нь нэмэгдүүлэх.
- Барааны хангамжийг сайжруулах.

Чөлөөт бүс байгуулах онцлог зарчим

Улс орны эдийн засгийн одоогийн бодит байдал, нийгмийн тодорхой хэрэгцээ шаардлага газар зүйн байрлалаас шалтгаалан дараахь онцлогтой байна.

- Тус орны зах зээл нь хил залгаа ОХУ, БНХАУ-аас нэлээд хамааралтай.
- Газар зүйн байршлын хувьд гадаадын хөрөнгө оруулагчдаас алслагдсан.
- Нэн тэргүүнд Ази, Номхон далайн орнуудтай хамтран ажиллах боломж илүүтэй.
- Улс орны янз бүрийн бүс нутагт оршдог эрдэс баялгийн томоохон ордуудыг түшиглэн хөрөнгө оруулах хэрэгцээ, шаардлага өсч байгаа.
- Гадаад худалдааны бүтцийн хувьд машин техник, төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, өргөн хэрэгцээний бараа голлон импортолдог, экспортод мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн дийлэнх хувийг эзэлдэг.

- Газрын нөөц, эрдэс баялаг ихтэй, зах зээлийн багтаамж сайтай орнуудтай хил залгадаг давуу талтай боловч далайд гарцгүй, дэлхийн зах зээлийн гол төв, зангилаанаас хол, эрс тэс уур амьсгалтай, хүн ам цөөн, үйлдвэрлэл, нийгмийн дэд бүтэц харьцангуй сул хөгжсөн зэрэг нь чөлөөт бүс байгуулахад харгалзах бодит хүчин зүйл юм.
1. Улс орны экспортын чадавхи, валютын орлого, бүс нутгийн хөгжлийн түвшинг нэмэгдүүлэхэд Монголын болон гадаадын хөрөнгө оруулагчдыг өргөнөөр татан оролцуулах.
 2. Дотоодын болон дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд туслах дэвшилтэт техник технологи оруулах,
 3. Улсын хил зэргэлдээ нутгийн эдийн засгийн уламжлалт хэлхээ холбоог гүнзгийрүүлж хилээр гарах, орох ачаа барааг нэмэгдүүлэх, зорчигчдийн зардал, чирэгдлийг багасгах, хил худалдааг хөгжүүлэх.
 4. Тухайн бүс нутгийн хүн амын ажил эрхлэлтийн түвшинг сайжруулах,
 5. Зах зээл хөгжсөн орнуудын бизнес худалдаа үйлчилгээ, эрхлэх соёл, удирдлага, маркетингийн туршлагыг нэвтрүүлэх.
 6. Хүн амд чухал шаардлагатай барааны хангамжийг сайжруулах.
 7. Эх орны үнэт түүхий эд, бүтээгдэхүүний хилээс гадагш хяналт, тооцоогүй зөөвөрлөх явдлыг хязгаарлах.
 8. Гадаад худалдааг цэгцтэй, үр өгөөжтэй явуулж, улс хооронд дамжин өнгөрөх экспорт, мэдээллээс орох ашгийг нэмэгдүүлэх.

Чөлөөт бүс байгуулах үе шат:

-Бэлтгэл үе

-Байгуулах үе

-Хөгжлийн үе гэсэн харилцан уялдсан үе шаттайгаар дэс дараалалтай хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах угтвар нөхцөл

Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах нөхцөл нь улс орны эдийн засаг зохион байгуулалтын дараахи угтвар нөхцөлийг бүрдүүлсэн байна.

- Чөлөөт бүс байгуулах нөхцөл нь улс орны эдийн засгийг хөгжүүлэхэд гадаад орнуудтай холбогдох тээвэр, газар зүйн тохиромжтой байрлалтай байх, дэд бүтэц сайн бүрдсэн буюу бүрдэх нөхцөл хялбар байх.
- Олон улсын стандартад нийцсэн орчин үеийн холбоо, эрчим хүч, зам тээвэр зэрэг үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтэц шинээр бүрдүүлэх буюу сайжруулах.

- Чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, чөлөөт бүсийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчид, аж ахуйн нэгж байгууллага, чөлөөтэй итгэл үнэмшилтэй ажиллах таатай орчин нөхцөл бий болгох.
- Чөлөөт худалдааны төв, гаалийн баталгаат агуулах, хил гаалийн шалган нэвтрүүлэх цогцолбор, үйлдвэрлэлийн барилга байгууламж, банк, зочид буудал, үйлчилгээний бусад цэг салбар байгуулах талаар дотоод гадаадын хөрөнгө оруулагчидтай гэрээ хэлцэл хийсэн байх.

Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах нутаг дэвсгэрийг сонгоход дараах шалгуурыг баримтлана.

1. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын шаардлагад чанд нийцсэн байх.
2. Тээвэр газар зүйн байрлалын хувьд гадаад худалдааны үйл ажиллагаа явуулахад тохиромжтой байх.
3. Зохих чиглэлээр үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж гадаадын зах зээлд гарах боломж илүүтэй байх.
4. Үйлдвэрлэл, нийгмийн зохих дэд бүтэц бүрдсэн буюу шинээр бүрдүүлэхэд дөхөмтэй байх.
5. Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц нөхцөл бүрдсэн байх.

Засгийн газар энэхүү хуулийг мөрдөж, дээрх үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, шаардлагыг иш үндэс болгон эхний ээлжинд Буянт Ухаагийн нисэх онгоцны буудал болон улсын хил орчмын нутагт Худалдааны чөлөөт бүсийг энгийн хэлбэрээр бий болгож, зохих туршлага хуримтлуулсаны үндсэн дээр эдийн засгийн чөлөөт бүсийг нутгийн гүнд үйлдвэрлэл худалдаа хосолсон хэлбэрээр үе шаттай хөгжүүлэх боломжтой юм.

Чөлөөт бүс байгуулсанаар бизнесийн үйл ажиллагаа, худалдааны эргэлтийг түргэтгэх, ачаа барааг баталгаатай хамгаалах, хадгалах, шуурхай нэвтрүүлэх бололцоо өргөжихийн зэрэгцээ гадаад худалдаа, тээврийн үйлчилгээ хийх арга, технологи, соёлын түвшинг дээшлүүлэх, улмаар Монгол улсын гадаадад нээлттэй байх чармайлтыг олон улсын хүрээнд бэхжүүлэхэд өргөн түлхэц үзүүлнэ.

Чөлөөт бүс нь худалдааны, үйлдвэрлэлийн, ХАА-н, аялал жуулчлал, үйлчилгээний, эдийн засгийн гэсэн хэлбэртэй байна.

Эдийн засгийн чөлөөт бүсэд худалдаа, үйлдвэрлэл, ХАА, аялал жуулчлал-үйлчилгээний үйл ажиллагааг хосолсон буюу нэгтгэсэн байдлаар эрхэлнэ.

Худалдааны чөлөөт бүсэд бараа бүтээгдэхүүний мөн чанарыг алдагдуулахгүйгээр хадгалах, хамгаалах, түүний сав, баглаа боодлыг сайжруулах, борлогдох чанарыг дээшлүүлэх, борлуулах үйл ажиллагааг эрхэлнэ.

Үйлдвэрлэлийн чөлөөт бүсэд тэргүүний дэвшилтэт технологи бүхий, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эх зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж борлуулах ажиллагаа эрхэлнэ.

ХАА-н чөлөөт бүсэд газар тариалан, мал аж ахуйн эрчимжсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагаа эрхэлнэ.

Чөлөөт бүсэд түүний хэлбэрээс үл шалтгаалан үйлдвэрлэл, нийгэм, зах зээлийн дэд бүтцийн бүх төрлийн үйлчилгээ явуулж болдог.

Аялал жуулчлал-үйлчилгээний чөлөөт бүсэд олон улсын стандарт шаардлагад нийцсэн зохистой дэд бүтэц бүхий үйлчилгээний цогцолбор бүрдүүлж, бүх төрлийн үйлчилгээ эрхэлнэ.

Чөлөөт бүсийн онцлог нь: Татварын хөнгөлөлттэй нөхцөл, аж ахуй нэгжийн бүртгэлийн хөнгөвчилсөн журам, шалган нэвтрүүлэх хялбарчилсан горим үйлчилдэг.

-Хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулахад импортын, гаалийн нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй.

-Чөлөөт бүсэд эрхлэх үйлдвэрлэл үйлчилгээ нь үндэсний болон олон улсын стандартад нийцсэн дэвшилтэт арга технологи эзэмшсэн байх шаардлагатай. Чөлөөт бүс нь тус бүсийг хөгжүүлэх хөгжлийг ойрын болон хэтийн төлөвлөгөөтэй, хөрөнгө оруулалтын төслүүдээр үйл ажиллагааны гол чиглэл нь явдаг, гадаад улс орнуудтай хамтын ажиллагааны өргөн цар хүрээтэй ажилладаг байх

Мөн чөлөөт бүс нь хөрөнгө оруулатыг татах, чөлөөт харьцангуй ба зардал шаардах, илүү тохиромжтой нутаг дэвсгэрийг сонгон авна.

Чөлөөт бүсийг Бургастайн боомтыг түшиглүүлэн байгуулах нь зүйтэй. Хот байгуулалтын үнэлгээг үндэслэн усан хангамж, ландшафт, газар зүй, экологийн байдлыг харгалзан Шар хөтөл орчим байгуулах нь тохиромжтой гэж төлөвлөж байна. Энд нийт 1100 орчим га газар хамрагдах бөгөөд суурьшлын бүс, үйлдвэр аж ахуйн бүс, гэр хорооллын бүс, амралт зугаалгын бүс гэсэн бүсүүдтэй байна.

III.8 БҮС НУТГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Говь-Алтай аймаг нь Төвийн, Бигэрийн, Төгрөгийн, Тонхилын, Баян-Уулын гэсэн 6 бүсэд хуваагдан хот, суурингийн тогтолцоонд шилжинэ. Энэ талаар бүс нутгийн тогтолцоонд тодорхой бичигдсэн.

Төвийн бүс: Энэ бүсэд Жаргалан, Тайшир, Дэлгэр, Халиун, Цээл, Шарга зэрэг сумдууд орох ба 3279,2 мянган га нутаг дэвсгэр, 8451 өрхийн 34,9 мянган хүн ам хамрагдаж байна. Энэ бүс нь Говь-Алтай аймгийн хөгжлийн гол тулгуур төв болох юм.

Нийт хот тосгоны 39.1 % нь байрлаж үйлдвэрлэл худалдаа эрхлэх юм. Аймгийн төв-Алтай хот нь энэ бүсийн төв байхаар төлөвлөгдсөн байна.

Бүсийн төвийн хөгжлийн талаар аймаг хөгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан юм. Төвийн бүсийн газар ашиглалтын байдал нь нилээд эрчимтэй байх бүс нутаг болно.

Газар зүй, нутаг дэвсгэрийн байршлын хувьд баруун бүсийн төв, тулгуур хотуудтай шууд харьцаатай, үйлдвэрлэл-үйлчилгээний талаар бусад бүсээс давуу талтай, төмөр ба засмал замд ойр дөт, зам дагасан хөгжлийн эрчимтэй бүсэд багтана.

Энд баруун бүсийн эрчим хүчний гол нөөц болох Тайширын УЦС, Монгол улсын Өрнө, Дорно бүсийг холбосон төмөр зам, Хөвсгөл аймгийн Ханх, Өмнөт хилийн Бургастай боомттой холбосон босоо тэнхлэгийн зам (сайжруулсан) дайран өнгөрч байгаа нь хөгжлийн түвшинг хурдасгах тулгуур болно.

Хүснэгт 76

Төвийн бүсийн газрын нэгдмэл сангийн ангилал, түүний өөрчлөлт (мян.га)

Төлөвлөгөөний үе шаг	Нийт нутаг дэвсгэр, мян.га	Аймгийн нутагт харьцуулсан хувь	Үүнээс					Улсын тусгай хамгаалалттай газар	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар
			ХАА-н газар	Хот тосгон буюу суурин газар	Зам шугам сүлжээний газар	Ойн сангийн газар	Усан сангийн газар		
2006-2010	3279,2	23,2	3309,8	7,2	9,6	80,5	6,0	168,5	116311
2011-2015	3279,2	23,2	2941,8	7,2	10,6	82,5	8,0	227,3	5167
2016-2023	3279,2	23,2	2940,8	7,2	14,1	87,1	6,0	227,3	

Аймгийн нийт хадлангийн газрын 83,8 %-ийг энэ бүсэд хамрагдаж малын тэжээлийн үйлдвэрлэлийн 48 %-ийг үйлдвэрлэх болно.

Бигэрийн бүс: Энэ бүсэд Бигэр, Чандмань, Цогт, Эрдэнэ зэрэг сумд орох ба 5013,9 мян.га нутаг дэвсгэр, 2779 өрхийн 11,5 мянган хүн ам, 364,9 мянган толгой мал сүрэг хамрагдаж байна.

Говь-Алтай аймгийн хувьд энэ бүс нутаг усалгаатай газар тариалан, жимс жимсгэнэ, хүнсний ногоо, дарс, гурил, малын тэжээлийн үйлдвэрлэл түлхүү хөгжүүлэхээр төлөвлөв. Мөн гурил, дарс, даршилж нөөшилсөн төрөл бүрийн ногооны жижиг үйлдвэр хөгжинө.

Бигэр сумын төв, Жаргалан тосгоныг бүсийн төв байхаар төлөвлөв. Жаргалан тосгоны байршил, зам харилцаа, үйлдвэрлэл үйлчилгээний газруудын нягтрал зэрэг нь бүсийн төвийн шаардлагыг хангаж байгаа юм. ГИДЦ газар, ховор амьтан ургамал, байгалийн өвөрмөц тогтоцтой үзэсгэлэнт газруудад түшиглэн аялал, жуулчлал, рашаан сувиллын үйлчилгээг түлхүү өргөтгөх болно.

Цаашид Талын мэлтсийн орд газрыг ашигласнаар бүс нутгийн хөгжлийн хурдац улам эрчимжих болно.

Хүснэгт 77

Бигэрийн бүсийн газрын нэгдмэл сангийн ашиглалт, түүний өөрчлөлт

Төлөвлөгөөний үе шаг	Нийт нутаг дэвсгэр, мян.га	Аймгийн нутагт харьцуулсан хувь	Үүнээс					Улсын тусгай хамгаалттай газар	Орон нутгийн тусгай хамгаалттай газар
			ХАА-н газар	Хот тосгон буюу сүүрин газар	Зам шугам сүлжээний газар	Ойн сангийн газар	Усан сангийн газар		
2006-2010	5013,9	35,5	1575,5	1,2	12,5	1255,1	2,6	2513,5	
2011-2015	5013,9		1173,3	1,2	13,2	1255,1	2,6	2618,7	11,6
2016-2023	5013,9		1172,2	1,2	15,2	1255,1	3,2	2618,7	

Аймгийн нийт нутгийн ХАА-н газрын 12,8 % нь энэ бүсэд хамрагдана. Үүнд 1815,1 мян.га бэлчээр, 0,2 мян.га хадлан, 1,2 мян.га тариалан, 0,5 мян.га барилга байгууламж орж байна.

Аймгийн нийт тариалангийн газрын 32,5 хувь энэ бүс нутагт хамрагдаж байна.

Цаашид Шугуй, Хаяа, Хүрхрээ, Хоёр байшин, Мянгай зэрэг томоохон усалтын системүүдийг хүчин чадлын хэмжээнд бүрэн ашигласнаар газар тариалангийн бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэх юм.

ХАА-н газар. Аймгийн нийт нутгийн ХАА-н газрын 20,8 % нь энэ бүсэд хамрагдана. Үүнд 2030,0 мян.га бэлчээр, 0,2 мян.га хадлан, 1,2 мян.га тариалан, 1,5 мян.га барилга байгууламж хамрагдана.

Баян-уулын бүс: Энэ бүсэд Баян-Уул, Хөх морьт сум орох ба 1215,1 мян.га нутаг дэвсгэртэй. Нийт 1391 өрхийн 5,7 мянган хүн ам 197,6 мянган толгой мал сүрэг хамрагдаж байна. Бүсийн төвийг Баян-Уул сумын төв Баян тосгоныг сонгож байна. Газар зүйн байрлалын хувьд Их нууруудын хотгорын зүүн өмнөд хэсэг Их Монгол, Хүйсийн говийн хөрс ургамлын эмзэг бүтэцтэй, элсний нүүлт, цөлжилтөнд

өртөмтгий нь энэ бүс нутагт МАА-г хөгжүүлэх, тоо толгойг өсгөхөд хязгаарлалт үүсгэдэг.

Бүс нутгийн эдийн засгийн хөгжилд тодорхой нөлөө үзүүлэхээр уурхай, илэрц газар одоогоор илрээгүй байна.

Улс орны ирээдүйн хөгжлийн хүрээнд боловсруулагдсан материалууд “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр, баруун чиглэлийн төмөр зам зэрэг байгууламжууд тус бүс нутгаар дамжин өнгөрөхөөр тусгагдсан байна.

Газар зүй, нутаг дэвсгэрийн байршлын хувьд баруун бүсийн зам харилцаа, эрчим хүчний гол зангилаа цэгт байрладаг нь бусад бүс нутгаас давуу талтай. Төмөр болон засмал зам, ногоон хэрэм дагуу байх нь дэд бүтэц, зам дагасан суурьшил, үйлчилгээний хөгжил өсөх болно.

Хүснэгт 78

Баян-Уулын бүсийн газрын нэгдмэл сангийн ашиглалт, түүний өөрчлөлт

Төлөвлөгөөний үе шат	Нийт нутаг дэвсгэр, мян.га	Аймгийн нутагт харьцуулсан хувь	Үүнээс					Улсын тусгай хамгаалалттай газар	Орон нутгийн тусгай хамгаалалттай
			ХАА-н газар	Хог тосгон буюу суурин газар	Зам шугам сүлжээний газар	Ойн сангийн газар	Усан сангийн газар		
2006-2010	1215,0	8,6	1209,2	1,3	2,3	0,3	2,1	2541,1	
2011-2015	1215,0		1205,6	1,3	2,3	1,2	2,1		
2016-2023	1215,0		871,8	1,3	4,4	3,6	2,1	418,9	

Төгрөгийн бүс: Энд Төгрөг, Бугат сум орох ба энэ бүсэд 1526,4 мян.га нутаг дэвсгэр, 1128 өрхийн 4,7 мянган хүн ам, 184,2 мянган толгой мал сүрэг хамрагдаж байна.

Бүсийн төвийг Төгрөг сумын төв Төгрөг тосгоныг сонгов. Төгрөг тосгон нь Алтай хотоос баруун зүгт 141 км зайтай далайн түвшнээс дээш 2800 км өндөрт оршино. Газар зүйн байршлын хувьд Монгол-Алтай нурууны Алаг хайрхан, Их хүрэн, Хөвчийн нуруу, Шарга, Алтайн өвөр зүүн гарын говь, Тахийн тал зэрэг уул тал говь хосолсон нутагтай нь уламжлалт мал аж ахуй хөгжүүлэхэд тохиромжтой. Бижийн голын услалтын системийг засварлаж ашигласнаар газар тариалангийн зарим бүтээгдэхүүний хангахаар тооцсон болно. Мөн МАА-н гаралтай түүхий эдийг боловсруулах жижиг үйлдвэр, хөргүүртэй махан зоорь барихаар тооцов. Мааньт, Хүрэн голын хүрэн нүүрсний уурхай болон бусад орд газруудыг түшиглэн уул уурхайн салбарыг хөгжүүлэх, шахмал түлшний жижиг үйлдвэр байгуулахаар төлөвлөв.

Төгрөгийн бүсийн газрын нэгдмэл сангийн ашиглалт, түүний өөрчлөлт

Төлөвлөгөөний үе шат	Нийт нутаг дэвсгэр, мян.га	Аймгийн нутагт харьцуулсан хувь	Үүнээс					Улсын тусгай хамгаалалттай газар	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар
			ХАА-н газар	Хот тосгон буюу суурин газар	Зам шугам сүлжээний газар	Ойн сангийн газар	Усан сангийн газар		
2006-2010	1526,4	10,8	1026,5	1,0	3,8	186,0	1,0	373,3	
2011-2015	1526,4	10,8	948,6	1,0	4,0	186,0	1,0	388,7	1,5
2016-2023	1526,4	10,8	939,9	1,0	4,0	186,0	1,4	396,8	1,6

ХАА-н газар. Аймгийн нийт нутгийн ХАА-н газрын 7,2% нь энэ бүсэд хамрагдана. Үүнд 1020,5 мян.га бэлчээр, 0,1 мян.га хадлан, 0,1 мян.га тариалан, 0,2 мян.га барилга байгууламж хамрагдана.

Тонхилын бүс. Энд Тохил, Дарви сум орох бөгөөд 108,5 мян.га нутаг дэвсгэр, 1145 өрхийн 4,5 мянган хүн ам, 298,0 мянган толгой мал сүрэг хамрагдаж байна.

Бүсийн төвөөр Тонхил сумын төв Зүйлийг сонгов. Алтай хотоос баруун тийш 230 км зайд Зүйлийн голын хөвөөнд далайн түвшнээс дээш 2200 м өндөрт оршино. Газар зүйн байршлын хувьд Монгол-Алтай нуруу түүний салбар Сутай, Дарвийн өндөр уулс Шарга болон Алтайн өвөрийн Хонин усны говь зэрэг уул тал говь хосолсон нутагтай нь уламжлалт мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой. Харгана түрүүний услалтын системийг засварлаж ашиглалтанд оруулах, боломжтой газрыг услах боловсруулах замаар бүсийн хэмжээнд газар тариалан хөгжүүлнэ. Цаашид шөрмөсөн чулуу зэрэг орд газрыг түшиглэн уул уурхайн салбарыг хөгжүүлэхээр төлөвлөсөн болно.

Тонхилийн бүсийн газрын нэгдмэл сангийн ашиглалт, түүний өөрчлөлт

Төлөвлөгөөний үе шат	Нийт нутаг дэвсгэр, мян.га	Аймгийн нутагт харьцуулсан хувь	Үүнээс					Улсын тусгай хамгаалалттай газар	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар
			ХАА-н газар	Хот тосгон буюу суурин газар	Зам шугам сүлжээний газар	Ойн сангийн газар	Усан сангийн газар		
2006-2010	1084,5	7,7	797,6	0,8	4,0	131,3	2,4	266,9	10,1
2011-2015	1084,5	7,7	658,2	0,8	4,0	131,3	2,4	295,2	
2016-2023	1084,5	7,7	646,5	0,8	4,0	131,3	2,4	306,7	

Алтай бүс. Энэ бүсэд одоогийн Алтай сумын бүх нутаг хамрагдах ба 866,3 мян.га нутаг дэвсгэр, 579 өрхийн 2,5 мянган хүн ам, 79,4 мянган толгой мал сүрэг хамрагдаж байна.

Бүсийн төвийг Алтай сумын төв Баян-Овоо тосгоныг сонгов. Баян-Овоо тосгон нь Алтай хотоос баруун зүгт 358 км Бургастайн хилийн боомтоос 26 км зайд тус тус оршдог. Газар зүйн байршлын хувьд Аж богдын нуруу, түүний эргэн тойрны говь тал нутаг хамрагдана. Усалгааны асуудал шийдэгдсэн нөхцөлд газар тариалангийн үйлдвэрлэл хөгжих боломжтой. Ялангуяа жимс жимсгэнэ, хүнсний нарийн ногоо тариалахад дулааны хангамж сайтай юм.

Аймгийн төв, бусад бүсүүдээс алслагдсан тул хөгжлийг тэтгэх нэгэн хүчин зүйл нь Бургастайн боомтоор дамжин хил худалдааг өргөтгөх, чөлөөт бүс байх болно.

Бургастай-Ханхын босоо тэнхлэгийн зам, мөн босоо тэнхлэгийн “Ногоон хэрэм” хөтөлбөр хэрэгжих, Талын мэлтэсийн алтны орд газрыг ашиглалтанд орох үед зам дагуу шинээр суурингууд байгуулагдах зэргээр бүс нутгийн бие даасан байдал улам бэхжих болно.

Хүснэгт 81

Алтай бүсийн газрын нэгдмэл сангийн ашиглалт, түүний өөрчлөлт

Төлөвлөгөөний үе шат	Нийт нутаг дэвсгэр, мян.га	Аймгийн нутагт харьцуулсан хувь	Үүнээс					Улсын тусгай хамгаалалттай газар	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар
			ХАА-н газар	Хог тосгон буюу суурин газар	Зам шугам сүлжээний газар	Ойн сангийн газар	Усан сангийн газар		
2006-2010	202,6	14,4	1081,6	0,3	3,2	334,8	0,1	996,4	
2011-2015	202,6		820,0	0,3	3,2	334,8	0,1	997,5	50,1
2016-2023	202,6		820,2	0,3	3,2	334,8	0,1	997,5	50,1

IV. ГАЗАР АШИГЛАЛТЫН ТАЛААР ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Хөдөө аж ахуйн газар ашиглалт

1. Аливаа гол, горхи, усархаг намагтай газраас 100 м-ийн дотор газар тариалан эрхлэхээр хагалах, химийн бордоо, хорт бодис ашиглахыг хориглоно.
2. Тариалангийн ажлыг 5% /3 хэм/-иас илүү налуутай газар эрхлэх нөхцөлд уг ажлыг газрын налууд хөндлөн хийнэ. Усны элэгдэлд орох болон хөрсний үржил шим буурахтай тэмцэх зорилгоор үр тариа, малын тэжээлийг ээлжлэн тариална.
3. 15 % /9 хэм/-иас илүү налуу газарт тариалангийн үйлдвэрлэл эрхлэх боломжгүй болно.
4. ХАА-н үржил шимтэй хөрсийг ХАА-н хэрэгцээнд ашиглах боломжийг хаасан эсвэл багасгасан аливаа үйл ажиллагааг хориглоно.
5. 30% /17хэм/-иас илүү налуу газар, гол нуурын эрэг хавийн газар мал аж ахуйн байнгын барилга байгууламж барих, мал сүргийг олноор байран байлгаж болохгүй.
6. Нутгийн ургамлын бүтэц, хэмжээг зохих хэмжээнд байлгах үүднээс малыг байнга сэлгэж бэлчээрүүлнэ.
7. Сэлгэж бэлчээрлүүлэх, бод, бог малыг хамт бэлчээх зэргээр зохицуулснаар бэлчээр болон газар ашиглалт нэн оновчтой болно.
8. Тариалан эрхэлж буй газар химийн хор хэрэглэхээс урьтаж тэнд шим бордоо, биологийн цэвэрлэгээний арга болох хортон мэрэгчид, шавьж устгагч ашиглах зэргээр байгалийн хяналтын арга хэрэглэнэ.
9. Салхинд амархан хийсэх элсэрхэг хөрст газрыг тариаланд ашиглахгүй, олон наст өвс, модны тохирох төрлийг суулгаж болно.
10. Байнгын тогтоол усыг усанд амархан идэгдэж жалга болдог хөрсөнд хадгалахгүй.
11. Эрдсийн бордоо хадгалах, тээвэрлэх явцад гарч болзошгүй алдагдал, хаягдлыг аль болох багасгах талаар анхаарна.
12. Хөрсийг сайтар судалж, гаргасан зөвлөмжийн дагуу эрдсийн бордоо ашиглана.
13. Шаардлагатай үед хөрс хамгаалах зорилгоор талбай хамгаалалтын ой зурвас байгуулна.
14. Хагалсан хөрсийг усны элэгдлээс хамгаалах зорилгоор дараахи арга хэмжээг хэрэгжүүлж болно. Үүнд:
 - а. Усжуулах боломжтой нутагт л хүрэн хөрсийг газар тариаланд ашиглах,

б. Хүрэн хөрстэй нутагт тариалан эрхлэхэд газар хагалалтын арга ажиллагааг хянах, хамгаалалтын ойн зурвас байгуулах, усны нөөцийн зурвас гаргах зэрэг ус хамгаалалтын ажил хийхийг шаардах.

Газрыг эрчимтэй ашиглах

1. Нуурын эргийн усны төвшнөөс харахад шинээр байнгын барилга байгууламж барихыг хориглодог. Гагцхүү суурин газар буюу амралт сувилалын ойр орчинд барихыг зөвшөөрнө.
2. Бүх хот, суурингийн газрын эзэлж байгаа нийт талбайн 10-аас доошгүй хувийг цэцэрлэгт хүрээлэн, ногоон зурвас зэрэг газарт зориулна.
3. Хүрээлэн байгаа байр, орон сууцад зориулан үйлчилгээний барилга байгууламжийг нягтруулж барих, харин тэдгээрийг замын дагуу сунжруулж барихыг цээрлэнэ.
4. Орон сууцны болон худалдаа үйлчилгээ үйлдвэрлэлийн бүсүүдийн хооронд ногоон зурвас байгуулна.
5. Ариун цэврийн зориулалттай барилга байгууламж нь бохирын нийтийн сүлжээ, хөрсний усны түвшингээс аль болох зайтай байх
6. Аливаа усны эргээс 30 м-ээс дотогш зайд бие засах газар байгуулахыг хориглоно.
7. Гол, горхи, нуур, усархаг, намагтай газар гол зам буюу ойролцоох барилга байгууламжаас 100 м-ийн дотор элс хайрга олборлохыг хориглоно.
8. 15% /9 хэм/ -иас дээш налуу газар барилга байгууламж барихыг хориглоно.
9. Хот суурингийн гаднах барилга байгууламжийн өндрийг эргэн тойронд байгаа уул нурууны хяраас доогуур харагдахаар байлгаж байгалийн тогтоц болон ой мод, ургамлын үзэмжийг хамгаална.
10. Зам барилга, шугаман байгууламжийн хэлбэр нь байгалийн зураглалын ерөнхий чигийг дагана. Газар нутгийнхаа дүр төрөхөөс эрс тодрон харагдах өнгө хэлбэрээс зайлс хийх
11. Барилга байгууламж барих явцад мод устгахгүй, ургамал ургах орчинг хөндөхгүй байхад анхаарна.
12. Эвдэрсэн хөрсөнд дахин ургамал суулгах ажлыг аль болох богино хугацаанд хийнэ. Хөрс, эвдэрснээс хойш өвс ургах нэг бүтэн улирлын дотор энэ ажлыг заавал хийсэн байх ёстой.
13. Ус сувгийн системд ашиглах ариутгагч нь ус хувиарлах байгууламжийн хүрээнд биологийн тэнцвэрт тогтворт байдлыг алдагдуулахгүй байх

14. Шинээр барьж буй орон сууцны болон үйлдвэрлэлийн барилга байгууламжийг ашиглалтанд оруулахаас өмнө бохирын цэвэрлэгч, гуравдагч шатны багаж төхөөрөмж бэлэн болсон байх ёстой.
15. Бохирын сүлжээг байгуулах, ажиллуулахад олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн стандартыг баримтална.
16. Хатуу хог хаягдал, бохирыг хадгалах стандартын шаардлага хангасан нүх цооногт хадгалах
 - а. Зам, барилга, байгууламж нь аливаа гол горхи, нуур, усархаг, намагтай газраас 100 м-ээс хол байрлах
 - б. Нүхний ёроолоос доош 2 м-ийн зайд хадан суурьтай эсвэл улиралын давтамжтай усанд давтагддаг газар цооног, худаг байрлуулахыг хориглоно.
17. Хатуу хог хаягдлыг хадгалахдаа тусгаарлах, цэвэрлэгээ болон устгалын нормийг хатуу сахиулах, өөр хавьд нь хөл хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ авна.

Үйлдвэрлэлийн ашиглалт

1. Амралт, аяллын цэг, нийтийн ариун цэврийн газар, дэд бүтэц зэрэг олон нийтийн зориулалттай барилга, байгууламжид хөрөнгө оруулах тухай заалтыг хамтарсан үйлдвэр байгуулах бүх гэрээ хэлэлцээрт тусгана.
2. Сав нутгийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй гадаадын пүүс, компаниуд байгаль орчныг хамгаалах талаар олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн болон монголын бүх хууль дүрмийг баримтлана.
3. Үйлдвэрийн газруудын хаягдал ус, ялгарах хий нь орчныг бохирдуулан доройтуулахгүй байх, тухайлбал: Үйлдвэрийн газар хөрс, агаар мандал, усны сав газрыг бохирдуулахгүй, холбогдох стандарт дүрэм журмыг мөрдлөг болгох.
4. Гадаадын аль ч пүүс компанитай байгуулсан гэрээ хамтарсан үйлдвэрийн гэрээнд байгаль орчныг хамгаалах тодорхой бөгөөд хатуу заалтыг тусгах, мөн энэ заалтыг зөрчсөн нөхцөлд хохирлыг арилгуулахаас гадна холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах.
5. Хорт бодис, шүлт, элементийн ашиглах явдлыг аль болох хязгаарлан хориглох
6. Эрдсийн /элс, хайрга орно/ хайгуул олборлолт хийсэн газрыг жич баталсан төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээнэ. Энд төлөвлөгөөнд олборлолтын ажил дууссаны дараа газрыг орон нутгийн өнгө төрхөнд буцааж оруулах техникийн болон бусад хог хаягдлыг зайлуулж зохих ёсоор устгах зэрэг сэргээлтийн ажлыг хийх арга, техникийг тодорхой тусгасан байна. Газрыг нөхөн

сэргээсний дараа хэрхэн ашиглах уг ашиглалт ойр хавийнхаа газрын бүсчлэлтэй хэрхэн нийцэхийг төлөвлөсөн байх ёстой.

7. Гол горхи, нуур, усархаг намагтай газар зам байгууламжаас 100 м-ийн дотор эрдэс олборлохыг хориглоно.
8. Шинэ үйлдвэрийн газруудын эрчим хүчний эх сурвалж нь байгалийн хий, нарны илч зэрэг эх үүсвэр байх явдлыг бүх талаар урамшуулна.
9. Хөрсний усны чанарт муугаар нөлөөлж болзошгүй аливаа шингэнийг газар доогуур хаяхыг хориглоно.
10. Хүн ам, зэрлэг ан амьтан, малын аюулгүй байдлыг хангах үүднээс үйлдвэрлэлийн газруудыг тойруулж хашаа барьж дохио тэмдэг хадна.

Тээвэр, холбооны зориулалтаар ашиглах

1. Эрчимт хөдөлгөөний засмал замыг 7% /4 хэм/-иас илүү налуу газар тавьж болохгүй.
2. 30% /17 хэм/-иас илүү налуу газар зам барьж болохгүй.
3. Байгалийн үзэсгэлэнт газраар тавьсан засмал зам болон уг газрын ойролцоо өнгөрөх утасны шугам, хий дамжуулах хоолой, дулааны болон цахилгаан дамжуулах шугамыг газар доогуур татна. Өөр техник технологи хэрэглэснээр байгалийн өнгө төрхийг алдагдуулахгүй байх.
4. Дамжуулах шинэ шугам, хоолойг байгуулахдаа цэцэрлэгт хүрээлэн хамгаалалттай газраас холуур татах, нийтийн амралт, аялалд зориулсан зурвас, бүс, түүх соёлын дурсгалт газрын үзэсгэлэнт үзэмжийг доройтуулахгүй байхад анхаарна.
5. Барилга байгууламжид хүрэх зам зурвасын дагуу ургамлыг арчлахад хорт бодисыг хэрэглэхгүй байх.
6. Цахилгаан дулааны шинээр барих станцууд агаарын бохирдлыг хязгаарлах хамгийн тэргүүний технологиор тоноглогдсон байх.

Байгаль хамгаалал, амралт, аялалын газрын ашиглалт

1. Тусгай хамгаалалттай газар болон амралт сувиллын газрын бүх ургамал амьтдыг хамгаалалтанд авна.
2. Хуурай цэвэрлэгээтэй жорлон болон 2 дахь шатны цэвэрлэгээний байгууламжийг ашиглана.
3. Байгалийн аялал жуулчлалын хөтөч нарт жил бүр аюулгүй байдал, анхны тусламж, байгалийн түүхийн талаар сургалт семинар явуулна.
4. Жуулчны бааз, амралт болон ашиг олох зориулалттай ажилладаг бусад амралт, аялал жуулчлалын байгууллагууд шинжилгээ судалгаа авах санд хөрөнгө хандивлана.

5. Байгаль хамгаалал, амралт, аялалын газарт суурин газар, үйлдвэрлэлийн бүс байгуулахыг хориглоно.
6. Орон нутгийн эдийн засагт дэм болох зорилгоор ашиг олох ажлын байр буй болгох үйл ажиллагаа явуулна.

Нуур, гол тэдгээрийн эрэг орчмын газрын ашиглалт

1. Гол, нуурт хаягдал ус цутгах зориулалттай шинэ байгууламж барихыг зөвшөөрөхгүй, гагцхүү хаягдал ус нь гол нуурын устай адил буюу илүү чанартай тохиолдолд зөвшөөрнө.
2. Тэжээлийг баяжуулахын тулд нитрит, нитрат, фосфаттай химийн бодис ашиглахыг хориглоно.
3. Хөлөг онгоц, мотор завинд жил бүр аюулгүй байдал, орчны бохирдолын шалгалт хийнэ.
4. Завины моторт жил бүр техникийн үзлэг хийж мөрдөж буй стандартад хүрч байгаа эсэхийг тогтооно.
5. 10 буюу түүнээс олон жил зорчигч тээвэрлэх завийг жил бүр шалгаж, бохирыг хадгалах бортоготой эсэхийг тогтооно. Бохирыг шууд нуур усанд шахаж гаргадаг төхөөрөмжийг бүх завийг хориглоно.

V. АЙМГИЙН ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр 2023 онд хөдөө аж ахуйн 615.3 мян.га-аар багасч байгаа бол тусгай хэрэгцээний газар 904.7 мян.га, усан сан бүхий газар 3.7 мян.га, ойн сан бүхий газар 776.9 мян.га, зам шугам сүлжээний газар 38.8 мян.га аар тус тус нэмэгдэж байгаа бол хот тосгон бусад суурин газар талбайд ямар нэг өөрчлөлт орохгүй юм. Одоогийн ашиглаж буй газрын нэгдмэл сангийн ангилалын талбайг бодож байсан арга аргачлал өөр байсанаас болж төлөвлөлтийн шатанд өсөж буй газрын талбай нэмэгдэгдлээ.

Хүснэгт 82

Аймгийн газрын нэгдмэл сангийн өөрчлөлт /мян.га/

Газрын ангилал		2005 газрын нэгдмэл сангийн тайлангаар /мян.га/	Төлөвлөлтийн эцэст нэмэгдсэн болон хасагдсан талбай /мян.га/	Төлөвлөлтийн хугацаа		
				2006-2010 он	2011-2015 он	2016-2023 он
Хөдөө аж ахуйн газар		8828.5	-615.3	8935.6	8723.2	8213.2
Үүнээс	Бэлчээр	8818.7	-622.4	8924.2	8709.4	8196.3
	Хадлан	2.3	2.3	2.4	3.1	4.6
	Тариалан	3.6	2.3	4	5	5.9
	ХАА барилга байгууламж	1.9	4.4	4.9	5.7	6.3
Хот тосгон бусад суурингийн газар		14.16		12	12	12
Үүнээс	Барилга байгууламжийн дэвсгэр газар	0.4	0.02	0.3	0.37	0.42
	Нийтийн эдэлбэр газар	12.65	-4.11	10.2	9.6	8.54
	Үйлдвэрийн газар		0.49	0.14	0.3	0.49
	Уурхайн дэвсгэр газар	0.7	1.45	0.1	0.4	2.15
	Гэр хороололын газар	0.34	0.08	0.3	0.35	0.42
Зам шугам сүлжээний газрын бүтэц		5.6	38.8	35.6	37.3	44.4
Үүнээс	Авто замын газар	4.4	30.3	32.8	33.4	34.7
	Шугам сүлжээний газар	0.9	2.5	2.1	3.1	3.4
	Агаарын тээврийн газар	0.2	1.6	0.6	1.6	1.8
	Төмөр замын газар		5.4			5.4
Ойн сан бүхий газар		1221.3	776.9	1988.3	1991.2	1998.2
Усан сан бүхий газар		14.2	3.7	16.8	16.8	17.9
Улсын тусгай хэрэгцээний газрын бүтэц		4061.3	904.7	4319.9	4527.6	4966
Үүнээс	Тусгай хамгаалалттай газар нутаг	3745.4	846.3	3890	4153.2	4591.7
	Хилийн зурвас	315.7	0	315.7	315.7	315.7
	Аймаг дундын отрын бэлчээрийн газар	114	0	114	114	114
	Бусад	0.03		0.03	0.03	0.03

ДҮГНЭЛТ

1. Говь-Алтай аймгийг Төвийн, Бигэрийн, Төгрөгийн, Тонхилын, Баян-Уулын болон Алтайн алслагдсан гэсэн 6 бүсээр хөгжүүлэхээр бүсчилсэн хөгжлийг үзэл баримтлал, улсын ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөө болон бусад бичиг баримтад тусгагдсан учир энэхүү үзэл баримтлалыг баримтлан аймгийн ГЗБ-ийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулав.
2. Аймгийн бэлчээрийн газрыг жижиг дунд болон уул уурхайн үйлдвэрлэл, зам шугам сүлжээ, хот тосгон суурин газруудыг шинээр байгуулах, өргөтгөх, газар ашиглалтыг үр өгөөжтэй болгон эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг арга хэмжээнүүдээс шалтгаалан бэлчээрийн газар тооны хувьд багассан боловч, бэлчээр ашиглалтыг сайжруулах, ургацыг нэмэгдүүлэх, ашиглалтыг малын төрөлд тохируулах замаар одоогийн байгаа малыг 600-800 мян.толгойгоор өсгөх боломжтой.
3. Хүн амын аж, амьдралыг дээшлүүлэх, тэдгээрийн амьдрах ая тух, хэрэгцээт ахуй хангамжийг хангах зорилгоор хот, тосгон, бусад суурингийн газруудыг өргөтгөх, шинээр барих зэрэгт газар олголтыг эрчимтэй явуулахаар төлөвлөв.
4. Зам, шугам сүлжээний газрыг “Мянганы зам” болон бусад стратеги төлөвлөлтүүдтэй уялдуулан 2006-2023 онд 8 дахин өсгөхөөр төлөвлөв. Гэхдээ зам, шугам сүлжээний газар олголтыг аль болох хязгаарлагдмал байдлаар олгохоор төлөвлөхийн зэрэгцээ, газар шорооны ажлаас болж үүсэх карьер, нүх зэргийг нөхөн сэргээхээр тусгав.
5. Ойн сан бүхий газраас заган ойг одоогийн хэмжээнд байлгаж, цаашид нөхөн үржүүлэх арга хэмжээг төлөвлөсний гадна, хар модон ойн талбайг өргөтгөхөөр төлөвлөв. Мөн “Ногоон хэрэм” төслийг хэрэгжүүлэх улмаар гэрийн модны үйлдвэрлэлийг эрчимжүүлэхийн тулд бургасны палантази байгуулахаар төлөвлөлөө. Хот, тосгон, бусад суурингийн газрын хөрсний элэгдэл, эвдрэлийг хамгаалах, тэнд амьдрагчдын эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор ногоон байгууламжтай байхаар төлөвлөсөн.
6. Усан сан бүхий газарт шинээр байгуулагдаж байгаа Усан цахилгаан станцын усан сангийн газруудыг тусгасны гадна, булаг шандын доорхи газрыг ариун цэврийн хамгаалалтын бүсийн хамт тодорхойлон аймгийн газрын нэгдмэл сангийн ангилалд тусгав.
7. Тусгай хамгаалалттай газар нутгийг Улсын тусгай хэрэгцээний газар ба орон нутгийн тусгай хамгаалалттай газар гэсэн 2 бүлэг болгон төлөвлөв. Тус аймгийн нийт нутгийн 26.5 %, улсын тусгай хамгаалалтанд хамрагдсан бөгөөд

энэхүү төлөвлөлтөөр улсын тусгай хамгаалалтанд 35.5 %, орон нутгийн тусгай хамгаалалтанд нийт нутгийн 4.0 % хамрагдаж байна.

8. Аймгийн газрын нэгдмэл сангийн ангилалыг 2006-2010, 2011-2015, 2016-2023 гэсэн үе шатаар боловсруулж гаргав.
9. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг ARCVEIW 3.3, ARC GIS 8.0, MAPINFO 7.8, AUTOCUT 2006 ERDASS программ хангамжаар боловсруулж тус бүр 2 % үйлдэв.

Төгсөв

АЙМГИЙН ГЗБ-ЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН МЕНЕЖМЕНТ

Үндэслэл: Унаган байгалиа хадгалах, нөөцийг нь зөв зохистой ашиглах, байгаль орчны тэнцвэрийг хадгалах зорилго бүхий аймгийн ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөний бодлогын хэрэгжилтийг Монголын үндэсний газрын менежментийн хэрэгжилтийн түвшинтэй шууд хамааралтай байна.

Газрын менежмент нь дараахи гол зорилтуудыг хэрэгжүүлнэ.

Тэргүүлэх зорилт 1. Газрын нөөцийн сангийн удирдлагын чадавхийг бэхжүүлж шинэ түвшинд гаргах;

Тэргүүлэх зорилт 2. Газрын нөөцийн менежментийг байгаль орчны тэнцвэрийг хадгалах, хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөөцийг нэмэгдүүлэх зорилгод захируулан иж бүрэн хэрэгжүүлнэ;

Тэргүүлэх зорилт 3. Аймгийн газрын мэдээллийн сан бий болгож иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчлэх

Тэргүүлэх зорилт 4. Газрын менежментийг өөрийгөө дэмжих систем бий болгох

Нэгдүгээр тэргүүлэх зорилтын хүрээнд:

1.1. Газрын нийтийн болон хувийн өмчлөл тэгш, шударгаар хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга зам нь:

а. Газрын харилцааг ардчилж, эрх зүйн орчныг бүрэлдүүлж байнга төгөлдөржүүлнэ. 2006-2023 онд

б. Иргэд, өрхийн хэрэгцээнд зориулан үнэ төлбөргүйгээр хувьчлах ажлыг тодорхой хугацаанд дуусах ажлыг зохион байгуулна. 2006-2008 онд

в. Төрийн өмчийн газрын төлбөртэйгөөр (дуудлага худалдаа, бирж) хувьчлах ажлыг эхлүүлж, нэгэнт эхлүүлсэн бол эрчимжүүлнэ. 2006-2023 онд

1.2. Газрын нөөцийг судлах, хуваарилалт, ашиглалтыг төлөвлөн зохион байгуулахад нэгдсэн удирдлагаар хангана.

Арга зам нь:

а. Аймгийн газрын нөөцийг эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн судлах, үнэлэх, ашиглалт, хамгаалалт, нутаг дэвсгэрийн оновчтой зохион байгуулалтыг төлөвлөн хэрэгжүүлэх ажиллагааг удирдлагын тулгуур хэрэгсэл болгоно. 2006-2023 онд

1.3. Газрын хуваарилалт, зохицуулалт, мэргэжлийн хяналт, олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгож хэрэгжүүлнэ. 2006-2010 онд

Арга зам нь:

Газарт тавих төрийн ерөнхий хяналт, мэргэжлийн хяналт, олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгож хэрэгжүүлнэ. 2006-2010 онд

1.4. Газрын тэгш, шударга татвар, төлбөрийн тогтолцоог бүрэлдүүлж төгөлдөржүүлнэ.

Арга зам нь:

а. Газрын зах зээлийн суурь үнэлгээг орон нутгийн хэмжээнд боловсронгуй болгоно. 2006-2010 онд

б. Газрын өмчлөл, эзэмшигч, ашиглагчийг хамарсан шударга татварын тогтолцоонд бүрэн шилжинэ. 2008-2010 онд

1.5. Газрын кадастрын үйл ажиллагааг эрхлэнэ.

Арга зам нь:

Газрын орон зайн болон атрибут өгөгдөл, газрын зах зээлийн ба үл хөдлөх өмчийн эрхзүйн байдлын бүртгэлийн мэдээллийн санг байгуулж, мэдээллийн менежментийг тасралтгүй эрхлэнэ. 2006-2010 оноос цааш үргэлжилнэ.

Тэргүүлэх зорилт 2-н хүрээнд дараах үйл ажиллагааг нэн чухал гэж үзэж хэрэгжүүлнэ.

2.1. Монгол үндэстний үеийн үед онцлон хайрлаж уугуул байдлаар нь хадгалан үлдээх газар нутгийн (экобүсийн) үндэсний өвийн санг буй болгож хамгаалалтанд авна.

Арга зам нь:

а. Аймгийн Улсын ба орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний сүлжээг байгуулах ажлыг дуусгана. 2016-2020 онд.

б. Байгаль орчны тэнцвэрийг улсын хэмжээнд хадгалан үлдээхэд чухал үүрэгтэй газар нутаг, экобус, нутаг дэвсгэр дэх хүн төрөлхтөний түүх, соёл иргэншлийн үүсэл хөгжил, мөхлийн талаархи газарт шингэсэн мэдээлэл, газар дэлхийн гарал үүсэл, хөгжил, өөрчлөлттэй холбоотой чухал мэдээллийг агуулсан газрууд, үндэстэн ястан, орон нутгийн хүн ардын тахин шүтэж, нандигнан хадгалах эрмэлзэлтэй байгалийн объект, газрыг бүртгэн газар нутгийн үндэсний өвийн сангийн реестр буй болгоно. 2008-2011 онд

2.2. Давуу байдлыг нь тэтгэн дэмжсэн хөгжлийн онцгой бүсүүдийн аргаар газар нутгаа хөгжүүлнэ.

Арга зам нь:

а. Үндэсний хэмжээний хөгжилд тодорхой чиг үүрэг гүйцэтгэж чадах нөхцөл нөөц бүхий сав нутаг, байгаль нутаг, дэвсгэрийн районуудыг илрүүлэн давуу байдлыг нь тэтгэн дэмжсэн хөрөнгө оруулалт, менежментийн бодлогыг хэрэгжүүлнэ.

б. Чөлөөт эдийн засгийн бүсүүдийг бүх хэлбэрээр нь байгуулна.

в. Дэлхийн хүн амын хүнсний хангамжид зохих хувь нэмэр оруулж чадахуйц чадавхитай бөгөөд өөрсдийн хүч хөрөнгөөр ойрын 10 жилд эзэмшиж чадахгүй газар

нутгийг гадаад улсуудад тусгай болзолтой гэрээгээр 60-99 жилээр түрээслүүлнэ. 2012-2015 онд.

2.3. Хот суурин газрын төлөвлөлт, газар олголтыг орон зайн зарцуулалт, оршин суугчдын нягтралыг харгалзсан нормативтай системд шилжүүлнэ.

Арга зам нь:

а. Бүх хот, тосгон, суурины тэг гортигийг газар зохион байгуулалтын журмаар тогтоож бусад ангиллын газраас хатуу зааглана. 2006-2011 онд.

б. Орон сууц, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, соёл боловсрол, албан газрын конторын зориулалт бүхий барилга байгууламжуудад дэвсгэр газрын нэгж талбайд ногдох барилгын нийлбэр талбайн доод хэмжээнд үндэслэсэн давхарлалын коэффициент тогтооно. 2004-2007 онд.

в. Хүн амын орон байрны бүсүүдэд нэг оршин суугчдад ногдох газрын нормативыг тогтооно. 2006-2010 онд.

2.4. Хот тосгон, суурингуудад хүн эрүүл, аюулгүй хүлцэхүйц тохиромжтой орчинд амьдрах нөхцөлийг хангана.

Арга зам нь:

а. Хот, тосгон, суурингуудын зохион байгуулалт, барилгажилт, тохижилт, экологийн нөхцөл байдалд аудит болон бенчмаркингийн (benchmarking) аргаар дүн шинжилгээ хийнэ. 2006-2010 онд.

б. Шаардлагатай хот тосгодод хот байгуулалтын реконструкци хийнэ. 2011-2015 онд.

в. Хүн амын төвлөрөл (нягтрал) ихтэй томоохон тосгодын орчны бүс нутгийн байгаль, орчны тэнцвэрийн чадавхид үнэлгээ өгч, ашиглалтын зориулалт, ачааллын зөвшөөрлийн системийг нэвтрүүлнэ. 2006-2010 онд.

2.5. Мал аж ахуй, газар тариаланг байгаль орчинд халгүй арга технологиор эрхлэх аргад шилжинэ.

Арга зам нь:

а. Бүс нутаг бүрээр байгаль орчны тэнцвэрийг хадгалах зорилтыг нэгдүгээрт тавьсан газрын менежментийг бүрэн нэвтрүүлнэ. 2006-2010 онд.

б. Газар тариаланд хөрсний үржил шимийн өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийн аргыг бүрэн нэвтрүүлнэ. 2006-2010 онд.

в. Газар хамгаалах шаардлагад бүрэн нийцсэн газар тариалангийн арга технологи нэвтрүүлнэ. 2006-2015 онд.

2.6. Цөлжилтөд нэрвэгдсэн болон цөлжилтийн үйл явцад байгалийн аясаар нэрвэгдэх магадлалтай газар нутгуудад цөлжилттэй тэмцэх бодит үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

Арга зам нь:

а. Хөрс тогтворжуулах болон ургамлан нөмрөгийг хадгалан хамгаалах зорилгоор цөл, цөлөрхөг хээрийн экосистемийн нөхцөлд ургаж байгаа унаган мод, сөөг, бутлаг ургамлуудыг ногоон бүс, зурвас, ногоон арал, ногоон хучлага зэрэг хэлбэрээр тариалж, ургуулах замаар газрын тусгаг бүрхэвчийн хувийг 45-с багагүй хэмжээнд хүргэнэ. 2006-2015 онд.

Тэргүүлэх зорилт 3-н хүрээнд нэн тэргүүнд дараахи үндсэн үйл ажиллагааг явуулна

3.1. Аймгийн газрын мэдээллийн сан бий болгон техник төхөөрөмжийн, программ хангамжийн, мэдээллийн сан хөмрөгийн, хүний нөөцийн дэд системүүдтэйгээр байгуулна. Эхний ээлжийг 2006-2010 онд.

3.2. Газрын сангийн данс бүртгэл, газар зохион байгуулалтын шугамаар бүрэлдүүлсэн газар ашиглалт, зохион байгуулалт, зохицуулалтын болон хөрс, бэлчээрийн цаасан дээр байгаа зураг мэдээллийг тоон мэдээлэлд шилжүүлнэ. 2006-2010 онд.

3.3. Аймгийн хэмжээгээр газрын нөөц, ашиглалтын орон зайн орчин үеийн мэдээллийг тандан судалгааны аргаар бүрэлдүүлнэ. 2006-2010 онд.

3.4. Газрын кадастрын зураглал болон бүртгэлийн мэдээллийг эхнээс нь тоон мэдээллийн горимоор гүйцэтгэж эхлэнэ. 2006-2010 онд.

3.5. Газрын мэдээллийн сан хөмрөгийг бүрдүүлсний дараа хот байгуулалт, дэд бүтэц, уул уурхай, байгаль орчин, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сантай болж мэдээлэл солилцооны горимд шилжинэ. 2010-2015 онд.

3.6. Газрын мэдээллийн системийн болон хүний нөөцийн чадавхийг бүрдүүлэх сургалт, дадлагажуулалтын бие даасан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ. 2006-2010 онд.

Тэргүүлэх зорилт 4-н хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.1. Тогтвортой газрын менежментийн шинжлэх ухаан-аргазүйн дэмжлэгийг буй болгож хөгжүүлнэ.

Арга зам нь:

а. Байгаль нийгмийн экологигсон харилцааны нөхцөл дэх газрын менежментийн онол-арга зүй, төлөвлөлт, төсөлжүүлэлт, зохицуулалтын норм, нормативын баазыг буй болгоно. 2006-2010 онд.

4.2. Мэдээллийн менежмент бүхий мэдээллийн сан буй болгоно.

Арга зам нь:

а. Газрын нөөц, чанар, төлөв байдал, үнэлгээ, өмчлөлт, эзэмшилт, ашиглалт хамгаалалтын талаархи байнга шинэчлэгдэж байдаг мэдээллийн баазыг буй болгоно. 2006-2011 онд.

б. Газрын менежментийн аймгийн газрын алба, орон нутгийн газрын даамлын хооронд болон нийгмийн үйл ажиллагааны бусад салбаруудын хооронд мэдээлэл солилцооны сүлжээтэй болно. 2010-2015 онд.

4.3. Тогтвортой газрын менежментэд шаардагдах хүний, материалын, мэдээллийн, санхүүгийн нөөцийг буй болгож байнга хөгжүүлнэ.

Арга зам нь:

а. Орчин үеийн газрын менежментийн үйл ажиллагааны салбаруудын онол-аргазүйг эзэмшсэн мэргэжилтнүүдтэй болох. 2006-2010 онд.

б. Газрын менежментийн орон нутгийн газрын даамлуудыг газрын менежментээр мэргэшсэн хүний нөөцөөр бүрэн хангана. 2010-2015 онд.

в. Газрын менежментийн төв орон нутгийн газрын даамлуудыг газрын нөөцийн судалгаа, зураглал, хэмжилт, боловсруулалт, мэдээлэлжүүлэлтийн хөгжингүй технологи бүхий шинэ үеийн багаж, техник хэрэгсэл, багц програмуудаар хангана. 2006-2010 онд.

г. Газар өмчлөх, эзэмших, ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх хүрээнд газар, газарт суурилсан эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус харилцааг зохицуулах эрх, эрхзүйн зохицуулалтын орчинг бүрдүүлж хөгжүүлнэ. 2006-2010 онд.

д. Газрын менежментийн гүйцэтгэх чиг үүрэг, үйл ажиллагааны процедур, газрын менежментийн байгууллага, албан тушаалтны статусыг тогтоох, бэхжүүлэх эрх зүйн орчинг хөгжүүлнэ. 2006-2010 онд.

4.3.1. Санхүүгийн эх үүсвэр, механизм

Газрын менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр, механизмд уламжлалт төсвийн урсгал санхүүжилт, улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаас гадна газрын татвар, төлбөрийн орлогоос газрын менежментийн арга хэмжээг санхүүжүүлэх хувь хэмжээг нэмэгдүүлнэ.

Газрын мэдээллийн сан байгуулах, орчин үеийн газрын менежментийн үйл ажиллагааны салбаруудын онол-аргазүйг эзэмшсэн мэргэжилтнүүдийг шаталсан сургалтанд хамруулна. Гадаад дотоодын хувийн сектортай хамтарсан хөрөнгө оруулалт хийх, олон улсын байгууллагын шугамаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг механизмыг ашиглана.

4.3.2. Бүх нийтийн оролцоо

Аймгийн газрын менежментийг хэрэгжүүлэхэд ард иргэд, байгаль орчин, газрын салбарын төрийн бус байгууллага, гадаад орнуудын газрын менежментийн болон байгаль орчны мэргэжлийн төрийн ба төрийн бус байгууллага, хувь хүмүүсийн оролцоо маш чухал.

Ялангуяа газрын үндэсний өвийн сан байгуулах, хадгалан хамгаалах, газрын хууль тогтоомжийн биелэлт, газрын төлөв байдал чанар, газар нөхөн сэргээлтэд тавих хяналтын нэг хэсэг нь төрийн бус байгууллага, орон нутгийн ард иргэдийн идэвхитэй үйл ажиллагаанд түшиглэнэ.

4.3.3. Гадаад бодлого

Газрын менежментийн бодлого нь дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө нээлттэй, түүний хүн ардад хүртээмжтэй байх чиглэлд нээлттэй байна. Нээлттэй байх зарчмыг дараах чиглэлд хэрэгжүүлнэ.

- Унаган төрхөө харьцангуй хадгалан үлдсэн янз бүрийн хэв шинж бүхий өргөн уудам нутаг дэвсгэр, түүний биологийн олон янз байдал, төрөл зүйлс, байгальтайгаа хүйн холбоо нь тасраагүй амьдралын хэв шинж зэрэгтэй чөлөөтэй танилцуулах нөхцөлөөр хангана.
- Хязгааргүй уудам орон зай-унаган байдалтай ландшафтын хослолыг рекреацийн зорилгоор хүртэхэд нээлттэй байна.
- Хөрс шороо, ургамлан нөмрөгийн онцлог давуу талыг ашиглан натурал уураг амин дэмээр баян, экологийн цэвэр орчинд бүтсэн экспортод гаргах хүнсний тансаг бүтээгдэхүүн, орцын материал үйлдвэрлэхэд газраа чөлөөтэй олгоно.
- Өөрсдийн хүч хөрөнгө, технологиор аж ахуйн эргэлтэнд оруулж чадахгүй байгаа зарим бололцоотой газар нутгуудыг гадаад улсын засгийн газарт тусгай болзол нөхцөлтэй гэрээгээр эзэмшүүлэхэд бодлогын хувьд нээлттэй байна.
- Газрын гүний усны ордуудыг түшиглэн говь, цөлийн бүсэнд хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн өндөр түвшинд хүрсэн бичил суурьшлын бүсүүдийг гадаад орны ажиллах хүчин, хөрөнгөөр буй болгохыг хөхүүлэн дэмжинэ.
- Газрын менежментийн техник, технологийн шинэчлэл хийхэд олон улсын байгууллага, гадаад улсын тусламж дэмжлэг, хөрөнгө оруулалтын механизм болон аж ахуйн нэгж, иргэдийн оролцоонд тулгуурлана.

5. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх үндсэн үе шат, гарах гол үр дүнгийн товч агуулга

5.1. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх үндсэн үе шат

Газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацааг төсөөлөхдөө дэвшүүлэн тавьж буй зорилтуудын хоорондын цаг хугацааны уялдаа, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга замын цар хүрээ, ажлын түвэгшил зэргийг харгалзсан бөгөөд хоорондын цаг хугацааны уялдааг голлон анхаарсан.

5.2. Гарах гол үр дүнгийн товч агуулга

Газрын менежментийн төлөвлөгөө буй болсноор газрын талаар төрөөс тогтвортой баримтлах бодлого буй болно.

Үндсэн зорилт 1-г бүрэн хэрэгжүүлснээр:

а. Газрын санг төрөөс удирдах удирдлага чиг үүргийн хувьд иж бүрэн болж, онол, аргачлал, арга хэрэгслийн хувьд менежментийн шинжлэх ухааны түвшинд хүрнэ.

б. Газрын кадастрын зураглалаар дэмжигдсэн газрын эрхийн бүртгэл (газрын эрхийн кадастр) буй болж, үл хөдлөх өмчийн харилцаа хөгжих эрхзүй-мэдээллийн таатай орчин бүрдэнэ.

в. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн газрын менежментийн арга ухааныг эзэмшсэн мэргэшсэн хүний нөөцтэй болно.

г. Хөгжингүй техник технологид суурилсан олон зориулалттай газрын кадастрыг бүтээнэ. Ийм кадастр эрхлэх мэдлэг ур чадвар бүхий хүний нөөцтэй болсон байна.

д. Байгалийн нөөц баялгийг эзэмших, ашиглах, хамгаалах үйлс экологижиж, хүмүүнлэг болоход томоохон алхмууд хийгдэнэ.

Үндсэн зорилт 2-г бүрэн хэрэгжүүлснээр:

а. Аймгийн газрын нөөцийг хадгалан хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөөцийг тэтгэн дэмжих зорилгод газрын менежмент бүрэн чиглэгдэнэ.

б. Газар нь өмчлөлийн зүйл, бизнесийн объект, байгалийн нөөц баялгийн үүргийг нэгэн зэрэг биелүүлж эдийн засгийн эргэлтэнд олон арга замаар өргөн хүрээтэй оролцуулах боломж бүрдэнэ.

в. Улсын тусгаар тогтнолд хохирол учруулахгүйгээр ашиглалтгүй байгаа, хангалттай ашиглахад эдийн засгийн чадавхи хүрэхгүй байгаа газар, газар нутгийг дэлхийн хамтын нийгэмлэг, гадаад улс, гадаад орны иргэд, аж ахуйн нэгжтэй хамтран аж ахуйн эргэлтэд оруулж, үр шимийг нь улам өргөн хүрээтэй хүртэж эхлэнэ.

г. Газар ашиглалтад бүсчлэл, зөвшөөрөл, хязгаарлалт, болзолтой ашиглалт зэрэг менежментийн зарчмыг нэвтрүүлснээр газар ашиглалтаар дамжуулан байгаль орчны тэнцвэрийг хангах болон хүний эрүүл аюулгүй, хүрэлцэхүйц нөөц, нөхцөлтэй газар зүйн орчинд амьдрах боломжийг хангахад ахиц гарна.

д. Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг байгаль орчны тэнцвэрт байдалд халгүй арга барилаар эрхлэх, байгаль-нутаг дэвсгэрийн биочадавхи, даацад тохируулан нормчлогдсон ачааллын зарчмаар бэлчээр нутгийг ашиглах горимд орж эхлэнэ.

е. Газар ашиглалтын нутаг дэвсгэрийн бүтцэд зарчмын өөрчлөлт орж, эдийн засгийн мезо, микро бүсүүд болон хөгжлийн голомтууд ялгаран гарна.

Үндсэн зорилт 3-г хэрэгжүүлснээр:

Нийтийн зориулалттай газрын мэдээллийн сантай болж аж ахуйн нэгж иргэдэд үйлчлэх бөгөөд буй болгосон мэдээлэл нь байгалийн нөөцийн ашиглалт, байгаль орчны хамгааллын менежментийн хүчирхэг хэрэглүүр болон ашиглагдана. Газрын мэдээллийн сантай болсноор газрын зах зээлд хяналт шинжилгээ хийх, газрын харилцаанд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, газрын татвар, төлбөр ногдуулах, хураах үйл ажиллагааг мэдээллээр дэмжих зэрэг олон талын ач холбогдолтой. Газрын мэдээллийн сангийн мэдээлэл нь өөрөө эргээд баялаг бүтээх баялаг болох болно.

Үндсэн зорилт 4-г хэрэгжүүлснээр:

Газрын менежментийг дэмжих системийг бүрэлдүүлж тасралтгүй ажиллуулснаар газрын сангийн төрийн удирдлагыг тогтвортой, үр ашигтай, нийгмийн тухайн үеийн социаль болон эдийн засаг, байгаль орчны менежментийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн явуулах боломж гарна.

6. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний товч агуулга

Төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх амин чухал хүчин зүйл нь төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилт, үйл ажиллагааны биелэлт болон үр дүн, түүний үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байх явдал юм.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах асуудалд голлон чиглүүлнэ.

Үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөнд мониторинг тавина.

Газрын төлөв байдал, чанар, хэмжээ, газрын сангийн бүтцэд мониторинг тавина.

Газрын хууль тогтоомжийн хэрэгжилтэнд ерөнхий болон мэргэжлийн хяналт, олон нийтийн хяналтыг хослуулан тавина.

Газрын кадастр, бүртгэл үйл ажиллагаа, үр дүнд бенчмаркинг хийнэ.

Газрын мэдээллийн системийн техник технологи, үйл ажиллагааны түвшинд бенчмаркинг хийнэ.

Газрын менежментийн аймаг, орон нутгийн газрын даамал, нэгжүүдийн үйл ажиллагаанд **SWOT** үнэлгээ хийнэ.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх гадаад дотоод орчны хүчин зүйлсийн өөрчлөлт, нөлөөлөлд үнэлгээ өгнө.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг харгалзан шаардлагатай бол төлөвлөгөөний зорилго, зорилт, үйл ажиллагаанд тодотгол хийж

болохоос гадна менежментийн шийдвэр, хэрэглэж буй арга хэрэгсэл зэрэгт өөрчлөлт оруулах, засвар, засал хийх ажиллагаанд уян хатан хандаж байх нь амжилтын үндэс болно.

7. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тухай

Төлөвлөгөөг байгалийн нөөцийн ашиглалт, байгаль орчны хамгааллын бусад хэсгүүдийн хөтөлбөртэй уялдуулж, тэдгээрийг нэгтгэн санал болгох түвшинд хүргэсний дараа төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жич боловсруулна.

Төлөвлөгөөний зорилго, зорилтууд, түүний үйл ажиллагаа бүрийг хэрэгжүүлэх болно.

Энэ төлөвлөгөөнд үндэслэн тухайн үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж хэрэгжүүлэх зарчмаар явах нь зүйтэй гэж үзэж байна.

Хүснэгт 83

Газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээний нэр	Хугацаа	Зардлын эх үүсвэр	Хариуцах байгууллага
1	Үнэ төлбөргүй газар хувьчлах ажиллагааг хэрэгжүүлнэ.	2006-2007 онд	Улсын төсөв	Засгийн газар Говь-Алтай аймгийн ЗДТГ, Газрын алба
2	Төлбөртэйгээр газар хувьчлах ажиллагааг үргэлжлүүлнэ.	2004-2023 онд	Улсын төсөв	Засгийн газар Говь-Алтай аймгийн ЗДТГ, Газрын алба
3	Газрын татвар, төлбөр, нөхөн олговрын зорилгоор газарт эдийн засгийн үнэлгээ өгнө.	2006-2010 онд	Улсын төсөв	Газрын менежментийн мэргэжлийн байгууллага, Аймгийн газрын алба, орон нутгийн даамлууд
4	Газрын кадастрын зураглалын ажлыг дуусган, бүх газрыг газрын эрхийн бүртгэлд заавал хамруулах арга хэмжээ авна.	2006-2010 онд	АХБ-ны зээлийн хөрөнгөөр	Газрын харилцаа, геодези, зураг зүйн агентлаг, Говь-Алтай аймгийн газрын алба
5	Аймгийн газрын мэдээллийн нэгдсэн сан зохион байгуулна.	2006-2010 онд	Олон улсын зээл, тусламж, улсын төсөв, хувийн секторын хөрөнгөөр	Засгийн газар, аймгийн ЗДТГ, Газрын алба
6	ТХГН-н үндэсний сүлжээг байгуулах ажлыг хэрэгжүүлж дуусгана.	2016-2023 онд	Улсын төсөв, олон улсын тусламж	БОЯ, БХБЯ, Говь-Алтай аймгийн ЗДТГ, Газрын алба
7	Газар нутгийн үндэсний өвийн сангийн реестр буй болгож хадгалан хамгаалах арга хэмжээг зохион байгуулна.	2006-2010 онд	Улсын төсөв, олон улсын төрөлжсөн байгууллагын тусламжийн хөрөнгө	БХБЯ, Газрын харилцаа, геодези, зураг зүйн агентлаг, Говь-Алтай аймгийн ЗДТГ
8	Хөгжлийн дотоодын онцгой бүс байж чадах газруудыг илрүүлж үнэлэх, хөгжлийн төсөл хөтөлбөрийг боловсруулах ажлыг зохион байгуулна.	2012-2015 онд	Улсын төсөв болон орон нутгийн төсөв	Санхүү, эдийн засгийн яам, БХБЯ, Говь-Алтай аймгийн ЗДТГ, Газрын алба
9	Чөлөөт эдийн засгийн бүс, онцгой түрээсээр гадаад улс, гадаадын аж ахуйн нэгжүүдэд ашиглуулах газруудыг сонгон авч, техник-эдийн засгийн	2012-2015 онд	Улсын төсөв	Санхүү, эдийн засгийн яам, БХБЯ, Говь-Алтай аймгийн ЗДТГ, Газрын алба

	үндэслэлийг гаргана.			
10	Хот, тосгон сууринуудын суурьшлын бүс газрын хил заагийг тогтоож бусад зориулалтын ангиллын газраас зааглана.	2006-2010 онд	Орон нутгийн төсөв	Говь-Алтай аймгийн газрын алба
11	Төрөл бүрийн зориулалтаар газар олгох нормативыг боловсруулж мөрдөнө.	2006-2010 онд	Орон нутгийн төсөв	БХБЯ, Газрын харилцаа, геодези, зураг зүйн агентлаг, Говь-Алтай аймгийн газрын алба
12	5000-с дээш хүн амтай хот тосгоны зохион байгуулалт, барилгажилт, хүн амьдрах газар зүйн орчинд аудит, бенчмаркинг хийж холбогдох арга хэмжээг авч эхлэнэ.	2006-2010 онд	Улсын төсөв болон орон нутгийн төсөв	БХБЯ, Говь-Алтай аймгийн ЗДТГ, Газрын алба
13	Аймаг, сумын төвүүдийн хот тосгоны орчны газрын байгаль орчны тэнцвэрийн чадавхид үнэлгээ өгч даацыг нормчлон ашиглах аргад шилжинэ.	2006-2010 онд	Улсын төсөв болон аймгийн төрийн сан	БХБЯ, Говь-Алтай аймгийн ЗДТГ газар, Газрын алба
14	Байгаль-нутаг дэвсгэрийн бүс районы онцлогт тохируулсан бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж нэвтрүүлнэ.	2006-2010 онд	Олон улсын төсөл, Улсын төсөв болон орон нутгийн төсөв	БХБЯ, ХХААЯ, Говь-Алтай аймгийн ЗДТГ, Газрын алба
15	Цөл, цөлөрхөг хээр нутаг болон цөлжилтөд нэрвэгдсэн газруудад ургамлан нөмрөг буй болгох ажлыг тусгай хөтөлбөрийн үндсэн дээр өргөн хүрээтэй эхлүүлнэ.	2006-2010 онд	Улсын төсөв, олон улсын зээл, тусламж	БХБЯ, Говь-Алтай аймгийн ЗДТГ, Газрын алба
16	Газрын менежментийн төв орон нутгийн нэгжүүдийг газрын хайгуул судалгаа, хэмжилт боловсруулалтын хөгжингүй технологийн багаж төхөөрөмжөөр хангана.	2006-2010 онд	Улсын төсөв, олон улсын тусламж, зээлийн хөрөнгөөр	БХБЯ, Газрын харилцаа, геодези, зураг зүйн агентлаг, Говь-Алтай аймгийн ЗДТГ, Газрын алба

АШИГЛАСАН МАТЕРИАЛ
Хууль, тогтоомж

1. Монгол улсын газрын тухай хууль
2. Байгаль орчны хуулид
3. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
4. Монгол улсын Газрын тухай хуульд заасан тусгай хэрэгцээний газруудын ашиглалт хамгаалалттай холбоотой хууль тогтоомжууд
5. Ойн тухай хууль
6. “Газрын хэвлийн ашиглалт хамгаалалт, нөхөн сэргээлттэй холбогдсон хууль тогтоомжийн эмхэтгэл” Байгаль орчныг хамгаалах алба, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар 2001 он

Хөтөлбөрүүд

7. Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги
8. Газрын шинэтгэлийн асуудлууд /2001 он, УБ/
9. Геологи-Уул уурхайн салбарын талаар ойрын жилүүдэд баримтлах чиглэл
10. “Говь-Алтай аймгийн Мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”, Алтай хот, 2006 он.
11. “Говь-Алтай аймгийн газар тариаланг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”, Алтай хот, 2005 он.
12. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
13. Засгийн газарт танилцуулахаар бэлтгэж байгаа Монгол улсын төмөр замын мастер план
14. “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” УИХ-ын 2001 оны 57-р тогтоол
15. “Монгол орны ойн бодлого ба ойн тухай үндэсний хөтөлбөр” БОЯ, НҮБ-ийн ХХАА байгууллага, УБ 2002 он
16. Монгол улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөр
17. Монгол улсад амралт сувилал, аялал жуулчлал хөгжүүлэх ерөнхий төсөл
18. Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр
19. Монголын хөгжлийн стратеги /1999 он/
20. Монгол улсын эдийн засгийн хөгжлийн үндэсний чадавхи, гадаад орчин /1996 он, УБ/
21. Монгол улсын нийгэм-эдийн засгийн тэнхлэгээр хөгжүүлэх үзэл баримтлал /200 он, УБ/
22. Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 2000 он
23. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 1994 он
24. Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал, 1995 он
25. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, 2001 он
26. Монгол улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр, 2002 он
27. Монгол улсын харилцаа холбооны нэгдсэн сүлжээний хөгжлийн мастер төлөвлөгөө
28. Монгол улсын 2000 оны хүн ам, орон сууцны тооллого, үр дүн
29. Монгол улсын бүсчилсэн хөгжил, хот байгуулалтын асуудал, товхимол, 29-38 хуудас
30. Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэл батлах тухай, УИХ-ын тогтоол, 2001 он
31. “Ногоо хэрэм” үндэсний хөтөлбөр, УБ, 2005 он.
32. “Ойн тухай үндэсний хөтөлбөр”, БОЯ, Ойн үндэсний хороо, УБ 2002 он
33. “Ой зохион байгуулалтын төсөл” /төсөл, ойн тархалтын зураг/
34. “Ойн хайгуул, төслийн архив”, 1958-2001 он.

35. УИХ-д 1996 онд өргөн барьсан Монгол Улсын Хүн амын нутагшилт хөгжлийн ерөнхий төсөл
36. УИХ-ын 2001 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан улсын дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэг буюу “Мянганы зам” болон бүсийн хөгжлийн дэд бүтцийн таван босоо тэнхлэг
37. УИХ-ын 2003 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан бүсийн тулгуур төв хотууд
38. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
39. Төрөөс экологийн талаар баримтлах бодлого
40. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ УБ, 2002 он
41. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ, өргөжүүлэх асуудал УБ 2002 он
42. Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр
43. Хүн амын нутагшилт, хөгжлийн ерөнхий төслөөр тогтоогдсон бүийн хөгжлийг тэтгэх дэд бүтэц, нийгэм, эдийн засаг, аж ахуйн уялдаа холбоо, бизнесийн орон зайд үйлчлэх зохистой хүрээ, 2001 он
44. Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн тулгамдсан асуудлууд /1999 он/

Бүтээл

45. Аймгуудын уур амьсгалын лавлахууд. Ус цаг уурын хэвлэл. 1981-1986.
46. “Аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын 2004, 2005 оны жилийн эцсийн мэдээлэл”, Говь-Алтай, 2005 он.
47. “ Алтай хот” . Говь-Алтай аймаг, Алтай хотын ерөнхий төлөвлөгөө, Зураг төсөл хот байгуулалтын “ Хот-айл” ХХК.
48. Ашигт малтмалын хайгуул, орд газрын талбайн байршлын 1:1000000-ны масштаб бүхий зураг (2003.01.01)
49. Ашигт малтмалын орд газруудын байрлал, макро эдийн засгийн бүс харуулсан 1:2500000-ны масштабтай мастер тик
50. “Ашигт малтмалын ашиглалтын талбайн байршил” (Геологи уул уурхай кадастрын алба, 2003 он)
51. “Аялал жуулчлалын бүс нутаг төлөвлөлт”, Г. Болормаа, УБ, 2002 он
52. “Аялал жуулчлалын маркетинг” Жамсансүрэн. Н, УБ, 2002 он
53. “Байгаль орчны төлөв байдлын тайлан” 2001-2003 он, БОЯ, УБ
54. “Байгаль орчны яамны албан мэдээлэл”, Байгаль орчин 1996/3, 1996/4
55. “Баруун бүсийн үржлийн шилмэл мал” УБ, 2003 он.
56. “Баруун бүс нутгийг хөгжүүлэхэд Говь-Алтай аймгийн оролцоо, цаашдын зорилт”, Н. Жанчивдорж.
57. “БНМАУ-ын бэлчээр, хадлан дахь тэжээлийн ургамал таних бичиг” Н.Өлзийхутаг, УБ, 1985 он.
58. “БНМАУ-ын бэлчээр, хадланд эдийн засгийн үнэлэлт өгөх асуудал” Б.Мягмаржав, УБ, 1967 он.
59. “БНМАУ-ын ургамлан нөмрөгийн үндсэн шинжүүд А. А. Юнатов, УБ, 1976 он.
60. “БНМАУ-ын рашаан” О. Намнандорж, 1970 он
61. “БНМАУ-ын хөрсний зураг” , М:1:2500000, Д. Доржготов, Д. Батбаяр, Г.Ундрал, УБ, 1974 он
62. “БНМАУ-ын Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төрөлжилт” Л. Нямбат, УБ, 1998 он.
63. “Буурал Аж Богд Буян заяаны бурхан нутаг”, Б. Чүхээг, УБ, 2003 он.
64. “Буянт мал”, Б. Мижиддорж, М. Найданхүү, Г.Наранцэцэг, УБ, 2001 он.
65. “Бүсчилсэн хөгжлийн гарын авлага” Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороо, УБ, 2005 он.
66. “Бэлчээр ашиглалтын уялдаа, тэжээлийн ургамлууд”, Ц. Даваажамц, Ч. Санчир, УБ, 1979 он
67. “Бэлчээрийн мал аж ахуйн газар зүй”, Д. Базаргүр, УБ, 2005 он.
68. “Бэлчээр хадланг сайжруулах арга”, С. Жигжидсүрэн, М. Бадам, УБ, 1980 он

69. “Газрын кадастр” Ц. Цэрэнбалжир, Б. Наранчимэг, УБ, 2004 он.
70. “Говь-Алтай аймгийн атлас”, Улсын геодези зураг зүйн газар, УБ, 1989 он.
71. “Говь-Алтай аймгийн бизнес эрхлэгчдийн 4-р зөвлөгөөн” Алтай хот, 2002 он.
72. “Газар ашиглалтын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх арга зам”, Г.Пүрэвцэрэн, УБ, 1989 он
73. “Газрын нэгдмэл сан, ашиглалтыг дээшлүүлэх арга зам”, Г.Пүрэвцэрэн, А.Бааст, УБ, 1986 он.
74. “Газрын менежментийн онолын үндэс”, Г. Пүрэвцэрэн, Ж. Наранцацралт 2000 он
75. “Газрын сангийн ашиглалт, хамгаалалтын менежмент”, Г. Пүрэвцэрэн, 2000 он.
76. “Газрын кадастр”, Ц. Цэрэнбалжир, Б. Наранчимэг, УБ, 2004 он.
77. “Говийн Их дархан цаазат газрын байгалийн нөхцөл, биологийн нөөц баялаг”, БОЯ, УБ, 1995 он.
78. “Говь-Алтай аймгийн товч түүх”, О. Пүрэв, Ч. Мижээхүү, Ч. Алтангэрэл, Ж.Дүгэр, УБ, 2000 он.
79. “Говь-Алтай аймгийг хөгжүүлэх төсөл” Дэд бүтцийн хөгжлийн яамны зураг төсөл судалгааны үндэсний төв, УБ, 1996 он.
80. “Говь-Алтай аймгийн газар ашиглалт хамгаалалтын байгаль эдийн засгийн үндэслэл”, Газрын бодлогын хүрээлэн, УБ, 1991 он.
81. “Говь-Алтай аймгийн 2004, 2005 оны газрын нэгдсэн сангийн тайлан”
82. “Гол мөрний сав газрын нэгдсэн менежмент” Үндэсний семинарын эмхэтгэл, УБ, 2003 он.
83. “Говийн өглөө” сонин №002
84. “Домогт говийн шийдвэрлэх зарим асуудлууд” УБ, 1994 он.
85. “Завхан аймгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн газар зүйн асуудлууд” УБ, 2001 он.
86. “Их нууруудын хотгорын элсний ургамлын аймаг, ургамалжилт”, Х.Буян-Орших /БНМАУ-ын ургамлын аймаг, ургамалжилтын судалгаа, дэд боть/, ШУАХ, УБ, 1981 он.
87. “Малын гэжээллэгийн норм”, Х. Гэндарам, УБ, 2001
88. “Макро эдийн засгийн бүсүүдийн голлох ашигт малтмалын зургийн орд илэрцүүдийн каталог” (АМХЭГ, Геологийн мэдээллийн төв, 2002 он)
89. “Монгол орноор жуулчлах зуун зам” Ш. Шагдар, УБ, 2001 он
90. “Монголын байгалийн газар зүй” Ш. Шагдар, УБ, 1999 он
91. Монгол орны 21 аймгийн хур тунадасны мэдээ 1995-2000 УЦУЭШХ
92. “Монгол орны уур амьсгал”, Н. Бадарч, УБ, 1971 он.
93. “Монгол орны уур амьсгал”, Б. Жамбаажамц, УБ, 1989 он.
94. Монгол орны газрын нэгдсэн сангийн тайлан 1990, 1999-2001, ГБХ, ГХЭГ
95. “Монгол орны зонхилох ургамлын лавлах” УБ, 2000 он.
96. “Монгол орны инженер газар зүйн үндсэн асуудал”, С. Жигж, УБ, 1979.
97. “Монгол орны газар зүйн гайхам сонин” О. Намнандорж, 1967 он
98. Монгол орны гадаргын ус
99. “Монгол орны геоэкологийн асуудал” 2003-2005 он, УБ
100. “Монгол орны ландшафт-экологийн зарим асуудлууд”, Д. Даш, УБ, 2000 он.
101. “Монгол орны нуурын каталоги /цэс/” Ж Цэрэнсодном, УБ, 2000
102. “Монгол орны ургамлын аймгийн тойм”, Н. Өлзийхутаг, УБ, 1989 он.
103. “Монгол орны физик газар зүй” УБ, 1969 он.
104. “Монгол орны хөдөө аж ахуйг хөгжүүлэх байгалийн нөхцөл”, Н.Жагварал, Р.Индра, УБ, 1974 он.
105. “Монгол орны хөрс, газар зүйн мужлалт”, Д. Доржготов, УБ, 1976 он.
106. “Монгол тахийн хувь тавилан” О. Амархүү, А. Энхтөр, Д. Авирмэд, УБ, 2004 он.
107. Монгол Улсад Үндэсний Аялал Жуулчлал Хөгжүүлэх Мастер Төлөвлөгөө
108. “Монгол улсын газар зүйн атлас”, УБ, 2004 он.
109. “Монгол улсын Өрнөд бүс” Л. Цэдэмдамба, О. Батхишиг, Х. Маам, УБ, 1999 он.

110. Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал УБ 1999 он.
111. “Монгол улсын статистикийн эмхэтгэл”, 2001-2005 он.
112. “Монгол өлгийн чуулган” цагаан ном (монгол орны байгаль орчин) УБ, 2002 он.
113. “Монголын Алтай-Соёны байгалийн өв Археологийн дурсгалууд”, Х.Лхагвасүрэн, Т. Бямбадорж, Н. Батсүх, УБ, 2001 он
114. “Монголын бэлчээрийн мал аж ахуйн ирээдүй”, Олон нийтийн санал бодлыг танадах судалгаа, нээлттэй нийгэм УБ, 2003 он.
115. “Монголын улаан ном” УБ, 1997 он.
116. “Нийгэм эдийн засгийн шинэ нөхцөл дэх газрын менежментийн үндсэн асуудлууд” Ж. Наранцацралт, дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээл, УБ, 1998 он.
117. “Олон нууруудын хөндий, Баянбүрдийн ургамалжилт”, Ж. Гал, УБ, 1975
118. “Ойт хээрийн бүсэд бэлчээрийг нөөцөлж ашиглах арга” БТЭШХ-ийн бүтээл, №8, 1982, С. Жигжидсүрэн, Ч. Оюунцэцэг.
119. “Тариалангийн газрын экологи-эдийн засгийн үнэлэгээний бүсчлэл” Ц.Цэрэнбалжир, Б.Наранчимэг, УБ, 2004 он.
120. “Таримал бэлчээр бий болгох асуудал”, БТЭШХ-ийн бүтээл, №3, 1973, С. Жигжидсүрэн, Ц. Цэдэндамба
121. “Төрөл бүрийн бэлчээрийн шимт чанар”, Р. Цэрэндулам, УБ, ШУАХ, 1968 он.
122. “Уул Уурхайн тогтвортой хөгжил” улсын зөвлөгөөнөөс гарсан зөвлөмж, 2002.12.20
123. “Уул Уурхайн салбарыг тогтвортой хөгжүүлэх бодлогын асуудлын талаархи зөвлөмж”
124. “Үлэмж тансаг говь мину
Үүлэн цэнхэр Алтай мину” Б. Осор, Б. Дамдинсүрэн, УБ, 2004 он.
125. “Үр тарианы үйлдвэрлэлийг цаг уурын нөхцөлтэй уялдуулан төлөвлөх арга” Л.Нямбат, УБ, 1989 он.
126. “Цахиур төмөр” сонин, №01(177), Алтай хот, 2006 он.
127. Хот, аймаг сумдын хүн амын тоо, Үндэсний статистикийн газар /1990, 1993-2001 он/
128. “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэтийн зохистой хөгжил, байршил, төрөлжилтийг тодорхойдох математик загварын схем”, Л. Нямбат, УБ, 1989 он.
129. Хүн амын нутагшилт, хөгжлийн хэтийн төлөв, Д. Сайнэр, 2001 он
130. “Эдрэнгийн нурууны бэлчээрийн голлох ургамлын өнгөт цомог” УБ, 2005 он.
131. “Ээж хайрхан уулын байгалийн дурсгалт газар” эмхэтгэсэн Б.Мижиддорж, Г.Довчиндорж, УБ, 2005 он.
132. “Газрын кадастр” Ц.Цэрэнбалжир, Б.Наранчимэг, УБ, 2004 он.
133. “Говь-Алтай аймаг Алтай хотын ерөнхий төлөвлөгөө”, Алтай хот, Зураг төсөл хот байгуулалтын “Хот айл” ХХК